



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-16</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>17-152</i>
<hr/>	
<i>1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>33-103</i>
<i>2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>103-135</i>
<i>3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>135-152</i>

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилоттой: Б.Бейсен, Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Б.Жаргалмаа, Д.Өнөрболор;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Д.Сарангэрэл, Ч.Ундрэм;

Тасалсан: П.Анужин, С.Батболд, Б.Жавхлан;

Хоцорсон: Т.Аубакир-05 минут, Ж.Батсуурь-07 минут, Э.Батиугар-2 цаг 10 минут, Х.Болорчулуун-05 минут, Х.Булгантуяа-15 минут, С.Ганбаатар 3 цаг 02 минут, Д.Ганбат-32 минут, Х.Ганхуяг-08 минут, Т.Доржханд-19 минут, Ц.Мөнх-Оргил-15 минут, Х.Нямбаатар-29 минут, Л.Оюун-Эрдэнэ-21 минут, Б.Саранчимэг-16 минут, Ж.Сүхбаатар-14 минут, Ц.Туваан-11 минут, Ч.Хүрэлбаатар-22 минут, Д.Цогтбаатар-15 минут, Б.Энх-Амгалан-08 минут, Л.Энх-Амгалан-49 минут, Б.Энхбаяр-28 минут, Н.Энхболд-33 минут, Т.Энхтүвшин-1 цаг 21 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Ш.Раднаасэд, Н.Алтанхуяг, Ц.Анандбазар, Н.Ганибал, Ц.Сэргэлэн, Ж.Батсуурь нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Ш.Раднаасэд, Н.Алтанхуяг, Ц.Анандбазар, Н.Ганибал, Ц.Сэргэлэн, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн мэдээлэл өгөх тухай албан бичгийг танилцуулав.

Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор О.Мөнхбаатар, Монголбанкны ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны

асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ц.Даваасүрэн, Ж.Батжаргал, Н.Алтанхуяг, Ж.Сүхбаатар, Х.Баделхан, Ц.Цэрэнпунцаг, Б.Энхбаяр, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Г.Ганболд, Х.Булгантуяа, Б.Саранчимэг, Б.Бат-Эрдэнэ, Н.Энхболд, Ц.Сандаг-Очир, Б.Баярсайхан, Ц.Идэрбат, Д.Ганбат, Ш.Раднаасэд, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Б.Батзориг, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Тогтохсүрэн, Л.Мөнхбаатар, С.Ганбаатар, Ш.Раднаасэд, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	11
Бүгд:	43

74.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Элбэгзаяа, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, мөн компанийн Бизнес, хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн газрын ахлах зөвлөх А.Нинжин, ахлах

референт Ж.Мөнх-Оргил, Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч Д.Галсандорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Д.Тогтохсүрэн, Т.Аубакир, С.Ганбаатар, М.Оюунчимэг, Э.Батшугар, Т.Энхтүвшин, Д.Ганбат, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч Д.Галсандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 16 цаг 01 минутаас 16 цаг 37 минутад хуралдааныг даргалав.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

НЭГ.ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН САНАЛ

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Х.Булгантуяа, Т.Доржханд, Г.Тэмүүлэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “биржийг үүсгэн байгуулах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль,” гэсний дараа “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “Санхүүгийн зохицуулах хорооноос” гэсний дараа “тусгай” гэж нэмж, “суудлын” гэснийг, мөн зүйлийн 4.1.5 дахь заалтын “брокерын санал болгосон” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын “spot гэрээ,” гэсний дараа “форвард гэрээ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын “арилжих” гэснийг “худалдах, худалдан авах” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.11 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын “уул уурхайн бүтээгдэхүүний” гэсний өмнө “Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.16 дахь заалт нэмэх:

“4.1.16.“форвард гэрээ” гэж уул уурхайн бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн ХОЁРДУГААР БҮЛЭГ-ийн гарчгийн “, ЗОРИЛГО” гэснийг хасаж, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байна.”

“5.2.Биржийн бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлийг дүрэмд тусгана:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтын “төлбөр тооцоо, хийх” гэснийг “арилжаа болон клирингийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.3.2 дахь заалтыг, мөн зүйлийн 5.3.3 дахь заалтын “даатгалын тогтолцоо,” гэснийг хасаж, мөн зүйлд

доор дурдсан агуулгатай 5.3.4 дэх шинэ заалт нэмж, мөн зүйлийн 5.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.4.эрсдэлийн удирдлагын бодлоготой байх бөгөөд учирч болзошгүй эрсдэлээ даатгалд даатгуулсан байх.”

“5.4.Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.6.Бирж нь хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.9 дэх хэсэг нэмэх:

“5.9.Биржийн арилжааг үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд Засгийн газар шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.5.2 дахь заалтын “худалдаа,” гэсний дараа “санхүү,” гэж нэмж, мөн заалтын “үнэт цаас,” гэснийг хасаж, мөн зүйлийн 7.5.6 дахь заалтын “үнэт цаасны” гэснийг “санхүүгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтын “үнэт цаасны арилжаа,” гэснийг, мөн зүйлийн 8.4.2 дахь заалтыг, мөн зүйлийн 8.7 дахь хэсгийн

“төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага нар нь биржийн эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтын “шаардсан” гэснийг, 10.1.9 дэх заалтын “гишүүнд суудлын эрх, гишүүн бус оролцогчид” гэснийг, 10.1.13 дахь заалтын “асуудлыг төрийн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 10.2.1 дэх заалтын “коджуулах,” гэснийг, 10.2.6 дахь заалтын “, нөхөн бүрдүүлэх” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 10.1.13, 10.2.9 дэх заалтын “терминал,” гэсний дараа “тээвэр логистик,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ангилал код, чанар стандарт, сорьцын жагсаалтыг” гэснийг “ангиллыг геологи,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.3, 12.4 дэх хэсгийг тус тус хасах.

“12.1.Биржийн арилжааг энэ хуулийн 10.2.4-т заасан журмын дагуу зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Арилжааны гэрээг бүртгэх, хэрэгжилтийг хангах

13.1.Биржээр бүтээгдэхүүнийг арилжаалахад дараах төрлийн арилжааны гэрээг байгуулна:

- 13.1.1.спот гэрээ;
- 13.1.2.форвард гэрээ;
- 13.1.3.фьючерсийн гэрээ;
- 13.1.4.опцион гэрээ.

13.2.Биржийн арилжаа хийгдэж, хэлцэл биелснээр арилжааны гэрээг байгуулсанд тооцно.

13.3.Бирж арилжааны явцад хийгдсэн гэрээг энэ хуулийн 10.2.11-т заасан журмын дагуу бүртгэнэ.

13.4.Арилжааны гэрээний үүрэг, хариуцлагыг тухайн арилжаанд зуучилсан брокер хариуцна.

13.5.Бирж, биржийн брокер нь холбогдох баримт бичгийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу бүртгэж, хадгална.

13.6.Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүн нь биржийн итгэмжлэгдсэн терминалд байршиж, бүртгэгдсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “биржид арилжаалахаар бүртгүүлсэн,” гэснийг “биржээр” гэж, мөн хэсгийн “байгуулна” гэснийг “байгуулж болно” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “биржийн бус зах зээлд” гэснийг “биржээс гадуур” гэж, 15.5.4 дэх заалтын “Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчаас” гэснийг “Хорооны улсын байцаагчаас” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Биржийн арилжаанд оролцогч дараах нөхцөл, журмыг зөрчиж арилжаанд оролцсон бол арилжааг зогсооно:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Биржийн арилжааны төлбөр, тооцоо

16.1.Фьючерс болон опцион гэрээний арилжааны төлбөр, тооцоог үнэт цаасны төлбөрийн болон тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйцэтгэнэ.

16.2.Спот болон форвард гэрээний арилжааны төлбөрийн үйл ажиллагааг дотоодын арилжааны банк, эсхүл үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйцэтгэнэ.

16.3.Төлбөр, тооцоог хийхэд баримтлах журмыг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр биржийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

16.4.Бирж нь тооцооны үйл ажиллагааг өөрөө, эсхүл үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр тооцооны үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18, 19 дүгээр зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17 дугаар зүйл болгох:

“17 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

17.1.Биржийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.биржийн үйл ажиллагааг зохицуулах асуудлаар Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

17.1.2.биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг холбогдох этгээдээс авах.

17.2.Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох журмыг батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 20.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

20.2.4.биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоосон журам батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.5.бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтын “хийгдэж төлбөр, тооцоо хийх” гэснийг “төлбөр, тооцоо хийх ерөнхий” гэж, 20.4 дэх хэсгийн “хянан шалгагчийн” гэснийг “Хорооны улсын байцаагчаас өгсөн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 20.2.7 дахь заалт нэмэх:

“20.2.7.биржийн зах зээлд оролцогчдын үйлчилгээний төлбөр, хураамжийг тухайн оролцогчдын саналыг харгалзан тогтоох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Хороо нь” гэсний дараа “геологи,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3, 21.4 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн “биржийн гишүүнээр элсэж суудлын эрх авсан” гэснийг “биржид гишүүнчлэлтэй” гэж, мөн зүйлийн 21.6.1, 21.6.2 дахь заалтын “харилцагчийн” гэснийг “биржийн арилжаанд оролцогчийн” гэж, 21.6.3 дахь заалтын “харилцагчаа төлөөлөн биржийн” гэснийг “биржийн арилжаанд оролцогчийг төлөөлөн” гэж, 21.6.4 дэх заалтын “биржийн бараа” гэснийг “биржээр арилжаалах” гэж, “харилцагчид” гэснийг “биржийн арилжаанд оролцогчид” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 21.6.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтын “байгуулах” гэсний дараа “, түүнд хувьцаа эзэмших” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 24.2.7 дахь заалт нэмэх.

“24.2.7.биржийн арилжааны оролцогчийг арилжаанд оролцуулахгүй байх, үнэ ханшид нөлөөлөх зорилгоор бодит бус, төөрөгдүүлсэн, эсхүл хуурамч мэдэгдэл, амлалт, таамаг гаргах, нийтлэх, чухал үйл баримтыг нуун дарагдуулсан, бодит үйл баримтын талаар худал мэдэгдэл хийх замаар хэлцлийн нөгөө талыг төөрөгдүүлсэн, эсхүл тодорхой арга, хэрэгсэл тоног төхөөрөмж ашиглан хэлцлийн нөгөө тал болох этгээдийг төөрөгдүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй гаргах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “зохицуулах байгууллагын” гэснийг “Хорооны” гэж өөрчилж, 25.2, 25.4 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.2.Биржийн гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон дотоод аудитын алба нь биржийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.”

“25.4.Бирж, биржийн арилжаанд оролцогч брокер нь биржийн хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхэд Хорооноос хяналт тавина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “хуанлийн” гэснийг хасаж, 26.3 дахь хэсгийн “маргааныг хүлээн авч хуанлийн” гэснийг “энэ зүйлийн 2-т заасан гомдлыг хүлээн авснаас хойш” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн” гэснийг “биржийн арилжаанд оролцогчийн” гэж, мөн зүйлийн 27.2 дахь хэсгийн “26.2” гэснийг “26 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖЭЭГҮЙ САНАЛ

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байна” гэсний дараа “Биржийн төрийн өмчийн оролцоо 66 хувиас доошгүй байна.” гэж нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

ГУРАВ.НАЙРУУЛГЫН САНАЛ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “ХУУЛЬ” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтын “бүхий” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.2.8, 10.2.9, 10.2.10, 10.2.11 дэх заалтын “журам” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтын “үүрэг” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтын “үйл ажиллагаа” гэснийг, долдугаар бүлгийн гарчгийн “ЗҮЙЛ” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “11.33 дугаар” гэснийг “11.34 дүгээр” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “өөрийн харилцагчийн” гэснийг “Биржийн арилжаанд оролцогчийн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 11.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “суудлын эрх бүхий” гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн ““6.18 дахь заалтын “11.30” гэсний дараа,” гэснийг “6.18 дахь заалтын “11.33,” гэсний дараа “11.34,” гэж,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох.

“1 дүгээр зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалт:

“3.1.12.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

2/6 дугаар зүйлийн 6.1.13, 6.1.14 дэх заалт:

“6.1.13.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;”

6.1.14.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, түүнд тавих шаардлагыг тогтоох.”

3/6 дугаар зүйлийн 6.2.9 дэх заалт:

“6.2.9.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааны чиглэлээр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтын дугаарыг “3.1.13” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Төрийн өмчийн хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Түвшинзаяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, мөн газрын шинжээч Б.Төрбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамьянхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Б.Төгсцэнгэл,

Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал, Т.Энхтүвшин, Д.Батлут нарын тавьсан асуултад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Түвшинзаяа нар хариулж, тайлбар хийв.

Бусад. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 12 дугаар сарын 14-ний өдөр төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар, Б.Баттөмөр, Н.Наранбаатар нар “жинхэнэ хулгайч нараа зарла”, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд “Жинхэнэ хулгайчдаа зарла”, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн “Жинхэнэ нүүрсний хулгайчдаа зарла”, ““Меланж” нүүрсний уурхайг шалга”, “Эрдэнэс таван толгойн ТУЗ-ын хамаарал бүхий “УИХ-ын гишүүд”-ыг шалга” гэсэн лоозонг ширээн дээрээ байрлуулсан байв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 9 цаг 10 минут үргэлжилж, 76 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ
2022 оны 12 дугаар сарын 15-ны
өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 07 минут
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Өглөөний амгаланг айлтгая. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

Хэлэлцэх асуудал 8 асуудал байна аа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд нэн яаралтай горимоор хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Дараа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Гуравдугаарт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Дөрөвдүгээрт, Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тавдугаарт, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Зургаадугаарт, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Долоод, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Наймд, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ ээ.

Хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гарах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Баагаагийн Баттөмөр, Одонгийн Цогтгэрэл, Нанзадын Наранбаатар, Салдангийн Одонтуяа, Шатарбалын Раднаасэд, Норовын Алтанхуяг, Цогт-Очирын Анандбазар, Наянтайн Ганибал, Цэдэвийн Сэргэлэн, Жамбын Батсуурь нараас бичиг ирүүлсэн байна.

Нийт 11 гишүүн үг хэлэх зөвшөөрөл хүссэн юм байна шүү?

Хамгийн эхэлж Пүрэвдорж гишүүн үг хэлнэ гэсэн. Пүрэвдорж гишүүн асуудал нэмэх горимын саналаар үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Өнөөдрийн МАН 7 жилийн турш эрх барьсан. Үнэмлэхүй олонх бас байсан. Бүх шатанд төр барьж байгаа, бүх хууль хяналтын байгууллагыг атгаж байгаа. Гэтэл өнөөдөр энэ ЖДҮ, концесс, Хөгжлийн банк, нүүрсний асуудал гээд энэ бүх юман дээр ингээд бид нар ерөөсөө ариухан цэвэрхэн энэ сөрөг хүчин л муухай гэж ярьдгаа хэзээ болох юм бэ. Тэгээд энэ хугацаанд АН-ынхан бүгдээрээ л гудамд байсан тэр хүмүүсийг шалгаад шилийг нь харахгүй яасан юм. Зөндөө шалгасан тэгээд юу ч гараагүй биз дээ. Тэгээд 2 жилийн туршид би энэ Гашиун сухайтын хулгай луйврын асуудлыг ярьсан. Гэмт хэргийн шинжтэй ийм бүх зүйлийг ярьж байхад яагаад наадахыгаа өнөөдрийг хүртэл ерөөсөө энэ дээр хяналт тавиагүй юм бэ?

Нүүрс бүртгэлгүй гараад байдаг юм бол тэнд нь хяналт тавиагүй Хилийн цэргийн Хилийн, тагнуулын газрын даргатай хариуцлага тооц л доо. Нүүрс нүүрсний машиныг бүртгэлгүй гаргаж байгаа тэр хилийн цэргийн даргадаа хариуцлага тооц л доо. Бүрдүүлэлт хуурамчаар хийхэд тэрэнд хяналт тавиагүй гаалийн даргадаа хариуцлага тооц. Тэгээд намайг Ганхуяг 2 удаа цагдаад өгсөн. Би цагдаад энэ гэмт хэргийн талаар тодорхой мэдээллийг бүгдийг нь өгсөн. Энэ мэдээллийн мөрөөр ажиллаагүй тэр цагдаагийн даргадаа хариуцлага тооц. Мэргэжлийн хяналтын тэр хилийн хяналтын албаны даргадаа хариуцлага тооц. Бөмбөлгийг будилуулж авлигал авдаг Халдвартын эмч нарт хариуцлага тооц. Дарга нарт нь хариуцлага тооц.

120 саяар тээвэр хийж байхад тэндээс нь тэр дүнгээс татвар аваагүй татварын байгууллагын даргадаа хариуцлага тооц. Тэгээд хамгийн эцэст нь нэг хамгийн үл бүтэх нэг хулгайч байгаа. Тэр бол Авто тээврийн үндэсний төвийн дарга.

2016 онд С зөвшөөрлийг хилээр гардаг машин болгон зүв зүгээр авдаг зүгээр цагаан цаас байсан юм. Энийг авлигын схем болгож улиралд жолооч болгон хоёр сая төгрөгийн авлигал төлдөг болгосон, энэ схемийг бий болгосон тэр Авто тээврийн үндэсний төвийн даргадаа яагаад хариуцлага тооцож шоронд хийхгүй байгаа юм бэ?

Тэгээд өнөөдөр өөрсдийнхөө гар хөлд бүгдэд нь хариуцлага тооцохгүй байж байж тэгээд тэр нэг олон нийтийн хяналтад байдаг орон нутгийн өмч дээр БНМАУ-ын хуулиар бүрэн эрх томилоод явж байхын оронд өөрсдийнхөө гар хөлд хариуцлага тооцоо гэж МАН-ын эрх баригчдаас Засгийн газраас энэ парламентаас шаардаж байна.

Г.Занданшатар: Одоо Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр асуудал нэмэх тул зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Б.Баттөмөр: Энэ сүүлийн үед Монгол Улсын цаашидын хөгжил дэвшилд хэрэгтэй энэ төрийн өмчийн хууль төрийн болон орон нутгийн өмчийн хууль, Шүгэл үлээгчийн хууль гээд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гээд шаардлагатай хуулиуд орж ирж байна аа. Энийг бол ингээд дэмжээд батлаад явах нь дээр. Энэ дээр нэмэх нь энэ хувийн ашиг сонирхлыг зохицуулах хуульдаа энэ орлого, зарлагыг нотолдог энэ юмнуудаа бас оруулж ирэх нь зүйтэй. Ерөнхий сайд мэдээлэл хийсэн байна лээ. Энэ бид нар ардчилал зах зээлийн нийгэмд шилжээд 30-аад жилийн хугацаанд бол Монгол Улсын эдийн засаг хөгжсөнгүй ээ. Эдийн засгийн өсөлт байхгүй, өгөөж байхгүй, нэг хүнд ноогдох орлогоор юу өрөөрөө дэлхийд тэргүүлдэг нийт хүн

амын 42 хувь нь ядуурчихсан, үйлдвэрлэл байхгүй хэрэглэгч улс болсон. Экспорт, импорт аль тал нь Орос, Хятадаас хамааралтай болчихсон. Мянган хүнд ноогдох халдварт өвчний тоогоороо дэлхийд тэргүүлдэг. Нийт хүн амын 60 хувь нь 0.03 хувьд ирээд нэг лист дээр бөөгнөрчихсөн. ОУВС-ийн хөтөлбөрт б удаа орсон. 7 дахь удаагаа орох магадлал өндөр. Дотооддоо бол бүрэн бараг дефолт болчихсон байгаа. Гадна талдаа дефолт болох магадлал өндөр. Түгжэрэл утаа гээд ингээд ярих юм бол бидэнд маш их асуудал бөөгнөрчихсөн байна.

Нийт баялгийн 90 хувь нь хүн амын нэг хувьд оногдож байгаа юм байна. Энэ бол энийг олон улсад олигархижсан загвар юм. Энийг бол бид бий болгосон байна. Гэтэл газар дээрх болон доорх баялгаараа Монгол Улс дэлхийд эхний 10-т ордог.

Яагаад хөгжихгүй байна гэхээр энэ хөгжихгүй байгаа шалтгааны нэг бол энэ хулгай. Сүүлийн 3 жилдээ энэ хулгайтайгаа тэмцээч ээ. Далд эдийн засагтайгаа тэмцээч ээ гээд хангалттай ярьсан. Тэгтэл байхгүй. Энэ жагсааж байж нэг баахан юм болж байж нэг хэдэн хүн барьж хориод хэрэгтэй, хэрэггүй хэдэн улсуудын нэр зарлаад ингэж л байна л даа. Бид үндсэндээ энэ 30 жилийн хугацаанд Монгол Улс энэ Монголын төр Монгол Улсаа удирдаж чадсангүй. Энэ илэрч байгаа. Хулгай бол бүүр гаарч байгаа. Энэ Таван толгой гэдэг энэ хулгайн үүр болсон газар байгаа. Удирдаж байсан хүмүүс нь бүгд шоронд ордог. Эсвэл гадаад зугтдаг. Хуулийн байгууллагаар шалгагддаг. Сая АТГ-аас 5 хүний нэр зарласан. Энэ 5 хүний нэр зарлаад их мундаг юм хийчихлээ ингээд жагсаалыг тараачихна гэж байвал горьдсоны чинь гарз шүү. Энийг өнөөдөр хэлчихье. Жинхэнэ хулгайч нар нь цаана нь үлдчихлээ энэ хэдэн жараахайгаар тоглож байна. Тэр тулууд нь цаана нь хэвтэж байна гээд энэ гадаа жагсааж байгаа улсууд чинь бүгд хэлж байна шүү дээ. Энэ 5 хүн бид

нар уулзаж ярилаа, ямар хамааралтай юм бэ гэсэн хамаарал байхгүй. Тэр Таван толгой гэдэг газрыг юу ч нийлүүлж байгаагүй, нүүрсэнд оролцоогүй, нүүрс худалдаж аваагүй, тээвэр явуулаагүй. Яах вэ бид нар бол дарга нарт долигонож гүйдэггүй, хов хор хутгаж гүйдэггүй өөрийн бодлоороо ажлаа хийгээд явдаг энэ 5 хүнийг л хаяж өгч байгаа юм байна л даа. Ингэхгүй ээ бид ч гэсэн адилхан хүн шаардлага гарвал гадаа гарч тэмцэнэ ээ. Зүгээр хонь шиг байж байгаад зүгээр алуулна гэж бол байхгүй шүү.

Хулгайч нараа зарлаа энэ ингээд биччихсэн байгаа юм. Жинхэнэ хулгайч нараа зарла, жинхэнэ хулгайч нараа зарла. Тэр гаалийн нэг байцаагч хилийн цэргийн офицер бол тэр 2600 машиныг бол гаргачихна гэж байхгүй шүү. Том том эрх мэдэл бүхий улс төрчид энд оролцсон байгаа. Энийг би хэлэх гэж байгаа юм. Би бол амьдралдаа хулгай хийж үзээгүй. Өнөөдөр би маш олон юугаар хэлсэн. Тэгэхдээ өнөөдрийн энэ чуулганы танхимд та бүгд хэлчихье. Хийж чадах ч үгүй би. Яахаараа би хулгайч болчихдог юм. Энийг би хэлье. Жинхэнэ хулгайч нар зарла гэдгийг хэлье ээ.

Энэ оффтейк гэрээ ил болсон нь сайн байна аа. Өчигдөр АН-ын бүлгээс энэ ҮАБЗ-ийн хурал Засгийн газрын хурлын шийдвэрийг ил болго гэсэн шаардлага тавьж байна. Энийг дэмжиж байна. Ил болгоё. Энэ Таван толгойн хулгай хийсэн энэ удирдах албан тушаалтнуудыг ямар шалгуураар тавьсан юм. Хэн тавьсан юм, томилгоонд нь хэн нөлөөлсөн юм. Энийгээ ил тод болго. Хулгай хийсэн хүмүүст энэ хариуцлагыг чангатгая л даа. Улсын сан хөмрөгөөр дамжиж ард түмэнд ирэх ёстой мөнгө хэдхэн хүний карманд орж байгааг шууд хулгай гэж хэлнэ. Энэ бол өнөөдөр эх орноосоо урвасантай тэнцүү хэмжээний ийм гэмт хэрэг шүү. Төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулна гэж байгаа юм.

Их мундаг засаглал сайжраад ил тод болоод ашгаа өгтөл хугацаа шаардана. Хамгийн эхний ээлжид хулгай хийдэггүй, хулгайгаас ангид, улс төрчдийн гал гар хөл болдоггүй ийм цэвэр шударга хүмүүсээ одоо Засгийн газар энэ ХК-уудаараа тавих хэрэгтэй. Тэгж байж үр дүн гарна. Ер нь бол Эрдэнэс таван толгойд энэ гарсан хулгай Засгийн газар хяналт тавьж чадаагүй.

Г.Занданшатар: Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Юуны өмнө эхлээд өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцэх төрийн өмчит ААН шинээр байгуулах уу гэсэн тогтоолын төсөлтэй холбоотойгоор би бас нэг төрөөс аж ахуйн үйл ажиллагаанд оролцохгүй байх ёстой гэсэн тогтоолын төслийг аль 4 сард Засгийн газраас санал авсан юм. Энийг бас өнөөдөр хамтатгаж хэлэлцэж өгөхийг Улсын Их Хурлын даргаас хүсэж байгаа. Төр бизнест оролцохгүй байх оролцох ААН-үүдийн дээд хэмжээг тогтоох гэдэг. Яг энэнтэй холбоотой асуудлууд үндсэндээ өрнөж байна л даа. Монгол Улсад төр, төсөв, төрийн өмчит ААН-үүд нь нийлээд одоо үндсэндээ эдийн засгийнхаа 50-иас дээш хувийг сүүлийн жилүүдэд эзэлдэг болчихлоо. Яг энийг дагасан худал хулгай яг ингээд Монгол Улсад нүүрлэхсэн.

Өнөөдөр төрийн өмчит болоод орон нутгийн өмчит 380 орчим ААН үйл ажиллагаа явуулж байна. Энэнээс хамгийн томоохон нэг ААН-ийн хөнжлийг сөхөхөд юу гарч ирж байгааг Монголчууд өнөөдөр хараад бараг улсаа сүйтгэх хэмжээнд хүрч байна. Нөхцөл байдал ямар байгааг бүгдээрээ үндсэндээ гайхаж бас балмагдаж байна. Зөвхөн Таван толгойн нүүрстэй холбоотой гэхэд тонн тутмаас нь 3 долларын авлига авдаг юм гэнэ, 5 долларын авлига авдаг юм гэнэ гэдэг яриа зүгээр л ердийн соёл болоод л тогтчихсон л байсан шүү дээ.

Улсын начин авахад найраагаар өгөөд авдаг, мөнгө өгдөг, авдаг гээд бүгдээрээ мэддэг мөртөө зөвшөөрдөг шиг тэр нүүрсний хулгайг чинь бүгдээрээ л мэддэг байсан шүү дээ. Ярьдаг байсан шүү дээ. Хэлдэг байсан шүү дээ. 30, 40 хүн гээд зарлачихлаа нү на гэж байсан. Тэр бол бараг бүгдээрээ ч байгаа. Мааш олон хүн байгаа юм энэ дээр. Тэгэхээр энэ бол үнэхээр бас асуудал энэний цаана дарагдаж байна аа. Зөвхөн 380 ААН цаана нь мааш олон ААН-үүд энд бий. Тэгээд энэ асуудлыг нэг ингээд намжаачихна гэж бас ойлгож байх шиг байна. Ард иргэдэд болоод энэ жагсааж байгаа залуучуудад яагаад гэсэн мааш олон асуудал асуулт үлдэж байна. Яагаад энэ олон нууц гэрээ нь эдийн засгийн энэ ахуйн шинжтэй энэ аж ахуйн шинжтэй гэрээнүүдийг нууцлав аа? Яагаад энэ гэрээнүүдийг ил болгоход ийм их хойрго хандаад байна аа? Яагаад цаана нь дахиад нууц гэрээ үлдсэн байж магадгүй гэхэд хариулт өгөхгүй байна аа? Яагаад яагаад гэсэн мааш олон асуултууд байна. Яагаад энэ шийдвэр гарахад оролцсон ҮАБЗ-ийн гишүүд нь одоо байгаа мөртөө тэр бичиг цаас яагаад ил гарахгүй байна аа? Яагаад гэдэг мааш олон асуултууд байгаад байна. Яагаад хамгийн гол нь 6 жил засаг барьж байгаа, төр барьж байгаа, дээд шатанд, дунд шатанд, анхан шатанд бүх шатанд хүчээ нэгтгэчихсэн эрх баригчид бүхэл бүтэн 6 жил улсынхаа эдийн засагтай тэнцүү хэмжээний хулгай байна гээд бүхэл бүтэн 6 жил засаглахдаа энийгээ яагаад илрүүлдэггүй юм бэ? Аль эсвэл ийм ур чадваргүй менежерүүд энийг чинь удирдаад байна уу? 6 жил хэрвээ нэг ААН-ийн компанийн захирал 6 жилийнхээ борлуулалтыг тэр чигээр нь тэнцүү борлуулалтыг хулгайд бараа бүтээгдэхүүнээ алдчихаад сууж байвал тэр захирлыг яах ёстой билээ? Тэр удирдлагыг яах ёстой билээ? Яагаад? Яагаад гэдэг асар олон асуулт байгаа юм.

Гэтэл энэний хариулт нь өгч байгаа хариулт нь эрх барьдаггүй намын хэдэн

гишүүн ч орчихсон байх шиг. Өөрснөө тэр сайдыг нь хийж, тамга дарж, гарын үсэг зурж байгаагүй нэг хэдэн гишүүн ч орчихсон байх шиг. Энэнд чинь ард иргэд жинхэнэ хулгайч нь ард нь сугарч үлдээж байна гэсэн ийм л ойлголттой энэ ард иргэд чинь өнөөдрийн нөхцөл байдал ийм л байна. Энэ яагаадудыг засахгүй аргалж өнгөрнө гэвэл яг энэ төр ард иргэдийн хооронд чинь үл итгэлцэл үл ойлголцол улам гүнзгий үлдэх гээд байна. Улам гүнзгий энд үлдэх гээд байна.

Энд цаасан дээр хуулийн дагуу засаглаж байгаа Төрийн ордонд засаглаж байгаа гэж байгаа. Одоо яг энэ парламент энэ бүгдийн чинь хооронд тэр л хууль ёсны гэж үзэхэд бараг эргэлзэх хэмжээнд ард иргэд чинь эргэлзэж байна. Тэгэхээр энэ олон яагаад гэдэг асуултад энэ дээд, доод, анхан шатанд хүчээ нэгтгэчихсэн эрх баригчид маш яаралтай даруй тэр жинхэнэ хулгайчдаа зарлаж хариулт өгөх ёстой л гэдэг гэдэг бол гарцаагүй шаардлага шүү. Энэ бүгдийг тал талдаа харгалзаж үзэж шийдвэрүүдээ гаргах ёстой л гэж бид бүхэнд үзэж байгаа.

Г.Занданишатар: Нанзадын Наранбаатар гишүүн асуудал нэмэх тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Н.Наранбаатар: Гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе ээ. Үг хэлэхээр санал өгсөн гэхээр зэрэг энэ АТГ-аас бас нүүрсний хулгайтай холбогдуулаад 17 хүний нэр зарласан. Энэний нэгэнд нь миний бие орсон учраас бас тодорхой байр сууриа илэрхийлж үгээ хэлье гэсэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бол бас зөндөө ярьсан байгаа. Өнөөдөр бас албан ёсоор чуулганы танхимд өөрийнхөө байр суурийг хэлье гэж ингэж үг авсан байгаа. Энэ нэр зарлагдсан хүмүүсийг ямар шалтгаанаар юунд холбогдуулж нэр зарласныг бол тэр АТГ-аас хэлээгүй байгаа. Нэр зарлагдсан зарим Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс бас АТГ очиж тайлбар мэдүүлэг аваагүйгээр яагаад нэр зарлав гэдэг асуудлыг бас асуухаар очсон

боловч яг холбогдох албан тушаалтнууд нь байхгүй байгаад бид бас тодорхой хариулт авч чадаагүй буцсан байгаа юм.

Тийм учраас өнөөдөр бид бас Хууль зүйн сайд болон АТГ-ын удирдлагуудад Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс асуулга тавья гээд ингээд бэлдчихсэн. Энэ хурлын дундуур би бид бас холбогдох улсуудад нь хүргүүлэхээр байгаа. Албан ёсоор бас асуулгынхаа хариуг авна гэж тооцож байгаа юм. Би бодохдоо яагаад намайг холбогдуулсан бэ гэхээр өмнө нь бол намайг дуудаж барьж асуугаагүй учраас үнэхээр битүү мэдэхгүй байна. Тэгээд зүгээр өөрөө бодохдоо Өмнөговь аймагтай хамаатуулж л энэ хулгайн асуудал яригдаад байгаа ордууд Өмнөговьд байгаа учраас л хамаатуулж байгаа байх. Миний бие бол 2016-2020 оны хооронд бол аймгийн Засаг дарга хийж байсан.

Тэгээд энэ үед бол бас энэ хулгайн асуудлууд нь тодорхой асуудлууд нь бол яригдаж байгаа. Тийм учраас холбогдуулж байгаа болов уу гэж бодож байгаа юм. Би энэ олон сонгогчдоо харж байгаад энд энэ чуулганд ганц зүйлийг баттай хэлье.

Энэ хулгайн асуудалд миний бие оролцоогүй ээ та бүхэн баттай итгэж болно оо. Хууль хяналтын байгууллагуудаар шалгуулна татгалзахгүй. Хууль хяналтын байгууллага жинхэнэ нь холбогдож уу үгүй юу гэдгийг бол тодорхой гаргаад ирэх байх гэдэгт бол найдаж байгаа. Би дуудсан цагт нь гаргаж өгөх ёстой бүх материалаа гаргаад тултал нь өөрийгөө шалгуулна. Нэг мөсөн шалгуулаад олон түмний энэ эргэлзээг байхгүй болгоно.

Харин энэ бидний ард нуугдаж байгаа жинхэнэ хулгайч нарыг илрүүлэхийг илрүүлж, ил тод болгож, хариуцлага тооцуулахын төлөө энэ шударга жагсагчидтай энэ ард иргэдтэйгээ бол би цаашдаа хамтарч ажиллах болно оо. Манай энэ аймагт үйл

ажиллагаа явуулдаг Эрдэнэс таван толгой ХК бол 100 хувь төрийн бүх удирдлагууд нь дээрээсээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Уул уурхайн яамнаас томилогддог. Ингээд ТУЗ нь гүйцэтгэх удирдлагаа томилдог, гүйцэтгэх удирдлага нь цаашаа гэрээ хэлцлээ хийгээд явдаг. Энэ яриад байгаа оффтейк гэрээ нууц гэрээнүүд чинь ҮАБЗ-ийн зөвлөмжөөр шийдвэр нь гарч Засгийн газраас үүрэг чиглэл өгөгддөг. Энэ бол Өмнөговь аймагтай ямар ч хамаа байхгүй. Энэ олон цаашаа байгуулагдсан туслан гүйцэтгэх гэрээ тээврийн гэрээ бүх зүйлүүд бол энэ компанийн удирдлагуудын хэмжээнд хийгддэг учраас Өмнөговь аймгийн орон нутгийн удирдлагууд бол энд оролцдоггүй ээ гэдгийг тодорхой хэлье. Мөн орон нутгийн Таван толгой ХК-ийн хувьд бол нээлттэй зах зээл дээр хувьцаа нь арилжаалагдсан 2700 гаруй хувьцаа эзэмшигчидтэй ийм ААН байгаа юм аа. Бүх үйл ажиллагаа нь бас нээлттэй явагддаг.

51 хувийн орон нутгийн өмчлөлийн эзэн нь ИТХ байдаг. ИТХ-аас ТУЗ нь томилогддог хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталгаажиг 9 ТУЗ-ийн гишүүн томилогддог. Тэндээсээ гүйцэтгэх захирал нь томилогддог. Ингээд цаашаа үйл ажиллагаагаа явуулдаг. Ийм ААН байдаг.

Тийм учраас энэ дээр бол улс аймгийн Засаг дарга үйл ажиллагаанд нь шууд оролцоод ингээд үүрэг чиглэл өгөөд ингээд компанийн дотоод ажилд бол оролцоод байдаггүй гэдгийг бол бас та бүхэнд хэлье.

Мөн дараагийн асуудал энэ боомтын асуудал. Боомт дээр үйл ажиллагаа явуулж байгаа олон байгууллагууд бол аймаг орон нутгаас хамааралгүйгээр дээд газраасаа бол томилогддог байгаа. Тийм учраас энэ нүүрсний энэ хулгайн хэрэгтэй холбоотой улсуудад энэ хүмүүс бол төрийн өмчит байгууллага энэ төрийн

хил боомт дээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийг томилдог энэ нууц гэрээ байгуулсан зөвшөөрөл өгдөг хүмүүстэй бол холбоотой гэдгийг би хатуу хэлье ээ.

Тэгээд миний хувьд шалгуулахад бэлэн байна. Хулгайчдыг олох ёстой.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Салдангийн Одонтуяа үг хэлнэ.

С.Одонтуяа: Өнөөдөр улс төрд үүссэн нөхцөл талбай дээрх эсэргүүцлийн өрнөл зэргээс үүдээд улс төрийн мэдэгдэл хийх шаардлага үүсэж байна. 2016 оноос хойш төрийн бүх эрх мэдлийг шүү. Бүх эрх мэдлийг дангаараа хэн нэгэнтэй ч хуваалцаагүй зөвхөн дангаараа эдэлж, хэнтэй ч хуваалцаагүй нам бол МАН гэдэгтэй хэн ч маргахгүй. Тэгээд 7 жил тасралтгүй эрх бариад энэ дур зоргоороо аашилсны чинь дүн өнөөдөр энэ талбай дээр ард иргэд тавьж байна шүү дээ. Та нарыг дур зоргоороо аашилаад болоод байдаг л гэж боддог. Энэний чинь дүнг өнөөдөр ард түмэн тавьж байна. Та бүгдийг хүчээ нэгтгэе гэхэд ард түмэн итгэсэн. Олон ч удаа сонголтоо харамгүй өгсөн. Тэгэхдээ та нарыг хүчээ нэгтгээд гүйцэтгэх засаглал нь Засгийн газрынхаа хууль хяналтын байгууллагуудтай хавсраад ард түмнээ тонон дээрэмдэхэд хүчээ нэгтгэнэ гэж ард иргэд бодоогүй. Та нар энэ дээр хүчээ нэгтгэсэн байна. Энэ хил дамнасан нүүрсний хулгайг энэ гүйцэтгэх засаглал хууль хяналтын байгууллагатай хавсрахгүйгээр хэн ч хэзээ ч хийж чадахгүй.

Та нар инфляцыг 16 хувьд хүргэхэд хүчээ нэгтгэсэн байна. Төрийн дээрмээр хувийн хэвилийг нухчин дарахад та нар энэ хүчээ нэгтгэсэн байна. Хүний эрхийг уландаа гишгэхэд та нар хүчээ нэгтгэсэн байна. Та нар хэдхэн залуу гараад жагсаад Засгийн газрын эсрэг яахад гав зүүчихсэн л бүгд гэрт нь хорьж байгаа шүү дээ. Та нар ийм нам гэдгээ эртхэн ухамсарлаад энэ өөрснөө нам мамаа тараадаг юм уу яадаг юм. Та нар

захаасаа энэ гишүүд чинь гомдлоо гаргаад эхэллээ. Тэгээд юм л бол сөрөг хүчин рүүгээ дайрдаг. Би энэ Их Хурлын танхимд би олон удаа дуугүй байсан. Нэг юу вэ гэхээр төмөр замын нарийн цариг тавиагүйгээс болж алдагдсан боломж хэчнээн их наяд гээд үгүй ээ МАН-ын гишүүд бүгд ярих юм. Ялангуяа манай Б.Энхбаяр гишүүн ярьдаг, Нямбаатар гишүүн ярьдаг, бүгд л ярьдаг. Би энэ нарийн царигийг МАН-ын 65 гишүүн хуруугаараа нарийн царигийг устгасан талаар та нарт хэлж өгье. 2014 онд Ардчилсан нам Улсын Их Хуралд олонх байхдаа энэ нарийн царигийг Таван толгой Гашиун сүхэйт, Хөөт бичигт чиглэлийн төмөр замыг нарийн царигаар тавих ийм тогтоол баталсан юм. Гэтэл 2020 оны 5 дугаар сард МАН 65 гишүүнтэй байхдаа энэ тогтоолыг хүчингүй болгосон юм. Эдийн засгийн байнгын хорооны дарга нь миний өөдөөс хараад сууж л байна. Мэдээж энийг бүлгээрээ ярьсан байлгүй. Бүлгийн дарга нь миний өөдөөс хараад сууж л байна тухайн үеийн.

Тэгэхээр та нар ингэж бүх юмаа сөрөг хүчин рүү чихдэхээ боль. Энэ нарийн царигийг устгах ажлыг өнгөрсөн парламентын 65 гишүүд тогтоол гаргаж энийг устгасан шүү. Одоо дахиж энэ алдагдсан боломж гэж битгий ингэж ард түмний тархийг угаа гэдгийг хэлмээр байна.

Нөгөөтээгүүр энэ сүүлийн үед энэ хүний эрхийг ерөөсөө уландаа гишгэдэг боллоо. МАН бол энэ хүний эрхийг уландаа гишгэж үй олноор нь хэлмэгдүүлэхдээ гаршсан нам шүү дээ. Миний өмнө би Цагаатгалын комиссын дарга. Өнөөдөр болтол бид нар энэ цагаатгаад барахгүй байгаа. Нэг гараараа болохоор нэг амаараа болохоор шүүх хяналтын байгууллага эцэслэн шийдвэр гаргаагүй үед хүнийг гэм буруутайд тооцож үл болно оо гэж хэлчхээд. Нөгөө гараараа Засгийн газрын гишүүд нь гараад нүүрсчид гээд ингээд зарлаж байгаа. Энэ дотор яах вэ гэм

буруутай хүмүүс байж болно. Тэрийг шүүх үгүй ээ ямар ч гэм буруугүй хүмүүс ч гэсэн байж л байна шүү дээ. Энэ чинь шинэ цагийн хэлмэгдүүлэлт шүү. Мааш аюултай шүү. Гэндэндэмбийн хэрэг, Лхүмбийн хэрэг, Японы тагнуулын хэрэг гэдэг чинь ерөөсөө ингэж нийт давллагаалж байгаа л хүмүүсийг хэлмэгдүүлж байсан.

Тэгэхээр энэ хэлмэгдүүлэлтээ зогсоо. Та нар ингэж хүнийг зарласнаараа Үндсэн хууль болон хүний эрхийн ноцтой зөрчил гаргаж байгаа гэдгийг бол дахин хэлмээр байна аа. Нөгөөтээгүүр энэ БЭТ томилоод л хувийн хэвшилүүдийг дарамталж байна. Энэ БЭТийг чинь 1991 оны БНМАУ-ын хууль тогтоомжоор энийг томилж та нар явуулаад байгаа юм. Гэтэл 1992 онд хувийн өмчтэй хүний эрхийг дээдэлсэн анхны ардчилсан Үндсэн хууль гарсан. Энэ Үндсэн хуулиар шийдээгүй ийм БЭТ-ийг өнөөдөр та нар хувийн хэвшил рүү илгээж шууд төр өмчдөө авлаа гэж зарлаж байна.

Энэ чинь бүх Гадаадын хөрөнгө оруулагчдыг та нар үргээж байна гэсэн үг. Маргааш та нар яах юм Оюутолгой дээр БЭТ томилох юм уу? Ингэж Монголын хөрөнгийн бирж дээр нэг номерын хувьцааны ноогдол ашиг тараадаг компани байхгүй. Энэ компанийг та нар нугасалж өөрсдөө хувааж идэх гэж байна. Төрд авснаараа та нар өнөөдөр юу гийгүүлсэн юм.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн асуудал нэмэх тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн гэж байна.

Ш.Раднаасэд: Энэ өнгөрсөн 2 хоног юу ч болоод өнгөрчхөв мэдэхгүй. Зүв зүгээр сууж байгаад жинхэнэ хулгайчдын урд талд амны хаалт болчихлоо. Тэгээд харин энэ нүүрсний юмыг би бүр сайн судалж үзлээ. Би энэ хууль хяналтынханд итгээд яваад байсан юм. Одоо энийг энэ түр хороо нэлээн нухацтай үзмээр байна

аа. Энэ өнгөрсөн хугацаанд нь 2010 оноос хойш 22 жилийн хугацаанд 86 сая буюу 12.8 их наяд төгрөгийн нүүрс зарсан байна. Зөвхөн 2018-2022 онд 7.5 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг зөвхөн Эрдэнэс толгой гэж компани худалдаж авсан байна. Нөгөө 12 их наядын чинь 7.5-ыг нь ингээд энэ компани чинь өөрөө үрчихсэн байна шүү дээ тэгээд энэ дотор нь энийг шалгаж ядаад байх юу байна аа? 576 гэрээгээр л энэ 7.5 их наядыг чинь ийш тийш нь цацаад хаячихсан байна. 396 гэрээгээр нүүрсээ зарсан юм байна. Давхардсан доогоор хэдэн ч компани байгаа юм? Тэгээд энийг нь үзэхэд одоо энэ дотор бол инээдтэй юм байна. Энэ АТГ-ын веб сайт дээр байгаа мэдээлэл шүү. Энэ 7.5 их наядтай энэ гэрээг та нар үзээрэй. 111 сая төгрөгөөр 40 тонны контейнер авдаг 880 тэрбум төгрөгөөр авто самосвал авдаг заримыг нь би бол зах зээлийн үнийг нь мэдэхгүй. Гэхдээ энэ дотор байж боломгүй юмнууд байна. Гучин сая төгрөгөөр подволк авах, дөчин сая төгрөгөөр юу гэдэг юм бээлий авна. 1.3 тэрбум төгрөгөөр эрүүл мэндийн үзлэг хийнэ. Ингэж мөнгө идэж байна шүү дээ. Та нар өнөөдөр оффтейк гэрээнээс чинь гадна дахиад энд бас дахиад булай юм энэ дотор байна. Энэ боомтын хяналтын хороог бүр өшөө өргөтгөх хэрэгтэй байна. Бүр 2 хуваа. Энэ Таван толгойтой холбоотой энэ хулгай хийсэн энэ юмнуудыг. Энэ дотор дандаа улс төрчдийн компани байгаа. Энийг зүгээр ард түмэнд цацаад энэ дотор хэн хэн ямар хуулийн этгээд үүсгэн байгуулагч байна гэхэд энэ ихэнх нь улс төрчдийн компани байгаа юм. Тэд нарын нөлөөлөл байгаа юм.

Хоёр хувааж энийг үзэхгүй бол болохгүй юм байна аа. Энэ оффтейктэй холбоотой энэ жинхэнэ хулгайчдаа яагаад зарлахгүй байгаа юм? Тэр Голомтын Баясгалан энэ Женкогоо барь л даа. Үнэхээр хулгайтай тэмцэх улс төрийн хүсэл зориг байгаа юм бол Ерөнхий сайд аа. Энэ хүмүүсээ барьж хориоч ээ. Хэдэн зуун тэрбумаар нь хэдэн

тэрбум доллароор нь ашиг хийгээд эд нар чинь явдаг. Энэ Таван толгой гэж компани ерөөсөө анх үүссэнээсээ хойш л энэ хэл амыг дагуулж байна. Энийг одоо цэгцэлж, энэ хамаг юмыг нь хаахгүй бол болохгүй. Анх тэр Энэбиш гэж хүн байгуулагдаж дарга болоод л 250 сая Чалкогийн гэрээ гээд хэрэгт холбогдоод 2014 онд хил даваад зугтсан. Одоо байхгүй.

Дараа нь Батсуурь гэж очсон бас. Одоо энэ Алтанхуяг Ерөнхий сайдын үед. Бас хэрэгт холбогдоод ял аваад явсан. Одоо энэ Ариунболд, Ганхуяг бүгд хэрэгт холбогдоод шалгагдаж байна. Энийг томилдог ТУЗ, энэ томилж байгаа энэ ТУЗ-ийн дарга нар ЗГХЭГ тухайн үедээ юу байсан юм Төрийн өмчийн хороо энэ хүмүүс чинь л орж нөлөөлж энэ дотор чинь хамаг юмаа хийж байгаа шүү дээ. Энэ хулгай зэлгийгээ цэгцлэхгүй юм уу?

Энэ зүгээр нэг өнөөдөр нүүрсний хэрэг биш. Яг үнэндээ бол ард түмэн энэ гадаа нүүрсний чинь утааг нь идэж байна. Энэ хэдэн хулгайч нар хамаг утаа нүүрснийх нь мөнгийг нь идэж байгаа байхгүй юу. Тэгээд ямар учиртай юм.

Өнөөдөр Уул уурхайн сайд хийж байгаагүй ЗГХЭГ-ын дарга хийж байгаагүй хүн ямар нэгэн байдлаар энэ ТУЗ-д холбогдож байгаагүй. Энэ оффтейк гэрээтэй холбоотой Засгийн газрын гишүүн хийж байгаагүй 4, 5 хүнийг гаргаж энэ нийгэмд яллуулах гэж гаргаж шийддэг нь. Эс үгүй бол энэ Тогтохсүрэн даргын хэлээд байсан тэр Ардын намын бүлэгт нүүрсний хэрэгт холбоотой хүн байхгүй ээ гэдгээ нотлохын тулд бид тавыг аваачиж түлхэж байгаа юм уу? Энэ хулгайгаа илэн далангүй яриад цэгцэлье л дээ. Тэр 21-нийг хүлээлгүйгээр энэ хэлэлцүүлгүүдийг хийе л дээ. Энэ хууль хяналтын байгууллагууддаа хамаг юмаа ил тод энэ гудамжинд ард түмэн чинь 7, 8 хоног жагсаж байна шүү дээ. Энэ цэвдэг гэхэд арай цэвдэг байна шүү дээ. Энэ гадаа 30 градусын хүйтнээс илүү

сэвдэг байна бид нар. Надад бол тийм бодол байна.

Өнөө маргаашгүй энэ хэлэлцүүлгүүдийг хийгээд Ганболд дарга энэ дээр санаачилгатай явах хэрэгтэй. Энэ гишүүд шахаад шаардлагатай гэвэл дахиад энэ зөвхөн Таван толгой дээр энэ худалдан авах ажиллагаа дээр дахиад сонсгол хий л дээ. Энэ хулгайч нарыг хэдий болтол өөгшүүлэх юм бэ? Одоо энэ чинь ингээд тараана нь хараарай. Эрүүгийн хууль батлагдсан ингэсэн. Нөгөө хүмүүсийг чинь зарласан, ингэсэн. Ингээд удахгүй араас нь энэ тавыг түдгэлзүүлнэ гэж оруулж ирээд ингээд л явна шүү дээ. Худлаа биш шүү дээ тийм яриа явагдаж л байгаа.

Ичихгүй бол энэ хулгайч нар юмаа ярихгүй бол би энийг нь гаргаж зарлана шүү. АТГ ямар ч үндэслэлгүй мэдээлэл байгаа юм.

Г.Занданишатар: Одоо Норовын Алтанхуяг гишүүн асуудал нэмэх горимын саналтай тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн.

Н.Алтанхуяг: Өглөөний амгаланг айлтгая. Раднаасэд гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Гадаа -30 градус энэ танхимын хулгайч нарт бол хасах 40 градус л байгаа. Муухай цэвдэг байхгүй юу. Тэгэхдээ би Ардын намын бүлэг гэдэг юм уу Ардын намынхныг бүгдийг нь тэгж боддоггүй л дээ. Би олон жил энд явж байна. Нэг тогоонд танай хуучин МАНАН гэж хулгайч нар, манайд бас МАНАН гэж хулгайч нар байсан байхгүй юу. Одоо энэ хулгайч нар чинь дахиад л танайд олонх нь үлдчихсэн. Тэд нар чинь ингээд л хажуудаа сууж байгаа амьтныг яг Раднаасэд гишүүний хэлж байгаа шиг хажуугаар хутга шаагаад л гаргаад л 2 намын хэрүүл болгож дуусгаад л, улс төрийн тэмцэл болгож дуусгаад л. Дундаас нь энэ олон 10 жилд дандаа хулгайч нар хожиж ирсэн. Тийм учраас энэ ард түмэн бол бас итгэл алдарч байна шүү дээ. Одоо энэ олон хоног

жагсаад бас нэг гайгүй болох юм байх. Ёстой жинхэнэ хулгайчаа зарлах юм байх. Ордоор нь гадаадад зарчихсан хулгайчаа олуулаа очоод бүлэглээд идчихсэн хулгайч нараа зарлах юм байх гэсэн чинь би энэ 5-ыг бол мэдэхгүй байна л даа. Би өмнө нь өөрөө бас зарлуулагдсан л нөхөр шүү дээ.

Та нар ингэж болохгүй ээ шударга бай л даа. Өнөөдөр ингээд энэ хэдэн хүнээр туг тахиад тэгээд дахиад нөгөө жинхэнэ хулгайч нараа хамгаалаад явж ерөөсөө болохгүй шүү болохгүй шүү.

Дахиад нэг юм хэлье. Одоо байна шүү дээ мэдээлэлгүй байж бид нар ерөөсөө ярьж байна. Би нэг л юм эртээрийн өнгөрсөн 7 хоногт би хэлсэн шүү дээ. Оффтейк гэрээ гээд байгаа юмнуудаа ил болгочхооч. Яахаараа энэ ААН-үүдийн хооронд байгуулдаг гэрээг нууц болгодог юм бэ? Тэгсэн Ерөнхий сайд ороод ирсэн байна ашгүй. Хэдэн гэрээ нийт ил болгосон байна. Үлдсэнийгээ ил болгооч. Тэр Ерөнхийлөгч Хүрэлсүх хэлсэн шүү дээ. Ард түмнээр таавар таалгаад ил тод биш учраас таавар таагаад байна. Их Хурлын гишүүд ч таавар тааж байна шүү дээ. Би яагаад юм ярьж чадахгүй байгаа вэ гэхээр мэдээлэл алга байна. Хулгай дээрэм хийчхээд нуучихсан гэрээг чинь ил гаргахгүй юмыг чинь бид нар яаж дүгнэлт хийх юм. Тэгээд энэ Хөгжлийн банк энэ нүүрсний хулгайтай энэ тэмцэнэ гээд ажлын хэсэг байгуулсан юм. Тэд нарыгаа ажиллуулаач ажиллахгүй байна шүү дээ. Энхбаяр гишүүн харин 1, 2, 3 сард оройтож байгаа юм. Одоо нөгөө нэг гэрчүүдийг дуудна зуун жаран хэдэн хүн. Үгүй ээ хэдүүлээ ингэж ажиллая л даа. Жаахан шударга бай л даа. Тэр оролцсон гэж үзэж байгаа бүх хүнээ дуудаач дээ. Хуулийн байгууллага дээр би сая хараад нэг юм ойлгосон.

Тэд нар хүч хүрэхгүй байна. 2-т энэний учрыг олохгүй байна. Энэ их хэцүү ажил байна.

Дээр нь та нар ингээд олны өмнө аваачаад хэн хэнийг дүүжлэх вэ? Энэ өрсөлдөгч нараас тэр тэрийг ингээд эртхэн шиг дүүжлээд олон түмэнд ингээд харуулчихъя. Одоо та нар яасан юм гэхээр цөөнхөөсөө дүүжлэхээс гадна өөрсдийнхөө хэсгээс нэг хэдийг нь гарзад нь гаргаж эхэлсэн. Үгүй ээ энэ хэд их олон юм яриад байдаг. Тэр тэр тэрийг дүүжил, ингэж болохгүй ээ, та нар.

Би дахиад нэг юм хэлье. Нүүрсний хулгай яах вэ гээд яригдаад хэдүүлээ яриад нэг шийдээд нэг жаахан шударга ажиллачихвал энэ бол болно оо. Зөвхөн Таван толгой чинь л өөрөө аймаар шүү дээ. Тэгээд Ардчилсан нам руу бас бүгдийг нь битгий чих л дээ. Манай энэ нэг бүлгийн 2, 3 эмэгтэйчүүдийг л олны өмнө дүүжлээд л, дүүжлээд л, дүүжлээд л. Цаагуур нь хулгайч нар идээд л, идээд л, уугаад л, уугаад л. Хагартлаа баяжаад л. Тэр мөнгө нь хамгийн аюултай нь буцаж улс төрд орж ирж байгаа шүү дээ. Энэ танай Ардын намд ямар улс төрд явж байгаа олон жил явж байгаа нөхдүүдэд бол дандаа ийм мөнгө байгаа шүү. Тэгээд одоо шинэ гишүүдийгээ дээр түүнд гаргана гэдэг гарзад гаргаж байгаа юм.

Би 2 дахь хулгайны тухай ярья аа. Би Ардын намын бүлгээс нэг юм хүсэх гэж байна, намын даргаас нь. Одоо зэсийн хулгай зогсоох тухай би энэ 343333 гээд нэг тогтоолын төсөл оруулснаас хойш би бас алуулж байна. Бараг намайг тэр Хөгжлийн банканд хамаатуулдаг чинь энэ зэсийн хулгайтай холбоотой шүү. Ганицхан Монголын ганицхан гэр бүл жилдээ 100 сая доллар идэж байна аа. Энийг Эрдэнэтийн ордын ард иргэд Эрдэнэт хотын бүтээн байгуулалтад өгье гэхээр май гэж Ардын намын бүлэг шийдвэр гаргасан байна лээ.

Харин эртээр та нар нэг дэмжиж байгаад энэ дээр хэлэлцье гэхихсэн байхгүй юу. Одоо тэгээд Байнгын хороон дээр очсон чинь юу болж байна вэ гэхлээр нэг ийм тоглоомын ажлын хэсэг

байгуулаад нэг зарлаад өө бид нар хуралдчихлаа гээд хуралддаг байхгүй юу. Тэгэхээр нь би юу гэж хэлж байна вэ гэхээр Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд намын даргаа танд бас Монголын хувь заяа таны гарт байгаа шүү. Надаас ялгаатай нь та Авлигатай тэмцэх даргыг тавьдаг болсон шүү. Та бас хүчийг зангидвал энэ олон хүн байна шүү. Мэдээж үе үеийн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гээд зовлонтой юм яривал би зөндөө юм ярина больчихъя.

Г.Занданшатар: Цогт-Очирын Анандбазар гишүүн үг хэлнэ.

Ц.Анандбазар: Баярлалаа. Бид тав нэрд дурдагдсан бараг сайн гэж би бодож байгаа. Яагаад гэвэл энэ хэрүүл их удаан үргэлжилнэ ээ. Ер нь капиталын сонгодог онол байдаг. Харсан хүн нь хулгайлдаг гэж. Хамгийн гол асуудал цаашид яах вэ гэдэгт байна. Бид бол нэр цэвэрлэгдээд гарна. Хулгай хийгээгүй хүн айх юм алга. Жинхэнэ хулгайч нарын нэрийг ард түмэн мэдэж байгаа юм байна лээ. Хүн болгон мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр цаашид энэ Таван толгойг яах юм ард түмний өмч болгож чадах юм уу гэдэг асуудал онцгой чухал байгаа юм. Үе үеийн Засгийн газар, Их Хурал дээр хэрүүл хийгээд л үлдсэн. Энэ Таван толгой бол гайхамшигтай орд шүү дээ. Та бүхэн мэдэж байгаа 30 долларын өртгөөр нүүрс үйлдвэрлээд газар дээрээ 100 доллароор зардаг ийм мөнгө хэвлэдэг машин. Монголбанк бол Монгол төгрөг хэвлээд инфляц үүсгэдэг ийм машин. Таван толгой бол гадаад валют хэвлэж инфляцыг дардаг ийм бэлэн машин байгаа юм аа. Ганицхан хамгийн гол аюултай юм нь юу байна гэхээр энийг харж байгаа Засгийн газар, албан тушаалтнууд бэлэн сул мөнгө байгаа учраас үеийн үед идэж иржээ. Одоо ер нь би бодож байгаа. Их Хурлын гишүүн болсон утга учраа ойлгож байна гэж бодож байгаа юм.

Энийг Монголын ард түмэнд 1990 онд малыг үнэгүй хувьчилсан шиг, 1996

онд байрыг үнэгүй хувьчилж Монголын ард түмэн анхны өмчтэй болсон шиг бүх хувьцааг ард түмэнд шилжүүлэх хэрэгтэй. Өнөөдөр хулгай хийснийхээ төлөө Их Хурлын 76 уучлалт гуйгаад Эрдэнэс Тавантолгойг ард түмний өмч болгож өгөх ёстой Ерөнхий сайд аа. Энийг ямар ч хүн хараад хулгай хийхгүй сууж чадахгүй. Цаашидаа ч ийм хулгай үргэлжилнэ гэж бодож байна. Зуун хувь ард түмний өмч болох юм бол энэ инфляц энэ ядарсан ард түмэн үнэхээр амьдарч чадна аа. Энэ шиг ор дэлхийд байхгүй шүү дээ. Дэргэдээ 2 төмөр замтай, дэд бүтэцтэй, машин техниктэй зүгээр л юань хэвлээд гадаад валют оруулж ирээд сууж байгаа юмыг яаж идэх аргаа олж ядсан хэдэн хүн нийлж байгаад хуйвалдаж идчихээд баригдах болохоороо гэмгүй хүмүүсийг зарладаг. Ийм л юм болж хувирч байна. Хэчнээн хүнийг ингэж хэлмэгдүүлж хэчнээн дарга нар солигдож шоронд явах вэ. Энийг зогсоох цаг болсон.

Ийм хуулийг би өргөн барина аа. Яагаад гэвэл энэ өмч Монголын ард түмний өмч түүнээс хэдэн дарга нар хулгайлаад сууж байдаг ийм өмч биш.

Ингэж чадах юм бол Монголын ард түмэн насан туршдаа сайн сайхан амьдрах боломжтой болно. Энэ хулгай үүрд таслагдана. Ганц хүн харах юм бол ямар ч бурхан тавиад тэр хулгайлаад байна шүү дээ. Энэ чинь МАН-даа ч байгаа юм биш. Энэ том хулгайг АН-ынхан улс төржүүлж өнгөрөөх юм бол бас л алдаа болно. Танай нам гараад дахиад хулгайлна шүү дээ. Энэ хүндээ байгаа юм биш ээ тогтолцоондоо байгаа. Тогтолцоог яаж өөрчлөх юм гэхээр 30 хувийг зарна гэж уул уурхай хийж байна. Дахиад хулгай явах гэж байна шүү дээ.

Яаж ийм юм хийж болох юм бэ? Цаад талд нь Хятадын нөхдүүд нэг Монголтой орж ирээд л хулгайлна. Ийм юм өгч болохгүй ээ. Харин том боломж гарсан дээр би хэлсэн. Хулгайчдыг энэ

удаа олоод, жинхэнээс нь зарлаад ард түмэндээ зуун хувь хувьцааг нь өгчихье. Ингэх юм бол Монголын ард түмэн цалин хөлс амьдрал ядуу байна гэж үглээд байхаа болино оо. 20 хувь нь хувьцаа эзэмшдэг. 1072 хувьцааны зарим нь зарчихсан зарим нь идэвхжээгүй байгаа. Он гарангуут энэ инфляцын зөрөөг арилгаж 2012 онд Сү.Батболдын Засгийн газрын үед хувьцаанд мөнгө олгосон шиг мөнгө олгох хэрэгтэй байна. Эзэн нь өөрөө харах юм бол хулгай гарахгүй шүү дээ. Одоо ингээд л хараад байхад нэг л том ухаантай хүмүүс яриад байдаг. Гаргалгаа ерөөсөө алга байна. Хэн нэгнийг барьж хийснээр энэ хулгай дуусахгүй ээ. Баригдахгүй байх гэж бодоод л хулгайлчихдаг юм байна лээ. Тэгээд хулгайлах нь баригдах болоод ирэхээр хэн нэгэн рүү түлхэж өөрсдийгөө аргалдаг. Үгүй ээ нэр зарла гээд байхаар тэр хууль хүчний байгууллага чинь нэр зарлахаас аргагүй шүү дээ. Цаасан дээр нэг юм байхаар нь толгойгоо авч үлдэхийн тулд зарласан хэрэг. Энэ чинь хууль зөрчиж байгаа асуудал.

Цаашидаа хуулийг мөрддөг нэг мөр болгох ганцхан арга бол нийт хувьцааг ард түмэнд өгөх ийм санаачилгыг Их Хурлын гишүүдээ гаргая. Энийг эсэргүүцвэл ард түмэн маш муухай харагдана шүү та бүхэн. Одоо энэ хулгайгаа зогсоох хэрэгтэй байна. Энэ хувьцааг гаргаад өгчих юм бол ямар ч дарга очоод ард түмнээс хулгайлж чадахаа болино. Алийн болгон хулгай ярьж суух юм. Ямар ч өртөггүй гучхан доллароор үйлдвэрлэж байна шүү дээ. Зуун доллароор зарж байна. Үгүй ээ тэгээд ямар ухаан зараад байгаа юм бэ. Ийм өндөр ашигтай компанийг хулгай хийчихлээ хаа байна. Хулгайч нь гээд л сууж байдаг ийм төр Засгийн газар гэж байж болох уу Ерөнхий сайд аа. Та маш сайхан санаачилга гаргасан. Энэ санаачилгаа ард түмэнд хүртээмжтэй болгох хэрэгтэй байна. Монголын ард түмэн юу хүсэж байна энэ ядуу амьдралаас салмаар байна гэж байна.

Хоёрхон сая төгрөгийн төлөө Солонгос руу бүх залуучууд дүрвэж байна шүү дээ.

Тэгээд одоо энэ жагсагчид юу болж байна гэхээр Монгол төрийн нэр хүнд рүү халдаж байна.

Г.Занданшатар: *Наянтайн Ганибал гишүүн.*

Н.Ганибал: *Нүүрсний хулгайн асуудал гээд Монголын ард түмэн 12 хоног энэ гадаа хүйтэнд залуучууд жагсаж байна. Өнөөдөр бид нар энийгээ ингээд эргэж харах нэг ийм зайлшгүй шаардлага харагдаж байна аа. Өнөөдөр Засгийн газар шүгэл үлээсэн л гээд байдаг. Яг 9 сард ОУВС үүнийг хамгийн түрүүнд хэлсэн шүү дээ. Та нар валютын нөөцөө бүрдүүлэх ямар ч боломжгүй болчихлоо. Экспортод нь гарсан тэр валют чинь буцаж орж ирэхгүй болж байна аа. Тэр нууц гэрээнүүд оффтейк гэрээнүүд чинь тэрбээр мөнгийг чинь сороод цаана аваад үлдэж байна гээд.*

Сүүлийн үед бид бүхэн 6 жил ингээд харж л байна л даа. Хувийн өмчүүдийг бүгдийг нь булааж явж байгаа. Тэгээд гаргаж ирж байгаа тэр үндэслэл нь юу вэ гэхээрээ Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнө буюу 1991 оны БНМАУ-ын тэр тогтоолоор бүрэн эрхт төлөөлөгч томилж байгаад тэр хувийн өмчүүд дээр томилдог ийм асуудал гарсан харагдаад байгаа юм.

Өнөөдөр бид нар чинь Монголын хүний эрх, эрх чөлөөтэй байдал, эд хөрөнгө өмчлөх гээд энэ ардчилсан чөлөөт нийгмийн үнэт зүйлийнхээ эсрэг бид нар Засгийн газар маань шийдвэр гаргаад явдаг ийм байдлаар асуудлыг шийддэг болчихлоо. Үүний нэг тод жишээ нь өнөөдөр бас дараагийн хувийн өмчийг булааж авах гэж байгаа энэ асуудал бидний нүдэн дээр ил болчихлоо. Нүүрсний хулгайч нарыг ил болгоод бүх юмыг цэвэрлээд сайхан болгоно оо гээд нийгмийг одоо ингээд бужигнуулаад эхэлсэн. Сэтгэлийн хөөрлийг улам дээд

цэгт нь дэврээсэн. Харамсалтай нь гарах гэж байгаа үр дүнг нь харсан чинь Өмнөговь аймагт байгаа тэр орон нутгийн Таван толгой гэдэг компанийг булааж авах гэж байгаа л үйлдэл байна шүү дээ. Одоо хар л даа. Энэ олон үймээний ард яг ийм л асуудал харагдана. Харагдах гээд байна. Одоо хулгайч гээд зарлаад ер нь хулгайч гэж зарлах эрх бидэнд байхгүй шүү дээ. Монголын ард түмэн ч байхгүй, төрийн байгууллага ч байхгүй Их Хуралд ч байхгүй. Засгийн газарт ч байхгүй. Гэм буруугүй хүмүүсийг өнөөдөр хулгайч гэж олны өмнө зарлаж байгаа нь бид нар Үндсэн хуулиа ноцтойгоор зөрчиж байгаа үйлдэл. Энэндээ бид нар дуугүй байж байна гэдэг бол Монголын парламент үнэхээр хүчгүй болсны нэг шинж ээ. Энийгээ бид нар хамгаалах гэж бид нар өнөөдөр ард түмний төлөөлөл болж Монголын ард түмнээс сонгогдсон байх гэж ойлгож байгаа юм.

Одоо Өмнөговийнхныг яах ёстой юм? Өнөөдрийн зарласан Их Хурлын 7 гишүүнийх нь 2 нь Өмнөговийн 2 гишүүн. Хулгайч гээд зарласан хүмүүсийнхээ дунд нь тэр аймгийн Засаг дарга энэ Иргэдийн хурлын даргын тэр Иргэдийн хурлын төлөөлөгчийг нь ингээд бүгдийг нь оруулчихсан. Тэр хүмүүсийг гэм буруугүй байхад нь хулгайч Өмнөговийнхон бүгдээрээ хулгайч гэсэн үг байна шүү дээ.

Цаашлаад энэ чинь юу гэсэн үг вэ гэхээрээ Өмнөговийн ард түмнийг нутгаас нь хөөж гаргаж байгаад газар нутгийг нь ухах гээд байгаа юм уу? Ийм юм руу та бүгд ингээд явж байгаа гэдгээ бас ухаарах цаг өнөөдөр бид нарт бас зайлшгүй шаардлагатай байна аа. Эрдэнэс Таван толгой жилдээ нэг олж байгаа ашиг нь 2019 онд нэг их наяд хэд гэлээ? Тэгээд тэндээ хувьцаанаасаа, 1072 хувьцаанаас ард түмэндээ 90 төгрөг өглөө гээд улс төрийн шоу болгоод та бүхэн сонгогдсон. Харин орон нутгийн Таван толгой бол жилдээ нэг хувьцаа 257 төгрөг өгдөг юм байна. Анх ганц удаа өгсөн тэр хувьцаанаас чинь 2.8 дахин

илүү хувьцааг тэр 1900 хувьцаа эзэмшигч нартаа, орон нутгийн иргэддээ олгодог түүгээрээ бүтээн байгуулалтаа хийдэг нээлттэй ХК л байна шүү дээ. 2 компанийн хооронд өглөг авлагын асуудлыг хулгай гэж зарлаж байгаад өнөөдөр тэр орон нутгийн 5 толгойг төрийн өмчид авах гэж байгаа ийм процесс явагдаж байна аа. Энийгээ бид нар бас мэдэх ёстой юм байна аа.

Дараа нь бид нар бас мартаж байх аа. Тэгэхээр энэ асуудлууд дээр хувийн өмч хүний эрх чөлөө 2-ыг хамгаалах үүрэгтэй Монголын Ардчилсан парламент ажлаа бас гүйцэд хиймээр байна гэж та бүхэндээ хэлье ээ.

Г.Занданшатар: Цэдэвийн Сэргэлэн гишүүн чуулганы хуралдаанд асуудал нэмэх тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Ардчилсан Монгол Улс өнөөдөр хүний эрх чөлөө эрсдэлд орох ийм аюулд нүүрлэж байна шүү гэдгийг би эрхэм гишүүддээ сануулъя гэж бодлоо. МАН манай нам хүний эрхийг дээдлэх талаар манлайлан ажиллаж анхаарч ажиллана гэж саяхан илэрхийлж олон түмний нүдийг итгэлийн нүдийг нь нээсэн. Энэ нүд нээгдэж эхэлсэн. Олон түмний нүд итгэж. Гэтэл одоо энэ нүд эргээд анихад хүрч байна шүү гэдгийг би бүлгийн гишүүддээ хандаж хэлэхийг хүссэн юм аа. Тиймээс МАН-ын бүлгийн гишүүддээ хандаж уриалахад намаа өөрөөр хэлбэл намаа манай намын бүлэгт байгаа энэ хулгай, луйвар, авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон этгээдүүдийг цэвэрлэх хэрэгтэй, шалгах хэрэгтэй гэдгийг би бас уриалж байгаа юм. Намаа цэвэрлэхгүйгээр явахгүй ээ. Энэ нүүрсний хулгайн хэрэгт нэр зарлагдсан хэдэн Улсын Их Хурлын гишүүдийн ард нуугдаж уснаас хуурай гарахыг эрмэлзэх ард түмнийг төөрөгдүүлэх шударга ёсны шаардлага тавьсан жагсаж буй иргэдийн анхаарлыг нь өөрсдөөсөө холдуулах гэсэн асар их мөнгөтэй

этгээдүүдийн зорилго үйл ажиллагаа харагдаад байна шүү. Ард түмэн бол биднээс хоёрхон зүйлийг хүсэж байна гэж би ойлгож байгаа юм.

Нэгдүгээрт шударга ёсыг, ерөөсөө л шударга ёсыг. Дээд шатандаа шударга ёс.

Хоёрдугаарт амьдралын түвшний ялгааг арилгаж өгөөч ээ амьдралын түвшнийг сайжруулж өгөөч ээ гэдгийг л төр засгаасаа хүсээд байна уу гэж би харж байгаа. Нийгмийн баялгаас бүх ард түмэн бүгдээрээ маш бодитойгоор амьдралд нь хэрэг болохоор шууд нөлөөлөх хэмжээний хувь адил тэгш хүртдэг болгож өгөхийг л хүсэж байгаа гэж би бол харж байна. 1072 хувьцаа гэж чихэр үмхүүлэхээ болино гэж харж байгаа. Нүүрсний хулгайтай тэмцэх Засгийн газрын бодлого үйл ажиллагааг миний бие хувьдаа анхнаас нь л дэмжиж ирсэн. Цаашид дэмжинэ. Энэ маш зүйтэй.

Харин энэ тэмцлийн үр дүнг эцэст нь хүргэж чадах хэрэгтэй. Ингэснээр нийгмийн баялагтаа ард түмэн жинхэнэ эзэн болох үүд хаалга бүрэн нээгдэнэ гэж харж байгаа шүү. Нүүрсний хулгайд нэр зарлагдсан гишүүний хувьд нэг зүйлийг хэлье гэж би бодлоо. Энэ нүүрсний хулгайтай холбоотой гэдэг юм уу нүүрстэй холбоотой гэдэг юм уу юу гэдэг юм, борлуулалт, олборлолт, тээвэрлэлт, гэрээ хэлэлцээр, экспорт гээд тэгээд бусад тэр худалдан авалт юу л байдаг юм энэ бүх асуудал миний бие ямар нэгэн байдлаар ямар ч холбоогүй гэдгээ юу ч гэсэн энэ Улсын Их Хурлын индэр дээрээс хариуцлагатайгаар мэдэгдье. Хуулийн байгууллага бол шалгах ёстой юмаа шалгах ёстой. Энэнд нь бид туслах ёстой. Би ч тусална, мэддэг юмаа бүгдийг нь хэлж өгнө.

Эцэст нь би энд ямар ч холбоогүй учраас нэр цэвэрлэгдэнэ ээ гэж би найдаж байгаа. За яах вэ зарлагдсанаараа өнөөдөр нэр төр уланд

гишгэгдээд явж байгааг би мэдэж байна. Үнэн бодитой мэдээлэл учраас л би энийг хэлж байгаа юм шүү. Тэрнээс би өөрийгөө өмөөрөх гэсэнгүй, би шалгуулахгүй гэсэнгүй. Зүгээр ээ бодитой юм бодитойгоороо гарна. Үгүй үнэн юу гэдэг билээ? Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ гэдэг. Би тэгээд туулай гүйцэж тарна гэж ойлгож байгаа. Энэ зорилгын цаана бол би өөртөө хамаатуулж хэлэхэд миний нэр төрийг л уландаа гишгэх гэсэн тэр доод түвшинд аваачих гэсэн л зорилго явж байгаа юм. Би энийг сайн мэдэж байна, эзнийг нь ч мэдэж байгаа. Харин энэний ард жинхэнэ хулгайч нар үлдэж байгаа шүү. Одоо энэ жинхэнэ хулгайч нараа зарлахыг би шаардаж байна. Энэ Эрдэнэс Таван толгойн компанийн ТҮЗ-ийн гишүүдтэй хамаарал бүхий Улсын Их Хурлын гишүүдийг нэг бүрчлэн зарлаж шалгахыг би шаардаж байна. Оффтейк гэрээг байгуулсан ҮАБЗ-ийн энэ ажлын протоколыг нь ил болгохыг би шаардаж байна.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт байгаа Миланж нэртэй нүүрсний уурхайн бүх үйл ажиллагааг ил тод шалгахыг би шаардаж байна. Би намаасаа гарна энэ тэр гэж юм ярихгүй ээ. Би тийм 3 нүүртэй хүн биш. Би 3 нүүртэй гэж хэллээ шүү. Харин би намаа цэвэрлэнэ.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлт ирүүлсэн байгаа.

Ж.Батсуурь: Гадаа 30 градусын хүйтэн. Энд сүүлийн 30 орчим жилийн булхай луйвар болж бүтэхгүй байгаа зүйлийг 30 орчим насны дундаж настай залуучууд Монгол түмэн гайхан биширч талбайд гарч 10 гаруй хонолоо. 30 жилийн өмнө төрж байсан хүүхэд юугаа мэдэх вэ, 30 жилийн дараа сайхан амьдралд сайхан эх орондоо сайхан амьдарна л гэж бодож байсан. Нэг л мэдэх нь ээ 30 жилийн хулгай луйвар зах

нь харагдахгүй далайд умбаж байгаагаа өнөөдөр илэрхийлж байна. Монголын ард түмэн ой санамжаа алдаагүй байгаа. Би энэ Ардын намынханд нэг зүйлийг хэлье.

Монгол Улсын төрийн эрх дээд байгууллага бол Улсын Их Хурал 1992 оноос хойш, ардчилсан Үндсэн хуулиас хойш 8 удаагийн сонгууль болсон. Энэ 8 удаагийн сонгуулийн долоод нь Ардын нам засаг барьсан. Сүүлийн 2016, 2020 онд хүч нэгтгээд алив гээд 65-аараа, 62-оороо зарим үед 72-оороо барьж байсан. Ингээд хүч нэгтгээд юу болсон бэ гэнгүүт Монголын сүүлийн 30 жилийн бүх луйвар хулгайг хийсэн байж байгаа юм. Тэгээд бие биеэ барьж чадахгүй талцана, хуваагдана. Энийгээ дийлэхийн тулд Монголын ард түмнийг талбайд хэвтүүлдэг. Ийм л зүйл болсон. Өнөөдөр хулгай луйврын дүн бол ойлгомжгүй болоод явчихлаа. ЖДҮ гээд гарч ирж байсан. Тавин хэдэн хүн нэр дэвшээд тавин хэдэн тэрбум ярьж байсан.

Дараа нь Хөгжлийн банк гээд гараад ирсэн 2 их наяд. Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын эрх барих дээд байгууллага Монгол даяараа төрийн байгууллагууд нь хэлэлцээд төсвийг 18-хан их наядыг баталж байхад 1 луйварчин Эрдэнэс Таван толгой дээр очоод 18 их наядыг ганцхан гарын үсгээр хэнд ч мэдүүлэхгүйгээр улс төрийн халхавч доор луйвар хулгай хийсэн нь тодорхой байна шүү дээ. Энийг яагаад бусадтай хуваалцах гээд байгаа юм? Төрийн эрх барих дээд байгууллага 8 удаагийн сонгуульд нь 7-д нь бүүр үнэмлэхүй 62, 65 ямар ч хуулийг гаргаж болох ямар ч луйврыг таслан зогсоож болох, ямар ч эрх мэдлийг зогсоож болох, ямар ч тогтолцоог өөрчилж болох ийм боломж байсаар байтал бие биеэ хаацайлаад бие биеэ өмгөөлж явсаар байж байгаад Монголыг элгэндээ аваад эвхэрчхээд. Тэгээд өнөөдөр тогтолцооны шинэчлэл хийе хулгайгаа нэрлэе гээд. Бие бие рүүгээ заагаад. Энэ чинь арай жоохон ичгэвтэр биш үү? ЖДҮ, Хөгжлийн банк, нүүрс, хүн амь, авлигал.

Та нарын дарга хийж байсан хүмүүс чинь хүний нүүрэн дээр өдий төдий тэрбумаар нь авлигал авангуут 40 саяар, адуу хулгайлсан хүн 8 жил, ЖДҮ 51 хүн л гэсэн 50 нь бараг энд орж ирчихсэн сууж байна. Хөгжлийн банк тэгээд аргаа барсан хүүхэд аавынхаа толгойг маажна гэнгүүт л АН руу дайрдаг. Өөдөөс нь үг хэлдэг. Болохгүй байгааг нь хэлдэг АН-ыг намнахын тулд 2 хуваагаад дарсан. Өнөөдөр та бүхэн ард түмэнтэйгээ нүүрээ тулж байна. Өөрсдөө ялчхаад булхайгаа нуухын тулд эвслийн Засгийн газар байгуулдаг. Өнөөдөр Ерөнхийлөгч хүчтэй байна гэж байна. Ерөнхийлөгчийн засаглалыг болиулах, Ерөнхийлөгчийг эрх мэдэлгүй болгох парламентаас сонгодог болгох, сонгодог тогтолцоотой болгох бүх эрх мэдэл нь танай Ардын намд 24, 25 жил байсан байна шүү дээ. Энэ 30 жилийн чинь. Тэгээд өнөөдөр юу яриад байдаг юм тэгээд? Тэмээ гэхээр ямаа гэж ярьдаг. Эрдэнэс Таван толгой чинь монголын ДНБ-тэй тэнцэх хэмжээний өр авлага үүсгэдэг. Монголын төсөвтэй тэнцэх хэмжээний хүмүүсийг нэг гарын үсгээр иддэг луйварддаг ийм байхад томоо Эрдэнэс Таван толгой байхад тэрүүхэнд нь байгаа жижиг шанага халбаган шанага шиг жижиг Таван толгойг барьж аваад аль ерэн хэдэн онд ард түмний хувьцаа болчихсон ийм хүмүүсийг аль Бүгд Найрамдах Монгол Ардын хуулиар БЭТ тавьж ингэж хувийн өмчийг булааж авах гэх мэтчилэн ийм л зүйлүүд болж байна шүү дээ.

Тэгээд та нар минь сэрээч ээ. Өнөөдөр Эрдэнэс Таван толгойг 1072 хувьцаа хүмүүс хувьцаагаа аваад аз жаргалтай амьдрах бүрэн боломжууд байсан шүү дээ. Тэгээд чи хулгайч, би хулгайч гээд. Та нар 24 жил өөрсдөө бүгдээрээ хулгай хийгээд тойроод хулгайгүй хүн байхгүй болчихсон. Ингээд би дахин хэлье. Аргаа барсан хүүхэд аавынхаа толгойг маажна гэж хаа ч эрх мэдэлгүй байсан АН руу наадгаа болих хэрэгтэй. Ингэж улс төржиж хулгайгаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Хэдийгээр хэлэлцэх асуудалтай шууд холбоогүй ч гэсэн үүссэн нөхцөл байдлын талаар энэ танхимдаа хэлэлцэж, гадаад, дотоод бодлогын аль ч асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж болно гэсний дагуу энэ үүссэн нөхцөл байдлын талаар хэлэлцэх нь зүйтэй учраас хэлэлцэх асуудалтай холбоогүй энэ тэр гэсэнгүй. Яг одоо гадаа -30 хэмийн хүйтэн байна. Жавар тачигнасан энэ хүйтэнд Сүхбаатарын талбайд шударга, ёс, тэгш эрх хариуцлага шаардсан иргэд өдөр шөнөгүй тэмцэж жагсаж байна. Тэд авлига албан тушаалын гэмт хэрэгтнүүд ард иргэдийнхээ боломжийг хулгайлагчдад хариуцлага тооц гэж шаардаж байна. Шуудхан хэлэхэд бол ард түмэн тэсэрч байна аа. Монголын ард түмнийг төрд төлөөлж байгаа та бид энэ өдрүүдэд бас бодит үнэтэй нүүр тулж байна. Ард түмний итгэл гэдэг бол нэхэл хатуутай. Ард түмэн нүдтэй шударга ёс гэдэг нэг л хариулттай. Хариуцлага сахилга бат ёс зүй, Улсын Их Хурлын чуулганы танхимаас Улсын Их Хурлын эрхэм гишүүд та биднээс эхлэх учиртай гэдгийг миний би олон удаа сануулж хэлж байсан. Одоо бид ер нь бодитой ажлууд л хийх хэрэгтэй байна. Хүлээлт үүсгээд л мэдэгдэл хийгээд байх биш. Жагсагчид иргэдийн шаардлагад санаанд нийцсэн хариулт өгөх хэрэгтэй байна. Арга саам хайж арга хэмжээ авч байгаа нэрээр өдөр хоногийг өнгөрөөж болохгүй ээ.

Шуурхай ажиллаж энэ шаардлагатай хуулиудаа өөрчлөлт оруулъя аа. Гэмт этгээдүүдийг илчилж тэдэнд хатуу хариуцлага тооцохын төлөө хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага их зүйлээ хийж гишүүд ажиллаа аа. Ард түмнээсээ эх орныхоо баялгаас хулгайлах үүд хаалгыг хаая. Өөрөөр хэлбэл ард түмнээсээ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд бол ард түмнийхээ талд байцаая. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд Монгол Улсад газар, түүний хэвлийн ой, ус, амьтан ургамал, байгалийн баялаг болон

ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж заасан. Энэ заалтыг улс төр бизнесийн зарим нөхдүүд бүлэглэлүүд уландаа гишгээж улсаа тонож байсан баримтууд ар араасаа хөвөрч ард түмний эгдүүцэл дургүйцлийг, зэвүүцлийг улам төрүүлж байна. Хулгай булхай нь илрэх болохоороо энэ гэмт этгээдүүд бүлэг этгээдүүд бас эрх зүйт төрийн тулх багана болсон парламентын засаглалыг үгүй хийх, ардчиллыг үгүй хийх суртал ухуулга хийж байна.

Нийгмийн эмх замбараагүй байдал руу тулхэх оролдлого хийж байна. Шударга ёсны тэмцэл хийж байгаа Засгийн газрыг огцруулах санаархлаа ил далд илэрхийлж байна. Бүр Монголын төр ҮАБЗ-ийг буруутгаж олны анхаарлыг үүссэн асуудлыг сарниулах оролдлого хийж байна. Ийм ч учраас сая энэ өнөөдөр олон гишүүд энэ асуудлыг хөндсөнтэй холбоотойгоор бас АН-ын гишүүдээс ҮАБЗ-д шаардлага тавьсан юм байна. ҮАБЗ-өөс мэдээлэл ирүүлж та бүхэнд танилцуулахыг хүссэн байна.

Энийг би та бүхэнд товчлон танилцуулъя аа. Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх ажлыг уялдан зохицуулах энэ зохицуулалт нь хэрхэн хангаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх дээд байгууллага бол ҮАБЗ юм гэж хуульд заасан. Үндэсний аюулгүй байдлын Засгийн газраас ил болгосон төсөл гэрээг нууцын зэрэглэлтэй байгуулахдаа үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэл болгосон нь эдгээрийг нууцлахыг ҮАБЗ-ийн тэргүүн гишүүдээс чиглэл болгосон гэсэн агуулга бүхий мэдээлэл тараасан нь бодит байдалд нийцэхгүй зарим тохиолдолд олон нийтийг төөрөгдөлд хүргэж мэдэхээр байна. Ийм учраас энэ бодит байдалд төдийлөн нийцэхгүй олон нийтийг төөрөлд хүргэхээр агуулгатай байгаа учир зөвлөмжийг бий болгох талаар хууль тогтоомжийн хүрээнд

хийгдэж байгаа ажлын талаар та бүхэнд мэдээлэл өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч ҮАБЗ-ийн тэргүүн бий болсон нөхцөл байдал, нийгмийн уур амьсгал, олон нийтийн шаардлагыг харгалзан мөн Засгийн газраас нэр бүхий хэд хэдэн төсөл гэрээг нууцаас гаргасантай холбогдуулан эдгээр байгууллагад эдгээрийг байгуулахад үндэслэл болгосон ҮАБЗ-ийн шийдвэр зөвлөмж байгаа эсэхийг шалгах, байгаа бол тэдгээрийг нууцаас гаргаж ил болгох асуудлыг судлан шийдвэрлэхийг үүрэг болгосон бөгөөд ҮАБЗ-ийн ажлын алба энэ асуудлыг хариуцан ажиллаж байна аа.

Эдгээрийг ил болгох асуудлыг хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлэхээр ажиллаж байна. Яригдаж байгаа асуудалтай холбогдуулан хэлэхэд дээр дурдсан Засгийн газрын тогтоолоор ил болгосон төсөл гэрээнүүдийг нууцлахыг ҮАБЗ-ийн шийдвэрээр зөвлөмж болгосон зүйл байхгүй болно оо. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Монгол Улсын төрийн болон албан нууцыг хамгаалах журамд заасны дагуу нууц баримт бичгийг ил болгох эсэх асуудлыг шийдвэрлэх тусгайлсан ажлын хэсэг байгуулан холбогдох дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулан тагнуулын байгууллагын саналыг авсан байх шаардлагатай бөгөөд, энэ байгууллагын саналыг үндэслэн төрийн нууцад хамаарах мэдээллийг энэ болгох асуудлыг зохицуулах шийдвэрлэх эрх зүйн зохицуулалттай байна. Ийм учир ҮАБЗ-өөс эдгээр шийдвэрийг ил болгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хурдан хугацаанд шийдвэрлэх болно.

Түүнчлэн эрхэм гишүүд та бүхэн холбогдох хууль, тогтоомж журамд заасны дагуу хүсэлтээ гаргаж эдгээр зөвлөмжтэй танилцах асуудал нээлттэй

ийм эрхтэй болно гэсэн байна. Тэгэхээр энэ АН-ын гишүүдээс ч тавьсан саяын энэ үг хэлсэн гишүүд ч тавьсан энэ санал эрхийнхээ дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжүүдтэй эдгээр асуудалтай холбогдуулж холбогдох хууль тогтоомжийн дагуу танилц нээлттэй байна гэдгийг хэлмээр байна.

Зөвлөмж энэтэй гишүүд танилцаж болно зөвлөмж нь ил болно гэж байна. Ингээд зөвлөмж бол нээлттэй байна та бүхэнд танилц. Тэгээд тэрийгээ холбогдох хууль тогтоомжийн дагуу бас нээлттэй болгож байгаа юм байна гэдгийг ҮАБЗ-өөс ирүүлсэн энэ санал дүгнэлтийг ажлын хэсэг гарган ажиллаж байгаа юмаа танилцууллаа. Ер нь бол Улсын Их Хурал энэ баталсан хуулийнхаа талд байж гагцхүү хууль засагладаг нийгмийн төлөө энэ олон жил бугшсан алдаа завхайрлыг засахын төлөө шийдвэртэй үйл ажиллагаа явуулах ёстой. Одоо танай, манай гээд маргалдаад тэмцэлдээд сууж байх цаг биш ээ. Нийт ард түмний эрх ашгийг төлөөлж ажиллах учиртай. Энэ ард түмэн үнийн өсөлт, ипотекийн зээл, татварын дарамтад туйлдаж цөхөрч байна гэж гомдоллож байна, саналаа хэлж байна. Нэг хэсэг нь нийгмийн баялгийг бүтээж улсдаа татвараа шударгаар төлж байхад, нөгөө хэсэг нь үр өгөөжийг нь өрмийг нь хүртэж, ард олныг, төр засгийг басамжилж сууж таарахгүй ээ гэж байна.

Түмэн олны төрд итгэх итгэл алдарч буйн бурууг МАН ч, АН ч, ХҮН нам ч, бие даагчдын төлөөллөөс бүрдсэн энэ парламент хүлээж хулгай нүүрлэсэн нийгмийн хохирогчид нь болсон ард түмнийхээ нэхэл хатуу шаардлагын хариуг бүрэн дүүрэн өгөхийн төлөө ажиллах шаардлагатай. Үүнд манай гишүүд манлайлан ажиллах, оролцох ёстой, өргөсөн тангаргаа биелүүлэх үүрэгтэй.

Улсын Их Хурлын чуулганы танхимд танай манай нам гэж талцаж

ард түмэнд таалагдах гэсэн популизм хийхээсээ илүү улс орны эрх ашиг ард түмний шаардлагад нийцэж ажиллая аа.

Ийм учраас Улсын Их Хуралд өчигдөр өргөн баригдсан Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг өнөөдөр хэлэлцэнэ. Тэгээд энэ хуулийг ажил хэрэгчээр яаралтай хэлэлцэж авлига албан тушаалын гэмт хэрэгт оноох ялын бодлогыг чангатгая аа. Ийм хэрэгт холбогдсон хүмүүст хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байх, өршөөл уучлал үзүүлэхгүй байх, хөрөнгийг нь хураах ийм ял оноодог өөрчлөлтийг хийе ээ. Энэ бол ард түмний шаардлагын нэг хэсэг байна аа. Энийг яаралтай хэлэлцэж шийдвэрлэе. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нүүрсний экспорт тээвэрлэлттэй холбоотой асуудлаар энэ сарын 21-нд нийтийн сонсгол хийхээр төлөвлөсөн. Энэ сонсголыг ард иргэд түүний дотор энэ жагсагчдын төлөөллийг оролцуулан үр дүнтэй хийе. Бодит байдлыг үнэн зөвөөр шүүн тунгаахад бүгдээрээ идэвхтэй оролцье. Эрх мэдэл албан тушаалын ард нуугдсан үүгээрээ далимдуулж хууль завшидаг ийм буруу стандарт байна гэсэн ийм шүүмжлэл хэлж байна.

Тэгээд хүний эрх, шударга ёс, тэгш эрх, хариуцлагыг Монголын нийгмийн үнэт зүйл болгон тунхаглахын төлөө хичээн ажиллахыг та бүхэндээ хандан уриалж байна.

Хуулиудаа хэлэлцэх асуудалд оръё оо. Одоо ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол улсын ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа,

Улсын Их Хурлын дарга,

Эрхэм гишүүд ээ,

Миний бие Жанжсин Сүхбаатарын талбайд иргэдтэйгээ хамт жагсааж, улс төр, уул уурхай, шүүх, хууль хяналтын байгууллагыг бүхэлд нь барьцаалсан МАНАН бүлэглэлд үгүй гэж хэлж, авлигад барьцаалагдсан 30 жилийг цэгцэлж, шударга ёс тогтсон шинэ 30 жилийг эхлүүлэхийн төлөө ордон дотор хүч мөхсөдвөл олон нийтийн дэмжлэг авч тууштай тэмцэхээ илэрхийлж байсан билээ. Ард түмэнтэйгээ хамт төрийн мөнгөөр Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Улсын Их Хурлын эрх мэдлийг алгассан завшсан хулгайг таслан зогсоож, Дархан төмөрлөг, Хөтөлийн цементийн үйлдвэрийг олон нийтийн өмчлөлд эргүүлэн авч энэхүү хэрэг шүүхэд шилжиж чадлаа.

Ард түмэнтэйгээ хамт баялгаа ашиглуулсны эцэст хорин хоёр тэрбум ам долларын өрөнд оруулсан Дубайн хулгайг таслан зогсоож Монголын талд ноогдох 2.3 тэрбум ам.долларын өрийг тэглэж, гацсан байсан гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж бас чадлаа. Ард түмэнтэйгээ хамт улсынхаа нэрээр бонд босгож бүлэглэлийн зарчмаар хувааж эх орноо дампууруулсан Хөгжлийн банкны хулгайг илчилж 805 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг эргэн төлүүлж, Чингис бондын хоёр тэрбум ам.долларын өрийг бүрэн төлж Хөгжлийн банкны хулгайн асуудлыг шүүхэд бас шилжүүлж чадлаа. Ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Таван толгой компани 6 сарын хугацаатай онцгой дэглэм тогтоож нүүрс тойрсон хулгайн асуудлыг олон нийтэд ил болгож, өнөөдөр амаргүй

нөхцөл байдлын дундуур энэ тэмцэл үргэлжилж байна.

Эрдэнэтийн 49 хувь, Оюутолгой, Хөгжлийн банк, Таван толгой, Эрдэнэс Таван толгой зэрэг эрх ашиг нь зөрчигдсөн авлигачдын амь тэмцэж бүх хүчээрээ Засгийн газар руу эргэн ноцож буйг би бүрэн ойлгож байна. 1 цаг хугацаанд олон авлигын хэрэг давхцан шалгагдах нь улс төрийн хувьд эрсдэлтэй гэдгийг ч би гүнээ ухамсарлаж байна. Нүүрсний хулгайг эсэргүүцэж, шударга ёсны төлөө жагсааж буй ард иргэддээ баярлалаа.

Хэрвээ энэ тэмцэл байгаагүй бол бид ордон дотор хүч мөхөсдөх байсныг бас нуухгүй ээ. Яагаад гэвэл Монголын экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрс, зэс бүрдүүлдэг бол Таван толгойн орд нь нүүрсний нийт экспортын 50 хувийг дангаараа бүрдүүлдэг Монголын нийт ард түмний баялаг юм аа.

Тийм ч учраас уул уурхай тэр дундаа нүүрс тойрсон далд эдийн засаг, тэдний төлөөллийг хангасан улс төр бизнес, хууль хяналтын байгууллагын сүлжээ амь бөхтэй өнгөрсөн 30 жил оршин тогтнож байна. Энийг л би нам дамнасан МАНАН бүлэглэл гэж томъёолсоор ирсэн. Зэсийн луйврыг шалгах Их Хурлын гишүүдийн саналтай би бас санал нэг байгаа. Нүүрс болон зэсийн судсыг авлигаас бүрэн чөлөөлөхгүйгээр Монгол Улс хөгжил дэвшлийн тухай, иргэдийн баян, ядуугийн ялгаа, хэт гүнзгийрсэн орлогын тэгш бус байдлыг арилгах тухай, ард түмний сонголт, мөнгөнөөс ангид байж, шударга төр засаг байгуулах тухай, Үндсэн хуульдаа тунхагласан хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоох тухай ойлголт байх ямар ч боломжгүй нь гашуун бөгөөд бодит үнэн билээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж, ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш яг 30 жилийн хугацаа өнгөрлөө. Ардчиллын 30 жилийн заагт дэлхий дахиныг хүндрүүлсэн цар тахал, дайн зэрэг томоохон сорилттой та бид хамтдаа нүүр туллаа. Нэг үгээр хэлбэл бид нар асуудлыг агуулгын хувьд харах зайлшгүй шаардлагатай нүүр тулж байна. Хэлбэр аливаа асуудлыг аргацаасан гал унтраах байдлаар цаашид явах боломж улам бүр хомсдож байна. Монгол Улс тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ардчилсан парламентын засаглалаа хамгаалж шинэ 30 жилийг эхлүүлэхийн тулд дараах 3 эрх зүйн суурь өөрчлөлтийг Их Хуралтай Засгийн газар хамтарч хийх шаардлагатай байна гэж үзэж байна аа.

1. Орлогын тэгш бус байдлыг арилгах.

Монгол Улсын эдийн засаг 1992 оноос хойш 17 дахин тэлсэн ч иргэдийн амьдралын чанарт дорвитой өөрчлөлт гарсангүй ээ. Нэг үгээр хэлбэл Монгол Улсын баялаг хэсэг бүлэг хэдхэн хүний гарт шударга бусаар төвлөрч, уул уурхайн баялаг иргэдийн амьдралд бодит орлого олж чадсангүй.

Засгийн газрын уул уурхайн далд эдийн засгийг ил болгохын төлөөх тэмцэл ч үүнтэй холбоотой юм аа. Миний бие өнгөрсөн 7 дугаар сард авлигатай тэмцэнэ гэдэг бол бид өөрөө өөрсдийгөө мөн намынхаа журмын нөхөдтэй ч тэмцэх үг гэж хэлж байсныг санаж байгаа биз ээ. Авлигатай тэмцэхэд намын харьяалал огт хамаагүй ээ. Авлигал бол Монголын төрд баламталсан хорт хавдар юм.

Хорт хавдрыг мэс заслын аргаар өвдөлт өгч эмчлэхгүй бол архагийн буглаж, эцсийн шатандаа орж, ардчилсан Монгол төрийн аминд хүрэх аюултай.

Хэдийгээр хувь хүний хувьд олон дайсантай болж байгаа ч ард түмний ирээдүйн боломжийг боомилсон авлигын гинжийг таслахын төлөө зүтгэх нь Монгол Улсын Ерөнхий сайдын журамт үүрэг юм аа. Авлигал арилаагүй цагт орлогын тэгш бус байдал бүрэн арилахгүй ээ. Орлогын тэгш бус байдал арилаагүй цагт Монголын ардчилал доголлон байсаар байх болно оо.

Энэ агуулгаараа уул уурхайн биржийн хууль төрийн өмчит үйлдвэрийн газруудыг олон нийтийн эзэмшилд шилжүүлэх багц хууль, Баялгийн сангийн тухай хууль, Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хууль зэргийг Монгол Улсын Засгийн газраас ойрын өдрүүдэд Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэх болно.

Хоёрдугаарт иргэний төлөөлөх эрхийг хангах тухай.

Монгол Улс бол парламентын засаглалтай ардчилсан улс билээ. Парламентын суурь үндэс нь нийт ард түмнийг төлөөлсөн бага ард түмэн байх төлөөллийн зарчим юм аа. Харамсалтай нь орлогын тэгш бус байдал тогтолцооны гажуудлаас улбаалж парламентыг иргэний төлөөллийн байгууллага гэхээс илүүтэйгээр дарга ангийн төлөөллийн мөнгөтэй хүмүүсийн байгууллага гэж ойлгодог болсоор удлаа. Энгийн иргэн 2 том намын гишүүнчлэлгүй иргэний сонирхлын төлөөллүүд, багш, эмч, инженер техникийн ажилтнууд, сэхээтнүүд, малчин, тариаланчид, оюутан залуучууд, ахмад, дунд үеийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлдвэрчний эвлэл болон ажилчдын төлөөлөл нийгмийн цөөнхийн төлөөлөл парламентад сонгогдох нь өдрийн од мэт ховор байсныг өнгөрсөн 30 жилийн статистик түүх хангалттай нотолно оо.

Ардчилал бол эрх мэдэл эд хөрөнгө хэт цөөнхөд төвлөрснийг эсэргүүцэж гарч ирсэн засаглалын хэлбэр билээ. Энэ

утгаараа парламентын ардчилал бол төр иргэн 2-ыг холбосон төлөөллийн төв байгууллагыг бүрэн төлөөлөх ёс зүйн өндөрлөгийн тухай ойлголт билээ. Тийм ч учраас сонгодог парламентын засаглалыг төгөлдөржүүлэх зорилгоор үндэсний их зөвшилцлийн ажлын хэсэг байгуулж иргэний төлөөлөх эрх иргэний хяналт тавих эрхийг өргөтгөх эрх зүйн цогц шинэчлэл хийх Улсын Их Хурлын эрхэм гишүүд, улс төрийн нийт намууд, иргэний нийгмийн байгууллагууд, ард нийтдээ уриалж байна.

Гурав.Хариуцлагын тогтолцоог чангатгах.

Монгол Улсын эрүүгийн тогтолцоо бол ард иргэдэд хатуу, авлигачдад зөөлөн байна гэж олон нийт шүүмжилж байна аа. Дуулиант хэргүүд шүүхийн шатанд замхарч шүүхээр эцэслэн шийдэгдсэн хэргүүд гаднын өмгөөллийн компани дээр задарч тэрбумаар хулгайлсан луйварчид хялбаршуулсан зарчмаар ял завишж, гавьяа байгуулсан мэт олон нийтийн сүлжээнд тааваараа тарвалзаж байгаа нь ард түмэн хилэгнэн уурсаж байна. 10 хуруундаа алтан бөгжтэй хууль сахиулагчдыг шударга ёс тогтооно гэдэгт олон нийт эргэлзэж байна. Зайсангийн амнаас Санзайн зуслан хүртэл Жи класс хөлөглөж тансаг хаусанд амьдарсан төрийн албан хаагчдыг орлогоо нотлохыг мөн олон нийт шаардаж байна аа.

Монгол Улсын Засгийн газраас өнөөдөр авлигал албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, авлигатай хийх тэмцлийг гүнзгийрүүлэх бодлогын хүрээнд Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дараах өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлж байна.

Үүнд:

1.Авлига албан тушаалын хэрэгт холбогдож шүүхээр шийтгэгдсэн

этгээдийн нийтийн албанд ажиллах эрхийг нь бүх насаар нь хасах, өршөөл уучлал үзүүлэхгүй байх. Бүх шатны сонгуульд өрсөлдөх эрхийг хасах.

2.Албан тушаалаа урвуулан ашиглаж авлигын замаар олсон хөрөнгө орлогыг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхээс үл хамааран хурааж улсын орлого болгох.

3.Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн авлигал албан тушаалын гэмт хэргийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг эрх зүйн орчныг хүчингүй болгох.

4.Авлигал, албан тушаалын гэмт хэрэгт тэр дундаа хахууль авах гэмт хэргийн ялын дээд хэмжээг 5-12 жил байсныг 12-20 жилийн хорих ял болгон нэмэгдүүлэх зэрэг авлигал албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгахаар тусгалаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Энэхүү хуулийн төсөлд тусгагдсан өөрчлөлтүүд магадгүй давс мэт шорвог сонсогдож магадгүй. Гэвч аалз мэт бүрхсэн авлигын торыг бид аргадан учирлаж, тастаж, хариуцлагатай засаглалыг бүрдүүлж чадахгүй ээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд авлигатай хийх энэхүү тэмцлээсээ алхам ч ухрахгүй гэдгээ би өнөөдөр дахин хатуу мэдэгдье. Монгол Улсын Засгийн газраас өргөн барьж буй Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн баталж өгнө гэдэгт итгэлтэй байна.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол төрд шударга ёс ялан мандах болтугай.

Г.Занданшатар: Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Лхагвын

Мөнхбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож бүрэн эрхт дуусгавар болсны дараа тоолох, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасах, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх, Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхээс үл хамааран хурааж улсын орлого болгох, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төсөл батлагдсанаар гарах зардлын тухайд материаллаг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тул зардал үүсэхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг Dparliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгааг бас танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Адъяа авлига албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой боловсруулсан хуулийн төсөлд хүний эрхийг хангах асуудлыг хэрхэн тусгасан,

хөөн хэлэлцэх хугацаа болон хүндрүүлэх нөхцөл байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд төслийн 6.7 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт шүүх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн учруулсан хохирлоо төлсөн бол эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх мөн ял шийтгэлийг сонгож болохоор тусгасан асуудлаар. Түүнчлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага албан тушаалтан нь түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоож бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхлэхээр заах биш шууд түдгэлзүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр гэмт хэргийг шуурхай илрүүлэх зорилгоор хэрэг маргааныг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг төдийгүй хэргийн холбогдогч гэм буруугаа хүлээн хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн тохиолдолд ялыг хөнгөрүүлдэг бөгөөд энэ зохицуулалттай холбоотой авлигын гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн эсэх, үр нөлөө өгч байгаа эсэх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй гэж заасан нь авлига албан тушаалын гэмт хэрэг илрэхгүй байх нь эрсдэл үүсэх эсэх мөн авлига албан тушаалын гэмт хэрэгт өршөөл уучлал үзүүлэхгүй байх талаар тусгасан нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хандаж байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу тодорхой гэмт хэргүүдэд бүх насаар нь хорих ял оногдуулдаг бөгөөд авлига албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах хуулийн төслийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд ялын бодлогод байгалийн баялаг тойрсон хууль бус зүйлийг хаасан зохицуулалтыг тусгаагүй, сайжруулсан зүйл харагдахгүй байгаа талаар, түүнчлэн авлига албан тушаалын гэмт

хэрэгт ялыг сонгох боломжтой байгаатай холбогдол холбоотой шүүх гэмт хэрэгтэн хөнгөн ялаар шийтгэдэг учраас зөвхөн хорих ял оногдуулдаг болгох, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа авлига албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах асуудлаар санал нэг байгаагаа илэрхийлж, гэмт хэрэг шударга бус зүйлтэй тэмцэх нь Монгол төрийн үүрэг хэдий ч нийгэмд өссөн нөхцөл байдалтай холбогдуулж нэг үйл явдал, нэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулсан бол учир дутагдалтай. Түүнчлэн төслийн хэлэлцүүлгийн шатанд иргэд олон нийтийн оролцоог хангаж олон талаас нь хэлэлцэх нь зүйтэй талаар тус тус хэлсэн болно оо.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 71.4 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД Пүрэвжавын Сайнзориг, Улсын Дээд шүүхийн

Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батаагийн Батцэрэн, УЕП-ын орлогч бөгөөд Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат, УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор Отгонбаярын Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Базаргүрийн Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Сэнгээгийн Гантулга, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч, доктор, дэд профессор Бадамын Батзориг, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Хулан байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байгаа юу.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Энэ авлига, албан тушаал, авлигын хэргийг үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг чангатгахтай холбоотой Засгийн газрын саналыг бол дэмжиж байна аа. Гэхдээ хэд хэдэн тодруулах зүйл байна Нямбаатар сайд аа. Би бол энэ авлига албан тушаалын хэрэг дээр торгох ял, зорчих эрхийг хязгаарлах ял байх ёсгүй юм уу гэж бодоод байгаа юм л даа. Би өөрөө хуульч хүн биш учраас бол нарийн юмыг нь сайн мэдэхгүй юм. Эмэгтэй хувь хүнийхээ хувьд бол бодоход авлига албан тушаалын хэрэг дээр торгох зорчих эрхийг хязгаарлах ял байх нь хэр оновчтой байдаг юм бэ? Би бол сая Ерөнхий сайдын хэлсэн үгнээс бол авлига албан тушаалын хэрэг дээр бол нэлээн хариуцлага чангатгаж байгаа гэж ойлгосон. Гэтэл энэ 12 дугаар зүйлийн 2

дахь хэсэг дээр чинь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах гүйцэтгэх албан тушаалтан энэ хэргийг үйлдсэн бол торгох ялтай юм байна шүү дээ. Зорчих эрхийг нь хязгаарлах ялтай юм байна шүү дээ. Тэгээд хорих ялтай. Тэгээд энэ авлига албан тушаалын хэрэг дээр энэ хариуцлагыг нь чангатган ялын бодлогыг чангатгана гэдэг атал яахаараа мнэгээд төрийн өмчийн бүх л хулгай, луйвар чинь энэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой ААН байгууллагууд тэдгээрийг энэ удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудтай холбоотой асуудал гараад ирнэ шүү дээ.

Тэгэхээр чинь тэнд гарч байгаа энэ хэргийг чинь болох яахаараа ингээд торгох, зорчих эрхийг нь хязгаарлах эс үгүй бол тэгээд хорих ял оногдуулна гээд. Тэгэхлээр чинь би бол жаахан эргэлзэж байна шүү дээ. Энэ хулгай луйврыг таслан зогсооно, хариуцлагыг нь чангатгана, ялын бодлогыг чангатгана гээд байсан чинь торгох ял орж ирж байгаа юм байна. Зорчих эрхийг нь хязгаарлах ял орж ирж байгаа юм байна. Тэгээд хорих ял орж ирж байгаа юм байна гэж. Энэ дээр та сайд юу гэж үзээд ийм юм оруулж ирсэн юм бэ гэж.

Хоёр дахь асуудал нь тэр 10 дугаар зүйл дээр хахууль авах гээд байгаа юм. Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд гээд ороод ирэхээр энэ чинь нийтдээ ААН байгууллагууд иргэд дээр бас хамтатгаад ААН байгууллагууд, иргэддээ бас энэ ялын бодлогыг нь чангатгасан юм ороод ирж байгаа юм биш биз дээ гэж.

Гурав дахь асуудал нь би энэ авлига албан тушаалын хэрэг дээр чинь хариуцлагыг хөнгөрүүлэх, хариуцлагаас чөлөөлөх юм байхгүй юм байна гэж ойлгож байсан юм. Би буруу ойлгож байгаа юм уу б.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дээр чинь хариуцлагыг хөнгөрүүлэх, хариуцлагаас чөлөөлөх гэсэн юм ороод ирсэн байна шүү дээ. Учруулсан хохирлоо

нөхөн төлсөн бол гэж байгаа юм. Гэтэл ард нь нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хариуцлагыг нь хөнгөлөх чөлөөлөх юм ороод ирж байна шүү дээ. Тэгээд хохирлоо нөхөн төлсөн бол бас яая гэх вэ? Нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэдэг чинь бас арай дэндэх юм биш үү. Хэзээ төлнө гээд тэгээд тэр хариуцлагыг нь хөнгөлөх, чөлөөлөх гэж байгаа юм бэ гэж.

Гурав дахь асуудал нь энэ албан тушаал, авлигын хэрэг дээр чинь оногдох ялын бодлогын интервал чинь арай дэндүү хол тэгээд шүүхэд зарим нэг нь хэт хатуу ял олгох, зарим нэгэнд нь хөнгөн ял оноох ийм боломж олгох юм биш үү? Зарим нь одоо хорих ял чинь 2-8 жил гэж байна шүү дээ. Зарим хорих ял чинь 12-20 жил гэж байна шүү дээ.

Тэгэхээр шүүгчийн үзэмжээр 2 жилийн ял өгч болно. 8 жилийн ял өгч болно. Ингээд энэ интервал чинь хэт одоо.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хишгээгийн Нямбаатар Хууль зүй дотоод, хэргийн сайд хариулна.

Х.Нямбаатар: Би Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Манайхан энэ 6, 7 дээр нэмээд хариулна биз. Энэ 22 дугаар бүлэгт нийтдээ Чинзориг гишүүн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 11 төрлийн бие даасан төрлийн гэмт хэрэг байгаа юм. Таны хэлж байгаа тэр ТӨК-ийн захирал, удирдлагууд, ТӨК-ийн төрийн болон орон нутгийн өмчит компанийн ажилтан албан хаагчид бусдад албан тушаалаа урвуулан ашигласан, хахууль авсан, өгсөн энэ үйлдлүүд нь энэ 22.1 буюу эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах энэ гэмт хэргээрээ зүйлчлэгдэнэ ээ.

Таны саяын асууж байгаа тэр 22 дугаар зүйлийн 12 буюу хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

гэдгийн ердийн бүрэлдэхүүн нь ердийн хувийн секторын ААНБ-ын удирдлагуудад хамаарч байгаа юм. Жишээлбэл хувийн ЕБС хүүхдүүдийг сонгон шалгаруулахдаа журам гаргаад сонгон шалгаруулж авах тэр шударга сонгон шалгаруулалт хийх ёстой атал захирал нь юм уу нэг багш нь хахууль аваад хүүхдийг уралдаант шалгаруулалтад давуу байдлыг үүсгээд оруулж байгаа тохиолдолд энэ 12-ын ердийн бүрэлдэхүүнээр зүйлчлэгдэнэ. Би зүгээр жишээ авч хэлж байна л даа.

Энэ удаад бид нар 22.12-ыг ийм хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй болгож оруулж ирж байгаа нь яг энэ төрлийн энэ хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэргийн субъект нь төрийн өмчийн оролцоотой ТӨК-ийн удирдах гүйцэтгэх албан тушаалтан захиргааны дүрэм, хэм хэмжээний акт, хэлцэл дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулж ашигласны улмаас өөртөө давуу байдал үүсгэсэн тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчилнэ ээ гэсэн ийм томъёолол орж ирсэн. Энийг зүгээр хэлэлцүүлгийн явцад ялгаж салгаж хэдүүлээ нэлээн дэлгэрэнгүй ярьж болно. 6.7 бол Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн эрүүгийн хариуцлагаас хөнгөрүүлэх чөлөөлөх үндэслэл байгаа юм. Энийг энэ удаа бид нар яагаад ингээд тодотгож оруулж ирсэн бэ гэхээр одоогийн байгаа зохицуулалт нь их тодорхойгүй байгаа юм.

Мөрдөн шалгах ажиллагааг явуулахад шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас хөнгөлж, чөлөөлөх асуудлыг нь тодорхой болгож өгье өө. Тэрнээс биш өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн энэ гэмт хэрэг гэдэг бол зөвхөн авлига албан тушаалын гэмт хэрэг гэж хязгаарлаж ойлгож болохгүй. Хүн амины гэмт хэрэг байж болно зохион байгуулалттай гэмт бүлэглэл хил дамнасан контор банд хийж болно. Энэ тохиолдолд бусад этгээдээ илчлээд

мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулахад дэмжлэг үзүүлсэн тохиолдолд л эрүүгийн хариуцлагаас хөнгөлж, чөлөөлөх асуудлыг ярина гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Тэгээд хэн Сайнзориг 6, 7 дээр нэмээд тайлбар хийнэ биз. 22.12 дээр бас нэмээд нэг тайлбар хийчих.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг 81.

Хууль зүй, дотоод хэргийн яам ТНБД.

П.Сайнзориг: Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Торгох ялуудыг бүгдийг нь хасаж байгаа гишүүн ээ. Энэ дээр ерөөсөө торгох ял нэмж орж ирж байгаа зүйл байхгүй. Зөвхөн хахууль өгөх буюу төрийн алба нийтийн албан тушаалтанд хахууль өгөх эсвэл энэ хувийн секторын албан тушаалтан хахууль өгөх эсэх дээр л үндсэн бүрэлдэхүүн дээр л торгох ял байгаа. Бусад хэсгүүд дээр торгох ялуудыг нь бүгдийг нь хасаж байгаа.

Хоёрдугаарт зорчих эрхийг хязгаарлах ял бол бас үндсэн бүрэлдэхүүн буюу тухайн тэр хүндрүүлэх нөхцөл байдал дээр нь ч юм уу онц хүндрүүлэх нөхцөл байдал дээр нь бол байхгүй. Нөгөө хэмжээ дамжаа болон улс төрд нөлөө бүхий этгээдийн үйлдэл дээр зорчих эрхийг хязгаарлах ял байхгүй. Зөвхөн хорих ял оногдуулахаар ялын бодлого нэлээн чангарч орж ирж байгаа.

Хоёрдугаарт яагаад тэр 22.13 гэдэг зүйлийг нэмж байгаа юм бэ гэхээр өнөөдрийн энэ хахууль авах гэдэг гэмт хэрэг нийт нэг зүйл ангиараа байгаа. Энд нь төрийн албан хаагчид хамаатай, нийтийн албан хаагчид хамаатай хувийн сектор ч хамаатай.

Тэгэхээр энийг мэдээж юу гэдэг юм нийтийн албан тушаалтнуудад ялын бодлогыг чангаруулж байгаатай

холбоотойгоор хувийн секторт оногдуулах ял энэ гэмт хэргийн асуудлыг нь тусад нь зүйлчилж бичихээс өөр аргагүй нөхцөл байдлын хувьд бид хэд тусад нь ялгаж 22.13 гэж орж ирж байгаа. Энэ бол цэвэр хувийн сектор. Магадгүй банк дээр зээл гаргахдаа тодорхой 10 хувийг нь авна ч гэдэг юм уу ийм зүйлүүдээр ингээд үүсдэг. Энэ бол тэр хувийн секторт хамаатай байгаа. Өөрөөр хэлэх юм бол 22.4 дүгээр зүйлийг бид нар ялын бодлого чангаруулж байгаатай холбоотойгоор ингэж салгаж үзсэн гэдэг зүйлийг хэлье.

Хоёрдугаарт энэ 6.7 буюу энэ тодорхой хэмжээний ялаас хөнгөлөх чөлөөлөх асуудлыг зохицуулсан заалт одоо байдаг. Энэ Засгийн газраас өргөж орж ирж байгаа дээр нь тодотгосон буюу түрүүн бол Нямбаатар сайд хэллээ. Мөрдөн шалгах шуурхай явуулж, гэмт хэрэг нотлоход дэмжлэг үзүүлсэн байвал эдгээрийг үзүүлнэ ээ гэдэг байдлыг л тодотгож оруулж ирж байгаа юм. Түүнээс биш мөрдөн шалгах ажиллагааг баахан цаг зардал болгож хийж хийж нотлогдоод ирэнгүүтээ би яг ийм байна гээд ийм байдлаар явах юм бол бас ял хариуцлагыг чинь хөнгөлөхгүй шүү. Анхнаасаа бас хамтарч ажиллаж энэ гэмт хэргийг нотлоход бас дэмжлэг үзүүлсэн тохиолдолд нийтлэг байдлаар энэ үйлчлэл нь зөвхөн авлигын 22 дээр биш. Ийм байдлаар бас тодотгож бас оруулж ирж байгаа. Бусдаар энэ заалт маань одоо ч хэвээр үйлчилдэг ийм заалт байгаа юм. Ялын интервалын хувьд угаасаа тодорхой интервалууд байгаа 3-6 сар, 6 сараас 2 жил. 1-5 жил 2-8 жил, 5-12, 12-20 гэсэн ийм интервалын хооронд шүүх эрх мэдлийн байгууллага тухайн тэр хэргийн нөхцөл байдал, хувийн байдал, хохирлоо төлсөн нь төлөөгүй гэдэг юм уу төлөхөө илэрхийлсэн энэ байдлуудыг нь харгалзаж байж шийднэ. Энэ ялын интервал дотор. Төлөхөө илэрхийлсэн гэдэг дээр бол нэг хэлээд орхичхож байгаа зүйл биш. Энийг нэлээн шүүх бас практикаараа тогтоож баталгаажуулж байгаа. Яг орлого олох

бололцоог нь ийм цалин хөлстэй юм байна, ийм аж ахуйн орлогоос ингэж олох юм байна гэдэг зүйлүүд нь нотлогдож байгаа тохиолдолд энэ илэрхийлсэн гэдэг зүйлийг баталгаажуулж, бас ялаас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг нь ярьж байгаа. Түүнээс биш би төлнө гээд хэлснээрээ биш. Энэ асуудлаас хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудал яригдах ийм бололцоогүй байгаа. Ер нь тэгээд мэдээж хахууль авах буюу нийтийн албан тушаалтан хахууль авах эсэх дээр бол ялын бодлого нэлээн чангарч Эрүүгийн хуульд байгаа хамгийн хүнд санкц буюу хорих ялын дээд хэмжээгээр 12-20 жил болгож орж ирж байгаа. Энэ зөвхөн улс төрд нөлөө бүхий болон зохион байгуулалттай байдлаар энэ хахууль авсан этгээдүүдэд хамаатай. Ийм зүйл анги бас орж ирж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье ээ.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя 1 минут.

С.Чинзориг: Би буруу ойлгоод байгаа юм уу? Хорих ял байхгүй гээд байх юм. Тэр 22.12 дугаар зүйл гээд байгаа юм уу? 22.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дээр чинь төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах гүйцэтгэх албан тушаалтан үйлдсэн бол торгоно, зорчих эрхийг нь хязгаарлана хорих ял өгнө гээд ийм 3 юм байгаад байна шүү дээ. Тэгэхээр одоо энэ гол энэ хулгай, луйвар чинь төрийн болон төрийн өмчийн оролцоотой ААН-тэй тэдгээрийн удирдах гүйцэтгэх албан тушаалтантай холбоотой юм гараад байна шүү дээ. Тэгж байхад чинь та нар торгоно, зорчих эрхийг нь хязгаарлана гээд ийм юм оруулаад ирж байгаа чинь энэ ялын бодлого чинь чангарч байгаа, хариуцлагыг сайжруулж байгаа юм мөн үү биш үү. Би буруу юм уншаад байгаа юм уу. Та нарын л өргөн барьсан хуулийг л би хараад хэлээд байна шүү дээ.

Г.Занданишатар: Пүрэвжавын Сайнзориг 81, Төрийн нарийн бичгийн дарга.

П.Сайнзориг: Чинзориг гишүүний асуулт нэмээд хариулъя. Одоо яг 22.12 буюу хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах. Энэ бол хүн зөвхөн төр хувийн хэвшилд аль алинд нь хамаатай заалт байгаа юм. Нэгхэн үндсэн бүрэлдэхүүнтэй. Өөрөөр хэлэх юм бол энэ дээр одоогийн санкц нь юу вэ гэхээр 2700 нэгжээс 14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 6 сараас 3 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг нь хязгаарлах эсвэл 6 сараас 3 жил хугацаагаар хорих ялтай ийм гэмт хэрэг дээр хүндрүүлэх бүрэлдэхүүнийг бид нар нэмж орж ирж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол 6 сараас гуравхан жилийн хорих ялтай ийм гэмт хэрэг байсан бол хүндрүүлэх буюу энийг нь ТӨК ингээд үйлдэх юм бол энэ ял хариуцлагыг нь яах вэ торгох санкц сонголттой байна.

Дээрээс нь 1-5 жил гээд ял хариуцлагыг нь нэмэгдүүлж бид нар төрийн өмч дээр бол ингээж нэмэгдүүлж орж ирж байгаа. Энэ бол үндсэн бүрэлдэхүүнд төрд ч хамаатай хувийн хэвшил хамаатай ийм зүйл анги байсан. 22 дугаар бүлэг. Тэгэхээр энийг нэмэгдүүлээд бид нар бас хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нь нэмж орж ирж яах вэ ялыг нь сонгох санкц бол орж ирж байгаа. Энэ бас яах вэ тодорхой хэмжээнд бас Эрүүгийн хуулийн.

Г.Занданишатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье ээ. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ өнөөдөр орж ирж байгаа хууль маань бол ингээд гадаа болж байгаа жагсаал цуглаантай холбоотой байх шиг байна л даа. Тэгээд энийг бид нар нийгмээс төр засгийн ажилд өгч байгаа үнэлэмж л гэж ингээж ойлгож харах хэрэгтэй. Бидний ажил ямар байна вэ гэдгийг л эндээс л

харж байх ёстой. Тэгээд тэрний нэг нь бол яах вэ энэ авлигын асуудлаар Эрүүгийн хуулийг чангатгах заалт байгаа л байх л даа. Өөр олон асуудлууд байгаа гэж би ингээж бодож байна. Тэд зөвхөн тогтолцооны өөрчлөлт гэдэг ийм зүйл шаардахаар нь урдаас нь нам сонгодог болгоно, пропорциональ тогтолцоог оруулна, гишүүдийн тоог нэмнэ гэдэг ч юм уу иймэрхүү юм ярьчихаар чинь нөгөө хэлцлийн үр дүн гарахгүй болчихоод байна шүү дээ.

Их Хурлын дарга минь тэр нам сонгодог тэр нэг Цэцийн гаргасан шийдвэр энэ тэрээ тархинаасаа авч хаяарай. Нам сонгодог сонгууль явагдахгүй шүү 2024 онд. Би тэрийг хатуу хэлье. Өнөөдрийн орж ирж байгаа энэ асуудал дээр би зүгээр нэг санал хэлье гэж бодож байна. Яах вэ ингээд сонсохоор бол хууль чангатгах гэж байгаа сайн юм шиг ингээж сонсогдож байж магадгүй. Тэгэхдээ нөгөө гол хайгаад өнөөдрийг хүртэл бид олохгүй байгаа нөгөө акул руу чинь хүрч чадах уу. Тэр л асуудал шүү дээ. Нөгөө хууль хүчний байгууллагуудыг нь томилчихсон. Тэнд нөлөөтэй болчихсон. Тэгээд нэг өөрийгөө хамгаалж чаддаггүй нэг хэдэн нөхдүүд нь тэгээд л ингээд л хэлмэгдээд дуусдаг ийм хууль болоод л, хамгаалж чаддаг нь бол ингээд ардаа үлдчихдэг. Би зүгээр гол зорилгодоо хүрэх болов уу наад хууль чинь гэдэгт л эргэлзээд байна шүү дээ. Аягүй гоё л сонсогдож байна л даа.

Тэгэхдээ гол эзэндээ наадах чинь очихгүй байх очдоггүй юм байна лээ. Хамгаалалттай нь бол хүрч чадах ч үгүй шүү дээ наадах чинь. Тэгээд нэг хувийнх нь тэгээд жирийн төрийн албан хаагчид энэ тэр гэсэн юмнууд нь хөөрхий хамгаалалтгүй нэг хэсэг нь ингээд л чанга чанга ял аваад л, хэлмэгдээд л хамгаалалттайнууд нь бол зүгээр үлдээд л. Манайд өнөөдөр амьдрал тийм л байгаа шүү дээ. Тэгэхээр тийм хууль болчих юм бол ямар ч үр дүн гарахгүй наадахыг чинь. Өнөөдөр хайгаад олдохгүй байна шүү дээ. Тэгэхээр наад

хууль чинь гараад хайгаад олоод ялчихна гэдэгт бол би огт итгэхгүй байна. Ийм хууль байх нь зүйтэй. Тэгэхдээ харин яг эзнээ олж ялладаг болохын төлөө яах ёстой юм гэдэг л асуудал бол байгаа болов уу гэж ингэж бодоод байна л даа. Тэгээд тэр талаас нь та бүхэн хэлэлцүүлгийн явцад бас анхаарна биз.

Ер нь бол төвөгтэй л эд байна. Хараад байхад хайгаад л байдаг. Тийм учраас яг тэр гол эзэнд нь очиж энэ ял нь хүрдэг байх тал дээр би зүгээр жаахан эргэлзээд байна л даа. Тэгж чадах болов уу үгүй болов уу. Нэг ийм л зүйлийг бас анхаараарай гэдгийг би бас ажлын хэсэг байгуулагдахад энэ чинь нөгөө шуурхай горимоор явах гээд байгаа билүү. Ер нь энэ хууль дээр нэлээн анхааралтай хандаж ингэж гаргах нь дээр шүү гэдгийг хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Санал, үг хэлсэн үү?

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн 12 дугаар сарын 14-нд Ренчиний Цэрэнпил, Дэмбэрэлийн Нямаа нарын ууган хүү болж эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнд төрсөн өдрийн мэнд хүргэж Монгол төрийн эрхэм түшээ ард түмний илч болсон танд болон танай гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд түүнийг дагасан хуулиуд өргөн баригдаж орж ирж байгаа юм. Үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжсн байгаа юм. Энэ авлигал хээл хахуультай тэмцэх үйл ажиллагаа түүнд

ноогдуулах ялын бодлого эд нарыг чангатгах ёстой үнэн. Тэгж байж бид нэлээн цэвэрших ёстой. Гэхдээ үүний нэрэн доор янз бүрийн юм яриад байдгаа болимоор байна. Энэ Улсын Их Хурлын гишүүдийн халдашгүй байдал энэ тэрийг ярьж байгаа асуудал, энэ хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай асуудлыг тэр нэг ТНБД мэдээллийн хэрэгслээр ярьдаг зүйл биш ээ. Сайнзориг оо та өчигдөр тийм юм яриад байна лээ. Наад хууль тогтоомжийн чинь хуулиар ямар хуулийг хэн өргөн барих вэ гэдэг асуудал тов тодорхой заагдсан. Улсын Их Хурлын хийгээд Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхэнд халдаж байгаа үйл явц наадах чинь. Одоо энэ чоно борооноор гэдэг шиг янз бүрийн юм ярьдагаа больцгооно шүү. Энийгээ нэлээн сайн ойлгоцгоох ёстой шүү.

Нийгмийн Сэтгэл зүй тийм амаргүй байна. Биднээс шударга ёс шаардаж байна. Гэхдээ наад гишүүдийн халдашгүй байдал чинь яг нарийндаа гишүүдийг хамгаалаад байгаа зүйл мөн юм уу? Сонгогчдыг өөрсдийг нь хамгаалж байгаа шүү дээ энэ Улсын Их Хурлыг нь хамгаалж байгаа шүү дээ. Халдашгүй байдлаар юу хангагддаг юм. Та хэд эртээд 4 хүний асуудал оруулж ирэхэд Эрүүгийн хуулиар 14 зүйлээр шалгах бололцоо байна. Түүний хоёрыг нь энэ халдашгүй байдлын цаана хамгаалагдаад байгаа. Бусад 12-ыг нь бид иргэдийн адил шалгах бололцоо байна гэж ярьсан биз дээ. Тэгээд энэ хуулиудыг иргэд олон түмэнд зөв сурталчлах таниулах юмнуудыг хиймээр байгаа юм аа. Худлаа нэг нэр хэлээд тэрний цаана аймаар юм байгаа юм шиг харагдуулаад асуудалд ханддагаа болих ёстой шүү. Энэ явж явж ийм зүйл гэж. Нөгөө талд энэ төрийн болон орон нутгийн өмчтэй тэр компаниудын удирдах хийгээд гүйцэтгэх албан тушаалтнууд янз бүрийн асуудал үүсгэсэн бол ялын бодлого нь чанга байх ёстой. Өнөөдөр энийг чинь л тойрч явж байгаа. Дээр нь яагаад энэ улсуудыг томилдог улсуудынх нь тухай асуудал яригдахгүй байна. Наад төрийн өмчийн

бодлого зохицуулалтын газар чинь тэр гэрээ хийсэн этгээдүүд чинь яагаад яригдахгүй байгаа юм. Үүнийг та нар юу гэж үзээд байна гэж.

Дараагийн нэг зүйл 22.1 бол албан тушаалаа урвуулан ашиглах гэж ярьж байгаа юм энэ өндөр албан тушаалтнуудад төдийлөн хамаагүй бараг үнэндээ. Их Хурлын гишүүн янз бүрийн бичиг гаргахгүй байж болно шүү дээ. Гэтэл бүхэл бүтэн нэгж толгойлж яваа хүн тэр нэгжийн хөгжлийг хангахын тулд ганц нэг гайгүйхэн ААН бойжуулахын тулд ийш тийшээ асуудал тавьдаг юм аа. Тэгээд хүсэлт тавьсан албан бичгийнх нь гарын үсгээр тэр амьтныг барьж аваачиж хорих тухай асуудал яригдах гэж байна шүү дээ наана чинь. Ойлгож байгаа биз дээ болох юм уу энэ чинь. Үүнийг юу гэж ойлгоод байна. Энэ сум орон нутгуудын чинь төсөвт ордог хүн амын орлогын албан татвар, газрын төлбөр, үл хөдлөх ч гэдэг юм уу энийг нэмэгдүүлэхийн тулд наад улсууд чинь хөгжлөө урагшлуулах гээд аж ахуй бизнесийн харилцаагаа ахиулах гээд бас бүхий л талаар анхаарч ажилладаг. Тэгээд тэрний төлөө бичиг гаргасныхаа төлөө хариуцлага хүлээх юм уу. Үнэхээрийн авлигал авсан тийм юм байгаа бол тэрүүнд ноогддог ял зэмийг нь бол том тогтоох ёстой үнэн. Энэ албан тушаал урвуулан.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би сая Батжаргал гишүүний эхний ярьж байгааг ерөөсөө ойлгосонгүй. Хууль тогтоомжийн хуулиар Монгол Улсын Засгийн газар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барих гол субъект нь. Ер нь цаашидаа бид нар хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл бэлтгэж байгаа. Тэр дээр Эрүүгийн болон Зөрчлийн хууль Төсвийн хууль, энэ яг тодорхой татварын хууль гэх мэт энэ хууль тогтоомжуудыг зөвхөн Засгийн газар өргөн мэдүүлнэ

гэдэг ийм өөрчлөлтүүд цаашаа явагдах байх. Сая Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бас хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт орох энэ ажил ингээд үргэлжлээд явагдаж байгаа юм. Тэгэхээр Сайнзориг бол өчигдөр зүгээр мэдээлэл хийсэн. Хууль тогтоомжийн хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаад Засгийн газрын хуралдаанаар оруулаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг өчигдөр яаралтай горимоор олгосон. Мэдээллийг олон нийтэд хийх хийхийг би даалгаж төрийн нарийнд даалгаж ийм ийм өөрчлөлтүүд орж байгаа.

22 дугаар бүлэгт хэргийг хялбаршилгүй болгож байгаа. 22 дугаар бүлгийн 22.1 22.4 22-ын энэ тодорхой зүйл заалтууд дээр бид нар нөгөө ял наймаацдаг хялбаршуулдаг энэ асуудал дээр иргэд олон нийтийг бухимдуулдаг байсан. 40 сая төгрөгөөр торгодог байсан. Энийг үндсэндээ болиулж байгаа. Энэ ердийн журмаараа хуульд заасан тэр ялаа өгдөг ийм зохицуулалт орж байгаа гэдэг л ийм мэдээлэл хийсэн гэдгийг хэлье. Би таны тэр 22.1-тэй холбоотой нэг зүйлийг тайлбарлахад манайх нөгөө нийтлэг эрх зүйн зохицуулалт хийдэг л ийм зүйл л дээ.

Тэгэхээр энэ 22.1-ийг өнөөдөр шүүхийн практикт юу гэж ойлгоод явчихсан бэ гэхээр нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж эсвэл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон бол энэ гэмт хэргийн субъект болоод байгаа юм.

Тэгэхээр өмнө нь шүүхийн практикт яг л ийм асуудал бий болсон. Энэ нь юу вэ гэхээр Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн тэр зээл авахад Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд тухайн үед жижиг, дунд

үйлдвэрийг дэмжих санд өөрийнхөө албан бланк дээр тодорхой ААН-ийн нэрийг дурдаж энэ ААН-ийг дэмжиж ажиллана уу гэсэн утгатай бичиг бичсэнийхээ төлөө өнөөдөр бас шүүхээр гэм буруутайд тооцогдоод ял шийтгэл авсан ийм тохиолдлууд байгаа. Таны саяын хэлж байгаа нөгөө орон нутаг өөрийнхөө сонгогдсон тойргийнхоо ААН байгууллагуудыг бойжуулах тал дээр дэмжлэг үзүүлж байгаа энэ хоёрын заагийг яаж гаргах вэ гэдэг дээр бид нар цаашид анхаарч ажиллая.

Ялангуяа Улсын дээд шүүх дээр энэ дээр тийм тайлбар гаргуулах чиглэл дээр бид нар бас анхаарч ажиллая.

Тэрнээс биш энэ нөгөө нийтлэг эрх зүйн зохицуулалттай улсад яг энийгээ бойжуулах гэж ингэж бичиг өгч байгаа нь албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэмт хэрэг болохгүй ээ гэдэг ийм болно болохгүй ээ гэдгийг өнөөдөр зааглаж ялгаж зүйлчилж ялгаж шалгах боломж хязгаарлагдмал байгаа. Бид нар нийтдээ нийтлэг албан тушаалд нийтийн албан тушаалтан гэж нийтлэг л ойлгож байгаа. Ашиг сонирхлын тухай хуульд заасан тэр албан тушаалтнуудыг бүхэлд нь нийтийн албан тушаалтан гэж байгаа юм. Тэр хүмүүст өөр өөрсдөд нь тодорхой хэмжээний албаны нөлөө албан тушаалын эрх мэдэл энэ байгаа. Энийгээ ашиглаад бусдад нөлөөлж байгаа нөлөөлөл болгоныг л урвуулан ашиглах энэ гэмт хэргийн үндсэн үйлдэл хэлбэр гэж энэ Эрүүгийн хуульд тодорхойлсон энэ ч агуулгаар мөрдөх байгууллага мөрдөж шалгаж ирсэн. Шүүгч яг ингэж ял оногдуулсан практиктай байгаа. Тэгээд саяын таны хэлсэн дээр бид нар бас анхаараад тайлбар гаргуулах тал дээр энэ нь яг хүчин төгөлдөр байгаа Эрүүгийн хуулийн энэ 22.1-д бол яг хууль дээр афтетик тайлбар хийчихсэн байгаа шүү дээ. Албан тушаалын байдал гэдэгт эрх нөлөөг хамаарна гээд. Урвуулан ашиглахад.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ж.Батжаргал: Сайд миний ярьсныг арай буруу ойлгосон юм болов уу. Өчигдөр танай Төрийн нарийн Улсын Их Хурлын гишүүдийн халдашгүй байдлыг арилгах ёстой гэдэг юм ярина лээ. Энэ бол Их Хурал, Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдаж байгаа зүйл.

Тийм учраас ярьдаг юмнууд хязгаартай байх тухай асуудал. Би энэ талаас нь ярьж байгаа юм, нэг.

Хоёр дахь зүйл. 22.1 дээр зориуд өөрийнхөө чиг үүргийг хэрэгжүүлээгүйгээс хэн нэгэнд давуу байдал үүсгэсэн тухай асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бид энэ эрх мэдлийн хуваарилалт чиг үүргийн тодорхой болголтынхоо асуудлыг илүү нягталж үзэхгүй бол байдал бас тийм амаргүй. Бас энэ нэгжийн удирдлагууд чинь хуучин бол мэргэжлийн хяналт чиг үүрэг хэрэгжүүлээд явдаг байсан. Энэ нөхдүүд шалгалт элдэв бус юмны доголдолтой гэдэг юм уу гүйцэд үр дүнгүй.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Батжаргал гишүүний тэр хэн Сайнзоригийн тухайд мэдээлэл хийсэн тухайд бол ер нь жагсагчдаас ийм шаардлага тавьж байгаа гээд Ерөнхий сайдад шаардлага ирсэн юм. Тэгээд шаардлагынх нь дагуу Ерөнхий сайд ер нь Хууль зүй, дотоод хэргийн яамыг энэ бүрэн эрх халдашгүй бүрэн эрх гэдэг энэ ойлголтыг цаашид арилгах ийм эрх зүйн зохицуулалт байвал яасан юм бэ гэдэг агуулгаар судлах ийм үүрэг даалгавар өгсөн. Би тантай санал нэг байна. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй бүрэн эрх гэдэг бол зөвхөн өөрсдийнх нь Улсын Их Хуралд хадгалагддаг ийм асуудал. Нөгөө талаасаа гадна талдаа иргэд олон

нийтийн тавьж байгаа шаардлага талаас бол ийм зүйлүүд байсан. Энэ талаас бид нар судалж байгаа гэдэг л ийм мэдээллийг хийсэн.

Цаашид бид нар бас энэ мэдээлэл өгөхдөө олон нийтэд мэдээлэл өгөхдөө нэг цонхоор зөв мэдээлэл өгч байя гэдэг дээр анхаарч ажиллая. Саяын тэр нөгөө нэг ер нь Эрүүгийн хуулийн энэ ерөөсөө 22 дугаар бүлгийн үйлдэл нь.

Г.Занданишатар: Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Тэгээд би бол энэ хуулийг агуулгаар нь дэмжиж байгаа. Энэ өчигдөр орж ирсэн учраас нарийн ширийнийг нь түрүүчийн Чинзориг гишүүний асуугаад байгаа шиг нарийн ширийн юмыг нь би мэдэхгүй байна шүү. Нэгдүгээрт энэ хөөн хэлэлцэх хугацаа энэ авлигал албан тушаалын хэрэг дээр яаж шийдэж байгаа юм. Тэрийг зохицуулсан юм уу үгүй юм уу?

Хоёрдугаарт нь одоо тэр төрийн өмчийн компани дээр нэг нөхөр тавьчихаад л. Тэнд чинь Их Хурлын гишүүд, сайд нар нь нөлөөлж тавиулж байгаа шүү дээ ерөнхийдөө. Тэгчхээд тэр нөхрөөр л баахан юм хийлгээд байгаа юм. Тэгэхээр тэр компанийн захирал төрийн өмчийн компанийн захирал дээр түрүүн сонсож байхад торгох ял байх шиг байх юм. Би буруу ойлгогчхов уу яав? Одоо ерөнхийдөө тавьсан тавиулсан 2 хоёулаа л адилхан л хэрэг хүлээдэг чангахан хэрэг хүлээдэг л болгохгүй бол одоо ямар юм болоод байгаа вэ гэхээр бид нар залуучуудыгаа шоронд явуулдаг ийм юм болчихоод байгаа шүү дээ. Нас нь жаахан явчихсан Төрийн сайд дарга янз бүрийн Их Хурлын гишүүд нэг залуухан нөхөр тавиад тэгээд тэр нь ял үүрч яваад байгаа байхгүй юу. Хөөе Сайнзориг оо миний санаа ойлгож байна уу? Тэгэхээр та нар энэ дээр хариулт өгөөч. Миний бодол бол зүгээр энэ явал ингээд багасгах вэ гэхээр тэр албан дээр очиж байгаа хүн тавьсан нөхөр ч гэсэн юм

хэлэхээр үгүй ээ би ингээд ийм ялд унана шүү дээ гэж хэлдэг. Нөгөө тэгж хэлж байгаа хүн ч би өөрөө ийм бас ялд унана шүү дээ гэдэг ийм ойлголтуудтай байхгүй бол болохгүй. Та нарын тэр торгодог ял ер нь байж болохгүй дээ. Би тэр хувийн хэвилийг яриагүй шүү. Энэ төр хавийн, төрийн өмчийн, төрийн албаны дарга цэргүүдэд ийм байж болохгүй. Би бол энэ хууль дээр ийм 2 л концепцтой байдаг. Нэгд хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь байхгүй байгаасай билээ. 2 дахь нь бол энэ ял наймаацаад хөнгөрүүлээд 40 сая төгрөгөөр гараад байдаг энэ чинь бол ёстой жинхэнэ завхрал болчихоод байна. Энийг өөрчлөөсэй билээ гэсэн ийм л бодолтой юм байгаа юм.

Тэгэхээр энэ саяын миний ойлгоогүй юм уу тодруулах гээд асуугаад байгаа асуудалд хариулт өгөөч ээ. Ер нь тэр төрийн өмчийн компанийн захирал том ял өгмөөр байна. Тэр хүнийг бас ийм сонголттой болгомоор байна. Алтанхуяг гэдэг нөхөр тавьчихаад чи одоо энэ зэсийн овоолгыг өг л дөө чи тэр нөхөрт гээд хэлэхээр нь би тэгвэл ингэнэ шүү дээ гээд ажлаа өгдөг л байранд аваачмаар байгаа байхгүй юу. Одоо зүгээр л Уулын баяжуулах үйлдвэрийн захирал нэг тэрбум долларын зэс ялгаж авдаг овоолоод л өгчхөж байгаа юм шүү дээ. Гэхдээ хаа байна бид нар нэг их ард түмний төлөөлөгч энд баахан юм хийдэг юм байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ Нямбаатар сайд та тэр хууль эрх зүйн юман дээр сайн хараарай би бол үзээгүй гэж хэлж байна. Дахиад сүүлд нь хэдүүлээ нэг хариуцлага яримаар байна. Та нар тэр өмнө нь хөөн хэлэлцэх хугацаан дээр ингээд 3, 4 нөхөр Нямбаатар Энхбаяр байсан байх. Раднаасэд хоорондоо шидсээр байгаад завхруулсан шүү дээ. Одоо та нараас би нэг юм асууя. Одоо энийг чинь уншиж бариад нарийн ширүүн ойлгох ийм цаг хугацаа алга. Хурдасгасан горимоор явж байна. Одоо явдаг юм байгаа биз. Энэ дээрээ та дараа нь үг үсэг дээр нь

хариуцлагаа хүлээгээрэй. Агуулга дээр нь хариуцлагаа хүлээнэ ээ гэдгээ хэлээрэй. Бид нар алийн болгон Их Хурлын гишүүд цаасаар хөөцөлдөх вэ. Амжих ч үгүй, мэдэх ч үгүй, боломж ч үгүй шүү дээ хэцүү.

Тэгэхээр та би ийм хөрөнгө оруулж ирж байгаа юм. Би энэнийхээ төлөө дараа нь хариуцлага хүлээнэ ээ. Янз бүрийн асуудал гарвал би мэдэж байна. Алтанхуяг чи битгий олон юм ярь гээд л надад хэлчихвэл би дахиад юм яриад баймааргүй байна.

Г.Занданишатар: Батзориг дарга хариулъя. 83.

Б.Батзориг: Ер нь бол Нобелийн шагналт эдийн засагч Бекер 1968 онд эдийн засгийн аргаар ер нь ялын бодлогыг тодорхойлсон байдаг юм л даа. Тэр юу вэ гэхээр авлигын гэмт хэрэг дээр ял нь бага байх юм бол авлигын гэмт хэрэг үйлддэг хүмүүс гэмт хэрэг үйлдэх магадлал бол маш өндөр. Ялыг нь өндөр болгоод хууль сахиулдаг илрүүлдэг арга замыг нь багасгачих юм бол бас тэр гэмт хэрэг хүссэн хүсээгүй нь нэмэгддэг гэж. Энэ Нобелийн шагналт эдийн засагч гаргасан байдаг юм л даа. Тэгэхээр Алтанхуяг гишүүний ярьдгаар бол яалт ч үгүй ялын бодлого өндөр байж байж дээрээс нь энд оруулж ирж байгаа процессын хуулийн зарим өөрчлөлтүүд орж ирж ингэж байж өөрөө энэ хуулиас айдаг болдог гэсэн ийм эдийн засгийн онол байдаг юм.

Тэгэхээр энэ онолын талаар нь л би хэлье дээ.

Г.Занданишатар: Хэн хариулах уу? Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Энэ бид нар уг нь Алтанхуяг гишүүнээ 5 сард яг энэ хуулийн төслүүдийг Их Хуралд өргөн мэдүүлсэн шүү дээ. Тэгээд бид нар яг энэ танхимд

бөөнөөрөө сууж байгаад хэлэлцэх эсэхээ шийдчихсэн. Одоо манай Хууль зүйн байнгын хороон дээр ажлын хэсэг гараад явж байгаа. Энэ тэгэхдээ том Эрүүгийн хуулийн өөрчлөлт явж байгаа юм. Тэгээд нөгөө гадна талд бас ийм шаардлага тавьж байгаа энэ цаг үед бид нар тэр Эрүүгийн хуулийн том хэлэлцүүлэг хийхээр асуудал нэлээн удна гэж бодоод тусдаа горимоор яг энэ 22 дугаар бүлэг дээр 40 саяар торгуулдаггүй болъё. Хэрэг хялбаршуулдаггүй болъё гэдэг л ийм зохицуулалтыг гол агуулгаараа оруулж ирж байгаа юм.

Та нөгөө хууль хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал ярьж байх шиг байна. Ерөөсөө тэр хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор ял завшсан хүн нэг ч байхгүй шүү дээ? Бид нар 2020 оны 1 сарын 10-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулаад хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам аргачлалыг өөрчлөөд эрүүгийн хэрэгт ялагдагчаар татсан өдрөөс эхлээд хөөн хэлэлцэх хугацаа зогсдог ийм зохицуулалтыг оруулж ирсэн. Тэгвэл 2017 оноос 2020 оны хоорондох завсрын заагт нь яг энэ асуудлаар ял завишх вэ гэдэг үүднээс Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын хууль гэдэг хуулийг тусад нь санаачлаад авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын шатанд шүүхийн шатанд хэрэг нь хэрэгсэхгүй болсон хүмүүсийг нэхэж ял шийтгэл оногдуулах ёстой гэдэг хууль санаачлаад энэний дагуу тэр нөгөө олон албан тушаалтнуудыг чинь бүгдийг нь ялгаж дуусгасан.

Яг энэний дараа Үндсэн хуулийн цэцэд хүмүүс мэдээлэл гаргаад тэр дагаж мөрдөх журмын хуулийг хүчингүй болгоё гэдэг ийм мэдээллийн дагуу ҮХЦ хуралдаад тэр дагаж мөрдөх журмын хуулийг хүчингүй болгосон. Гэхдээ дагаж мөрдөх журмын хууль нь хэдийг нь өөрөө үүрэг ролио гүйцэтгээд дууссан. Тэгэхээр энэ хөөн хэлэлцэх хугацаа гээд нэг ийм

нийгэмд бүрхэгдсэн юм яриад л өчигдөр манай Раднаасэд энэ тэр яриад л над руу дайрч байх шиг байна лээ. Би бол мань хүний сэтгэл зүйг ойлгож байгаа юм. Өнөөдөр ингээд бас нэр ус нь зарлагдаад бас ингээд асуудал ихтэй байгаа. Тэгээд ийм бухимдаж байгаа. Сэтгэл зүй дээр би нэг их сөрсөн юм яриад яах вэ гээд дуугүй байгаа юм. Ерөөсөө хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой хэн ч ял завхсан зүйлгүй. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой тэр журмыг ерөөсөө тухайн хүнийг эрүүгийн хариуцлагад дуудаад татсан өдрөөс эхлээд л зогсчхож байгаа юм.

Тэр завсрын зохицуулалт нь ямар байсан бэ гэвэл хөөн хэлэлцэх хугацаа зогсохгүй анхан шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл үргэлжилдэг байсан. Тэгээд тийм ч учраас хүмүүс хэргээ шийдүүлэхгүй шүүх хуралдааныг хэчнээн жил хойшлуулсаар байгаад хөөн хэлэлцэх хугацаагаа дуусгадаг ийм зохицуулалт байсан. Энэ алдаагаа хууль тогтоогч хэдийн зассан. Одоо та надаас асууж байх шиг байна. Энэний хариуцлагыг чи ер нь хүлээнэ ээ гээд хэлчих ээ гээд. Одоо Улсын Их Хурлын гаргаж байгаа хуулийн төслийг бид нар санаачилж оруулж ирснийхээ хувьд хэлэлцүүлэг дээр гишүүд өөрсдийнхөө санал байр суурь, зарчмын зөрөөтэй, саналаа гаргах эрх нь нээлттэй.

Миний үүрэг бол энэ Засгийн газрын хуулийн бодлого хариуцаж байгаа сайдын хувьд олон нийтийн өнөөдрийн 4 сарын өнөөгийн энэ олон нийтийн эсэргүүцэл шаардлагад нийцүүлж 22 дугаар бүлэгт хэргийг хялбаршилгүй болгоё. Гол гол тэр гэмт хэргүүд дээр нь торгуулийн ялгүй болгоё. 40 саяар торгодоггүй болгоё гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирсэн. Үүнийхээ хариуцлагыг бол би хүлээнэ ээ.

Г.Занданшатар: Норовын Алтанхуяг гишүүн 1 минут тодруулж асууя.

Н.Алтанхуяг: Ингээд нөгөө төвөгтэй л дээ. Та нарын асуултад хариулахгүй болохоор. Одоо тэгээд хөөн хэлэлцэх хугацаа байгаа юм уу, байхгүй юм уу гэж би асуусан шүү дээ. Тэгээд нэг баахан түүх ярьчихлаа, за яах вэ. Одоо тэр төрийн өмчийн компанийн нөхөр чинь тэгээд торгох ял авах юм уу, авахгүй юм уу гээд бид нар дотор нь ингээд деталь руу ороод нэг асууна шүү дээ. Энэ 2-т нь хариулчих.

Ер нь энэ би өчигдрийн энэ нэг зарлаж байгаа зарлуулж байгаа энэ тэрийг чинь ойлгохоо байчихсан л даа. Хууль хяналтын байгууллагыг зарлаад байгаа юм уу? Нам оролцоод намын тушаалтнууд оролцож зарлаад байгаа юм уу. Зарлахдаа би энэ гишүүдийн тэр телевизээр ярьж байгааг нь сонссон чинь нэг ч удаа дуудаж асуугаагүй янз бүрийн юм яриагүй мөртөө гэнэтхэн над гэтэл нь зарлаад, над гэтэл Улсын Их Хурал руу оруулдаг. Бид нар дээр ч тийм юм юм болсон шүү дээ.

Тэгэхээр иймэрхүү юманд л хөөрхийс яачхаж байгаа юм болоо л гэж бодож байгаа байх. Та Хууль зүйн сайд хүн байна даа. Энэ бас асуудалд анхаараач ингэж болох юм уу? Би тэр аль нам нь.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг хариулна. 81. Дараа нь Нямбаатар сайд.

П.Сайнзориг: Алтанхуяг гишүүний ярьж байгаа зүйл дээр хөөн хэлэлцэх хугацааны асуудал түрүүн засагдсан. 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан энэ хуулиар хөөн хэлэлцэх хугацаа тоолох арга зүй дээр гарч байсан энэ асуудлууд нэг мөр шийдэгдэж засагдсан байж байгаа. Тэгэхээр хөөн хэлэлцэх хугацаа тодорхой ямар түвшинд тасалдаж зогсох вэ эргээд яаж тоолох вэ гэдэг асуудлууд нэг мөр шийдэгдсэн ийм зүйл байгаа. Энэ дээр ч гэсэн бас яах вэ зүгээр тодорхой хэмжээний бүрэн эрхийн дуусгавар

болсны дараа бас хөөн хэлэлцэх хугацааг бас тоолж тоолох асуудлыг бас тодруулж бас энэ хуулийн төсөл дээр бас орж ирсэн. 22.12-дугаар зүйл нь үндсэн бүрэлдэхүүн нь байгаа нь ерөөсөө 6 сараас 3 жилийн хорих ялтай ийм зүйл байгаа юм.

Тэгэхээр энийг бас хүндрүүлэх бүрэлдэхүүн оруулж байж бас ялын бодлогыг чангатгаж байгаа. Тэгэхдээ хэлэлцүүлгийн үед бас таны ярьж байгаа энэ саналуудыг нягталж бас тодорхой хэмжээний эндээс нь магадгүй тэр торгох ялыг нь бас хасаж болох юм. Тэгэхдээ энэ.

Г.Занданишатар: Хишгээгийн Нямбаатар сайд гүйцээж хариулъя.

Х.Нямбаатар: Би хариулчихъя аа. Нэгдүгээрт хөөн хэлэлцэх хугацаа байгаа. Байх байхдаа өмнө нь манай эрүүгийн эрх зүйд хэрэглэгдэж байсан тэр яг зохицуулалтаараа байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт торгох ял байгаа. Энэ бүх юмыг хахууль авах өгөх нөгөө нийтийн албан тушаал урвуулах гэдэг энэ гэмт хэрэг гэдгээр 22 дугаар бүлгийг зөвхөн энэ хэдээр төсөөлж болохгүй. Энэ 22 дугаар бүлэгт нийтдээ 11, 12 төрлийн гэмт хэрэг байгаа. Гадаад улсын төрийн байгууллага Олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, нийтийн алба нь нөгөө 22.1 буюу эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хахууль авах, хахууль өгөх цаашилаад гадаад улсын төрийн байгууллага, ОУБ-ын албан тушаалтныг хахууль дахь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах улсын нөөцийг хууль бусаар зарцуулж үрэгдүүлэх, төсвийн бус.

Г.Занданишатар: Нямбаатар сайд гүйцээгээд хариулчихъя.

Х.Нямбаатар: Дураараа аашилах хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан

ашиглах гээд. Өөрөөр хэлбэл нийгэмд учруулж байгаа хор аюулын шинж чанар нь харилцан адилгүй гэмт хэргүүд дээр төр ялын бодлогоо оногдуулахдаа ялгамжтай өгөх ёстой. Тэр эрх мэдлээ оруулах гэдэг дээр торгуулийн ял байхгүй болсон. Хахууль авах гэдэг дээр торгуулийн алба байхгүй болсон. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гэдэг дээр торгуулийн ялыг хассан. Гэтэл нийтийн албан тушаалтан дураараа аашилсан гэдэг бол жишээлбэл өөртөө байхгүй эрх мэдлээ гаргаад сумын Засаг дарга тээврийн замыг хааж байгаа юм. Нөгөө сумын иргэд нь хэлээд энүүгээр тоос босоод байна гэнгүүт орон нутгийн шинж чанартай замыг хааж байгаа бол дураараа аашилах үйлдэл байхгүй юу. Энэ дээр бүгдэд нь хорих ялгаа өгөөд байвал болохгүй. Бид нар тэгээд энэ Эрүүгийн хуулийг батлахдаа нийгмийн сэтгэл зүйн хөөрөл энэ байдалтай уялдаж ингэж хамаагүй савж болохгүй ээ гэдгийг л хэлье.

Ерөөсөө олон нийт юу гэж байна гэхээр тэр үндэслэлгүйгээр хөрөнгөжиж байгаа нөхөр чинь албан тушаалын байдлаа урвуулж байгаа нөхөр чинь хахууль авч байгаа нөхөр чинь 40 саяар торгуулаад байна гэдэгт л бухимдаад байгаа шүү дээ. Тэрнээс биш сумын сургуулийн нягтлан нярав жил болгон аудитаар ороод 250000 төгрөгийн зөрчил гарангуут түүнд нь дандаа хорих ял өгөөд байвал энэ маань өөрөө бас хэт ялын бодлого шоронжссон тэр бодлого чиглэл рүүгээ явна аа. Барааны саван дутааж болдог биз дээ. Тавантолгойн захирлын тухайд яагаад ч тэр хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулах гэдгээр зүйлчлэгдэхгүй шүү дээ. Хэрвээ гэм буруутай нь нотлогдвол. Энэ хахууль авах тэр бусад нөгөө энэ 22.4-өөрөө зүйлчлэгдэнэ. Давхар зүйлчлэгдэнэ. Тэгэхээр энэ бол хэдүүлээ өнөөдөр ингээд хууль хэлэлцүүлгийг нөгөө шүүхийн яллах танхим болгож болохгүй гэж бодож байгаа. ямар ч байсан бид нар ялыг ялгамжтай ноогдуулах ёстой. Шаардлагатай гэж үзвэл тэр 12-ын

хэдийг л манайх уг нь ялгаж оруулж ирсэн юм л даа.

Хувийн сектор хуулийн этгээдийг ТӨК-аас нь ялгаж оруулж ирсэн юм. Тэгэхээр тэрийг шаардлагатай гэвэл тусад нь энэ хэлэлцүүлгийн явцад бүр үндсэн бүрэлдэхүүн ердийн бүрэлдэхүүнтэйгээр томъёолоод хэдүүлээ оруулаад ирье. Яагаад гэвэл Дэгийн тухай хуулиар бид нар хөндчихсөн учраас хардаад байгаа бол нөгөө 22.1-тэй адилхан ялын дээд хэмжээтэй болгож давхар зүйлчлээд оруулж ирье. 22.1-ээ нөгөө ТӨК төрийн өмчийн оролцоотой компанийн удирдах гүйцэтгэх албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэдэг шинэ гэмт хэрэг болгож томъёолох боломжтой гэдгийг хэлчихье.

Уг нь бол энэ урьд нь 22.4 гээд хахууль авах гээд энэ гэмт хэргээр зүйлчлэгдэж л явах учиртай. Урвуулах, хахууль авах 2 чинь шал 2 ондоо юм байгаа юм.

Г.Занданишатар:

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Сүхбаатар: Тэгээд өнөөдөр бид нар бас нэлээн тийм дэлхийн байдал гэж ярих юм бол ороо бусгаа Монголын байдал гэж ярих юм бол нэлээн бухимдалтай ийм цаг үед бас тодорхой авлига албан тушаалын гэмт хэрэг гээд төрийн эсрэг ард түмний эсрэг байдаг. Энэ хулгайтай луйвартай холбоотой энэ гэмт хэргийн хүлээлгэх хариуцлагыг улам чангатгах тухай асуудлыг ярьж байна.

Ардчилсан нийгэмд бол тайван жагсаал цуглаан гэдэг бол олон түмний эсэргүүцэл шүүмжлэлээр илэрдэг. Тайван жагсаал цуглаан гэдэг бол нийтийнхээ тэр бухимдлыг гаргаж тавьж байгаа том шахалт шаардлага болдог төрд тавьж байгаа юм. Төрийг сахилгажуулдаг төрийг эрүүлжүүлдэг ардчиллын хамгийн гол арга механизм.

Энийг бол бид хүлээн зөвшөөрч дасан зохицох ёстой. Мэдээж цаг үе маань би түрүүлсэн ийм байна. Тэгэхээр бидний юунд бухимдаад байна вэ гэдэг дээр тэгээд л сүүлийн хэдэн жил бид шударга ёсны тэмцлийг л ярьж байгаа юм.

Сая ч гэсэн энэ орж ирж байгаа хууль дээр шударга ёс чи хаана байна, хариуцлага хаана байна. Хэн ял завшаад байна гэж асууж байна. Тэгэхээр бид бол ярьсан шүү дээ. Хөөн хэлэлцэх хугацаа буруу байна гээд одоогийн Улсын Их Хурлын дарга, Ерөнхий прокурор, Дээд шүүхийн ерөнхий шүүгчид Засгийн газарт ял завших ёсгүй гээд албан бичиг том шахалт шаардлага явуулж байсан. Тэрний дагуу сая Нямбаатар сайд хэлж байна. 2020 оны 1 сард энэ хөөн хэлэлцэх хугацааны чинь асуудал засагдчихсан.

Тэгэхээр хөөн хэлэлцэх хугацааг засагдсаныг сайн хүмүүс ойлгоогүй юм шиг байна. 2020 оноос эхнээс хойш бол хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой ял завшаад байгаа явдал бол гарахгүй байгаа. Харин Засгийн газрын оруулж ирж байгаа энэ зүйл дээр тэгэхдээ нөгөө ялыг нь чангатгаж байгаа улс төр нөлөө бүхий этгээдүүдийн ял чангатгаж байгаа учраас хорих ял нь нэмэгдэж байгаа учраас хөөн хэлэлцэх хугацаа чинь улам хойшлоод явж байгаа. Тэгэхээр хөөн хэлэлцэх хугацааны тухайд манай жагсааж байгаа зүйлүүд олон нийт бухимдаад байгаа зүйл дээр манай хүмүүс бол бас тайван байж болно. Энэ бол сүүлийн 2 жил засагдчихсан явж байгаа шүү. Харин ч хөөн эх хугацаа уртсаад явж байгаа. Түрүүн хэлж байгаагаар хөөн хэлэлцэх хугацаа цаашид авлига албан тушаалын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа гэж байх ёсгүй гэдэг нэг юм байгаа. Тэр үнэн. Тэр дээр бид бас наанатай цаанатай энэ дотроо бид нар энэ авлига албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд 2 ялгамжтай юм байх ёстой. Улс төрд нөлөө бүхий этгээдүүдэд л хүмүүс их бухимдаад байгаа шүү дээ бас. Зүгээр тэр жирийн албан хаагч нар, баги, эмч нар гээд энэ

субъект чинь бас давхар болдог байхгүй юу. Тэр дотор тодорхой зөрчлүүд албан тушаалын гэмт хэргийн асуудлууд гардаг. Тэгэхээр тэнд болохоор зэрэг яг энэ улс төрд нөлөө бүхий этгээдүүдэд чангатгасан тэр ялыг хэрэглэж бас болохгүй байгаа учраас энэ тэр торгох ял дээр жишээлбэл манай зарим улсууд буруутгаад байгаа ч чинь энэ торгох ялыг чинь юунд хэрэглэх гээд байгаа юм гэхээр тэр чөлөөлөх гээд байгаа гэхээр зэрэг ялын дээд хэмжээ нь бага улсуудад хэрэглэх гээд байгаа байхгүй юу.

Түүнээс биш яг одоо тэр жинхэнэ тэр том авлигач гээд байгаа тэр акул гэж яриад байгаа улсууд бол энийг хэрэглэхгүй гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр манай нөхөр ажлын хэсэг бас хэлэх хэрэгтэй байгаа юм. Тэр хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хорихоос өөр төрлийн ял оногдуулна гээд бухимдуулаад байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь тэр улс төрийн нөлөө бүхий этгээдүүдэд хэрэглэгдэх юм уу, хэрэглэгдэхгүй юм уу. Энийгээ нэг сайхан тодорхой хэлчих хэрэгтэй. Энэ дээр бол бид нар бол хэрэглэхгүй гээд л орж байгаа юм. Тэгэхгүй бол энэ үгэн дээр яваад байна шүү дээ. Ер нь хэдэн шаардлага л тавьж байна шүү дээ. Бүх насаар энэ улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг хасъя гэж байна. Энэ төсөлд орчихсон байгаа энийгээ тодруулаад тэр заалтыг нь хэлчих. Хөөн хэлэлцэх хугацааны асуудал байхгүй болчихсон байгаа угаасаа. Энэ нь улам урсаад явж байгаа юм. Юун дээр бухимдаад байна вэ гэхээр манай энд сууж байгаа Дээд шүүх, Ерөнхий прокурор, цаашидаа АТГ, хууль хэрэглээ чинь болохгүй байгаад байгаа байхгүй юу бас. Ганцхан бүхнийг хууль дээр овоолж хаяна гэдэг чинь Их хурал, Засгийн газар хариуцлага тооцдог субъект мөн үү? Энийг Нямбаатар сайд хэлэх ёстой. Ямар хэмжээний хариуцлага тооцох вэ? Их хурал Засгийн газар.

Хариуцлага тооцно гэдэг бол улс төрийн хариуцлага хуулийн хариуцлага гэж байдаг.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг. Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

П.Сайнзориг: Сүхбаатар гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа дээр бас нэг нэмэлт мэдээллийг өгөөч ээ гэж байна. Тэр улс төрд нөлөө бүхий этгээдийн асуудал бол үндсэн бүрэлдэхүүнээр зүйлчлэгдэх ямар ч боломжгүй. Энэ 22 дугаар бүлгийн гэмт хэргүүд дээр. Дандаа хүндрүүлэх байгаа эсвэл онц хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр. Тэр онц хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр нь дандаа хорих ял байгаа. Өөр сонгох санкц байхгүй. Тэгэхээр 6.7 дугаар зүйл дээр тэр тодорхой хэмжээний мөрдөн байцаалтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэдэг бол нийтлэг байдлаараа үйлчлэх энэ асуудал байгаа. Мэдээж энэ авлига ашиг сонирхлын гэмт хэрэг дээр янз янзын л хүмүүс холбогдож байгаа. Сургуулийн багш, захирлаас эхлээд маш олон.

Тэгэхээр энэ улс төрд нөлөө бүхий буюу яг энэ тодорхой өндөр албан тушаалтнуудад бол энэ 6.7-оор өөр төрлийн санкц буюу ял оногдуулах ямар ч боломжгүй.

Тийм учраас энэ дээр бол бас янз бүрийн байдлаар буруу зөвөөр ашиглачих вий хорих ял өгөхгүйгээр ингээд зорчих эрх хязгаарлах ч гэдэг юм уу эсвэл торгох ял өгчих юм шинжтэй гэдэг зүйл бол байхгүй. Тэгэхээр улс төрд нөлөө бүхий этгээдүүдээр хахууль авах ч тэр, албан тушаалын байдал, эрх мэдлээ оруулахдаа ч тэр зөвхөн хорих ял байгаа. Тэгээд энэ хорих ялууд нь түрүүн Нямбаатар сайд хэлсэн дандаа нэмэгдсэн байж байгаа. Ийм зүйлүүдийг хэлье ээ.

Г.Занданишатар:

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн тодруулж асууя нэг минут.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын гишүүн бол нэг албан тушаалтан бас биш байгаа юм. Энэ бол ард түмний төлөөлөгч. Би өөрийнхөө үргэлж ард түмний төлөөлөгчийг бичдэг бүх юман дээрээ. Тэгэхээр ард түмний төлөөлөгчийн хувьд хэлээд байна шүү дээ. Ард түмэн чинь асууж байна. Энд байгаа улсуудаас. Хариуцлага тооц хөрөнгө хураа гээд байгаа юм. Хөрөнгө хураах тухай дээр эд нар бас тодруулж хэлмээр байна. Хариуцлага тооцно гэхээр шүүх энийг мөрдөн байцаадаг нь бол Мөрдөн байцаах алба, АТГ, прокурор. Тэгэхээр шүүхээр шийдүүлсэн хэрэг 2017 онд 44 байсан бол өнгөрсөн жил 160 болтлоо өссөн байна. Гэхдээ сэтгэл дундуур байна шүү дээ. Хариуцлага тооц хөрөнгө хураа гэдэг дээр манай ажлын хэсэг бас энд оролцож байгаа улсууд юмаа хэлмээр байна. Энэ шаардлагуудыг. Их Хурал Засгийн газар чинь та бүгдийн өмнөөс хариуцлага тооцоод хуулийн хариуцлага хүлээлгэхгүй, хөрөнгийг нь хуваагаад явахгүй.

Тэр хууль дээр хөрөнгө хураахтай холбоотой заалт нь яг ямар байна. Энийг нь бас сонгогчдодоо иргэддээ бас танилцуулмаар байгаа юм. Тэгээд ер нь бол ял чангатгая гэдэг бодлого бол өнгөрсөн жил Их Хурал гаргачихсан шүү дээ.

Г.Занданишатар: Батаагийн Батцэрэн Улсын Дээд шүүхийн эргийн танхимын шүүгч. 80.

Б.Батцэрэн: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Тэр гэмт хэрэг үйлдсэн хүний гэмт хэргийн замаар олсон орлого гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан хэрэгслийг бол хурааж улсын төсөвт шилжүүлэх ёстой. Энэ бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5-д байгаа тодорхой заалт юм. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хөөн

хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр эрүүгийн хариуцлага татаагүй хүний хувьд бол хөрөнгийг нь хураах шийдвэрийг бол ердийн журмаар шүүх шийдвэрлэнэ гэдэг заалт нэмэлтээр орж ирж байгаа.

Дээр нь энэ төр нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж байгаа тохиолдолд прокурор энэ хөрөнгийг хураах хохирлыг нөхөн төлүүлэх иргэний нэхэмжлэл гаргахаар, тэр нэхэмжлэлийг нь эрүүгийн хэрэгтэй нь хамтруулан шийдвэрлэхээр ийм нэмэлт заалтууд орж ирж байгаа юм.

Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой бас гишүүд асууж байгаа учраас би.

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчих. Ноён Батцэрэн Шүүгч гүйцээж хариулъя.

Б.Батцэрэн: Тэгэхээр 2015 оны 12 сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлээд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолох заалт бол хуульчлагдсан юм аа. Энэ бол хуулийнх нь үзэл баримтлал тэгээд бусад хуулийнхаа хэм хэмжээтэй харилцан уялдаатай ингэж батлагдсан. Харин энэ хууль хэрэгжиж эхлээгүй байхад 2017 оны 5 сарын 18-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн хуулиар хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болтол тоолохоор нэмэлт, өөрчлөлт орсон. Ингээд энэ хууль хэрэглээний зөрөөтэй байдлууд үүссэн учраас 2020 оны 1 сарын 1-ны өдрийн хуулиар энэ заалтыг өөрчлөөд, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэрэг үүсгэж яллагчаар татах хүртэл тоолдог тэр заалтыг сэргээн хуульчилсан.

Энэ бол энэ хөөн хэлэлцэх хугацааны талаарх онолын ойлголт. Мөн энэ хуулийнхаа бусад зүйл заалтуудтай

харилцан уялдсан. Ингэснээр энэ хуулийн зөрчил хийдлүүд бол нэг мөсөн арилсан. Гэхдээ энд нэг асуудал бий. Энэ нэмэлт, өөрчлөлтийг орохоос өмнө үйлдэгдсэн гэмт хэргүүд дээр энэ хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг хэрэглэх үү, хэрэглэхгүй юү, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үү, үгүй юү гэдэг ийм хууль зүйн маргаан маш их гарсан. Шүүхийн практикт бас хууль хэрэглээний ийм зөрүүтэй шийдвэрүүд гарч эхэлсэн.

Тийм учраас Улсын дээд шүүх 2022 оны 3 сарын 9-ний өдрийн нийт шүүгчийн хуралдаанаар албан ёсны тайлбар гаргаад хөөн хэлэлцэх хугацаа тоолох журам бол өөрөө процессын шинж чанарыг агуулсан хэм хэмжээ юм.

Тийм учраас энэ хууль батлагдсан өдрөөс хойш энэ хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг буцааж хэрэглэхгүй гэсэн ийм агуулгаар тайлбар гаргасан байгаа. Ингэснээр одоо энэ хууль зүйн маргаан бол эцэслэгдэж, шүүхийн практикт бол хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтсон гэж ойлгож болно. Буцааж хэрэглэхгүй. Гэхдээ нэр бүхий хуульчид иргэд өнөөдөр ҮХЦ-д энэ Улсын дээд шүүхийн тайлбар Үндсэн хуульд нийцээгүй гэдэг үндэслэлээр мэдээлэл гаргасан. Үүний дагуу маргаан үүсгэх хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа гэдгийг бас нэмж хэлье ээ.

Г.Занданшатар: Тэгэхээр ийм асуудал үүсээд Нямбаатар сайд Хууль зүйн байнгын хорооны дарга байсан байх. Сүхбаатар зөвлөх зөвлөх байсан. Тэгээд бид нар чинь Улсын Их Хурлаас ажлын хэсэг гаргаад хөөн хэлэлцэх хугацаагаар энэ ял завиших явдлыг хуульчилж халах зорилгоор хуулийн өөрчлөлт хийгээд Цэц энэ тэр дээр очоод тэгээд явсаар байгаад ял завихсан зүйл бол байхгүй гэж сургалт судалгааны албанаас мэдээлсэн байх тийм ээ. Одоо Хавдесламын Баделхан гишүүн.

Х.Баделхан: Баярлалаа Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг дэмжиж байгаа.

Өнөөдөр энэ иргэдийн тавьж байгаа шаардлага ч гэсэн энэ. Ер нь өмнөх Эрүүгийн хууль дотроо бол энэ хөөн хэлэлцэх хугацаагаар ял завихдаг гэсэн асуудал иргэдийн дунд бол тийм ойлголт байгаа.

Хоёрт бол ял наймаацдаг. Олон хүн бол хахууль хэрэг хийчхээд тэгээд ял наймаацаж байна. Ялаа эдлэхгүй байна гэж.

Гуравт нь ер нь бол авлигын ялын бодлого бол маш сул байна гэж иргэд ер нь ярьсан. Энэ асуудлыг бол энэ хуулийн төсөл өөрөө бас оруулж ирж байгаа юм байна. Хуулийн төслийг бол ерөнхийдөө дэмжиж байгаа. Миний асуух асуулт бол бас энэ хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуулт. Сая олон тайлбар хэллээ жирийн иргэд бол энийг зарим нь сайн ойлгохгүй л дээ. Хуулийн төсөл дээр бол албан тушаалаасаа албан тушаалтан ямар нэг хэрэг үйлдсэн байвал тэрийг түдгэлзүүлээгүй байвал, эсвэл оргон зайлсан байвал хөөн хэлэлцэх хугацааг зогсооно оо гэж хуулийн төсөл дээр заасан байна.

Тэгэхээр ер нь энэ авлига албан тушаалын хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацаа гэж ер нь байх шаардлага байна уу. Ер нь заавал яахаараа ингээд хөөн хэлэлцэх хугацаа байдаг юм. Энэ хуулиараа яг хэрэг үйлдсэн хүн энэ хөөн хэлэлцэх хугацаагаар тэр хийсэн боловч ингээд хэрэг завхрах бололцоо байдаг юм бэ гэсэн асуултыг бол иргэд их тавьдаг л даа.

Би ч гэсэн энэ түдгэлзүүлээгүй оргон зайлсан байвал хөөн хэлэлцэх хугацааг зогсооно оо гэсэн ойлголтыг ерөөсөө авлигын хэрэг дээр бол тэр хөөн хэлэлцэх хугацааг хэлэлцэхгүй л гэж ер нь заачхаж болдоггүй юм уу гэсэн нэг асуулт байна.

Хоёр дахь нь бол энэ ялын бодлогоо чангаруулаач ээ гэж иргэд их шаардаж байгаа. Ялын бодлогоо чангаруулсан байна. Хөри Хятад улсад бол энэ авлигын гэмт хэрэгтэй бол тууштай тэмцэж байгаа туршилага байгаа. Манай улсад яагаад энэ хүн шиг ажиллахгүй байна гэсэн асуудлыг бол иргэд их ярьдаг. Яг яаж чангаруулсан юм бэ? Өмнө нь ямар байсан юм одоо ямар боловсон юм бэ гэж.

Гурав дахь нь бол энэ сая нэг хэсэг хүмүүсийн нэрийг зарласан л даа авлигачин гэж гишүүд. Тэгээд энэ иргэд бол энийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Өөрсдөө нэр гаргачихсан байж байгаа. Энэ дээр хуулийнхан нь ямар бодолтой байдаг юм бол ямар дүгнэлттэй байдаг юм бол.

Дараагийн асуулт бол сая Ерөнхий сайд хэллээ. Эрдэнэтийн асуудлыг бид нар шийдсэн. Хөгжлийн банкны асуудлыг бид нар шийдсэн шүүхийн байгууллага руу шилжүүлсэн гэж. Иргэдийн хүсэж байгаа нь бол ерөөсөө шүүхээс эцэслэн шийдэгдээд шийд авч байсан нөхцөлд бол шийдсэн гэж үзэж байгаа. Засаг шийдлээ ч гэсэн шүүхээр шийдэгдээгүй их уддаг юм. Тухайлбал Эрдэнэтийн хэрэг бол ер нь хэзээ шийдэгдэх юм бэ? Энэ чинь олон удаа яригдаж байгаа анхаарал татсан асуудал гэсэн хэдэн асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: *Хэн хариулах уу? Пүрэвжавын Сайнзориг Төрийн нарийн бичгийн дарга.*

П.Сайнзориг: *Баделхан гишүүний асуултад хариулья.*

Таны нэгдүгээр асуудал ер нь ялын бодлого чангарч байгаа юм байна. Тэгэхдээ ямар өөрчлөлтүүд оров яг тодорхой хэлээч ээ гэж байна.

Тэгэхээр одоо юу гэдэг юм? Иргэдийн бас анхаарал татаад байгаа 22.1 дүгээр зүйл буюу авлига албан

тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах энэ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнээс торгох ялыг бас хассан байгаа.

Өөрөөр хэлэх юм бол үндсэн бүрэлдэхүүн дээр зөвхөн зорчих болон хорих ялтай. Энэ нь өөрөө нэгээс 5 жилийн ялтай. Энэ дээр бол гол төлөв ямар этгээдүүд вэ гэхээр дунд шатны албан тушаалтнууд гол төлөв хамаатай. Өөрөөр хэлэх юм бол цэцэрлэг сургуулийн захирал ч гэдэг юм уу эсвэл яам, Тамгын газрын дунд шатны хүмүүст л. Энэ гэмт хэргийг бас хүндрүүлэх нөхцөл байдалтай буюу их хэмжээний хохирол учруулж үйлдэх юм бол дан ганц хорих ялтай. Энэ гэмт хэргийг албан тушаалын гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээдүүд үйлдэх юм бол 5-12 жилийн хорих ялтай, зөвхөн хорих ялтай. Ийм байдалтай ингээд одоо чангарч байгаа. Хахууль авах гэмт хэрэг байна. Энэ өөрөө эргээд төрийн нийтийн албан тушаалтанд ч хамаатай, хувийн секторын албан тушаалтанд ч хамаатай байсныг бид нар 2 задалсан.

Хувийн секторуудыг энэ одоогийн байгаа түвшинд нь бол хадгалсан. Харин төрийн албан хаагчид буюу нийтийн албан хаагчид улам энэ ялыг чангаруулж Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан хорих ялын бодлогод нийцүүлээд хамгийн чанга ял буюу улс төрд нөлөө бүхий эсвэл зохион байгуулалттай этгээдүүд буюу энэ төрийн өндөр албан тушаалтнууд гэдэг юм уу тодорхой этгээдүүд хахууль авсан байх юм бол 12-20 жилийн ял буюу хамгийн Эрүүгийн хуулийн чанга ялыг бид нар оруулж ирж байгаа. Энэ дээр ял наймаацах гэдэг юм уу эсвэл бас хорихоос өөр төрлийн ялаар солиулах ямар ч бололцоо байхгүй. Ердийн горимоороо шийдэгдэх ийм байдлуудаар бас хуулийн энэ өөрчлөлтүүд орж байгаа. Нэр зарлах асуудал бол бас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх бүхий этгээдүүд л прокурорын зөвшөөрлөөр зарласан гэж ойлгож байгаа учраас энэ бас хуулийн хэлэлцүүлгийн явцад бас хэлэх боломжгүй байна.

Цаашидаа бол яах вэ ер нь зүгээр энэ таны ярьж байгаа энэ хөөн хэлэлцэх хугацааны асуудал ч гэдэг юм уу. Сая бас Дээд шүүх маань бас тайлбарыг өгсөн. 2020 оны 1 дүгээр сарын 10-ны хуулиар бас тодорхой өөрчлөлтүүдийг засаад Улсын дээд шүүх маань тайлбар гаргаад зарим юу гэдэг юм зүйлүүдийг илүү их тодруулсан байдлаар энэ хуулийн өөрчлөлтүүд ингээд хэрэгжээд нэгмөсөн практик тогтоож байгаа.

Тэгээд гол асуудал мэдээж юу гэдэг юм тодорхой бас гэмт хэргийг тэр талаасаа шалгаж байгаа бол цаг хугацаатай байх ёстой гэдэг таны хэлж байгаа энэ зүйл бол зөв. Тэгэхдээ энэ ялын бодлогыг чангаруулж байгаа учраас энэ хэмжээгээрээ бас хөөн хэлэлцэх хугацааны тоолох хугацаа бас нэмэгдээд бас сунасан гэдэг зүйлийг бас танд хэлье ээ.

Г.Занданишатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Тийм Баделхан гишүүний асуултад би яах вэ нэмээд хариулахад хөөн хэлэлцэх хугацаа гэдэг бол яг тэр үг зүйн утгаараа ч тэр хэргийг

Өдүүлсэн хүний араас нэхээж хэлэлцээж зарга шүүх хугацаа гэж одоо ч гэсэн ойлгогдож байгаа юм.

Дэлхий дахинд эрх зүйн хөгжил хандлагын хувьд дэлхийн 2 дугаар дайны дараа нацистуудыг шүүх ажил дэлхий нийтээрээ явагдсан Европын улсуудад. Тэгээд тухайн үед Европын улсуудын эрүүгийн хариуцлага хүлээлгэх ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байсан. Тэгээд 1945-1965 оны хооронд үндсэндээ энэ 20 жилийн хугацаанд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн нацистуудыг шүүж бараагүй дуусаагүй. Дахиад 10 жилээр сунгасан.

Тэгээд сүүлдээ эцэс сүүлд нь Нэгдсэн Үндэсний Байгууллага, олон улсын энэ байгууллагуудын шахалт

шаардлагаар дэлхий нийтээрээ хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хөөн хэлэлцэх хугацаагүйгээр бүх насаар нь тэр шалгах ийм эрх зүйн үндэслэл бүрдсэн. Бид ямархуу хандлага барьж энэ хууль тогтоомжуудыг бичдэг вэ гэхээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудаа үндэслэл болгодог. Монгол Улс Авлигын эсрэг конвенцод нэгдэж орсон. Энэ конвенцынхоо хүрээнд өнөөдөр энэ авлигын эсрэг гэмт хэргүүдийг томъёолох ялын бодлогоо төлөвлөх энэ чиглэл рүүгээ анхаарч ажиллаж байгаа. Бүр Авлигын эсрэг конвенцоор авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаагүй болго гэж нэгдэн орсон улс орнуудад даалгаагүй учраас энэ өнөөдрийн энэ хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт бол хангалттай хэмжээнд хариуцлага хүлээлгэх, түүний хойноос нэхээж, хариуцлага татах энэ боломжууд хугацааны хувьд хангалттай байгаа гэдгийг хэлье.

Г.Занданишатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн асуулт асууна.

Ц.Цэрэнпунцаг: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Ингээд товчхон зүгээр асуулт алга. Санал хэлэх гэсэн юм. Энэ бид нар авлигачтай тэмцэх ёстой хатуу тэмцэх ёстой. Тэгэхдээ энд бид нар нэг юмыг бас анхаарч хянамгай байх ёстой. Өмнө нь гарч байсан бидний хар түүх байгаа. Тийм ээ хэлмэгдүүлэлт гэдэг юм бол явдаг. Тэгэхээр зэрэг өнөөдөр бид нар бол энэ ардчилсан нийгмийн суурь зарчим, хүний эрх, хүний хувийн өмч гэдэг юмыг бол бид нар хамгаалж энэ суурь зарчмыг бол сайн бодож, энд хандах ёстой. Тэгээд бас сэтгэл хөдлөлөөр өнөөдөр бүгдийг нь шийтгээд өгье гэж орж байгаад энэний хажуугаар гэмгүй энэ ард иргэдээ бид нар бизнес эрхлэгчдэдээ хамгийн гол нь хэлмэгдүүлчих вий гэж ингээж бодож байна.

Тийм учраас бол энэ дээр бас энэ хууль санаачилж байгаа хууль дээр

ажиллаж байгаа хэсгүүд маань сайн ажиллаж байгаа байх гэж найдаж байна. Энэ тал дээр бол бид нар ялангуяа энэ Сайнзориг байж байна уу? Сайнзориг чинь сая тэр Таван толгой дээр томилогдсон БЭТ байгаа байх тийм ээ? Тэгээд энэ дээр бол бас нэлээн гишүүд яриад байгаа шүү дээ. Хувийн өмчтэй, хувийн хөрөнгө оруулагчтай энэ компани дээр томилогдож ажиллаж байгаа учраас бас энэ яг практик амьдрал дээр тулж байгаа байх. Ийм асуудлууд үүснэ. Цаашидаа ч гэсэн энийг бас энэ хууль гарснаар бас иймэрхүү үр дагаврууд сөрөг үр дагаврууд гарах вэ гэдэг талаас бас урьдчилж энэ тал дээр бол аль болохоор зэрэг ийм сөрөг үр дагавар гаргахгүй байх талаас нь ажиллаж байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр бол санаа зовохгүй байж болох уу? Ерөнхий нэг ийм асуулт асууя гэсэн юм.

Г.Занданишатар: Сайнзориг
Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Цэрэнпунцаг гишүүний сүүлийн л асуултад хариулъя. Яах вэ хуультай холбоогүй юм байна. Тэгэхдээ Засгийн газар бас холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тодорхой ААН дээр бол онцгой дэглэм тогтоосон. Тодорхой мандатуудыг бас өгсөн байгаа. Энэ мандатын хүрээнд яах вэ БЭТ буюу миний зүгээс ямар арга хэмжээ авах гэж байгаа юм гэхээр нэгдүгээрт энд бас хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай санхүүгийн болон бусад үйл ажиллагааны чиглэлээр аудит оруулах. Энийгээ олон нийт хэвлэл мэдээллийн байгууллагад өгөх буюу энэ олон нийтийн эргэлзээд байгаа энэ олон зүйлүүд дээр бас нэг талд нь гарч мухарлах энэ ажиллагаа хийх байгаа. Энэ асуудлаараа би бас холбогдох орон нутгийн удирдлагууд болон компанийн бүхий л албан тушаалтнуудтай хамтран ажиллаж байгаа.

Нөгөөтээгүүр бас Эрдэнэс
Тавантолгой компанийн олборлох

талбайгаас тодорхой нүүрснүүдийг авсан аваагүй, зарим юу гэдэг юм Тавантолгой ХК-ийн талбай дээр байсан зарим мөргөцөг шатсан, шатаагүй, олборлосон, олборлоогүй гээд олон нийтийн бас эргэлзээг төөрүүлээд байгаа ийм зүйлүүд дээр бас мэдээж бас энэ чиглэл дээр хууль хяналтын шалгалт явж байна.

Тэгэхдээ эргээд бас компанийн талаас нь хяналт шалгалтыг зөв болгож Эрдэнэс Тавантолгой ХК-тай энэ нүүрсний авч ашигласан аваагүй гэдэг зүйлүүдийг нэг талд нь бас мухарлаад энэ талбайгаас нь авсан нүүрсийг нь нүүрсээр нь буцааж өгөх үү эсвэл бусад хэлбэрээр тооцоо нийлэх үү гэдэг асуудлыг түргэн шуурхай шийдэж бас олон нийтэд мэдээлэх. Ийм үндсэн одоо чиг үүргийг хэрэгжүүлж бас шуурхай ажиллах ийм үүрэг хүлээж байгаа. Бусдаар бол тэр Таван толгой хувьцаат компанийг орон нутгийн хувьцаа эзэмшигч нь бол эрхийг хэрэгжүүлж байгаа байгууллага нь орон нутаг байгаа. Төрийн аль нэг байгууллагууд шилжүүлж авах байдаг юм уу эсвэл яг энэ Тавантолгой ХК-ийн орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлдэг тэр зарим үйл ажиллагааг зогсоох ч гэдэг юм уу ийм зүйл бол байхгүй. Энэ талаараа ч бас албан хаагчдад нь хэлсэн орон нутгийн зохих удирдлагууд болон ТУЗ-ийн гишүүдтэй зарим орон нутгийг төлөөлсөн гишүүдтэй ч уулзахдаа хэлсэн. Ийм мандат Засгийн газраас олгоогүй энийг бол хэрэгжүүлэхгүй. Энэ бол зөвхөн одоо олон нийтийн дунд эргэлзээд байгаа тэр мэдээллүүдийг мухарлаад нэг талдаа гаргах ажиллагааг та нөхөдтэй хамтарч хийнэ гэдгээ илэрхийлсэн байж байгаа.

Г.Занданишатар: Цэдэндамбын
Цэрэнпунцаг гишүүн 1 минут.

П.Сайнзориг: Сайнзориг сая тодорхой хэллээ. Ер нь зүгээр би зүгээр энэ шууд энэ хуультай хамаагүй ч гэсэн Сайнзоригийг байгаа учраас хэлж байгаа юм шүү. Сая энэ өглөө чуулган дээр

маань энэ сөрөг хүчнийхэн маань энэ асуудлыг бас буруу талаас нь ойлгогдохоор яриад байгаа учраас энийг олон нийтэд зөв мэдээлэл хүргээрэй тэрнээс манай бидний зүгээс бол Их Хурал ялангуяа Эдийн засгийн байнгын хорооны зүгээс бол ямар нэгэн энэ хувийн өмчтэй харьцахад бол ийм төрөөс ийм түрэмгий бодлого явуулахгүй, явуулж байгаа гэж ийм ойлголт бас ард түмэнд очиж байгаа нь бол бас буруу юм.

Тийм учраас та бүхэн энэ яг одоо энэ томилогдоод ажиллаж байгаа ажлын зорилго ажлын даалгавраа ард түмэнд тодорхой мэдээлэл хүргээрэй гэж Сайнзоригт сануулж хэлье.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Амарсайхан гишүүн алга байна хаслаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Авлигын гэмт хэрэг авлигачидтай тэмцэж байгаа Засгийн газрын санаачилгыг дэмжиж байгаа. Эрүүгийн хууль бол авлигын гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийн зөвхөн нэг хэсэг байгаа. Энэ бол ялын бодлогоор дамжуулж тэмцэж байгаа нэг хэлбэр. Нөгөө тал нь бол энэ Авлигын гэмт хэргийг илрүүлдэг байгууллага, энийг шалгадаг байгууллага, энийг хянадаг байгууллага, энийг ялладаг шүүхийн системийг боловсронгуй болгож яг тэмцдэг илрүүлдэг ч хараат бус тэмцдэг илрүүлдэг ийм чадавхтай болох асуудал бол бас нөгөө тал нь. Бид нар энэ 2 дахь талаа орхиод зөвхөн ялын бодлогыг чангаруулж тэмцэнэ гэвэл энэ үлгэр болно.

Хэрэв одоо энэ шалгадаг илрүүлдэг байгууллагыг улс төрийн хараатай хэн нэгний захиалгаар, хонгил угсардаг бол энэ бол өөрөө бид нар зүгээр л эргэн тойрноо харж болно. Улс төрийн өрсөлдөгчөө намнадаг, хорьж байгаад бизнесийг нь дээрэмддэг. Тэр Дорлигжаваас эхлээд ийм л юм руу орно.

Тийм учраас энэ хоёр дахь талыг боловсронгуй болгох дээр Засгийн газар Хууль зүйн сайд ямар бодлоготой байгаа вэ гэсэн эхний асуулт байна.

Хоёр дахь асуулт бол энэ Эрүүгийн хууль дээр ард түмнийхээ шаардлагын дагуу ард түмэн бол авлигачдыг бүгдийг нь л цээрлүүл гэж байгаа юм. Тэгэнгүүт яаж цээрлүүлэх гэж байна гэж ямар асуудал гаргасан гэхээр хахууль өгсөн, хахууль авсан 2-ыг хоёуланг нь толгойг нь авна, цаазална, яллана гээд тэгэнгүүт нөгөө хахууль өгсөн хүмүүс нь хахуулиа өгснөө илчлэхээ больчихож байгаа юм. Ингэнгүүт эндээс хэн хожиж байна гэхээр хахууль авсан хүн хожоод гараад байгаа юм.

Тийм учраас Эрүүгийн хууль бол маш ухаалаг байх ёстой. 2017 оноос өмнө бол хахууль өгснөө сайн дураараа илчилбэл адилхан хариуцлагатай байсан. Одоо ингээд энэ 2017 оноос эхлээд энэ Нямбаатар сайд тэр үед ажлын хэсгийн ахлагч байсан. Тэгээд хахууль өгснөө сайн дураар илчлэх юм бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэдэг ийм шинэ Эрүүгийн хууль үйлчилж эхэлсэн. Энэ бол ухаалаг бодлого. Энэ ухаалаг бодлогын үр дүнд харин авлигын гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр одоо ард иргэд маань энэ хялбаршуулсан журмыг авч хая гээд байна. Тэгэхээр энэ хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэснээс хойш буюу 2017 оноос хойш авлига албан тушаалын гэмт хэргийн илрүүлэлт, авлига, албан тушаалын гэмт хэргээс учирсан хохирлын барагдуулалт, зөрчигдсөн эрхийг сэргээх байдал дээр ямар өөрчлөлт гарсан бэ гэсэн нэг ийм тодорхой асуулт байгаа юм.

Миний ойлгож байгаагаар бол хялбаршуулсан журмыг бүрмөсөн байхгүй болгочихъё гэдэг бол том авлигач акулудыг хэзээ ч илрэхгүй болгох ийм эсрэгээрээ сөрөг үр дагавраа оруулна

гэж бодож байгаа юм. Жишээлбэл хялбаршуулсан журам гэдэг ийм хөшүүрэг байгаа учраас магадгүй энэ хоригдчихсон нүүрсний Эрдэнэс Тавантолгойн захирал байсан Ганхуяг магадгүй хүмүүсийн нэр хэлж байж магадгүй. Өөрөөр хэлбэл чамд захиалга өгсөн, шийдвэр гаргуулсан, нөлөө үзүүлсэн ч тэр даргынхаа нэрийг хэлбэл чиний асуудлыг арай хялбар нөхцөлөөр авч үзнэ гэдэг ийм хөшүүрэг байгаа учраас магадгүй хэлж байж магадгүй шүү.

Энэ хөшүүргийг аваад хаячихаар хэрэг дээрээ хаашидаа тэр хүн хэлсэн ч хэлээгүй ч 20 жилийн ял авах ийм нөхцөл байдал дээр бол хэлэхгүй болчихно. Эсрэгээрээ авлигын гэмт хэрэг чинь бүрэн илрэхээ больчихно. Тэгэхээр энэ дээр ямар хөшүүрэг зохицуулалт байж болох вэ гэдгийг ерөнхий прокуророос асууж байна.

Г.Занданишатар: 82. Максимын Чинбат. Хишгээгийн Нямбаатар сайд хариулаад явъя.

Х.Нямбаатар: Би Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт статистик хэлье. Энэ хэрэг хялбаршихаас өмнө АТГ жилд дунджаар 2-4 хэрэг шийдэж байсан. 2017 оноос эхлээд 2017 оны 7 сарын 1-ээс хэрэг хууль үйлчилж эхэлсэн. 63 хэрэг шийддэг болсон. 2014 онд хэрэг хялбаршуулсан журмаар шийддэг энэ мотиваци хөшүүрэгтэй болсон зохицуулалтын үед 84 хэрэг шийддэг болсон.

2020 онд 114 хэрэг шийддэг болсон, 2021 онд 161 авлига албан тушаалын хэргийг шийдэж мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгаж прокурорын байгууллагад шилжүүлсэн гэсэн ийм статистик байгаа. Энэ дээр Сайнзориг дараа нь нэмж хариулах байх. Сая Энхбаяр гишүүн Хууль зүй дотоод хэргийн сайдын хувиар цаашид энэ

материаллаг хууль процессын хуулийг шинэчлэх нэг хэргээ. Мөрдөн шалгах ажиллагааны талаар тогтолцооны талаар яаман дээр ер нь ямар бодлого гараад явж байгаа вэ гэдэг асуулт асууж байна.

2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Мөрдөх албаны Үндэсний мөрдөх албаны тогтолцоог бүрдүүлнэ гэдэг ийм мөрийн хөтөлбөрийн заалт орсон байгаа. Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр Үндэсний мөрдөх албаны тухай хуулийн төслийг боловсруулах ажил ямар ч байсан явагдаж байгаа. Энэ бол зөвхөн нэг нам эрх барьж байгаа нам хийдэг зүйл биш. Энэ бол үндэсний зөвшилцлийн үндсэн дээр энэ Мөрдөх албаны тогтолцоог цаашид өөрчлөх үү үгүй юү гэдгийг ярих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бараг НҮБ-ын зарчим, зөвшилцөл, зуун хувийн зөвшилцөл дээр энэ тогтолцоог хэрхэн бий болгох вэ гэдгээ бид нар цаашид танилцуулна. Сөрөг хүчин, иргэний нийгмийн байгууллага, эрх барьж байгаа нам бусад бүх байгууллагуудад танилцуулсны үндсэн дээр явуулья гэдэг ийм байдлаар судалгааны ажил хийгдээд явж байгаа. Бид нарын одоогийн байдлаар бол 3 мөрдөх алба байгаа. Тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, АТГ гэдэг.

Энэ 3 байгууллагын 22 дугаар бүлгийн хэргийг АТГ мөрдөөд тагнуулын хэргийг буюу төрийн эсрэг гэмт хэргийг тагнуулын байгууллага мөрдөөд бусад хэргүүд дээр нь мөрдөн шалгах ажиллагааг цагдаагийн байгууллага нь мөрдөж байгаа. Энэ дотор хэргийн харьяалал давхардаж байгаа хэд хэдэн бас хэргүүд байдаг.

Тэгэхээр цаашид бид нар Үндэсний мөрдөх албаны хэвтээ тогтолцоог бүрдүүлээд даргыг нь төрийн эрх барих дээд байгууллага болж байгаа Их Хурал маань олонх, цөөнхийн 100 хувийн зөвшилцөл дээр нэг удаа томилдог ийм томилгоо дэлхий нийтэд бас түгээмэл

байдаг. Энэ чиглэл рүү явах хэрэгтэй. Гол нуруутай аль нэг улс төрийн нам, байгууллага, даргын удирдлагад удирдагддаггүй. Зөвхөн мэргэжил, ёс зүйн шаардлага, зарчимдаа баригдаж ажилладаг. Ийм байдлаар мөрдөх албаны тогтолцоог бүрдүүлье гэдэг байдлаар судалгааны ажил хийгдэж байгаа гэдгийг хэлье. Сайнзориг саяын тэр хэрэг хялбаршихтай холбоотой асуудал дээр нэг хариулт өгье.

Г.Занданишатар: 81. Пүрэвжавын Сайнзориг Төрийн нарийн бичгийн дарга.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүний асуултад нэмж хариулъя. Мэдээж Эрүүгийн хуулийн бодлого, ялын бодлогыг чангаруулах гэдэг бол авлига ер нь нийтлэг байдлаар гэмт хэрэгтэй тэмцэх нэг л арга хэрэгсэл. Тэгэхээр гэмт хэрэг гараад байгаа шалтгаан нөхцөлүүдийг бид нар бас илүү их анхаарч тэр чиглэл рүүгээ бас хууль эрх зүйн орчноо анхаарах зайлшгүй шаардлагатай байгаа юм. Энэ хүрээндээ Засгийн газраас нэлээдгүй олон хуулиудыг өргөн барьсан. Газрын, авлигын гэдэг юм уу, ашиг сонирхлын эрсдэл өндөртэй байгаа салбаруудын чиглэсэн бүхий л реформуудыг хийхийг оролдож байгаа. Энэ хүрэн дээрээ Засгийн газраас газрын реформ, төрийн өмчийн реформ тэр дундаа ТӨК болон орон нутгийн өмчит компанийн засаглалын болон ил тод байдлын асуудлыг хангасан реформ. Эргээд энэ одоо бүхий л төрийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан процесс хуулиудыг бид нар анхаарч өгөх ёстой. Процессгүй учраас юу гэдэг юм ингээд явчихъя, тэгээд явчихъя гэдэг зүйлээс бусдад давуу тал бий болгож байгаа ч юм уу ийм зүйлүүдийг ингээд гардаг.

Тэгэхээр энэ зүйлүүдээ бид хэд цаашдаа анхаарч засаж залруулахгүй бол маш олон зүйлүүд ингээд л явна. Нөгөө талдаа яг бас Энхбаяр гишүүний хэлж байгаа зөв. Мэдээж энэ хялбаршуулахын бас давуу талууд болон сөрөг гэдэг юм уу

ийм зүйлүүд байсан. Сөрөг эффектууд бол ингээд торгох ял авчихлаа л гэдэг байдлаар иргэд маань эмзэглэж байсан. Тэгэхээр бид хэд энийг бол бас хасчхаж байгаа. Ер нь зүгээр хялбаршуулах асуудал байснаар бол гэмт хэргийн илрүүлэлт бол зөвхөн авлига гэхгүйгээр бусад гэмт хэрэг дээр ч гэсэн ялангуяа зохион байгуулалттай ийм гэмт хэргүүд дээр бол илрэх байдал бол нэмэгддэг гэж судлаачид маань үзэж байгаа. Практик ажилтнууд бас хэлээд байгаа юм. Ер нь зүгээр өмнө нь Засгийн газраас бас өргөн барьсан Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт одоо яг хэлэлцэх эсэхээ шийдээд Хууль зүйн байнгын хороон дээр байгаа хууль дээр бол 22.1, 22.4 буюу хахууль авах, 22.1 албан тушаал эрх мэдлээ урвуулах 22.8 байх аа. Би төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулах гэмт хэргүүд дээр л хялбаршуулах асуудал байхгүй ээ.

Бусад 22 дугаар зүйлийн бусад 7, 8 гэмт хэрэг дээр бол хялбаршуулсан асуудал нь байя гэдэг байдлаар өргөн барьсан байсан. Энэ удаагийнх бол нэлээн өргөжүүлээд бүхэлд нь 22 дугаар бүлэг дээр бол хялбаршуулаагүй гэдэг байдлаар орж ирээд байгаа. Мэдээж хэлэлцүүлгийн шатанд Улсын Их Хурлын гишүүд бас тодорхой саналууд гаргаад явахад бүрэн эрх нь Их Хуралд байгаа. Тэгээд энийг мэдээж тал талаасаа дэнсэлж байж бас ярих нь зүйтэй. Тэгээд бас тодорхой зүгээр энэ чиглэлийн судлаачдын байр сууриуд бол байгаа. Миний баруун гар талд сууж байгаа хүмүүс хүртэл ингээд л энэ бас бодлогыг бас уян хатан хандах ёстой шүү дээ. Баланстай хандах ёстой шүү гэдэг зүйлийг л тогтмол хэлж байгаа.

Тэгээд Батзориг доктор, Занданишатар дарга зөвшөөрвөл бас 83 дугаар микрофон дээр маш товчхон бас нэмэлт мэдээлэл өгье.

Г.Занданишатар: 83.

Б.Батзориг: Тэгэхээр авлигатай тэмцэх ажил бол маш олон төрлийн арга. Ер нь олон улс Монгол Улсад олон жил шахаж байгаа авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлээ нэмэгдүүл гэж байгаа. Тэгэхээр ингээд тоо баримтаас харахад 17 оноос хойш нийт шалгаж байгаа гэмт хэрэг 11-24 хувь өссөн байгаа. Авлигын хэрэг шүүхээр шийдэгдсэн хэрэг 29-өөс 42 хувь нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл авлигатай тэмцэх ажил бол шинэ түвшинд хүрчхээд байгаа юм. Тэгэхээр ял чангалах бол нэг янз. Харин түүний гарцаагүй баримтаар хуулийн дагуу нотлох боломжийг нээх боломжийг нээхээс гадна хүний эрх гэдэг асуудал дээр тулж байдаг л даа. Тэгэхээр улс төрд нөлөө бүхий этгээдүүд авлигын гэмт хэргийг хэзээ ч ганцаараа үлддэггүй. Маш нарийн бодож төлөвлөдгийг бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Энэ гэмт хэрэг илрүүлэх нэг гол арга бол хялбаршуулах, хамтран ажиллах, гэрчээр тогтоох, гэрчийг хамгаалалтад авах, мөн хэргээ илчлэхтэй холбоотой асуудал байгаа.

Шүүхийн шийдвэрийг уншиж байхад та бүхэн ч гэсэн бас үздэг байх. Улс төрд төлөө бүхий хүн хэргээ хүлээсэн гэж байгаа юм. Тэгтэл тэр хүн өөрийнхөө хэргийг хүлээх биш тэр хүмүүстэй хамтарч ажиллаж байгаа тэр хэргүүдээ хүлээдэг. Тэгэхээр ингээд бүх иргэд дээр хавтгайруулан ялангуяа авлигын хэрэг дээр энэ хялбаршуулдаг асуудлыг процессын хуулиар хасчихаар бас жишээлбэл ял нь бага байгаа учраас гал шүүх рүү очиж байгаа юм. Ялыг нь өндөр болгоод хялбаршуулдаг бусад арга хэрэгслийг багасгачих юм бол энэ шүүх рүү явдаг гал чинь прокурор, АТГ руу л очно.

Тэгэхээр энэ ялын бодлогоо нотолдог процессын бодлогоо жигд авч явах байх аа. Тийм ч учраас Улсын Их Хурлыг энэ авлигын асуудлаар тусгайлан хэлэлцэж байна. Тэгээд та бүхэн санаа оноогоо хэлэх юм бол бид хууль зүйн

хувьд онолын хувьд арга шийдлүүдээ гаргаад явах бүрэн боломжтой.

Г.Занданишатар: 82. Прокуророос Максимын Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч.

М.Чинбат: Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Энэ дээр би энэ 2, 3 тоон судалгаа та бүхэнд хэлье.

Тэгэхээр авлига албан тушаалын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байдлыг бид судалж үзэхэд 2018 онд 20 хүнд холбогдох 12 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна. Энэ үзүүлэлт 2020 онд 203 хүнд холбогдох 92 хэргийг шийдсэн. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар бид 301 хүнд холбогдох 138 хэргийг яллах дүгнэлт үйлдэж шүүхээр шийдвэрлээд байна. Тэгээд энэ дотроо гэмт хэргийн илрүүлэлт мөрдөн байцаах ажиллагааны чанар, үр дүн, прокурорын яллах ажиллагаа нь нэмэгдсэний л гол үр дүн гэж харагдаж байна. Нэмж хэлэхэд хохирол төлөгдсөн байдал дээр гээд аваад үзэхэд 2018 онд бид 295 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд төлүүлж байсан бол 2020 онд 207 сая төгрөг гэж байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 1.8 их наяд төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд төлөлсөн байна. Энэ дотроо одоо яриад байгаа энэ хялбаршуулсан журмаар авлигын хэргийг яаж шийдвэрлэсэн байна вэ гэж үзэхэд 2017, 2018 онд энэ тоон үзүүлэлт байхгүй. 2019 онд нэг хүнд холбогдох нэг хэргийг авлигын хэргийг хялбаршуулсан бол 2020 онд 29 онд холбогдох 16 хэрэг, 2021 онд 50 хүнд холбогдох 26 хэргийг, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 82 хүнд холбогдох 39 эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шүүхээр шийдвэрлүүлээд байна.

Энэ нь бол ердийн журмаар шийдвэрлэх гэхээс ямар үр дүнгээ өгч байгаа вэ гэдгийг бол энэ тоон

үзүүлэлтээс бид харж зөв үр дүнтэй хуульчлах шаардлага байна гэж бол үзэх гээд байна. Тэгэхээр Засгийн газрын барьсан төсөл дээр бол та бүхэн Их Хурлын тогтоох хууль журам эрхийн асуудал гэрээ шүүх үндэстэй холбоотой шүү. Өмнөх хууль дээр бол энэ албан тушаалын хэргүүд дээр 1, 2, 3 хүндрүүлэх зүйлүүд дээр бол сонгох ялын санкцууд бол байсан тийм ээ. Торгох байна, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял байсан. Тэгэхээр тэр хуульд заасан хэмжээнд бид ялтайгаа тохироод яллагдагчтайгаа тохиролцоод ял наймаацаад ингээд явж байсан. Одоо энэ хуулийн төслөөр бол ялангуяа хүндрүүлж байгаа нөхцөл дээр улс төрд нөлөө бүхий этгээд дээрээ бол ялын сонгох санкц нь хязгаарлагдаж байна.

Тийм учраас тэр тогтоосон хэмжээнд бид хуульчилсан нөхцөлд мөн хялбаршуулснаар хэргийг шийдвэрлэх ийм боломж бол бас байгаа юм л гэж ойлгож байна.

Хэрвээ энийг бүр байхгүй болгочихвол тэгээд хэргийн илрүүлэлт, чанар, үр дүн дээр ямар үр дүн гарахыг бол бас нэлээд сөргөөр л нөлөөлнө л дөө.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6, 7 дээр гэмт хэргийг дэмжлэг үзүүлэх энэ нөхцөл байдлыг бас нэмж оруулж өгч байна.

Г.Занданшатар: Одоо Мөнхөөгийн Оюунчимэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Бид нарт энэ Эрүүгийн хууль гэдэг бол шинжлэх ухаан байгаа. Тэгэхээр олон нийтийнхээ санаа бодолд хөтлөгдөөд хааидаа авлига албан тушаалын гэмт хэрэг дээр улс төрд нөлөө бүхий этгээдүүд дээр торгох ял байхгүй болчихлоо. Зорчих эрхийг хязгаарлах ял байхгүй болчихлоо. Зөвхөн хорих ял үлдлээ. Тэгээд хорих ялаа хамгийн дээд буюу бүх насаар нь хорих ялаар шийтгэдэг болж байгаа үед дахиад

дабаль хэрэг хялбаршуулах юмыг авчихаар би бол нэг ийм юм бодоод байгаа юм. Эрүүгийн хуулийн зорилго бол яллах цээрлэхээс гадна зөрчигдсөн эрхийг сэргээх хохирлыг барагдуулах байгаа юм. Сая хэлж байна шүү дээ. Одоо гуравхан жилийн өмнө 200 сая төгрөгийн хохирол барагдуулдаг байсан бол одоо 1.8 их наядын хохирол барагдуулдаг болчихлоо гэж. Энэ чинь өөрөө эффектээ өгөөд байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр Дээд шүүхийн Батцэрэн шүүгчээс.../минут дуусав/

Г.Занданшатар: 80. Тэгээд хариулахын өмнө Батаагийн Батцэрэн Дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч. Түрүүн Бадамын Батзориг хариулсан. Тэрний дараа Максимын Чинбат хариулсан. Протоколд нэрээ хэлж явахгүй бол протокол бичигдэж байгаа учраас хэн ярьж байгаа нь сүүлд нь нэргүй үлдчихээд байдаг учраас дандаа протокол тэмдэглэлд үлдэнэ. Батцэрэн шүүгч

Б.Батцэрэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Улсын Дээд шүүхийн шүүгч Батцэрэн. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг асуудал бол Монголд төдийгүй дэлхийн бүхий л улс оронд дэмжиж хөгжүүлж байгаа ийм тусгай журам байгаа юм. Монгол Улсын одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн процессын хуулиар 8 жилээс дээш хугацаатай хорих ял оногдуулахаар заасан хэргүүд дээр угаасаа хэргийг ердийн журмаар шийдвэрлэдэг ийм хуультай. Зөвхөн 8-аас доош жилийн хорих ял оногдуулахаар заасан хэргүүд дээр гэм буруугаа хүлээсэн хүний хэргийг прокурор зөвшөөрвөл хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг ийм тусгай журам бий.

Монгол Улсад жилд 13000 хүнд холбогдох хэргийг шүүх шийдвэрлэж байгаа бол үүнээс өнгөрсөн энэ жилийн байдлаар 300 хүнд холбогдох хэргийг шийдвэрлэж байна. Авлигын гэмт хэргийг. Гэхдээ энэ тоон дотор нийтийн

албан тушаалтны үйлдсэн бусад хэргүүд ороогүй гэдгийг анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл нийтийн албан тушаалтан эрх мэдэл албан тушаалын байдлаа ашиглаад, хөрөнгө завшсан хэрэг бол өмчийн эсрэг гэмт хэргээр зүйлчлэгдэж байгаа. Энэ тоо бас нэмэгдэнэ. Ингээд нийт шийдвэрлэж байгаа хэргийн 30-40 хүртэл хувь нь өнөөдөр хялбаршуулсан журмаар шийдэгдэж байна. Энэ дотор авлигын гэмт хэрэг ч гэсэн яг ийм үзүүлэлттэй явж байгаа. Тэгэхээр асуудлын гол нь юу вэ гэхлээр шүүхээс өмнөх шатанд прокурор, яллагдагч, өмгөөлөгч 3 ялын төрөл хэмжээний талаар хэргийн зүйлчлэлийн талаар тохиролцоод ирдэг тэрийг нь шүүх баталдаг энэ асуудал чинь гэм бурууд нь тохирохгүй байна л гэдэг ийм шүүмжлэл явсан. Тэгэхээр асуудлын гол нь хэргийг хялбаршуулахдаа биш юм. Асуудлын гол нь тухайн үйлдэлд оногдуулах ял, шийтгэлийн төрөл хэмжээндээ л байгаа юм. Тийм учраас хэрвээ энэ авлигын гэмт хэргийг ердийн журмаар шийдвэрлэдэг болох юм бол гэм буруугаа хүлээсэн ч гэсэн энэ хэргийг шүүх ердийн журмаар хэлэлцээд гэм бурууд нь тохирсон төрөл, хэмжээний ялыг оногдуулдаг. Ингэхдээ тэр гэм буруугаа хүлээсэн байдлыг нь харгалзаад Эрүүгийн хуулийн 6.7-д заасан тэр хууль зүйн хөнгөлөлтүүдийг хэрэглэх боломж нь өнөөдөр нээлттэй байгаа. Тэгэхлээр сая ажлын хэсгийн гишүүд хэлсэн. Угаасаа авлигын гэмт хэрэг дээр оногдуулах ялын төрөл хэмжээг нэмж байгаа юм байна. Зарим төрлийн гэмт хэрэг дээр торгуулийн ялыг нь хасаж байгаа юм байна. Тийм учраас хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тохиолдолд торгуулийн ял дээр тохиролцох тэр боломж бол өнөөдөр хаагдчихаж байгаа байхгүй юу. Тэр байгаа хорих ял дээрээ хөнгөрүүлэх байдлаар ял тохиролцох боломжийг нь үлдээж байна.

Г.Занданишатар: Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дагаж орж ирж байгаа хуулийн төслүүдийг бүгдийг нь яг 100 хувь дэмжиж байгаа. Ер нь бол бид нар ингээд гадаа иргэд маань орлогын тэгш бус байдал, шударга ёсыг хүсэж, тэмцэж байгаа. Ялангуяа нүүрс тойрсон асуудал бол үнэхээр хэдэн их наяд төгрөгөөр яригдаж байна шүү дээ. Сая доллар, тэрбум доллар гээд яригдаж байгаа энэ үед бид нар асуудлыг үнэхээр цэгцлэхгүй бол улс орон цаашаа явахад хэцүү болжээ гэдгийг л бид зөндөө яриад л байгаа. Хууль бол гаргаад байгаа. Гэхдээ асуудлын гол нь хуульдаа биш, хуулийн хэрэгжилт дээр асуудал маш их байна шүү дээ. Сая би Батцэрэн гуайтай бас санал нэг байна. Энэ асуудлын гол нь хялбаршуулахдаа биш харин энийг яаж авч үзэх вэ гээд. Одоо энэ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь зөвхөн иргэд гадаа жагсангуут өөрчлөлт оруулахгүй бол болохгүй юм байна гээд 22.1-д өөрчлөлт оруулж байгаа асуудал биш гэж би харж байгаа юм. Яагаад гэвэл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Эрүүгийн хууль гэдэг чинь өөрөө бүхэл бүтэн шинжлэх ухаан. Бас энэ дээр хууль хүчний байгууллагынх маань туршилага, сүүлийн 25 жил, 30 жил яагаад авлигал арилахгүй, авлигал буурах битгий хэл улам гараад бүр том том тоо нүд, толгойд багтамгүй тооны хэмжээнд хүрээд өсөөд байна гэхээр энэ чинь нэг асуудал байгаад байна даа. Тэгэхээр бид нар өнөөдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа сая хэлж байна шүү дээ. Ялын бодлогыг торгох, тэр хилийн хориг тавих гэхээсээ илүү шууд хорих ялаар оноодог болох хялбаршуулсан заалтыг бүр авч хаях тухай хатуу заалтаар орж ирж байна гэж байна. Яг ингэж заалт оруулаа гээд өнөөдөр авлигал хэр буурна гэсэн тооцоо байгаа вэ Нямбаатар сайд аа. Бид нар Улсын Их Хурлын ч гэсэн Засгийн газраа ч гэсэн ялыг чангатгая, хуулийг сайн хэрэгжүүлье, ялангуяа дунд шатан дээр, агентлагууд дээр, улс төрийн том албан

тушаалтнууд дээр шийдвэр гаргах түвшинд гарын үсэг зурж байгаа их мөнгө эргэлддэг газар бол авлигал ингээд буурах биш улам гаараад байна. Бүр боловсроод байна. Өнөөдөр нүүрсний хулгайчдыг илрүүл яг бодит эздийг нь зарла. Тэр оффтейк гэрээг ил болго гээд иргэд маань энэ хүйтэнд жагсаж байна шүү дээ. Би иргэдийг ингэж жагсаж байгаад үнэхээр бол дэмжиж байгаа. Анх төрийн мөнгөний бодлого ярьж байх үед Олон Улсын байгууллагын дүгнэлтээр Монгол Улс оффтейк гэрээ гэдгээр асар их мөнгө өөр улсын барилгын компаниуд руу орж байна гэсэн дүгнэлт байна. Энэ оффтейк гэрээ ямар учиртай юм бэ, хэдий хэмжээний мөнгө яригдаж байна вэ гээд би анх ярьж гарч ирсэн л дээ. Тэгээд өнөөдөр оффтейк гэрээнүүд ил болж байгаад үнэхээр талархаж байгаа.

Харин Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар бид өнөөдөр зүгээр нэг иргэдээ жагсаалыг тараахтайгаа биш харин энэ хууль дараа нь үнэхээр Монголын муухай болгоод байгаа авлигыг үнэхээр бууруулж чадах уу? Хэдэн хувь бууруулна гэсэн тооцоо байгаа юм? Энэ нэмэлт, өөрчлөлт оруулснаар. Энэ ялын бодлогыг чангатгаснаар. Тэгээд энэ тооцоог би эхлээд асууя гэж бодож байна. Түрүүн Ерөнхий сайдын хэлсэн үгтэй бол яг санал нэг байгаа. Орлогын тэгш бус байдлыг л эсэргүүцэж ард түмэн тэр чигээрээ байж байна шүү дээ. Хаа сайгүй ийм болж байна. Бүр дэндүү болж байна шүү дээ. Баян, ядуугийн ялгаа. Тэгэхээр орлогын тэгш бус байдлыг халъя гэдэг чинь өөрөө авлигыг л бид зогсоож байж энэ орлогын тэгш бус байдлыг бид халж чадна гэж байна. Тэгэхээр авлигыг бид хэзээ хуулиар нэмэлт, өөрчлөлт орсноор тэгш бус байдал, энэ авлига маань арилчих уу. Яг энийг хийж хэрэгжүүлэх хууль хүчний байгууллага, дэд бүтэц, хүний нөөц, тэр хүсэл тэмүүлэл нь байна уу? Энэ дээр та нар маань хэр судалгаа хийж байгаа вэ? Яагаад гэвэл асуудлын гол нь хуульдаа биш хуулийн хэрэгжилтэд байгааг хүн бүхэн ярьж байна шүү дээ. Бид нар ард

түмнээ төлөөлөөд энд сууж байна. Иргэд маань ярьж байна шүү дээ. Хаа сайгүй бүр авлига гаарч байна гээд. Шат шатандаа явж байна гээд. Тэгээд өнөөдөр орж ирж байгаа Эрүүгийн хууль дээр ялын бодлогыг чангатгахдаа албан тушаалын ангиллаар нь оруулж ирж байгаа юм байна л даа. Багш, эмч бол ийм, нийтийн албан тушаалтан бол ийм, улс төрийн өндөр албан тушаалтан бол ийм гээд зааглаж орж ирж байгаа юм байна. Үүний үр дүнг бид нар яаж харах вэ. Ингэснээр нөлөөлөл нь буурах хандлага байгаа. Бусад улс орны жишиг ийм байгаа гээд та нар маань хэр судалгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Оюунчимэг гишүүн нэлээн өргөн хүрээтэй асуулт асууж байна. Бид ер нь авлигатайгаа хамгийн зохимжтой яаж тэмцэх юм бэ. Ялыг чангатгаснаар, ялын бодлогыг чангатгаснаар авлигын гэмт хэрэг чинь хэдэн хувиар буурах юм бэ гэдэг ийм статистик тоогоо зарла гэдэг зүйлийг ярьж байна. Тэгэхээр дэлхийн улс орнуудад авлигын индексээрээ хамгийн сайн үзүүлэлттэй Скандинавын хойгийн орнууд, баруун Европын орнуудын туршилагаас үзэхэд эдгээр улс орнуудад нэгдүгээрт rule of law индексээрээ тэд нар тэргүүлж байж авлигын энэ үзүүлэлтүүд нь буурсан. Нэгдүгээрт

Хоёрдугаарт. Эдгээр улс орнуудад эдийн засгийн өсөлт нь 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 10.000 доллароос хэд дахин илүү өндөр болж байж авлигатайгаа их тэмцэлтэй эд нар ахиц гаргасан.

Гуравдугаарт. Эдгээр улс орнууд 1960-аад оноос 1990-ээд оны хооронд төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулах чиглэлээр 30 гаран жилийн эрчимтэй тэмцлийг явуулсны үр дүнд өнөөдөр төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулж

чадсан. Энэ олон цогц арга хэмжээнүүдийг хийсний үр дүнд эдгээр улс орнууд авлигагүй нийгмийг цогцлоож байгаа гэдэг ийм судалгааг бид нар авсан.

Тэгэхээр өнөөдөр зөвхөн Эрүүгийн хуульд ялын бодлогыг чангатгаад, хэргийг хялбаршуулдаггүй болгоод торгуулийн ялыг бүгдийг нь хасаад, хорих ялыг нэмэгдүүлээд, бүх насаар нь нийтийн албан тушаал хаших эрхийг нь хасаад бид нар өнөөдөр энэ Засгийн газар, Төр авлигатай хийх тэмцэлтэй өөрийн гэсэн хүсэл эрмэлзэлтэй байгаа гэдгээ олон нийтэд харуулж байгаа үйлдэл гэдгийг та ойлгох хэрэгтэй.

Хоёрдугаарт дээр дурдсан эдийн засгаа тэлэх, өргөжүүлэх, компаниудынхаа засаглалыг сайжруулах энэ чиглэл дээр бид нар дорвитой алхам хийхгүйгээр зөвхөн ялын бодлогыг цэгцлээд авлигатайгаа 100 хувь тэмцэнэ гээд яривал өрөөсгөл болно.

Монгол Улсын Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийг өргөн мэдүүлээд тодорхой хугацаа болж байна. Энэ хуулийг бид нар яаралтай батлах хэрэгтэй байгаа юм.

Хоёрдугаарт манайх ерөөсөө гуравхан том компаниуд дээр бүтцийн өөрчлөлт хийж, олон нийтэд нээлттэй компани болгож, хувьцааг нь гадаад, дотоодын хөрөнгийн биржүүдээр худалддаг энэ шийдвэрийг яаралтай гаргах хэрэгтэй. Энэ нэг нь “Эрдэнэс монгол” гээд. Эрдэнэс монгол-ын бүтцэд “Эрдэнэс таван толгой” ч байгаа, “Эрдэнэт” ч байгаа, “Монрос” ч байгаа, “Шивээ овоо”, “Багануур” бүгд байгаа. Цаашилаад нөгөө бусад газрын ховор элемент уран чиглэлийн лиценз эзэмшиж байгаа компаниуд бүгд байгаа.

Нэгдүгээрт “Эрдэнэс монгол”-оо хэдүүлээ нээлттэй болгох хэрэгтэй. Засаглалыг нь сайжруулах ёстой. Гаднын бирж дээр хувьцааг нь гаргах ёстой.

2 дахь зүйл бол манайд 2 банк байгаа. Нэгийг нь сая нэвт шувт шалгачихсан Хөгжлийн банк, нөгөөх нь шалгаж амжаагүй байгаа Төрийн банк. Энэ банкнуудаа бүтцийн өөрчлөлт хийгээд нээлттэй болгох ажил хийгдэж байгаа. Ингээд энэ хэдийгээ хийчихсэн тохиолдолд улс төр өөрөө эдийн засгийн сонирхолгүй болж ирнэ. Эдийн засгийн сонирхолгүй болоод ирэхээр төрийн өмчит компаниудыг тойрсон авлигын тэр гэмт хэргийн асуудал үндсэндээ нэг талдаа шийдэгдэнэ. Өөрөөр хэлбэл манаачтай, хянадаг эзэнтэй, засаглал сайтай, зорилготой, ашигтай ажилладаг энэ компаниуд дээр үндсэндээ энэ зүйл арилна гэдгийг би хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя. 1 минут.

М.Оюунчимэг: Эрүүгийн хуулийг нэмэлт, өөрчлөлт оруулж чангатгах, ялангуяа нийтийн албанд болоод өндөр албан тушаалтнуудыг илүү их ингэж болохгүй юм байна гэдэг ёс зүйг суулгах тал дээр энэ хууль бол чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт би итгэлтэй байгаа учраас хурдан, яаралтай гаргах ёстой гэдэг дээр санал нэг байна л даа.

Би өөрөө жишээ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн салбарт ажиллаж байсан хүний хувьд харахад сүүлийн 25 жил харахад авлигын хэрэг хээл, хахууль авсан хэргүүд улам л ихсээд байгаа, гаараад байгаа байхгүй юу. Тэгээд гол учир нь юу байна гэхээр тодорхой нэг хэсэг хүмүүсийг нь шалгадаг, харин асар их мөнгөтэй тэр арын эзэд нь хуулийн хамгаалалтад давхар ороод, тэгээд ийм хүмүүс нь шалгагддаггүй үлддэг, дараа дараагийн хүмүүсээ бэлтгээд л гаргаад ирдэг шүү дээ. Одоо ч гэсэн нүүрсний хулгай дээр иргэд энийг эсэргүүцээд жинхэнэ эздийг нь зарлаадхаач гээд хэлж байна л даа. Тийм учраас бид нар яг энэ дээр жишээ нь Европын холбоонд тэр авлига авсан өндөр албан тушаалтныг шууд газар дээр нь баримттай нь шалгаад зарлаж

байна. Гэтэл өнөөдөр өглөө гишүүд ярьж байна шүү дээ. Жинхэнэ эздийг нь зарлаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Дараа нь шууд Нямбаатар сайд хариулчих.

О.Цогтгэрэл: Авлига албан тушаалын хэргийг чангатгах тухай нэмэлт, өөрчлөлтийг зарчмын хувьд бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Үүний нөгөө талд сая яригдаад байна. Ер нь энэ авлигын асуудлыг чинь хуулийг чангатгах замаар бууруулах уу. Нөгөө талд нь төрийн өмчтэй тэр тусмаа төрийн уул уурхайтай холбоотой компаниудын засаглал ил тод, нээлттэй байдлыг шийдэх замаар иргэдийн хяналтад, иргэдэд хувьцаа очих замаар энэ асуудал шийдэгдэх ёстой юу. Яг одоо эрх баригчид бол энийг яг ингэх ёстой гэдгийг миний мэдэхээр 2020 оноос хойш, тэрнээс өмнө 6 жил ярьж байна. Яг бодит нөгөө үг, үйлдэл хоёрын зөрүү нь их гараад байдаг бодитоороо энэ асуудал хийгддэггүй. Яг өөрсдөө үүнийгээ номлоод ярьдаг. Яг бодит байдал “Эрдэнэс таван толгой”-н Ариунболд гэдэг нөхрийг шоронд орлоо, тэр нөхрийг Ганхуягаар солиод, дахиад саяын шоронд ордог Ганхуяг гэдэг нөхрийг БЭТ гэдэг Ганбат гэдэг нөхрөөр солилоо. Ингээд л яваад байх юм уу. Гоё нээлттэй болгоно, ил тод болгоно гээд л яриад л байдаг. Яг бодит байдал дээр нөгөө 1072 гэдэг хувьцаа чинь яг хаана байгаа юм. Тэр компанийн баланс дээр ч байхгүй, хоосон бичилт хийчихсэн. Жишээ нь Төрийн банк гэж байна. Төрийн банкны 5 хувийг хувьчилж гаргаж байна гэж байна. Тэр төрийн завхарсан банкны 5 хувийн хувьцааг авч хүн ер нь яг яах вэ дээ.

Дахиад хувьчлалын төлөвлөгөө гээд 2020 онд нь баахан юм баталсан. Хэдэн авто зам ашиглалтын хэдэн компани. Яг ийм байдлаар нөгөө ам, ажил 2 маань зөрөөд байна. Нөгөө баялгийн сан гээд дэлхийн жишээг баахан судалсан зүйл

хаачив. Одоо бүр чимээгүй болсон. Ирээдүйн өв сан гээд байгалийн баялгийн хуваарилалтыг шийддэг дэлхийн сайн арга зам жишгийг Ирээдүйн өв сан маань 2023 оны төсвөөр Ирээдүйн өв сангаа бүр 2030 он хүртэлх Ирээдүйн өв сан маань бүр хов хоосон болчихсон. Нөгөө баялгийн хуваарилалт, нөгөө ил тод байдал, иргэдийн хяналт энэ бүх зүйл яриад байдаг. Бодит байдал дээр юу ч байхгүй. Тэгээд Төрийн банкны 5 хувь, Авто зам, засвар арчлалт хувьчилна гэсэн нэг тогтоол цаас, нөгөө 1072 байхгүй. Үгүй ингэхээд баахан хүн залуучууд шоронд яваад байхаас өөр яах вэ дээ энэ чинь. Тэгэхээр яг л энэ асуудал өөрөө тэгээд нөгөө нэг шилэн данс гэдэг юмны хөтлөлт хаана байна? Иргэдийн хяналтад л аваачиж байж энэ авлига, хээл хахууль гэдэг юм чинь буурдаг нь зүгээр л тов тодорхой л асуудал байна шүү дээ. Тэгэхлээр яг энэ асуудлаар энэ асуултаар би уг нь Ерөнхий сайдаас асууж, хариулт авч мэтгэлцье гэж бодож байсан. Тэгэхээр Ерөнхий сайд байхгүй болохоор яг Эрүүгийн хуулийн тухайд нь хэлж ярих зүйл алга. Дэмжиж байна.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Цогтгэрэл гишүүний хэлсэн үгийг сая би сонслоо. Бид нарын яг л энэ нүүрсний хулгай, нүүрсний хулгай гэдэг асуудал олон нийтийн анхаарлын төвд байгаа яг энэ цаг үед бид нар хийх ёстой ажил бол яг л сая таны хэлдэг энэ хэдэн төрийн өмчит компаниудаа хувьчлахыг нь хувьчлаад, олон нийтийн хяналтад оруулахыг нь хяналтад оруулах л ёстой. Бид нар 10 сард Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийг өргөн барьсан. Энэ хуулийн үндсэн концепц нь төр яг ямар ямар бизнес хийхээ тодорхой болгоно. Хийх бизнесээ 4, 4 жилээр төлөвлөнө. Бусад секторуудад хувийн сектортой цуг өрсөлдөхгүй гэдгээ олон нийтэд зарлана. Тэгээд төрийн өмчит компанийн хууль урагшлах алхам илүү хурдтай болж ирж

байна л даа. Өнөөдөр Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий хууль орж ирж байна. Энэ хуультай хамтад нь хосоор нь хэлэлцэж явъя гээд өмнө нь нөгөө хуулиа хэлэлцчихсэн байгаа. Тэгэхээр саяын таны хэлсэн дээр санал нэг байгаа. Ер нь саяын “Эрдэнэс таван толгой” компани дээр бүрэн эрхт төлөөлөгч тавьж байгаагийн гол үндсэн зорилго бол олон улсын нэр хүнд бүхий аудитын компанийг оруулж, дараа нь зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулж олон нийтэд нээлттэй ийм хувьцаат компани болгох энэ чиглэлээр Засгийн газар дээр дурдсан “Эрдэнэс Монгол”-ын бүтцийн бараг ихэнх компаниуд дээр ийм бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байгаа гэдгийг танд хэлье.

Г.Занданишатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Монгол Улсын Засгийн газраас өнөөдөр үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдсон хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай горимоор Улсын Их Хурал хэлэлцэж байна. Энэ нөхцөл байдалд уялдуулж асуудлыг шийдэх нь зөв хэдий ч зөвхөн энэ уялдсан нөхцөл байдалтай холбогдуулж аливаа асуудлыг гаргадаг ийм асуудал цаашид байх уу, үгүй юу. Одоо энэ эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн ялангуяа авлигын гэмт хэрэг үйлдсэн, түүнтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа, хялбаршуулсан журам, ял шийтгэл оногдуулах үндсэн зарчмууд чинь байж л байсан. Энийг чангатгах, түүнчлэн энэ дээр гарсан хууль хэрэглээний үндсэн ойлголтууд түүнтэй холбоотой асуудлууд шийдэгдэх энэ хуулийн төсөл дэмжих асуудлын нэг гэж ойлгож байгаа. Бид өнөөдөр энэ асуудлыг шийдэж байж авлигатай Монголын төрд тэмцэх авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах нь зөв хэдий ч Монгол Улс Хүний эрхийн конвенцод нэгдсэн улс. Хүний эрхтэй

холбоотой, хууль эрхийн хэрэглээтэй холбоотой асуудлуудыг бид цаашидаа хэлэлцүүлгийн явцад ярьж, шийдэх асуудал байх гэж бодож байна.

Түүнчлэн энэ үүссэн нөхцөл байдалтай холбоотой эрүүгийн ял шийтгэлээ чангатгах юм байж. Тэгээд дахиад асуудал гээд тогтолцооны асуудал, Үндсэн хуулийн асуудал, Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмье, намын жагсаалт оруулъя гэдэг ийм юм руу цаашидаа явах ийм асуудал гарч ирвэл бид хэзээ ч зөвшөөрөхгүй шүү.

Дээр нь өнөөдөр хөөн хэлэлцэх хугацааны тухай нэг асуудал байдаг. Монгол Улсын Үндсэн Хуулийн цэц хөөн хэлэлцэх хугацааг тооцно гэдэг асуудлыг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан байгаа. Өнөөдөр хөөн хэлэлцэх хугацаатай асуудал бол парламентад сүүлийн 2, 3 жилийн хугацаанд Энхбаяр гишүүн, Раднаасэд гишүүн 2-ын хооронд бөөн маргаан тэмцээн болж ирсэн. Гэтэл өнөөдөр Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцийн дүгнэлтээр хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэнэ гэсэн. Тэгээд сүүлд нь Монгол Улсын Дээд шүүх нэг тайлбар гаргаад, хэрэглэж болохгүй гэсэн ийм зөрөлдөөн байдаг юм шиг байгаа юм. Энийг нь хууль санаачлагч шүүхэд энийг алийг нь барих юм. Би буруу ойлгоод байна уу, зөв ойлгоод байна уу. Буруу юм ярьсан бол бас та нар авах гээхийн ухаанаар хандаарай. Ийм асуудал бол өнөөдөр ардчилсан төрт, хууль дээдлэх зарчим, хууль шүүхийн өмнө тэгш байх, шударга шүүхээр шүүлгэх энэ асуудал чинь яригдах ёстой шүү гэдэг ийм санал бодолтой байна.

Аливаа нэг тэмцэл хөдөлгөөн нийгэмд учирсан гэмт үйлдлийг засахын тулд хууль хэрэглээний эрүүгийн хэрэг, бусад гэмт хэргийг шийдэж ирсэн үзэл баримтлал үндсэн концепц дээр энийг тохируулж явах ёстой гэдэг ийм санал бодолтой юм байна.

Г.Занданшатар: Үг хэллээ.
Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Нямбаатар сайд аа, хөөн хэлэлцэх хугацааны асуудал байдаг. Та, Раднаасэд, Энхбаяр 3 бие бие рүүгээ шидээд л яваад байдаг ийм зүйл байгаа. Тэгээд би Хууль зүйн байнгын хороо дээр бараг 30 минут аягаар нүдэж байж, эсэргүүцэл илэрхийлж байгааг санаж байгаа байх. Тэгээд өнөөдрийн энэ хууль дээр чинь бас эсэргүүцэхээс өөр аргагүй заалт ороод ирчихсэн байж байна. Тэгээд энэ орж ирж байгаа өөрчлөлтөөр 17.1.8-аараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийнхаа 17.1.8-аар хэрэг хялбаршуулахгүй гэхэж байгаа юм. Сайн байна. Хүмүүс 40 сая төгрөгөөр торгуулаад ингээд яваад байгааг болиулж байгаа юм байна. Гэтэл 17.1.6-аар гэм буруугаа хүлээсэн хүнд тэгээд гэмт хэргийг нотолсон хүнийг Эрүүгийн хуулийн 6.7-оор ялыг нь хөнгөрүүлэх тухай заалт чинь хэвээрээ байж байна шүү дээ. Би тэгээд өнөөдөр энэ нүүрсний гэмт хэрэг дээр би жишээ яриад өгье. Ганхуяг гэдэг хүн жишээ нь шоронд сууж байгаад баахан хүмүүсийг ийм, тийм гээд бүгдийг нь мэдүүлэг өглөө. Тэгэнгүүт бүх гэмт хэргүүд ийм ийм гэм хэрэг гээд мөрдөн байцаагч нь асуунгуут бүгдийг нь нэрлээд тэгсэн, тэгсэн гээд хэлчихлээ. Тэгэнгүүт тэр хүний хэргийг ямар ч байсан энэ хуулийн өөрчлөлтөөр бол хялбаршуулахгүй юм байна. Тэгэхдээ шүүх дээр очоод нөгөө хүнийг чинь нийтийн албан тушаалтан их хэмжээний хохирол учруулсан бол 2-8 жил гээд байж байна шүү дээ. Тэгээд 2-8 жил гэж байна. Тэгэхээр энэ хүнийг чинь буцаагаад тэр 6.7-оор гэмт хэргээ нотлоод, хохирлоо барагдуулчихсан бол тэнсэн харгалзах ял өгөх боломжтой ийм заалт явж байна шүү дээ. Хэдэн их наядаар нь гэмт хэрэг үйлдэж, завшигчаад, улс орныг тоночлоод, тэгээд тэнсэн харгалзах ял руу очоод аль эсвэл хамгийн бага 2 жилийн ял руу оччихоод, тэгээд 1 жил суугаад гараад байх ийм боломжийг энэ хууль чинь өгч байна шүү дээ.

Тэгээд өнөөдөр та нар бид нар сайн санаад жагсагчдын саналаар юмнуудыг хааж байж болно. Гэтэл наадах шүүгч чинь, прокурор чинь наадхыг чинь цоорхойг бүгдийг нь ашиглана шүү дээ. Цоорхойгоо нөхөөд, нөхөөд явахгүй бол тэгээд бүх боломжийг нь өгдөг, бүх гэмт хэрэгтнүүд хуулийн цоорхойгоор гардаг. Гарангуут нь энэ баталсан хууль нь ийм тийм гээд энэ парламент руу чинь чулуу шидээд байна шүү дээ.

Тэгээд 2015 онд орж ирсэн тэр хуулийг 2017 онд бүгдийг нь баахан цоорхойтой болгочлоод тэр цоорхойгоор нь шүүхийнхэн баахан юм шийддэг. Хуулийнхан тэрүүгээр заримыг нь хонгилдоод, заримыг нь хурдан шийдвэрлээд гардаг ийм л зүйлийг хийж байгаа шүү дээ. Энэнээс чинь болоод парламентын нэр хүнд унаж байгаа. Тийм учраас хуулийнханд, ялангуяа шүүхийнхэнд ийм цоорхой ерөөсөө олгож болохгүй. Энд сайхан ялыг нь жоохон томруулаад, тэр нөгөө нэг торгох ялыг багасгаад юу гэдэг билээ. Зорчих эрхийг хязгаарлах энэ ялуудыг байхгүй болгосон ч гэсэн үүний чинь хажуугаар тэр 6.7-оор бүгдийг нь тэнсэн харгалзах ялаар гаргачих ийм боломжтой болж байна шүү дээ. Ганхуяг та нарын нэрийг хэлэхээс айгаад бушуухан шиг тэр мөрдөн байцаагчид бүх юмаа хэлээд, бушуухан шиг дээр прокуророор хянуулаад, хурдан шиг шүүх дээр очоод тэгсэн байна, тэгсэн байна, тэгсэн байна гээд шүүхээр шийдвэрлүүлээд, давж заалдахгүйгээр ингээд л нэгхэн жилийн ял эдлээд гараад байх ийм боломжийг энэ хуулиар олгож байна шүү дээ. Тийм учраас Байнгын хороон дээр би энэ 17.1.6 дээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Батаагийн Батцэрэн. 80.

Б.Батцэрэн: Улсын дээд шүүхийн шүүгч Батцэрэн. Пүрэвдорж гишүүний

асуултад хариулна. Тэнсэх журмыг Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд тусгайлан хуульчилсан. Тэнсэх журмыг зөвхөн 1-5 жил хүртэл хорих ялтай хэрэг дээр л хэрэглэж болдог. Үндсэн нөхцөл нь гэм буруугаа хүлээсэн байх, хохирлоо төлсөн эсвэл бодитой нөхөн төлөхөө илэрхийлсэн байх. Эдгээр шаардлагууд хангагдсан байвал тэнцэх журмыг хэрэглэж болдог. 2-8 жил хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг дээр тэнцэх журмыг 6.7-д заасныг баримтлан хэрэглэх боломжгүй. Ийм хариулт өгье. Ер нь хялбаршуулсан журмаар прокурортой ялаа тохиролцоод ирж байгаа хэргийн хувьд шүүх шууд баталж өгөхгүй л дээ. Процессын хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар нэгдүгээрт гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон юм уу гэдгийг заавал шалгаж үзнэ. Өөрөөр хэлбэл гэмт хэргээ хүлээсэн тэр мэдүүлэг нь бусад нотлох баримтаар хөдөлбөргүй нотлогдсон байх ёстой.

Хоёрдугаарт энэ нотлогдсон хэргийн нөхцөл байдалд прокурорын сонсгосон тэр зүйлчлэл тохирсон уу гэдгийг давхар шалгаж үзнэ. Тэгээд прокурорын санал болгосон ялын төрөл хэмжээг хүлээн зөвшөөрсөн үү. Дээр нь учруулсан хохирлыг, хор уршигийг, дээр нь бусад үр дагавар буюу гэмт хэргийн орлогоо гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгслүүдээ хураалгах, эдгээрийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд 6.7 дугаар зүйлийг хэрэглэх хууль зүйн боломж нээгдэж байгаа юм.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг. 81.

П.Сайнзориг: Пүрэвдорж гишүүний асуултад нэмж хариулъя. Одоогийн байгаа хуулиа ч тэр, энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ч тэр өнөөдрийн нийгэмд үүсээд байгаа яригдаад байгаа гэмт хэргүүд дээр тэнсэх бололцоо байхгүй. Байхгүй. Тэнсэх бололцоо нь юу вэ гэхээр 5 түүнээс доош жилийн хорих ялтай ийм гэмт хэрэг дээр энэ асуудал яригддаг. Өнөөдрийн нөхцөл

байдлуудыг яригдаж байгаа гэмт хэргүүд буюу 2-8 жил, 5-12, 12-20 жилийн асуудалтай гэмт хэргүүдэд нийгэмд яригдаж байх шиг байна. Тэгэхээр. Энэ хүрээндээ угаасаа тэнцэх гэдэг бололцоо байхгүй. Энэ дээр гишүүд маань мэдээллийг зөвөөр илэрхийлээсэй гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт ер нь 6.7-г яагаад хөндсөн бэ гэхээр хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагааг тасралтгүй хийж ирж байгаа юм. Мааш их цаг хугацаа болон зардал мөнгөөр хийдэг. Гэтэл яг эцсийн мөчид шүүх шилжүүлэх болохоор ийм ийм асуудлууд байна гээд илэрхийлдэг. Тэгэхээр энэ дээр бид нар энэ хэрэг хянан шийдвэрлэх анхнаасаа мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нь нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан гэж тодотгож оруулж ирж байгаа юм. Анхнаасаа хууль хүчний байгууллагатай хамтарч оруулаад, хамтарч ажиллаад, шуурхай шийдүүлэх талаас нь нотлох баримтуудыг гаргаж өгсөн юм уу эсвэл тэр үнэхээр ард нь байгаа хүмүүсээ зааж өгсөн ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг л бид нар тодотгож энэ дээр оруулж ирж байгаа юм. Тэгэхээр энийг бас тодруулж хэлэх нь зөв байх.

Хоёрдугаарт Пүрэвдорж гишүүн хэлж байсан. Тэгээд тодорхой тусгай ангиудын гэмт хэргүүдээс зөвхөн зорчих эрхийг ч юм уу бусад юм нь үлдчих юм биш биз дээ гэж. Тийм зүйл байхгүй байгаа. Улс төрд нөлөө бүхий буюу ерөнхийдөө хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн дээрээс торгох ялуудыг бүгдийг нь авсан байгаа. Бүгдийг нь авсан. Одоо зөвхөн хорих ялтай. Тэгэхээр хорих ялын интервал дотор тодорхой хэмжээний нөхцөл байдлыг хохирлоо төлсөн ч гэдэг юм уу, эргээд гэм буруугаа хүлээж байгаа ч гэдэг юм уу ийм зүйлүүдийн юм байлгаж энэ интервал дотор шүүх энэ хуулийг хэрэглэх гарц нь угаасаа Эрүүгийн.../минут дуусав/

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: 22.1.2-оор хуучин 1-5 байсан юм байна. Одоо энэ шинэ өөрчлөлтөөр 2-8 болгож байгаа юм байна. Тэгэхээр 6.7.1.3-аар хамгийн бага ялаас 50 хувиас доошгүй өгнө гэж байгаа юм. Тэгэхээр наадах чинь Ганхуягийг 1 жилээр ял өгөх нь байна шүү дээ. Тэгээд л шоронд 6 сар суугаад л гараад ирэх нь байна шүү дээ. Ийм юм гэж юу байдаг юм бэ. Та нар ингээд боль л доо та нар. Шүүхийнхэн чинь бүгдийг нь, прокурорынхон чинь бүгдийг нь, хуулийнхан чинь бүгдийг нь тэр цоорхойгоор нь явуулна шүү дээ. Боломжгүй гэж энэ 6.7 чинь тийм заалттай шүү дээ. Хохирлоо нөхөн төлсөн бол, гэмт хэргийг нотолсон бол, тэрийгээ хүлээн зөвшөөрсөн бол 2-8 жил гээд өөрөөр хэлбэл 22.1.2 чинь 2-8 жил ял өгнө. Ганхуяг чинь улс төрд нөлөө бүхий.../минут дуусав/

Г.Занданишатар: Пүрэвдорж гишүүн ээ. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдож ял оноох болохоос биш танхимд ял оноохгүй шүү дээ. Хишгээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Пүрэвдорж гишүүн ээ, хэдүүлээ энд нэгдүгээрт Улсын Их Хурлын чуулганы индэр бол хэн нэг хүнийг ялладаг шүүх хурлын танхим биш.

Хоёрдугаарт ийм сенсац тарьж үндэслэлгүй мэдээлэл тараадаг зүйл ч биш.

Улсын Их Хурлын гишүүн хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэдэг зүйлийг нэлээн явцууруулмаар байна. Өөрөөр хэлбэл 6, 7 авлигын гэмт хэрэг тэр дундаа 22.1, 22.4 энэ тэрд ерөөсөө огт хамаарахгүй. 22.1.3-ын ялын хэмжээ чинь 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж байгаа шүү дээ. Тэгэхээр наад 6, 7 чинь 5-аас доош жилийн ялтай хэрэг дээр л үйлчилнэ гэж байгаа юм. Тэгэхээр авлигын хэрэг дээр 6,

7-г хэрэглэхгүй гээд би тодорхой хэлчихье. Чи юугаа мэддэг юм бэ Пүрэвдорж оо. Чи юугаа мэддэг юм чи. Ойлгомжтой хэлээд байна шүү дээ. Бүх хуульчид хэлж байна шүү дээ. Авлигын хэрэг дээр авлигын хэрэг.../минут дуусав/

Г.Занданишатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Энэ удаагийн Их Хурал үнэхээр бүрэн эрхийнхээ 60, 70-аад хувийг нь өнгөрөөж байна л даа. Улс, эх орныхоо төлөө ч их олигтой ч юм хийсэнгүй. Их Хурлын гишүүн болсноосоо хойш Оюутолгойн түр хороо, Эрдэнэтийн 49 хувь, Дарханы төмөрлөг, Хөтөлийн цемент, Хөгжлийн банк, Нүүрсний асуудал гээд л өнгөрсөн 30 жилийн хулгайтай ноцолдсон ийм ажлын хэсэг, дэд хороо ийм юмнуудад орсоор байгаад л дийлэнх хугацаагаа өнгөрөөж байна л даа. Энэ Их Хуралд ер нь бүтэн нэртэй хүн ч үлдсэнгүй. Нийгмээрээ л Их Хурлын гишүүдийг бүгдийг нь л үзэн ядаж байна. Гэхдээ өнөөдөр юунд өөдрөг сууж байна гэхээр энэ асуудлуудыг гаргаж ирснээрээ цаашид нууц гэдэг гэрээ нэрийн доор хэзээ ч хулгай хийх боломжгүй болгож байгаа даа, Оюутолгойгоос тавигдсан байсан 2.4 тэрбум долларын өрнөөс салсан даа, цаашид олон төрлийн хулгайнуудыг, ирээдүйд гарч болох олон хулгайнуудаас урьдчилан сэргийлж байгаадаа л өөдрөг сууж байна. Тийм учраас энэ удаагийн Их Хурал, Засгийн газар бол одоо хэдийгээр нийгэмд үзэн ялагдаж байгаа ч гэсэн түүхэнд үлдэнэ гэж би найдаж байгаа юм. Үүний дагуу ч гэсэн нийгмийн шаардлагаар Эрүүгийн хуулийн 22.1 гээд нийгмийн шаардлагаар л улс төрчид хоорондоо хэрэлдээд л баталж байна л даа энэ хуулийг батлах нь. Гэхдээ энэ хуулийн заалтууд өмнө нь байсан. Би энд байгаа Дээд шүүхийн шүүгчид прокуроруудаас асуух гээд байгаа юм. Энэ зүйл ангиар өмнө нь ер нь хэр олон хүмүүс шийдэгдэж байсан юм. Өнөөдөр хуулиар Их Хурлын танхимд байгаа Их Хурлын гишүүдийг, төрийн өндөр албан

тушаалтнуудыг шийднэ л гэж бодоод байгаа л даа бид нар. Гэхдээ яг нарийндаа бол Их Хурлын гишүүд чинь шийдвэр гаргадаг хүмүүс биш шүү дээ. Нэг ч гэрээ дээр ч юм уу, шийдвэр дээр гарын үсэг зурахгүй. Явж явж байгаад энэ хуулийн зүйл ангиар хэн ялагдах вэ гэхээр нөгөө хэдэн сумын дарга нар, сумын Иргэдийн хурлынхан, хэдэн төсөвт байгууллагуудын нөгөө сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нар, төсвийн нягтлангууд л энэ зүйл ангиар чинь ялагдах байхгүй юу. Тэгэхээр зэрэг өмнө нь яг энэ зүйл ангиар хэчнээн хэрэг үүсгэгдээд, энд нь яг улс төрд нөлөө бүхий хэчнээн хүн ер нь шийдэгдсэн юм бэ? Энэ зүйл ангиар эсвэл төрийн албан хаагчдаас хэчнээн хүн ямар хэмжээний шийтгэл аваад байгаа талаар тодорхой мэдээлэл өгөөч ээ.

Тэгэхээр энэ дээр би юу хэлэх гээд байна гэхээр цаашидаа улс төрд нөлөө бүхий этгээд гэдгээс гадна нийтийн албаны энэ хуульд хамрагдах хүмүүсийнхээ хамаарлыг жоохон ялгаж өгөхгүй бол энэ хуулийн чинь үйлчлэлийн доор олон төрийн албан хаагчид хэлмэгдэх ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр ийм ноцтой хуулиудыг оруулж ирэхийн өмнө яг энэ хуулийг хэрэглэж байгаа шүүхийнхэн, прокурорын байгууллагынхан, мөрдөх байгууллагынхны саналуудыг маш сайн судалж байж, энэ хүмүүсийн үгийг сонсож байж Хууль зүйн яам хуулийн төслүүд оруулж ирдэг байхгүй бол сэтгэлийн хөөрлөөр, нийгмийн шахалтаар том том хуулиуд орж ирдэг. Энэ хүрээнд нь хэлмэгдэх сүүлдээ цаашидаа төрийн албанд ажиллах хүнгүй болох ийм хэмжээнд ч хүрч магадгүй. Тэгэхээр энэ дээр бас прокурор, шүүгч, шүүхийн байгууллагаас орж ирж байгаа төлөөллүүдийн санаа бодлыг сонсьё гэж бодож байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 82. Максимын Чинбат Ерөнхий прокурорын орлогч. Төрийн хууль цаазын зөвлөх.

М.Чинбат: Ганболд гишүүний асуултад Ерөнхий прокурорын орлогч Чинбат хариулж байна. Эрүүгийн хуульд улс төрд нөлөө бүхий этгээд гэдгийг бол тайлбарласан байгаа. Тэгээд улс төрд нөлөө бүхий этгээдээс эрүүгийн хариуцлага хүлээсэн байдлыг 2020, 2021, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар бид судалгааг нь гаргасан. Энэ 3 жилийн байдлаар 16 хэрэгт 16 шүүгдэгч ял шийтгүүлсэн. Энд шийтгүүлсэн ялыг нь төрлийг нь аваад үзэхэд ялаас чөлөөлсөн 1 хүн хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан байна. Тэнсэгдсэн хүн байхгүй. Торгох ялтай 8 хүнд 12-40 сая төгрөгийн торгох ял шийтгэл оногдуулсан. Зорчих эрхийг нь хязгаарлах ял оногдуулаагүй. 7 хүнд 1.6-4.6 жилийн хорих ял оногдуулсан байна.

Г.Занданшатар: Одоо Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна.

Х.Булгантуяа: Жагсагчид ямар ч байсан тодорхой үр дүнд хүрч байна. Бид нар хэр их мөнгө “Эрдэнэс таван толгой”-н том хулгайгаас алдсан юм бэ гэдгээ ядаж хэдэн талаасаа нэгтгээд сууж байна. Өнөөдөр Эрүүгийн хуулиа чангатгая гээд ороод ирж байгаа нь сайн байна. Төрийн өмчит компанийнхаа засаглалыг сайжруулахгүй бол дараа нь хэн ч очоод ахиад хээл хахууль авах, хулгай хийх боломж нь бүрдчихсэн байна гээд энэ бүгдээ засаад суух гэж байгаа нь сайн байна. Тэгээд хүмүүс яг ингэдэг юм. Улсын Их Хурлын гишүүд яг өнөөдрийг болтол юу хийж байсан юм бэ гэдэг асуудлыг ярьдаг юм. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд уг нь яг л жирийн ард түмний төлөөлөл болж энд суугаад, асуулт асуугаад, хууль батлаад явах үүрэгтэй. Хэрвээ надад ямар нэгэн удирдамж байхгүй бол жишээлбэл би өнөөдөр Төрийн банк дээр очоод алив тайлан балансаа гаргаад ир. Би Их Хурлын гишүүн байна. Би наадхыг чинь шалгана. Алив та нарт ямар шийдвэр гаргасан тэр ТУЗ-ийн шийдвэрийг гаргаад ир. Би шалгана гэдэг эрх надад байхгүй. Надад удирдамж эндээс ажлын

хэсэг Улсын Их Хурлаас гаргаагүй л бол тийм эрх байхгүй. Эсрэгээрээ аягүй бол Улсын Их Хурлын гишүүн өөрийнхөө давуу эрхийг ашиглаж би төрийн өмчит компанийн ч байдаг юм уу, төрийн шийдвэрт эсрэгээрээ буруу нөлөөлөх гэлээ, өөртөө ашигтай байдлаар нөлөөлөх гэлээ гэдэг ийм хардлагад өртдөг юм. Уг нь ингэх гэж тэнд Төлөөлөн удирдах зөвлөл гэж бүхэл бүтэн бүтэц байгаад, зарим нь нэмэлт цалин авч байгаа, машин унаж байгаа, хангамжтай байгаа. Уг нь тэгэх гэж тэнд нэг хэсэг хүмүүс аминдаа байгаад байгаа юм.

Гэхдээ би энэ хуулийг бас ялангуяа эрүүгийн хуульд бол эрэмдэг, зэрэмдэг байдлаар битгий гар хүрээсэй гэж хүсэж байгаа юм. Би энэ удаагийн хуулийн өөрчлөлт бол зөвхөн өнөөдөр хэдэн хүмүүсийн хэргийг чангатгахдаа биш, авлига, хээл хахуулийн хэрэгтэй тэмцэх гэдэг том өнцгөөс харж оруулж ирээсэй гэж хүсэж байгаа юм.

Өнөөдөр Монголчууд сая Сүхбаатарын талбай дээр жагсаж байгаа нь байгаа нь ганцхан нүүрсний хулгайтай ч биш. Юмны үнийг буулгах дээр, Орос Украины дайныг болиулж чаддаггүй юм бол, өмнөд хөршийнхөө ковидтой тэмцэж чаддаггүй юм бол ядаж авлига, хээл хахуультайгаа тэмцчихээч л гэж хүсээд байгаа юм. Тэгэхээр би нэгдүгээрт 22.5 дээр иргэд өнөөдөр ямар нэгэн байдлаар шударга бустай нүүр тулаагүй иргэн гэж ер нь байхгүй. Ядаж төрөхдөө хуучин набор өгдөг байсан. Одоо бол бүр больсон. Сувилагч, эмчдээ хэдэн зуун мянган төгрөг, хэдэн төгрөг атгуулж байж төрөхөөс өөр аргагүй болдог. Хүүхдээ сургууль, цэцэрлэгт өгөх гэж хэдэн төгрөг хэн нэгэнд дандаа төрийн албан хаагчдад, төрийн албан тушаалтнуудад өгөхөөс өөр аргагүй болдог. Жижиг нь жижиг, дундах дунд, том нь томыг өнөөдөр аваад байгаа учраас иргэн миний карманаас нийгмийн даатгал татвараар бараг 1/3-ийг шууд цалин дээрээс нь

суутгаж авчхаад, ахиад би яагаад мөнгө төлөх ёстой юм бэ гээд уурлаад байгаа юм.

Тэгэхээр иргэд хахууль өгснийхөө төлөөгөөр энэ хуулиар бол 27 саяас 100 сая төгрөгийн торгууль төлөх юм байна. 6 жилээс 3 жил хүртэл хоригдох юм байна. Ингээд бизнес эрхэлдэг байсан бол бизнес эрхлэхийг нь болиулах юм байна. Тусгай зөвшөөрлийг нь авах юм байна. Тэгэхээр өнөөдөр хэн энэ хээл хахуулийн эсрэг шүгэл хүлээх юм бэ. Эсрэгээрээ том нь том, жижиг нь жижиг, дундах дунд хэмжээний энэ хээл хахуулийн эсрэг авлига, хээл хахуулийн эсрэг бид нар шүгэл хүлээх эрхийг олгооч. Иргэдэд өнөөдөр хахууль өглөө гэдэгт нь хэрвээ шоронд орох юм бол хэн үүнийг илчлэх юм бэ. Одоо энд ямар хээл, хахууль авлигын хэргүүд илчлэгдэж байна.

Нэгдүгээрт та бүхэн маань үүн дээр мэдээлэл өгөөч. Би сая та бүгдийн танилцуулгыг харлаа. Магадгүй нэг улс төрийн албан тушаалтан нөгөө өөрийнхөө өрсөлдөгч улс төрийнхөө албан тушаалтан агнах гэж ингэж байж магадгүй. Тэрнээс биш жирийн иргэн би халамжид амрагдахынхаа төлөө хэдэн бондгор аарц өгснийгөө би хэзээ ч мэдээлэхгүй шүү дээ. Яах юм хэн тэрний төлөө 27 сая төгрөгөөр торгуулах юм. Хэн тэрний төлөө өнөөдөр 3 жил шоронд суухыг хүсэх юм. Тэгэхээр хэрвээ иргэн болгон та авлига өгөхийг хэрвээ хэн нэгэн шаардсаныхаа төлөө эс үгүй бол та өгчих, тэгээд дараа нь та өөрөө үүнийг мэдээллээ. Танд ямар ч ял шийтгэл байхгүй ингэх юм бол энэ харин авлигатай тэмцэж чадаж байгаа юм. Энэ бол жинхэнэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Булгантуяа гишүүн ээ. Хэдүүлээ яг чуулганы индэр дээрээс нэг ийм эрх зүйг үгүйсгэх үзлийг бүгд дэвэргэж ярьдгийг л хэдүүлээ болимоор байгаа юм. Бүх газар эмнэлэг ч тэр,

сургууль ч тэр дандаа авлига авч байгаа юм. Энэ болгонтой чинь тэмцэл явуулаад боловсролын салбарт чинь энэ намар харьцангуй дэвшил гарсан шүү дээ. Одоо яг та сая гэмт хэрэг нуун дарагдуулсан болно шүү. Аль төрөх эмнэлгийн хэн гэдэг хүн, хүн төрөхөө очиход нь мөнгө нэхсэн юм. Тэрнийх нь мөрөөр бид нар шалгамаар байгаа юм. Энэ чуулганы индрээс бид нар аль болох бодит зүйлүүдийг ярих, гэмт хэргийн талаарх мэдээлэл байвал түүнийгээ шалгуулах энэ чиглэлээр л яримаар байгаа юм. Өнөөдөр Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт хээл хахууль өгөх гэдэг гэмт хэрэг байгаа. Энэ конвенцоороо ч тэр янз бүрийн дарамт шахалтад ороод хээл хахууль өгөх гэмт хэргийн субъект болсон тохиолдолд хэргээ мэдүүлээд үнэн зөвөө хэлээд, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулдаг ийм журам зохицуулалт хэвээр л үйлчилж байгаа юм.

Сая бид нар анх оруулж ирсэн төслөөрөө хээл хахууль өгөх гэмт хэрэг дээр хэрэг хялбарших нөхцөлийг хэвээр үлдээе гэдэг ийм байр суурьтай ярьж байсан. Өөрөөр хэлбэл өгөх гэмт хэрэг нь өөрөө хэргээ илчилж, илэрхийлж тодорхой дарамт шахалтын улмаас нийтийн албан тушаалтнаар үйлдэл хийлгэх эсвэл үйлдэл хийлгэхгүйн төлөө өгсөн үйлдлээр илэрдэг учраас өгсөн хүмүүст илүү ял шийтгэлийн бодлогоороо бид нар хөнгөлөлт үзүүлж байх ёстой гэдэг ийм зарчим, байр суурь дээр байгаа. Зүгээр бид нар ер нь цаашидаа ерөөсөө л авлигатай тэмцэх хамгийн том тэмцэл бол эдийн засгийн өсөлт. Тэгээд цаашиа эрүүл мэнд, боловсролын салбарын том тогтолцооны шинэчлэлийг л бид нар хийх ёстой шүү дээ. Ингэхгүй зөвхөн ялын бодлогоор өнөөдөр авлигатайгаа 100 хувь тэмцээд, үр дүнд хүрчихсэн улс байхгүй.

Маш олон улс орнууд авлигын шүүх байгуулж үзсэн байгаа. Харамсалтай нь өнөөдөр тэдгээр улс орнууд авлигынхаа ялын бодлогыг чангатгаад, шүүх

байгуулаад тэмцэлд олигтой үр дүнд хүрсэн зүйлүүд байхгүй. Харин Скандиновын хойгийн орнуудын авлигатайгаа хийсэн тэмцэл бол ерөөсөө л эдийн засгаа том, үр дүнтэй өсгөөд эрүүл мэнд, боловсролынхоо салбарыг сайжруулаад цаашиаад төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулсан.

Би түрүүн хэлсэн шүү дээ манайх ерөөсөө хоёр, гуравхан төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулаад, олон нийтийн публич компани болгочих юм бол энэ ерөөсөө төрийн өмчит компани руу хүн очиж томилогдъё гэж гуйдаг, намын сонгуулийн дараа, улс төрийн сонгуулийн үр дүнгээр гүйцэтгэх удирдлага нь солигддог ийм тогтолцоо үндсэндээ бүрэн халагдах ёстой шүү дээ. Ингэж байж л бид нар авлигатайгаа бодитой тэмцэнэ. Батзориг доктор саяын Булгаа гишүүний асуултад хариулья.

Г.Занданшатар: 83. Бадамын Батзориг. Хуульчдын холбооны гишүүн, доктор, профессор.

Б.Батзориг: Тэгэхээр Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл хахууль өгөх гэмт хэргийн тайлбар дээр ийм заалт байгаа. Хясан боогдуулах замаар хахууль өгсөн байх юм бол өөрөө сайн дураараа хэргээ илчилбэл хариуцлагаас чөлөөлөөд зогсохгүй, тухайн төрийн үйлчилгээг хэвээр нь үлдээнэ гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл ямар нэгэн зөвшөөрөл авсан байх юм бол тэр нь хэвээрээ. Сайн дураараа илчлэх юм бол хариуцлагаас чөлөөлнө гэж байгаа юм. Санаатай хахууль өгөөд, тэгээд тэр хүн маань өөрөө хэсэг хугацааны дараа хэргээ хүлээгээд ирэх юм бол ялаас чөлөөлнө. Тэгэхээр ямар нэгэн байдлаар төрийн үйлчилгээг хясан боогдуулах замаар авсан тохиолдолд хэргээ Авлигатай тэмцэх газарт илчилж очвол ямар ч хариуцлага байхгүй. Одоо хуулийн зохицуулалт хэвээр байгаа. Үүнийг хөндөөгүй байгаа. Тэр битгий хэл төрийн авсан үйлчилгээг нь хэвээр нь

үлдээнэ гээд хуулийн заалтад заачихсан энд бол хөндөөгүй.

Г.Занданишатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн .

Х.Булгантуяа: Би өргөн барьсан хахууль өгөх гэдэг хэсгийг л уншаад энэ бол яг л тэгж л ойлгогдож байна. Хахууль өгөх нь ч гэсэндээ чангарсан юм байна. Тэгээд үнэнийг хэлэхэд мөнгөтэй хүн ч гэсэндээ ер нь нэмж хүнд мөнгө өгье гэж бодохгүй байх л даа. Аргаа бараад л хахууль өгч байгаа байх. Аргаа бараад л хахууль өгч байгаа байх. Тэгээд өнөөдөр иргэдийн бухимдаад байгаа нь сая Нямбаатар сайд хаана байгаа юм тэр хахууль чинь гээд. Тэгээд огт хахууль байхгүй гэж Хууль зүйн сайд маань эсвэл үзэж байгаа юм уу. Өнөөдөр төрийн байгууллагуудад шат шатандаа бухимдал их байна. Хавчиж байгаа зүйлүүд их байна гэж иргэд яриад байгаа учраас хахууль өгсөн хүн нь хахууль өгч байгаа хүн маань өнөөдөр давхар 27-100 сая төгрөг торгуулдаг, 6 сараас 3 жил хүртэл ял эдэлдэг байх юм бол хэн энэ хахуулийг илчлэх юм бэ л гэж л яриад байгаа юм л даа. Тэгээд би танай шүгэл үлээгчийн хуультай чинь ч гэсэндээ зөрчилдсөн ийм юм давхар болчихоод байгаа юм биш биз дээ гэж л .../минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Батсүхийн Саранчимэг гишүүн.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр Эрүүгийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын эдийн засагт төрийн өмчийн компаниудын эзлэх байр суурь асар их байгаа. Тэгээд үүнийгээ дагаад томоохон уул уурхайд суурилсан төрийн өмчит компаниудын авлига, хээл хахууль, албан тушаалын шинжтэй гэмт хэргүүд өсөхгүй бүр асар их тоогоор, асар их мөнгөөр яригдаж байгаад үнэхээр харамсалтай байна. Тэгээд өнөөдөр гадаа жагсаалынхан ч гэсэн

энийг илчил, ил тод байлга гээд байгаа энэ цаг үед ч гэсэн бид нар Улсын Их Хурлын гишүүнийхээ үүргийн дагуу хуулийн төслийг хэлэлцээд, энэ дээр ажиллаж байгаа. Тэгээд цаашидаа бид нар энэ асуудлыг дахиж гаргуулахгүй байхын туд яах вэ гэвэл бид нар ил тод л байх ёстой. Энэ компаниудын үйл ажиллагаа, ашиг орлого, санхүү бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой. Тийм учраас бид нар ил тод байдлын тухай хууль дээр Засгийн газар анхаараад, яаралтай оруулж ирэх шаардлагатай байгаа юм.

Тэгэхээр энэ хууль хэзээ орж ирэх вэ. Бид нар ер нь бол нууц байж байгаад л энэ хулгайч нь гараад, нууц биш ил байсан бол өнөөдрийн ийм байдалд хүрэхгүй гэж үзэж байгаа учраас энэ хуулиа хурдан оруулж ирээч ээ. Энэ хууль хэзээ орж ирэх вэ гэсэн асуулт байна.

Г.Занданишатар: Хишигээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Өнөөдрийн чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд Уул уурхайн биржийн тухай хууль тавигдсан харагдсан. Тэгэхээр ер нь Хууль зүй, дотоод хэрийн яам дээр олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажил үндсэндээ дуусаж байгаа. Үргэлжлүүлээд олборлох салбарын ил тод байдлын хууль, биржийн хууль 2 Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хамтад нь хэлэлцэгдэж явах байхгээж бодож байна. Бид нар ерөөсөө манай эдийн засгийн бүтэц бол өөрөө уул уурхайн түүхий эдийг дийлэнхийг нь өмнөд хөршид экспортлох замаар төсвийн орлого бүрддэг ийм л улс. Тэгэхээр уул уурхайн түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулж, худалдан борлуулахдаа биржийн тогтолцоогоор үнэ хаялцуулж, ил тод худалдан борлуулах нэг тогтолцоо бидэнд үгүйлэгдэж байгаа юм.

Хоёрдугаарт олборлох салбарын ил тод байдал гэдэг их өргөн хүрээтэй

ойлголт учраас энийг бүхэлд нь ингэж Засгийн газраас цогцоор нь оруулж ирж байгаа гэдгийг танд хэлье.

Г.Занданшатар: Өчигдөр Дэлхийн банкныхантай уулзсан. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж, таваарын бирж, Олборлох байдлын ил тод байдлын санаачилгын хуулиудыг дэмжиж хамтарч ажиллая гэсэн. Тэгээд энэ Их Хурлаар хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг” төсөлтэй уялдуулья гэсэн тийм санал солилцсон. Тэр олборлох байдлын ил тод байдлын санаачилгын хууль маш чухал юм байна лээ. Бүх уул уурхайн салбарт. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би 2 зүйл асууя.

Нэгдүгээрт хуулийн төслийг дэмжиж байгаа гэдгээ хэлье. Дараагийн асуух гээд байгаа юм бол хууль батлагдсан өдрөөсөө хэрэгжиж эхлэх үү. Хэрэгжих хугацаатай холбоотой хариулт өгөөч. Дараа нь асуух гээд байгаа юм бол дэлхий нийтэд авлигалтай тэмцэх чиглэлээр амжилт олсон улс орнуудын ялангуяа Эрүүгийн хуулиар хүлээлгэж байгаа хариуцлага, ялын бодлоготой холбоотой ийм харьцуулсан судалгаа байдаг уу. Авлигыг бууруулах чиглэлээр Эрүүгийн хуулиараа хүлээлгэж байгаа ялын бодлого хэр нөлөө үзүүлсэн байна тийм судалгаа байх уу. Өнөөдөр манайд нүүрлэсэн хулгай, авлига, луйвар ийм зүйлтэй бол Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлагыг нь чангаруулж байж, ялын бодлогыг нь нэлээн хатуу болгож байж тэмцэхээс өөр нөхцөл байхгүй байдал байхгүй л ийм л байдалтай байна. Тийм учраас би дэмжээд байгаа гэдгээ хэлье.

Дараагийн нэг юм бол компанийн засаглалыг сайжруулахтай холбоотой асуудлыг ярьж байгаа. IPO гаргана гэж байгаа. Энэ талаар тодорхой зүйл тайлбар өгч болох уу. Би бол энэ Монгол хүндээ байдаг байна уу эсвэл хаанаа

байна вэ. Юмыг ер нь буруу тал руу нь эргүүлж, хувьдаа, өөртөө ашигтай байдлаар эргүүлэхдээ ер нь гарамгай болчихсон ийм улсууд байна л гэж би ойлгоод байдаг.

Төрийн өмчийн мэдлийн компанийг удирдаж байгаа хүмүүсийн үйл ажиллагаа ямар хэмжээнд болж байгаа билээ бид бүгдээрээ мэдэж байгаа. Дээрээс нь ард иргэдэд хувьцаа эзэмшүүлээд нээлттэй болгож байна гэж яриад байгаа боловч бодит байдал дээр ямар байдалтай байна. Тун багахан хувьцааг нь төр ихэнх хувьцааг нь эзэмшээд багахан хувьцааг нь эзэмшиж байгаа хүмүүс л энэ компанийг чинь нийтээр нь 100 хувь өөрийнхөө эрх мэдэлд авчхаад яваад байгаа шүү дээ. Тэгэхээр би олон улсын хэмжээнд IPO гаргана гэдэг асуудал дээр дахиад манайхны нөгөө урт гар, хөл, хуруу, хумс нь дүрчих үү үгүй юу. Энэнээс сэргийлэх бололцоо нөхцөл байх уу гэдэг ийм асуултыг би асуух гээд байгаа юм. Дараагийнх нь юм бол ийм байна шүү дээ тэр Оюутолгой гээд. Тэгэхэд Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг чинь эхнээс нь будилуулсан улсууд. Будилуулсныг нь тогтоогоод ялыг нь үүрүүлсэн. Шүүх дээр ямар үндэслэлээр ял оноосныг нь бол тэр нь эргэлзээтэй. Тэр нь өөрчлөгдчихдөг юм шиг байгаа юм. Тэгээд сүүлд нь зүгээр болоод л чөлөөлөгдөөд, чөлөөлөгдөөд гараад ирдэг. Энэ бүхэнд чинь бол ард түмэн үнэхээр эгдүүцэж байгаа шүү дээ. Би энэ Улсын Их Хуралд суусан он жилүүддээ бол төрийн албыг төрлийн алба болгохоос та нар хол хөндий байгааг ээ. Элдвийн төсөл тендер, лиценз, концесс, худалдан авалтын буруу булхайн юманд битгий оролцооч гээд ингээд байнга л үглэж, хэлж захиад байгаа. Тэгээд хэлэх бол үр дүнд хүрдэггүй юм байна л даа. Энийг хаах чиглэлээр авлигатай тэмцье, үр дүн гаргая гэж байгаа бол улс төрийн намуудын хуулийн хүний нөөц, боловсон хүчний асуудал, тэр хувь хүний.../минут дуусав/

Г.Занданишатар: *Хишигээгийн Нямбаатар сайд хариулъя.*

Х.Нямбаатар: *Би Бат-Эрдэнэ сайдын асуултад хариулъя. Ер нь бол хэдүүлээ засаг дээр ярьж байгаа шүү дээ Бат-Эрдэнэ сайд аа. Юу гэхээр одоо нэгэнт энэ асуудал олон нийт Засгийн газрын нүүрсний хулгайтай тэмцэх бодлогыг олон нийт ингэж дэмжиж байгаа энэ цаг үеийг бид нар маш овжин ашиглах ёстой. Энэ нь юу вэ гэвэл “Эрдэнэс таван толгой” цаашиаад “Эрдэнэт” гээд томоохон компаниудаа бид нар олон улсын аудит оруулаад, зөвлөх үйлчилгээ аваад, ялангуяа “Эрдэнэс таван толгой” дээр БЭТ томилогдсон энэ цаг хугацаанд нь амжуулаад, олон нийтийн компани болгох ажлыг зохион байгуулъя гээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан даргаар ахлуулсан олон нийтийн болгох чиглэлээр судалж санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тэгэхээр удахгүй энэ асуудал санал, дүгнэлт нь боловсроод олон нийтийн болгох энэ чиглэлийн ажлын төлөвлөгөөгөө Засгийн газраар батлуулах байх гэсэн эхний хариултыг өгье.*

Хоёрдугаарт ер нь бол ерөөсөө л би түрүүн би одоо 3 дахиа л хэлж байна. Ялын бодлогыг чангатгаад авлигатайгаа хийх тэмцлээ бүрэн бид нар хийж чадахгүй. Тогтолцоогоо шинэчилж, хулгай зэлгий орох завсар, зайгүй болгож байж цаашидаа явна. Бид нар Норвегийн тэр баялгийн санг бид нар судалж үзэж байсан. Норвегийн баялгийн сан гээд.1960-1990 оны хооронд Норвегийн баялгийн сан бүрэлдэх гэж нэлээн олон жилийн хугацаа болсон юм байна лээ. Засаглалынхаа зөв байдлыг олох гэж. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дойчибан гээд төмөр замын гол компани нь дандаа алдагдалтай ажилладаг, ашиггүй байсан, бас л хулгай зэлгий нүүрлэсэн байсан. Тэгээд 2 Герман нэгдсэн дараа бүр алдагдал нь дээд хязгаартаа хүрсэн гэж байгаа юм. 1994

онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад Дойчибаны дэд бүтцийн үндсэн суурь өмчлөх эрх нь төрдөө үлдээд Дойчибандаа үлдээд, дэд бүтэц дээр нь чөлөөт зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг явах ангиудыг явуулах өрсөлдөөнийг бий болгож чадсан. Өнөөдөр Европ дэлхийн хамгийн том тэргүүлэх потенциалтай, хүчин чадалтай компаниудын нэг болсон. Манай төрийн өмчит компани ашигтай ч ажиллаж байсан, ашиггүй ч ажиллаж байсан байж л байдаг. Төр оймс, хувцас, оёхоос авхуулаад хоол, гурил, будаа хийх бүх л бизнесийг хувийн сектортойгоо өрсөлдөж хийдэг. Тэгэхээр бид нар цаашид төр яг ямар, ямар бизнесийг хийх вэ гэдгээ 4, 4 жилээр төлөвлөдөг, тэрнээс бусад бизнесээ огт хийхгүй хувьчлаад, хийж байгаа бизнес дээрээ олон нийтийн болон гаднын нээлттэй хувьцаат компани болох чиглэлээр публич компани болгож, хяналтаа явуулах л энэ чиглэл рүү явах хэрэгтэй. Тэгээд энэ нь өөрөө магадгүй улс төрийг сонирхолгүй болох байх гэдэг.../минут дуусав/

Г.Занданишатар:
Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут .

Б.Бат-Эрдэнэ: *Баярлалаа. Миний асуултад хариулсангүй л дээ. IPO гаргана гэж байгаа тэгэхээр энэ олон улсад нээлттэй компани болоход яг энэ хулгай луйвар орохгүй, яг хатуу хяналттай байж чадах уу. Энэ талаар судалгаа хийсэн ийм зүйл байна уу. Мэдээж Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа БЭТ томилсон арга хэмжээний хүрээнд бол төрийн өмчийн тэр том компани “Эрдэнэс таван толгой”компанийн засаглал, энд нүүрлэсэн хулгай, луйвар бүх юмнуудыг хаалт тавиад, энэ компанийн үнэлгээ бол тодорхой хэмжээгээр нэмэгдэх байх. Хамгийн гол нь тэр олон улсад гаргасан байхад манай нөгөө луйварчид чинь тэнд урт гар, хуруу хумсаа дүрээд сүйд хийчих юм биш биз дээ гэсэн ийм л санаа зовнил, хардалт*

байгаад байгаа юм. Энэ дээр тодорхой хариулт өгөх бололцоо байхгүй юу.

Г.Занданишатар: Эрүүгийн хуультай шууд холбоогүй учраас Засгийн газрын танхим дээрээ энэ компанийн засаглалын асуудлууд, төрийн өмчийг компанийн хууль дараа нь хэлэлцэнэ. Тэр дээр ярих асуудал байна. Одоо Нанзадын Наранбаатар гишүүн. Алга байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн алга байна. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Хуулийг хэлэлцэж байгаатай холбогдуулаад 2 зүйл дээр байр сууриа илэрхийлье гэж бодсон юм. Агуулгын хувьд, зарчмын хувьд, үзэл баримтлалын хувьд гэмт хэрэгтэй тэмцэх, ялангуяа авлигын гэмт хэрэг, ялангуяа улс төрд нөлөө бүхий өндөр, дээд албан тушаалын хүмүүс хийж байгаа энэ хэрэгтэй тэмцэх санааг нь бол дэмжиж байгаа.

Тэгээд бид нар ер нь хуульд бол бүх хуульд, ямар ч хуульд заавал тийм юу байх ёстой юм гол гэх юм уу даа үзэл баримтлал. Тэгээд хуулиар хийж болдог зүйлүүд, болдоггүй зүйлүүд гэдэг юмнуудаа бид нар ялгаж, салгаж байж асуудалд хандаж байхгүй бол ямар нэгэн хурц асуудал гарахаар тэрийг дагаад, тэр тохиолдол болгонд хуулиуддаа өөрчлөлт оруулаад эс үгүй бол ялангуяа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг шалгаж, мөрдөхтэй холбоотой хуулиуд дээр их олон талаас нь бодож байж болгоомжтой хандахгүй бол зөвхөн тухайн үеийн уур амьсгалд автагдаад, конектур хөөгөөд хуулиудаа батлаад байвал маш их тогтворгүй байдлууд бий болно. Тэгээд нөгөө эцсийн үр дүндээ хүрэхгүй байж магадгүй. Тэгээд энэтэй холбогдуулаад би 2 зүйлийг хэлье гэж бодсон юм.

Эрүүгийн хуулийн өөрчлөлтийн I дүгээр зүйл дээр хуулиар халдашгүй байдлыг нь баталгаажуулсан албан тушаалтнуудын бүрэн эрхийг түдгэлзээгүй бол гэмт хэргийг хөөн

хэлэлцэх хугацааг нь зогсоогоод, дуусгавар болсных нь дараа тоолж эхэлнэ гэж байгаа юм. Түүрүүн хэн нь хэлэв. Нэг гишүүн хэлсэн. Энийг ерөөсөө юугүй болгочихвол яасан юм. Ялангуяа ийм хэргүүдийг хөөн хэлэлцэх хугацаа гэж юм байдаггүй. Хэзээ ч байсан, хэдэн жил ч өнгөрсөн тэр хүнийг шалгадаг, үздэг. Энэ чинь нийтийн эрх ашгийн эсрэг үйлдсэн томоохон гэмт хэргүүдийн тухай ярьж байгаа учраас хугацаа нь өнгөрчихсөн юм даа гээд орхиж болмооргүй санагдаж байгаа юм. Тэгээд янз бүрийн хугацаа зааж байхаар нь нэгмөсөн ерөөсөө хугацаагүй байна. Хэзээ илэрнэ, тэр үед нь шалгаж байна, шийтгэж байна гэдэг ийм агуулгаар оруулбал болох уу. Энэ талаар та бүхэн маань хуулиа боловсруулж байхдаа ярьсан уу. Нэг ийм асуулт байна.

Халдашгүй байдалтай холбоотой, бүрэн эрхтэй холбоотой бас би зүгээр далимдуулаад энэ хоёрын ялгааны талаар жоохон хэлчихье. Хүмүүс ойлгохгүй байх шиг байдаг юм. Халдашгүй байдлын дэд хороо гэхээр нөгөө гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлдэг газар шиг бодоод байдаг. Дэс дараатай явдаг. Дэд хороо, Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо яваад эцсийн шийдвэрийг Их Хурал гаргадаг. Бүрэн эрх өөрөө нэг өөр асуудал. Халдашгүй байдал гэдэг нь тусдаа асуудал. Яг одоо амьдрал дээр бол олон хэргүүдийг халдашгүй байдалд нь хүрэлгүйгээр мөрдөөд, шалгаад илрүүлээд, шүүх хүртэл явчихсан хэргүүд байж байгаа. Тэгэхээр энэ тал дээр нь бид нар бас анхаарах ёстой юм байна лээ. Тэр халдашгүй байдал гэдэг бол хүмүүсийг гэмт хэрэг хийсэн нөхдүүдийг хамгаалах тухай асуудал биш. Төрийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой, аюулгүй байдал, тусгаар байдал, ард түмний төлөөлөл санал, бодлоо ямар нэгэн юмнаас айж, ичихгүйгээр чөлөөтэй илэрхийлж байдаг тэр л баталгааг нь хангаж байгаа ийм зүйл шүү дээ. Тэгэхээр энийг зөвхөн ганц

хэрэг үйлдсэн хүмүүстэй холбож ойлгох нь учир дутагдалтай байдаг юм. Энийг нэг далимд нь хэлчихье.

Хялбаршуулсан журмын талаар би саналаа хэлчихсэн. Тэгэхээр энэ тал дээр ярьсан зүйлүүд байна уу. Яагаад энэ хувилбарыг нь сонгов. Түрүүн прокурорын тайлбарлаж байгаа, бусад хүмүүсийн тайлбарлаж байгаагаас харахад энэ журмыг хэрэглэдэг болсноос хойш ялангуяа авлигын гэмт хэргийн илрүүлэлт, шийтгэл бол бараг жилдээ 2-6 хэрэг шүүхээр ордог байсан бол түрүүн хэд гэсэн бэ. Бараг 180, 160.../минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би Энхболд гишүүний хэлж байгаатай яг 100 хувь санал нэг байна. Бид нар хууль тогтоох байгууллага, аливаа сэтгэл хөдлөл, эмоци, нийгмийн сэтгэл зүйн яг энэ давлагааг дагаж, хууль тогтоох үйл ажиллагааг хийж болохгүй гэдэгтэй санал нэг байгаа. Бид нарын батлан гаргах энэ хууль бол хүний эрх, эрх чөлөөнд шууд хязгаарлалт хийдэг хамгийн том төрийн албадлагыг хэрэгжүүлдэг механизм нь. Тийм учраас энийг тал талаасаа хэлэлцэж, ярилцаж байж батлах нь зүйтэй гэдэгтэй санал нэг байна.

Хоёрдугаарт төсөлд дурдсан тодорхой бүрэн эрх, халдашгүй дархан эрхтэй хүмүүсийн тухайд хэргийг шалгах явцад мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулсан тохиолдолд тухайн хүнд холбогдох хэргийг түр царцаагаад бүрэн эрх нь дуусгавар болсны маргааш үргэлжлүүлж шалгадаг олон улсын туршилагууд байгаа. Одоо бид нар нөгөө халдашгүй эрх, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн тухай асуудал их гадуур яригдаж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад саад учруулахгүй тохиолдолд заавал Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай асуудал өнөөдөр

процессын хуульд заавал хөндөөгүй зүйл шүү дээ. Мөрдөгчийн дуудсан цагт нь ирээд байдаг, тайлбар, мэдүүлгээ өгөөд байдаг, прокурорт хэрэг нь шилжихэд цуг яваад оччихдог. Тэгээд шүүх дээр гэм буруугийнх нь асуудал шийдэгдэж байж дараагийн асуудал яригдана. Хэрвээ байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулж байгаа тохиолдолд шууд хэргийг нь царцаагаад, хөөн хэлэлцэх хугацааг нь зогсоогоод, бүрэн эрхийн хугацаа 6 дугаар сарын 31-ний өдөр дуусмагц 7 дугаар сарын 1-нд нь шууд дууддаг ийм механизм ялангуяа эрх зүйн өндөр хөгжилтэй орнуудад байдаг юм байна лээ гэдгийг хэлье.

Би харин таны нөгөө хэлж байгаа зүйлтэй төдийлөн санал нийлэхгүй байна. Энхболд гишүүн ээ. Энэ юу вэ гэхээр ер нь авлигын хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацаагүй болгочихвол яасан юм бэ гээд. Энэ бол хүнийг насаар нь эрүүгийн хариуцлагад татаж, мөрдөж шалгах ийм нэг талдаа хүний эрх зүйн байдлыг илтэд дордуулсан зүйл болно. Өөрөөр хэлбэл энд ерөөсөө дэлхий нийтээрээ хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг дээр л хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байя гээд. Энэ бол өнгөрсөн зуунд гарсан тэр дэлхийн 2 дугаар дайны үеийн цэргийн гэмт хэрэгтнүүдтэй холбоотой асуудлыг өнөөдрийг хүртэлх хугацаанд шүүж байгаа юм. Өнөөдрийг хүртэл хугацаанд олон улсын шүүхэд дуудаж яллаж байгаа. Одоо бараг сүүлч нь 100 орчим настай хүмүүсийг яллаж байгаа юм. Бусад хэргүүд дээр нийгэмд учруулж байгаа хор аюулынх нь шинж чанарт таарсан хөөн хэлэлцэх хугацаа зайлиггүй байх ёстой. Эс бөгөөс улс төрийн зорилгоор, бусад субъектив байдлаар хүнийг насаар нь мөрдөж, шалгаж, ялах ийм сөрөг үр дагавар байдаг учраас хөөн хэлэлцэх хугацаа бүх төрлийн хэргүүд дээр байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн 1 минут тодруулъя.

Н.Энхболд: Хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Хэлэлцэхийг нь дэмжинэ. Хэлэлцэхдээ хэдүүлээ их олон талаас нь ярьж сая сайдын үгэнд ч гарч байна. Тэр эрх зүйн байдлыг дордуулахгүй байх тухай асуудлыг тал талаас нь их ярих хэрэгтэй болж байна. Нөгөө талаар ингээд харахад нэг хэргийн төлөө хэд хэдэн ял ноогдож байгаа юм шиг ийм зүйлүүд байна. Гишүүдийн дунд ч ийм яриа явж байна. Энэ болж байна уу, үгүй юу. Тэр түрүүчийн нөгөө миний хэлсэн зүйл байна шүү дээ. Хөнгөвчилсөн аргаар, түргэвчилсэн аргаар шийддэг дээр. Энэ дээр хамгийн гол нь тэр хүнийг хашираах шийтгэхдээ юм уу, эс үгүй бол хохирлыг барагдуулахдаа юм уу гэдэг. Одоо яагаад энд хүмүүст дургүйцээд байна вэ гэхээр хэдэн тэрбумаар нь хэрэг хийсэн гэхээд төдхөн саяар торголоо гэдэгт нь хамгийн их дургүй хүрж байгаа байхгүй юу. Гэтэл тэрийг хохирлыг нь бүрэн барагдуулчихсан байхад нөгөө хүнд ноогдуулах ялыг нь харж үзэж байх энэ.../минут дуусав/

Г.Занданиатар: Сандагийн Бямбацогт гишүүн. Алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн хаслаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хууль зүйн сайдаас нэг юм асууя. Мэдээж Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой заалтуудыг, түүнд оногдуулах ялыг нэмэгдүүлж байгаад мэдээж буруутгах аргагүй. Гэхдээ нэг талаараа Эрүүгийн хуулийн ялыг чангалах тусмаа нэг сөрөг юм нь цагаан захтнууд гэдэг юм уу, улс төрд өндөр эрх бүхий албан тушаалтнуудын асуудал замхраад, явж явж ялын бодлого нь жирийн иргэд дээр тэр чангатгасан хууль нь буугаад байдаг ийм сөрөг үзэгдэл гараад байдаг гэж хуульчид үздэг. Тэрний нэг илрэл нь энэ болчих вий дээ. Энэ хулгайтай холбогдуулж нийгмийн шаардлагаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт

орүүлж, улс төрд эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын ялыг чангалах гэж байгаа гээд төрийн албанд ажиллаж байгаа, хуулийн мэдлэг, мэдээлэлгүйгээсээ болоод нэг эмнэлгийн дарга, нягтлангууд ч юм уу, цэцэрлэгийн дарга, нягтлан, нярвууд, сургуулийн эрхлэгч, захирлууд ч гэдэг юм уу ингээд ялын бодлого нь хариуцлага алдсанаасаа болж энэ өндөр улс төрчидтэй, энэ өндөр хохиролтой хулгайчдаас болж хохирох асуудал үүсэж байна л даа нийтээрээ. Тэгэхээр хуулийн ялгаа, заагийг гаргаж, энэ ялын бодлого зөвхөн төрийн эрх барих дээд байгууллага, улс төрчид, улс төрд нөлөө бүхий этгээдүүдтэй холбоотой асуудлыг нь ялгаж салгаж зааглахгүй бол нийтийн алба нь гээд нийтээр нь ингэснээр ийм сөрөг нөлөө гарчих вий дээ гэж. Нөгөө талаар би ингээд харж байхад 6.7-оор эд нар удахгүй “Эрдэнэс таван толгой” компани нүүрсний хулгайтайгаар холбогдсон нөхдүүд 1 сарын дараа суллагдах л юм байна л даа энэ хуулиар. Тэгээд мөрдөн байцаалтаар тэр мөрдөн байцаалтын үйл ажиллагааг, тэр үг, өгүүлбэрээрээ орж ирээд суллагаад, дараа нь тэгээд одоо энэ 5 гишүүнийг ялласнаар нийгмийн энэ бухимдлыг жоохон дараад, тэгээд яг жинхэнэ хулгайчид нь гарч ирэхгүй байх, нуугдах, илрэхгүй байх ийм нөхцөл үүсэх вий дээ.

Өнөөдөр 5 нөхдүүд зарлагдаад нийгэмд ад үзэгдээд явж байна. Энэ ер нь Авлигатай тэмцэх газар нэр зарладаг нь зөв үү, үгүй юу. Шүүхийн шийдвэр гараагүй байхад олон нийтэд ингэж урьдчилж ялладаг нь зөв үү, үгүй юу. Энэ ер нь хэлмэгдүүлэлтийн нэг төрөл мөн үү, үгүй юу. Энэ 5 гишүүн, түүний ар гэр, ах дүүс, аав ээж, үр хүүхдүүд яаж нийгэмд давхар яллагдаж байгаа гэдгийг ойлгож байгаа юу. Шүүхийн шийдвэр гараагүй байгаа шүү дээ. Тэгээд нийгэм захиаллаа зарла гэсний төлөө гээд. Би бол хувьдаа 5 гишүүдийг энэ хэрэгт холбогдчихсон улсууд гэж хэлэхэд, нийгэм ч гэсэн тэгж ойлгож байгаа юм билээ. 99 хувь нь. Яг жинхэнэ эзэд нь бол

гарч ирсэнгүй л гэдэг дээр олонх нь байгаа юм шиг байна лээ. Тэгээд энэ хууль чинь цаашидаа нэмэлт, өөрчлөлт хийснээр яг энэ асуудалтай цаашидаа зөвхөн нүүрсний хулгайгаар тогтохгүй. Улс төрд нөлөө бүхий улсуудтай холбоотой энэ хууль нь энэ асуудал дээр яг гол эзнийг нь олох тал дээрээ болж чадах юм уу. Тэгээд аливаа асуудалд уснаас хуурай гараад, үлдээд байдаг бол энэ нийгэмд чинь энэ жагсаалт чинь энүүгээр дуусахгүй. Цаашидаа жагссаар байх болно. Төрийн өмчийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар.

Х.Нямбаатар: Сандаг-Очир гишүүн ээ, би яг саяын хэлж байгааг яг хэнд хандаж хэлээд байгааг ерөөсөө ойлгосонгүй. Засгийн газар руу хандаж хэлж байгаа юм уу. Мөрдөх алба руу хандаж хэлж байгаа юм уу. Эсвэл ажлын хэсэгт хандаж хэлж байгаа юм уу. Тэрнийхээ яг хаяг, эзэн хаягаа маш тодорхой хэлээрэй. Би жагсаалын иргэдтэй гарч уулзалт хийхдээ би нэг зарчим дээр өнөөдрийг хүртэл хатуу зогсож байгаа. Өөрөөр хэлбэл хэн нэг хүний гэм буруутай асуудлыг шүүхээр эцэслэн тогтоох хүртэл бид ямар нэгэн байдлаар хүний нэрийг хэлж чадахгүй гэдэг л ийм зүйлийг би жагсаал болгон дээр хэлж байгаа юм.

Очсон өдөр болгон өөрөөр хэлбэл Мөрдөх алба ажлаа хийгээд, прокурорын тодорхой зөвшөөрөл хүрээ хязгаарын дотор мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэгт шалгагдаж байгаа, гэхдээ гэм буруу нь эцэслэн нь тогтоогдоогүй асуудлаар мэдээлэл хийе гэдэг ийм байдлаар 2 хоногийн өмнө Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах алба Улсын Их Хурлын нэр бүхий 7, 8 гишүүний нэрийг зарласан. 7, 8 гишүүний нэрийг зарласан. Энэ дээр би тэр хэвлэлийн хурлыг санаж байгаа. Ийм хүмүүс шүүхээр гэм буруутай нь эцэслэл тогтоогдоогүй шүү гээд. Тэгэхээр энэ

асуудлаар хандаж саяын та захиа хаяглаж байгаа бол тэрийг Авлигатай тэмцэх газарт хаяглах хэрэгтэй. Бид нар өнөөдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл дээр ерөөсөө иргэд, олон нийтийн бухимдаад байгаа өчнөөн тэрбум төгрөгийг авлигад авсан хүнийг 40 сая төгрөгөөр торгоод, явуулаад байна. Энэ зохицуулалтаа өөрчилж өгөөч гэдэг шаардлагыг Сүхбаатарын талбай дээр жагсааж байгаа иргэдээс удаа дараа бидэнд өгсөн. Өнгөрсөн 4 дүгээр сард болсон жагсаалын үеэр мөн ийм шаардлага өгсөн. Үүний дагуу уг нь Их Хуралд өргөн бариад, хэлэлцүүлгийн шатанд явж байгаа юм. Тэгэхээр бид нар гадаа иргэд энэ хүйтэнд жагсааж, цуглаад эсэргүүцлээ илэрхийлээд бухимдал их байгаа учраас Улсын Их Хурал яаралтай горимоор энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөөч ээ. Энэ 22 дугаар бүлэгтэй холбоотой асуудлыг яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулъя гээд хүсэлтийг өчигдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Өнөөдөр яаралтай горимоор явж байна. Тэр нэр бүхий хүнийг хэдүүлээ чуулганы индэр дээр яллаж болохгүй. Гэхдээ энэ авлига, албан тушаалын гэмт хэрэг дээр 22.1 ч тэр, 22.4 ч тэр одоо яг гол зүйлчлэгддэг энэ зүйлүүд дээр дандаа 5-аас дээш жилийн хорих ялтай гэмт хэргүүд учраас 6.7 үйлчлэхгүй гэдгийг би дахиад хэлье. Бид нарын оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлтөөр хуучин байсан зохицуулалт бий. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, нөхөн төлсөн эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр 5 жил, түүнээс бага хугацаагаар тэнсэж болно гэж байгаа юм. Тэгэхээр та өөрөө энэ 22 дугаар зүйлийн 22.1-ийг хараарай.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Сандаг-Очир: Эрүүгийн хуульдаа бас энэ төрийн өмчийн компанийн оролцоотой цаашидаа үүсэж болох хулгайнууд дээр чинь дандаа Төлөөлөн удирдах зөвлөл байгаа шүү дээ. Гарын үсэг зурсан гэдэг юм уу, шийдвэр гаргасан энэ нөхдүүд нь буруутаад явдаг. Тэр шийдвэр гаргалтад нөлөөлсөн, тэр хүнийг томилсон гэдэг юм уу, эрх бүхий албан тушаалтнууд ерөөсөө асуудалд холбогдохгүй ард нь үлдэж байна. Тухайлбал “Эрдэнэс таван толгой” маш том Төлөөлөн удирдах зөвлөлтэй. Өнөөдөр Төлөөлөн удирдах зөвлөл гэдэг байгууллага ямар хариуцлага хүлээх вэ. Компани нь ийм хохирол амсчхаад, төрд учруулчхаад, хохиролд орчхоод байж байхад Төлөөлөн удирдах зөвлөл зүгээр суугаад байх уу. Эрүүгийн хуулиар. Томилсон албан тушаалтнууд ингээд зүгээр ард нь үлдээд хоцрох уу энэ Эрүүгийн хуулиар. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр. Энэ дээр ямар асуудал хөндөгдөж байгаа юм. Зөвхөн захирал хариуцлага хүлээгээд, энэ хохирлыг төлүүлсэн гээд.../минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах уу. 81. Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Яг тухайлсан фактыг болон үйл явдлыг мэдэхгүй учраас бас хэлж болохгүй байна. Гэхдээ үнэхээр тэр Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь хууль бус эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлөөс ямар нэг байдлаар хууль бус чиглэл, давуу байдал олгох тийм зүйлүүд өгөгдсөн байх юм бол хариуцлага хүлээх боломжтой. Тэгэхээр энэ бол заавал гарын үсэг зурснаараа бас үйлдэгддэг асуудал биш. Энэ нь эргээд тодорхой хэмжээний амаар эсвэл тодорхой юу гэдэг юм бусад байдлуудаар нотлогдож болно. Тэгэхээр энийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бол тогтоох байх. Хэн нь ямар оролцоотой, ямар үйл ажиллагааг хариуцаж яваад буруу, зөрүү шийдвэр

гаргав гэдэг зүйл дээр. Тэгэхээр юу гэдэг юм энэ асуудал дээр бол ийм зүйл байгаа. Цаашидаа ер нь зүгээр Төлөөлөн удирдах зөвлөлийг, гишүүдийг ч гэсэн түрүүн Нямбаатар сайд хэлээд байгаа. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийг бүр тодорхой болгож, төрийн алба гэдэг юм уу тодорхой зарим зүйлүүд дээр бүр улс төрийн албан тушаалтнууд ч гэсэн Төлөөлөн удирдах зөвлөлд томилогдож байгаа зүйлүүд байгаа. Энийг зогсоож, нээлттэй сонгон шалгаруулалттай, бизнесийн зарчмаар нь явж, төрөөс янз бүрийн чиглэл, удирдамж өгдгийг хязгаарлах ёстой. Шинэ хуулийн төсөл дээр зөвхөн ашиг орлогоо нэмэгдүүл, тодорхой хэмжээний хэмнэлт, үйл ажиллагаа үр ашгаа нэмэгдүүл гэдэг чиглэлээр л чиглэл өгнө. Төрийн зүгээс буюу хувьцаа эзэмшигчийн зүгээс. Бусдаар юу гэдэг юм үүнтэй гэрээ, контракт хийх эсвэл ийм зүйлүүдийг хий гэдэг ч юм уу ийм удирдамжууд, энэ хүнийг томил, чөлөөл гэдэг удирдамж өгөхгүй. Тэр бол компанийн засаглал болон бусад зүйлүүд бол бизнесийн зарчмаараа явж байж дараа нь хэнтэй, ямар хариуцлага хүлээх вэ гэдэг нь тодорхой болно. Тэгэхээр ер нь зүгээр юу гэдэг юм Эрүүгийн хуулийн асуудал бол нэг асуудал байхад, нөгөө талдаа бусад тэр хууль, эрх зүйн орчноо давхар сайжруулж явж байж таны ярьж байгаа зүйлүүдийг бас мухарлаж, шат шатандаа хариуцлагатай ажиллана гэж харагдаж байгаа. Тэгэхээр хийх зүйлүүд нэлээдгүй байгаа.

Г.Занданишатар: Тэгэхдээ энэ сая Нямбаатар сайд ч гэсэн тодорхой хэллээ. Нийгмийн сэтгүүл зүй, хуучин тэр Антихрист гээд яллаж байсан тэр шүүхийн практик, муу практик энэ тэртэй уялдуулаа, тэгээд Дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч хариулчихвал саяын Сандаг-Очир гишүүний асуулт дээр Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж байна шүү дээ. Энэ шүүхийн хуульд шүүхийн реформын хүрээнд уг нь тэр санаа орсон байх ёстой. Нийтийг төөрөгдүүлэх, хулгайч

хулгайчийг бариарай гэж хаширах, жинхэнэ хулгайч нуугдаж гарахын тулд олон нийтийн сэтгэл санааг өөр зүгт чиглүүлэх. Ингэхээр энэ нөгөө шүүн таслах ажиллагаанд болон мөрдөх ажиллагаанд саад учруулах, залах гэсэн. Одоо энэ орчин үеийн Фэйсбүүк, нийгмийн сүлжээний эерэг болон сул талыг ашиглаж. Одоо энэ чинь дайны хэрэгсэл болчихсон. Энэ чинь 4 дүгээр үеийн дайны эрсдэл гэж нэрлэгдэж байгаа шүү дээ. Тэгээд энэ талаар бас шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийг юу гэж үзэж байна. 80. Батаагийн Батцэрэн шүүгч. Бусад улсад шүүх шууд хэрэг үүсгэдэг юм байна лээ зарим улсад.

Б.Батцэрэн: Улсын дээд шүүхийн шүүгч Батцэрэн. Тэгэхээр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар хэн нэгэн хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэх нь үндэслэлтэй байсан уу, яллагдагчаар татах үндэслэл бүхий нөхцөл байсан уу гэдэг дээр шүүхийн хяналт байхгүй байгаа. Харьцуулсан судалгаа хийж үзэхэд бол Англи-Саксафоны эрх зүйн тогтолцоотой улс орнууд хүнийг баривчилсан даруй тэр хүнийг шүүхийн өмнө авчраад анхны хэлэлцүүлгийг явуулаад, энэ хүнийг яллагдагчаар татах үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон гэж үзвэл цаашид мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгоод ингээд гэм буруугийн асуудлыг тогтоох ийм ажиллагаа явагддаг байх нь ээ. Монгол Улсын хувьд түрүүн би хэлсэн. Энэ бол шүүхийн оролцоогүйгээр, прокурорын шийдвэрээр хүнийг эрүүгийн хэрэгт холбогдуулан яллагдагчаар татаж явдаг. Шүүх зөвхөн цагдан хорих, баривчлах таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зөвшөөрлийг олгож, шүүхийн өмнөх шатанд хяналт хэрэгжиж байна. Тэгэхээр цаашидаа бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү боловсронгуй болгох, хүний эрхийг дээдлэх үзэл баримтлалын хүрээнд шүүхийн өмнөх шатанд Үндсэн хуульд заасан хүний эрхийг зөрчиж хийгддэг

ажиллагаанууд тухайлбал хүнийг баривчлах, цагдан хорихоос гадна хүний орон байранд нэвтрэн орох, эд хөрөнгийг нь хураах, үзлэг нэгжлэг явуулах, нууцаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах зэрэг энэ зөвшөөрлийг бол шүүхийн хяналтад шилжүүлэх асуудлыг бид судалж, авч үзэх ёстой гэсэн ийм хувийн байр суурьтай байдаг.

Г.Занданшатар: Яг тэр ч асуудал биш л дээ. Ер нь зүгээр шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж байгаа. Шүүхийн хуульд утга санааг нь оруулсан байгаа. Шүүхийн шийдвэрт нөлөөлөх гэсэн зорилготой, хэвлэл мэдээллийн болон олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах бол мөрдөн шалгах ажиллагаанд ч гэсэн нөлөөлөх ажиллагаа гэж үздэг тийм практик байна. Тэрийг судлах, шүүхийн хуулийн хэрэгжилт ер нь бүрэн хангалтгүй л яваад байгаа л даа. Мэдээж эрх зүйт төр тогтоож байгаа юм чинь алхам алхмаар дэвшил гарч байна. Өргөс авсан юм шиг сайхан болчихно гэж юу байх вэ. Лхагвын Мөнхбаатар гишүүн. Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Улсын Их Хурлын гишүүн болсон цагаас хойш нийгмийн салбар болгонд бугшсан авлигын асуудал, ёс зүйн асуудлыг нэлээн их ярьж байгаа гишүүний нэг гэж өөрийгөө боддог. Харамсалтай нь төдийлөн анхааралд өртөж, төдийлөн дорвитой арга хэмжээ авагдахгүй яваад байна. Юу гэж хэлэх гээд байна гэхээр ерөөсөө Монгол Улсын хөгжлийн гацаа болсон ёс суртахууны доройтол нь эцсийн цэг дээрээ хүрч, ард түмний уур бухимдал энд хүрч байна гэж харж байгаа юм. Тэгэхдээ энийг сайн цагийн эхлэл гэж харж байгаа юм. Ямар нэгэн байдлаар худал хуурмаг, бузар булай нь ил гарч, идээ бээр нь шахагдаад, яр шарх эдгээрэд сайн сайхан цаг ирэхийн дохио гэж харж байгаа. Үүнтэй уялдуулаад орж ирж байгаа Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж

байна. Энэ дээр би нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна.

Өнөөдрийг хүртэл хууль, шүүхийн байгууллагад итгэх иргэдийн итгэл ямар түвшинд өнөөдөр байдаг вэ. Хууль, шүүхийн байгууллагад өнөөдөр авлига байхгүй гэдэг асуудал байсан уу. Байгаагүй. Тодорхой хэмжээнд итгэл алдагдсан байж байгаа. Тэгэхээр энэ 22.1 дүгээр зүйлийг хүндрүүлэх нөхцөлөөр оруулж ирэхэд хууль хяналтын байгууллагад байгаа авлига, дахиад нэмэгдэх юм биш биз дээ. Нэгдүгээрт энэ асуултыг асуумаар байна.

Хоёрдугаарт ажлын хэсэгт Хүний Эрхийн Үндэсний комиссоос ямар ч хүн байхгүй байна. Би төлөөлөл байх ёстой гэж харж байна. Энэ хууль хэрэгжвэл ямар нэгэн байдлаар хүнийг хэлмэгдүүлэхгүй байх тал дээр дүн шинжилгээ хийсэн үү гэдэг. 2 дугаар асуудал.

Гуравдугаарт. Энэ хуулийн 22.8 дугаар зүйл, заалт яагаад хүндрүүлэх нөхцөлөөр орж ирэхгүй байгаа юм бэ. Төсөв захирагч, төрийн өмч, төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулах, зориулалтын бусаар зарцуулах, зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан гэх мэт 2.8 дугаар зүйл дээр мөн ижил хүндрүүлэх зүйл заалт орж ирэх ёстой гэж харж байна. Тэгээд энэ яаж орж ирж байгаа юм бэ. 3 жил гэдгийг нь 2-5 жил гэдэг чинь хүндрүүлэх нөхцөл болж чадаж байгаа юм уу. Эцсийн эцэст өнөөдөр Улсын Их Хурал гээд, гишүүд гээд байна. Цаана нь яг гарын үсэг зурдаг, би олон дахин хэлж байгаа эрх ямба эдэлдэг, албан тушаалд цалин пүнлүү аваад, энэ тодорхой ажлуудыг толгойгоороо хариуцаад явж байгаа хүмүүст хариуцлага хүлээлгэхээсээ илүү Улсын Их Хурал руу хариуцлага хүлээлгэх гэж явдаг. Гэтэл энд чинь хууль хэрэгжүүлэх Засгийн газар гэж байна. Тэрний доор ажил хариуцаж байгаа хүмүүс үүнд нь хяналт тавьдаг хуулийн

байгууллага, хуулийн салбар гэж байгаа шүү дээ. Тэгэхээр 22.8 дугаар зүйл дээр яг ямар зүйл, заалт дээр нь яаж орж ирж байгаа юм. Миний хувьд гишүүний хувьд энэ бол яг адилхан хүндрүүлэх зүйл, заалтаар орж ирэх ёстой гэж харж байна.

Сүүлийн жилүүдэд Улсын Их Хурлын гишүүдийн нутаг нутгаараа ч юм уу, ямар нэгэн нам улс төрөөр ажилд томилсон хүмүүсийн хулгай ингээж чимээгүй яваад, нөгөө хүмүүсийг ард түмэн хэнийг нь ч таньдаггүй хэсэг, хэсэг бүлгээрээ хулгай хийгээд л ажлаас халагдахаараа түүнийгээ хариуцлага тооцсонд тооцоод, улсыг хохиролгүй болгох тал дээр хэн ч санаа зовохгүй ингээж явдаг байсан учраас төрд орж ирээд түр зуур хулгай хийгээд гардаг ийм сүлжээг тогтоочихсон шүү дээ. Энэ бол үнэн. Өглөө кинон дээр хэлдэг дээ. Тэр Сэлэм Тогмидыг буудсан хүнийг олсон уу гээд. Олсон гэхэд үгүй ээ, тэр цаад талын эзнийг нь олсон юм уу гэдэг тийм хэсэг гардаг. Яг л тэр шиг л ийм нөхцөл байдал байж байгаа шүү дээ. Тэгээд асуултдаа хариулт.../минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Нэгдүгээрт. Энэ хуулийн төслийг боловсруулах ажил яг дөнгөж сая олон нийтэд эсэргүүцэл бухимдал үүсээд, жагсаал цуглаан хийхэд боловсруулж, оруулж ирж байгаа зүйл биш Баярсайхан гишүүн ээ. Энэ өмнө нь бид нар 2022 оны 5 дугаар сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд, 2022 оны 5 дугаар сард Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь хэлэлцэх эсэхээ шийдсэн байсан юм. Тэгэхээр ажлын хэсэгт Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүх, судлаачид, практикийн хуульчид, өмгөөлөгчид, хүний эрхийн салбарын олон хуульчид ажилласан. Ингээд бид нар ажиллах явцдаа авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийг чангатгана гэж Угаасаа Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөрт тусгаж явсны дагуу яг төлөвлөгөөний дагуу энэ нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж ирж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт. Та ер нь ямар зүйл заалтууд чангарсан юм бэ, одоо бид нараас гадна цаана чинь төсөв зарцуулаад сууж байдаг хүмүүс чинь илүү их өдөр тутамдаа ашиг сонирхлын зөрчил үүсгээд байна гэж байгаа юм. Тэгэхээр нэгдүгээрт бид нар 22.1 буюу нөгөө албан тушаалын байдлаа урвуулан өөртөө болон бусдад давуу байдал үүсгэж байгаа энэ гэмт хэргийг маш зөв томъёолъё гээд 22.1.2, 22.1.3 ийм адил зохицуулалттай байсан учраас бид нар энийг өөрчлөөд нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хасаж, 2 жилээс 8 хүртэл жилийн хугацаатай хорих ялаар шийтгэнэ гээд. Энэ хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албан тушаал ажиллах эрхийг нь бүх насаар нь хасаж, 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гээд өөрчлөн найруулж, оруулж ирж байгаа юм. Та жишээлбэл аль нэг шатны Засаг даргатай холбоотой асуудал хөндөж байгаа бол энэ өөрөө улс төрд нөлөө бүхий албан тушаалтан гэдэг энэ ангилалд хамаараад явчхаж байгаа юм. 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Бүх насаар нь нийтийн албанд ажиллах эрхийг нь хязгаарлахаар зохицуулж ирж байгаа юм.

Сая та тэр 22.8-ыг асууж байх шиг байна. Энэ нөгөө нийт төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гээд. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гэмт хэргийг бид нар нэлээн шинээр бичсэн. Яг энэ өөрчлөлтөөр. Нэгдүгээрт төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гэдгийг төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, зах зээлийн дунджаас дээгүүр үнээр авсан, нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр хадгалсан, зохиомол хомсдол бий болгосон, төрийн

өмчийн төсөвт байгууллагын хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнэлж борлуулсан, төсвийн хөрөнгийг өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг шаардлага хангаагүй бараа ашиглаж өртгийг нь бүрдүүлж барьсан бол нөгөө нийтийн алба.../минут дуусав/

Г.Занданшатар: Улс төрд нөлөө бүхий этгээдүүд гэдэг нь хүндрүүлэх нөхцөл болж байгаа юм. Хэн хариулах вэ. Пүрэвжавын Сайнзориг. 81.

П.Сайнзориг: Яах вэ ер нь зүгээр хууль, шүүхийн байгууллагад итгэх иргэдийн итгэл сайнгүй байгаа. Сайнгүй байгаа. Тэгээд яг энэ чиглэлтэй холбогдох хууль, тогтоомжийг өөрчлөх, хандлагыг өөрчлөх гээд олон зүйлүүдийг үе шаттай хийж л байна л даа. Сая шүүхийн реформ явлаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор. Түрүүн Нямбаатар сайд цаашидаа Мөрдөх албаны тогтолцоо, эргээд юу гэдэг юм энэ олон зүйлүүд дээр бас хувийн эрх зүйн шинэчлэл хийгдээгүйгээс болоод зарим хувийн эрх зүйн маргаан нь эрүү рүү явдаг ч гэдэг юм уу, энийгээ дагаад хууль, шүүхийн байгууллага буруу зөрүүгээр шийдлээ гэдэг ийм олон зүйлүүд байдаг. Тэгэхээр бид хэд юм болгон энэ 30 жилийн хугацаад л явж ирсэн үр дүн байгаад байгаа юм. Энийг засна гэдэг нэг өдрийн, 4 жилийн ажил биш л байна л даа. Одоо тэгээд бидний хүний нөөц байгаа, аль болох л хурдтайгаар л ажиллаж байгаа. Тэгэхээр энийг үе шаттай шийдээд явж байгаа гэдэг зүйлийг танд хэлмээр байна. Тэгээд энэ бас цаашидаа олон нийтийн итгэлийг сэргээх энэ алхмуудыг л хийх ёстой. Энэ ч өөрөө нөгөө төрийн бүтээмжийн гол үзүүлэлт нь байдаг. Хууль, шүүхийн байгууллагадаа хэр итгэж байгаа нь энэ төрийн бүтээмжийн үзүүлэлтийн нэг шалгуур байдаг. Эндээ бас холбогдох бүхий л байгууллагууд анхаарч байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна. Ер нь түрүүн Нямбаатар сайд хэлсэн. Энийг

өмнө нь өргөн барьсан. Тэгэхдээ төрийн бүхий л байгууллагуудаас бүх саналуудыг авч байсан Хүний Эрхийн Үндэсний комиссоос гэсэн саналуудыг авч байсан. Энэ удаагийн өргөн барьж байгаа дээр ямар ч байсан холбогдох яамдууд, Улсын дээд шүүх, Прокуророос саналуудыг нь аваад, нэгтгээд явж байгаа. Мэдээж бас тодорхой хэмжээний ажлын хэсэг ажиллаад, тал талын төлөөллийг нь оролцуулаад явах бүрэн бололцоотой гэж харж байна.

Тэгээд 22.8 дээр бол бас хүндрүүлэх бүрэлдэхүүн нь аль хэзээний хуульчлагдсан байдаг. Өөрөөр хэлэх юм бол 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн байдаг юм. Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол 2-8 жилийн хорих ялтай гээд, зөвхөн хорих ялтайгаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах юм бол бас ийм өндөр ялтай гэмт хэрэг бол одоо байдаг.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Би бол суулт асуухгүй. Нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна. Өнгөрсөн хавар болсон ажлаа хий жагсаал, одоо энэ хариуцлага тооц гэж байгаа жагсаал бол ганцхан төрийн түшээдэд юм уу, Засгийн газрын тэргүүн, удирдлагуудад хэлээд байгаа юм биш ээ. Энэ бол ялангуяа төрийн албанд ажил хариуцаж байгаа, дунд, доод шатны мөн хууль, хяналтын байгууллага, шүүхийн байгууллага, төрийн албан хаагчид, ялангуяа төрийн өмчит үйлдвэрийн газрууд гээд хүн болгоныг хариуцлагатай байгаагч. Битгий хулгай хийгээч. Эх орондоо хайртай байгаагч гэж хэлж байгаа жагсаал шүү. Тэгээд энийг зүгээр нэг улс төрийн тоглолт нэг Их Хурал өөрчлөгдөх, Засгийн газар өөрчлөх ийм асуудал явж байна гэж ерөөсөө харах хэрэггүй ээ. Би энэ үгээрээ юу гэж хэлэх гэж байгаа юм гэхээр чуулганы хуралдааныг үзэж байгаа, ажил хариуцаж байгаа хүн болгон дор

бүрнээ хандлагаа өөрчилж, ажлаа сайн хийх, хариуцлагатай хийх тухай хаширч байгаа шүү.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Олон жилийн өмнө Монгол Улсын ерөнхий сайдаар ажиллаж байсан Дашийн Бямбасүрэн гуай Монгол Улс бол ядуу улс биш ээ. Монгол Улс байгалийн баялагтай баян улс. Гагцхүү дээр нь байгаа хүмүүс ханаж цадахгүй хулгай хийгээд байгаа учраас өнөөдөр ийм байдалтай байгаа юм гэдгийг хэлж байсан. Би тэр бол буурал дарга бас улс төржсөн байдаг юм уу, тийм биш үнэхээр бодит байдлыг л хэлж байсан юм уу л гэж боддог юм. Гадаа ард иргэд юу гэж ярьдаг вэ гэхээр 1.500.000 километр квадрат нутагтай, 3 сая гаранхан хүн амтай, байгалийн асар их баялагтай, бүх хүмүүс нь бичиг үсэг тайлагдчихсан, 70 сая малтай ийм байж бид яагаад ингэж амьдраад байгаа юм бэ гээд. Тэгээд энэ бүхэн өнөөдөр явж явж ард түмний нэлээн тийм хилэн тэсэрч байна л гэж л харж байгаа л даа. Тэгээд ер нь томоохон хэргүүдийг хараад байхад Эрдэнэт, Хөгжлийн банк, одоо энэ нүүрс гээд л хараад байхад үнэхээр ч бас ард түмний тэр гайхаад байгаа, тэр олон жилийн өмнө тэр Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүний хэлсэн үг нийлж байна л гэж хараад байгаа юм. Тэгээд ер нь нэг хагархай цонхны онол гэж байдаг юм байна лээ шүү дээ. Нэг цонх хагарчихад тэрийг хурдан нөхөхгүй бол тэр цонх байшингийн бүх цонх хагараад дуусдаг. Тэр битгий л хаалгыг нь эвдээд ордог ийм санал байдаг юм байна лээ. Тэгээд энэ томоохон хэргүүд шийдэгдэхгүй байгаагаас ер нь ингэж болдог юм байна гэсэн ийм ойлголт төрийн бүх л шатанд төрөөд, тэгээд өнөөдөр харин Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд Авлигын хууль, Эрүүгийн хууль, тэр дундаа яг албан тушаалтнуудтай холбоотой байгаа хуулийг чангатгаж оруулж ирж байгаа

нь магадгүй энэ цагаас хойш төрийн бүх шатанд, хувийн хэвшил дээр ч тэр авлига, албан тушаалын асуудлууд нэлээн цэцэрэх юм болов уу гэж бодож байгаа.

Тийм ч учраас өнөөдрийн энэ хуулийг дэмжиж байгаа юм. Нэг асуудал байгаа юм. Юу гэх саяхан Монгол Улсын Дээд шүүхийн 3 шүүгчийг танилцуулах танилцуулга Их Хурлын чуулганд явагдсан. Энэ үеэр би Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаас тодорхой асуултууд асууж байсан. Тэр нь юу вэ гэхээр шүүх хуралдаан ялих, ялихгүй шалтгаанаар маш их хойшилдог. 18 удаа хойшилж байна гэдэг. Тэр битгий хэл 50 удаа хойшилсон ийм тохиолдлууд ч бас шүүхийн практикт байдаг юм байна лээ. Энэ талаар асуухад Шүүхийн ерөнхий зөвлөлийн Зүмбэрэлхам дарга юу гэж хариулсан гэхээр. Шүүх процессын хуульд нэлээн алдаа байх шиг байна. Энийг бид нар засаж, залруулах ёстой юм гэсэн ийм тайлбарыг хэлж байна. Тэгэхээр би Нямбаатар сайдаас ер нь цаашидаа шүүх процессын асуудлыг ер нь бас яаж шийдвэрлэх юм бэ. Энэ шүүх дээр хэрэг маш ихээр буцдаг. Зарим нэг хэргүүд бүр 10 жил ч болж байгаа тохиолдлууд байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ Эрүүгийн хуулийн өөрчлөлт дээр тусгагдаагүй ч гэлээ гэсэн ер нь Монгол Улсын Хууль зүйн яам, хуулийн бодлогыг барьж байгаа хүмүүс энэ тал дээр ямар бодлого баримталж байгаа юм бэ гэдгийг би асууя гэж бодож байгаа юм.

Эцэст нь бол одоо энэ хууль яаралтай горимоор орж ирж байгаа учраас гишүүд саналаа хэлээд, батлагдаад цаашаа хэрэгжээд, батлагдсан цагаасаа хэрэгжээд явах байх. Тэгэхээр бид хууль батлаад, хуулийг сурталчлах ажлыг орхигдуулах гээд байдаг нэг ийм талтай. Тэгэхээр энэ хууль маань өнөөдөр төрд ажиллаж байгаа, хувийн бизнес эрхэлж байгаа энэ 1 сая гаруй хүнд хамаарах үйл ажиллагаатай нь шууд холбогдох учраас энэ хуулийг сурталчлах ажлыг батлагдсан цагаас нь эхлээд маш

шуурхай явуулж, танилцуулах, танин мэдэх, сурталчлах энэ ажил руугаа би төрийн бүх л шатны байгууллагууд ажиллаасай гэж бодож байгаа юм. Энэ бол олон хүнийг эрсдэлээс хамгаална. Хуулийн хэрэгжилт нийгэмд илүү хүчтэй тусах болов уу гэж, хүрэх болов уу гэж бодож байгаа. Саналаа цуг хэлье гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Түрүүн Баярсайхан гишүүн их зөв асуудал хөндөж байна лээ. Ялын бодлогыг чангатгаад ирэхээр салбарын хууль сахиулагчид, шүүх, прокурорын байгууллагад авлигын асуудал чинь эргээд гарчих вий гээд. Тэгэхээр бид нар нөгөө тогтолцоогоо л яаж зөв болгох вэ гэдэг асуудал яриад байгаа юм. Тэгэхээр Засгийн газраас удахгүй шүүх байгуулах хууль буюу Монгол Улсын шүүхийн тогтолцоог шинээр эмхлэн байгуулах хуулийн төсөл оруулж ирэхээр бэлдэж байгаа юм. Энэтэй уялдаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүхийн процесстэй холбоотой, процессын дүрэм журамд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа гэдгийг хэлье. Бид нар 2021 онд шүүхийн хуулиа баталсан. Шүүхийн хуулиар бид нар шүүхийн үндсэн суурь зарчмуудыг тодорхойлж өгсөн. Шүүхийн ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчдийг хэрхэн шилж сонгож, Ерөнхийлөгчөөр батламжлуулах уу, шүүгчээр тохоон томилогдсон хүн маань ямар ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргахгүй байх ёстой. Хэрэв мэргэжлийн алдаа, ёс зүйн алдаа гаргавал Шүүхийн сахилгын хороо гэдэг байгууллага ямар арга хэмжээ авах вэ гэдэг Шүүхийн ерөнхий хуулийг баталж гаргасан. Одоо бид нар нөгөө Шүүхийн тухай хуулиа гаргах гээд байгаа юм. Зарим аймаг дээр 7 шүүх байна л даа. Эрүүгийн анхан шатны 1 дүгээр шүүх, Эрүүгийн анхан шатны 2 дугаар шүүх, Иргэний анхан шатны 1, 2 дугаар шүүх, Захиргааны хэргийн шүүх, Эрүүгийн давж заардах шатны шүүх,

Иргэний давж заалдах шүүх гээд. Тэгэхээр бид нар шүүхийг илүү оновчтой, шүүхээр үйлчлүүлж байгаа хүмүүстээ илүү хүртээмжтэй, хэргийн ачааллыг тэнцвэржүүлж, байгуулах шаардлагатай байгаа юм. Зарим газрын шүүх жишээлбэл жилд 3, 4 хэрэг шийддэг ийм шүүхүүд байна. Аймгийн Захиргааны хэргийн шүүхүүд. Тэгэхээр жишээлбэл 2 аймгийн хооронд 60 километр засмал замаар холбогдсон газруудад бид нар татвар төлөгчдийн мөнгийг хэмнэж, зөв оновчтой хуваарилах үүднээс шүүх байгуулах хуулиа оруулж ирнэ. Ингэхдээ цуг процессын зарим өөрчлөлтүүдийг оруулж ирэхээр төлөвлөж байгаа гэдгийг хэлье.

Дээр нь ер нь Баярсайхан гишүүний асуултад нь ч гэсэн Идэрээ гишүүний асуултад нь хамтатгаад хариулахад бид нар тогтолцоогоо шинэчлэхгүйгээр мянга илүү өөдрөг үр дүн хүсэн хүлээгээд хэрэггүй. Тийм учраас цаашид бид нар Үндэсний мөрдөх албаны шинэ тогтолцоог бүрдүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн яам дээр судалгаа хийгдээд, төсөл боловсруулагдаад явж байгаа. Гэхдээ эдгээр тогтолцооны шинэчлэлийг хийхийн тулд бид нар дандаа зөвшилцөл дээр хийх ёстой. Сөрөг хүчинтэйгээ ойлголцож байж, бусад намуудтайгаа ойлголцож байж энэ тогтолцооны шинэчлэл рүүгээ явна. Даргыг нь томилохдоо зөвхөн эрх барьж байгаа намын хамтын шийдвэр, олонхын шийдвэрээр биш. Нөгөө НҮБ-ын шийдвэр гаргалтын үндсэн зарчим буюу зөвшилцөл гэж байдаг. 100 хувь зөвшилцөлд хүрч байж томилдог тэр ... /минут дуусав/

Г.Занданишатар: Тогмидын Доржханд гишүүн. Алга байна. Жамбын Батсуурь гишүүн алга байна. Ер нь гишүүд анхаарахад Их Хурал хууль тогтоогч болохоос биш хууль биелүүлэх ч юм уу, шүүх эрх мэдэл биш. Тусдаа заавал байх ёстой эрх мэдлийг нь тусгаарласан. Хэрэг яриад байж

болохгүй. Түрүүн тийм жишээнүүд гараад байгаа учраас анхааруулахад. Засгийн газар бол хууль биелүүлэх асуудлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. Мөрдөн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг мөрдөх байгууллагууд Засгийн газар хэрэгжүүлнэ. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд прокурор хяналт тавина. Гэм буруутайг шүүх тогтооно. Үндсэн хуулийн үндсэн суурь зарчим яг л ийм л зарчим дээр үндэслэгдэнэ. Хууль тогтоогчдын шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж яриад байгаа. Энд хэрвээ ярих юм бол бид шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх гэж байгаа оролдлого болоод явчихна. Энэ бол гэмт хэрэгт тооцогдож явдаг юм. Бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульд бид анхаармаар л байгаа юм. Шүүх хуульд оруулсан юм санааг нь. Одоо Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Яах вэ тэр Улсын Их Хуралд сонгогдоод, ард түмний мандат хүн хэдийд юугаа ярихаа өөрөө мэдэх байх. Тэрэнд их заавар, зааварчилгаа өгөх гээд байх шаардлага байхгүй. Энэ уг нь Эрүүгийн хуулийг ийм нөхцөл байдалд ингэж ярьж болохгүй л дээ. Тэгээд түргэн түүхий, гал унтраах, улс төрийн маягаар иймэрхүү асуудлыг шийдэж болохгүй л юм байгаа юм. Энэ дээр та нар юу гэж бодож байна. Манай мэргэжилтнүүд. Өглөө Ерөнхий сайд улс төрийн чанартай үг хэлчхээд гараад явчихлаа. Тэгээд энэ уур амьсгалаа дарахын тулд ийм хууль оруулж ирлээ гээд явж байна. Авлигатай тэмцэх авлигын индекс гэж байдаг. Тэр уг нь 60, 70 руу ороод ирчихсэн байсан. Өнөөдөр 110-д байна уу, 112-т байна уу. Өнөөдөр авлига, албан тушаалын хэргүүдийг л яриад байна л даа. Тэгээд тооцоо судалгаа хийсэн үү. Энэ хуулийг гарснаараа ямар үр дүн гарах юм, яах юм. Өмнө нь юу юун дээр алдсан байсан юм гэсэн тооцоо судалгаа байна уу. Яг юундаа байгаа юм. Тэгээд болдоггүй, барьдаггүй байсан юм бол өмнө нь яагаад

энэ хуулиа өөрчилдөггүй байсан юм. Тэгээд өмнө нь гэмт хэрэгтнүүд шийтгэгддэггүй байсан юм уу. Зохих ялаа авдаггүй байсан юм уу. Өмнө нь энэ хүмүүс тэгээд ял завичихсан гэсэн үг үү. Юундаа байна. Энийг та бүхнээс сонсмоор байна. Нөгөө талаар хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн 6, 7 жилд яаж, яаж өөрчлөв. Хэн хэний бүрэлдэхүүнтэй, ямар ямар үед, яаж өөрчлөв. Тэрийг нэг мэдмээр байх юм. Одоо энэ ял завихсан маш их ард түмний баялгийг хулгайлчихсан ийм хүмүүсийн мөнгө, төгрөгийг хаана яах юм. Тэр зарим мөнгө төгрөг нь гадаадад оффшорт байна гээд байх юм. Тэрийг олж илрүүлэх, авчрах, ард түмэнд нь буцааж хурааж өгөх ийм юм байх уу. Энэ хууль дээр ийм зүйл заалт байна уу. Тэгээд уг нь бол энэ Засгийн газар ч байдаг юм уу бид нар ийм байдалд оруулчихжээ. 2, 3 жил энэ юмны хажуугаар ингээд явчихсан байна эсвэл зохих хуулийг бид нар хугацаанд нь оруулж ирээгүй юм байна гээд харцуцлагаа хүлээгээд, дараа нь бас энэ хуулийг ярилцвал зүгээр юм байгаа шүү дээ. Ингэж шат дараатай. Тэгэхгүй бол улс төрийн уур амьсгалаар иймэрхүү маягаар хандаад, ингэж явж хэдэн гишүүдээ янз янзаар зарлаад л. Энэ төрийг бас дархлааг нь байхгүй болгох гээд, тэгээд хэн нэгэн сайд нь ч юм уу Улсын Их Хурлыг тараана гээд л дуртай хүмүүс нь тийм юм байхгүй шүү дээ. Хаашаа юу руу уриалаад байгаа юм. Гэх мэтчилний ийм асуултууд байна. Судалгаа шинжилгээ энээ тэрээ юм чинь алга байна. Тэгээд жишигээр Авлигатай тэмцэх газрыг өмнө нь зөндөө хонгил угсарч байсан. Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхийлөгч нь тавьдаг байсан. Одоо Ерөнхий сайд нь тавьдаг болчихсон. Авлигатай тэмцэх газар бол тусгай субъектийг эрхэлж байцааж авдаг. Тэгээд Нийслэлийн прокурор дээр шийдүүлээд ингэж шийддэг. Тэгээд юм сайжирсан юм уу. Бүгд л захиалгаар явдаг шүү дээ. Энийг юу гэж бодож байна. Иймэрхүү юм байна уу, байхгүй юу. Тэгээд яагаад өмнө нь сайн байгаагүй юм. Хуульдаа байсан юм уу. Хууль

хэрэгжүүлж байгаа хүмүүст байсан юм уу. Юундаа байсан гэж бодож байна.

Г.Занданшатар: Нямбаатар сайд хариулна. Хишигээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Таныг нөгөө бүлгийн даргын өгнө, өгөхгүй гээд яг хэрүүл хийж байх үед 5 сард энэ хуулийг чинь хэлэлцэх эсэхийг шийдчихсэн шүү дээ. Та маш завгүй байсан. Тэр үед яг одоо бид нарын ширээн дээр чинь тавьчихсан байгаа авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлогыг чангатгах өөрчлөлт хамт орж ирсэн юм. Тэгэхээр тооцоо судалгаа нь тэр үеэр хийгдсэн.

Хоёрдугаарт. Монгол Улсын Засгийн газраас төрийн өмчит компанийнхаа хуулийг Улсын Их Хуралд өргөн барьчихсан байгаа шүү дээ. Энэ жагсаал цуглааны сураг чимээ байхгүй байх үед Төрийн өмчит компаниудыг ер нь 4, 4 жилээр төр ямар бизнесийг хийх, хийхгүйгээ шийддэг болж гээд хуулийн төслөө өргөн барьчихсан байгаа. Таны зөвлөхүүд ер нь ажил хийхгүй байна даа. Танд ямар хуулиуд орж ирж байгаа энэ тэрийг ерөөсөө мэдээлэхгүй юм.

Хоёрдугаарт Ганбат дарга Transparency international байгууллагын жил болгон гаргадаг Авлигын төсөөллийн индексээр бид 110 дугаар байрт байгаа нь үнэн. Энэ байгууллага сүүлийн 5, 6 жилийн хугацаанд үнэлгээ гаргадаг аргачлалуудаа өөрчилсөн. Бидэнд 3 юм хий гэж үүрэг өгсөн. Ганбат дарга би таныг бас энийг дэмжиж ажиллах байх гэж бодож байна.

Нэгдүгээрт Төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруул гэдэг ийм зөвлөмжүүдийг өгсөн.

Хоёрдугаарт Улс төрийн намуудынхаа санхүүжилтийг тодорхой болго.

Гуравдугаарт шүгэл үлээгч буюу олон нийтийн хяналтыг гаргаж ир гэдэг ийм үүрэг өгсөн.

Монгол Улсын Засгийн газраас Төрийн өмчит компанийн хуулиа өргөн мэдүүлээд байгаа. Шүгэл үлээгчийн хуулийнхаа төслийг өргөн мэдүүлээд байгаа. Тун удахгүй Улс төрийн намуудын тухай хууль, Улс төрийн намын санхүүжилтийн хуулиудаа өргөн мэдүүлэхээр төлөвлөж байгаа. Монгол Улс, Олон улсад шалгуур үзүүлэлт болгодог хамгийн гол индекс болох *rule of law* индексээр 60 дугаар байрт явж байгаа шүү. Та утсан дээрээ ороод нэг үзээрэй. Хууль засагладаг индексээрээ бид нар дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын яг араас 60 дугаар байрт байгаа. Би өчигдөр орж үзсэн. Өөр асуулт байвал би хариулъя.

Г.Занданишатар: Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Ганбат даргын асуулт дээр нэмээд хариулъя. Ер нь мэдээж энэ 2 хуулиудын зааг дээр асуудлууд өрнөж байгаа гэдгийг яг энэ цаг хугацаанд ойлгоосой гэж хүсэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол 2002 оны Эрүүгийн хууль өнөөдөр 2015 онд батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 1-ээс өмнө Эрүүгийн хуулийн орчин үйлчилж байгаа юм. Тэгэхээр энэ орчныг дагаад хялбаршуулсан гэдэг юм уу энэ ялын бодлогын өөрчлөлтүүд явж байгаа. Өмнө нь бол жишээ нь 2002 оны Эрүүгийн хуулиар төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэдэг гэмт хэрэг дээр хохирол шаарддаг байсан. Үлэмж хэмжээний буюу тухайн үеийн үлэмж хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-100 дахин хамаатуулж үздэг. Тэгэхээр өмнө нь гэмт хэрэг гэж үздэггүй байсан зүйлүүдийг шинэ 2017 оны 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж байгаа хуулиудаар гэмт хэрэгт тооцож байгаа. Өнөөдөр 1 төгрөг гэдэг юм уу хохирол учруулаагүй

байсан ч албаны эрх мэдлийг тодорхой хэмжээнд урвуулан ашигласан асуудлыг гэмт хэрэгт тооцож байгаа. Энэ байдлаараа авлига, албан тушаалын гэмт хэрэг тодорхой хэмжээнд өсөж байгаа. Тэгэхээр ер нь юу гэдэг юм хуулийн бодлого цаашидаа чангараад явж байгаагийн үр дүн гарч байгаа юм. Тэрнээс биш юу юугүй бас өмнө нь бүх зүйлс их сайхан байсан одоо ингээд балраад байгаа гэдэг зүйл биш. Мэдээж энэ тодорхой хууль, эрх зүйн зохицуулалтын үр дагавар гэдэг юм уу энэ шууд үр дагавраар энэ зүйл илэрхийлэгдэж байгаа. Нэг талаасаа хэлэхэд, нөгөө талдаа бас үе үеийн Засгийн газрын бас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл бас эргээд шүүх, прокурорын байгууллагуудын энд хяналт тавьж, хэргийг хянан шийдвэрлэж байгаа тоон үзүүлэлтүүд өсөж байгаа нь өөрөө эргээд тодорхой нийгэмд үүсээд ямар ихэссэн юм бэ ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр энийг бас тодорхой хэмжээнд *rule of law* буюу хууль дээдлэх ёс ажиллаж байна л гэж бас хэлмээр байгаа юм. Энийг харин улам цаашидаа чамбайруулж, ялын бодлогоо чангатгая гэсэн бодлоор өнөөдрийн хууль өргөн баригдсан.

Г.Занданишатар: Тэр гэмт хэргийн бүрэлдэхүүнээс материаллаг бүрэлдэхүүнийг хасахаар субъектив хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсноо бол засаагүй зөв гэж үзэж байна уу. Нэг төгрөгийн ч гэсэн хохиролтой бол гэж байсан бусдад хохирол учруулсан байсан гэдгийг шүүх юу гэж үздэг юм ер нь. 80.

Б.Батцэрэн: Улсын Дээд шүүхийн шүүгч Батцэрэн. Тэгэхээр нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэргийг урьд нь материаллаг бүрэлдэхүүнтэй байсныг 2015 оны Эрүүгийн хуулиар хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгосон. Хохирлын хэмжээг үл харгалзаж өөртөө болон өөрийн хамаарал бүхий бусад хүнд давуу байдал олгосноор энэ гэмт хэргийн шинж хангагдах юм. Тэгэхээр энэ гэмт

хэргийн үндсэн шинж бол Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 16 дугаар зүйлд заасан тодорхойлолттой бол нийцэж байх ёстой. Ер нь хуулийг хэрэглэхдээ бид Монгол Улсын хууль болон Олон улсын гэрээний заалтыг баримтлах, баримталж хуулийг тайлбарлан хэрэглэдэг. Тэгэхээр авлигын эсрэг гэмт хэрэг бол нэгдүгээрт албаныхаа эрх ашгийн эсрэг байх ёстой.

Хоёрдугаарт, хувийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх энэ 2 үндсэн шинжийг хангаж байж гэмт хэргийн шинж нь хангагдана. Тэгээд давуу байдал нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод зааснаар хууль бус буюу зүй бус ийм давуу тал бий болсноор гэмт хэргийн шинж хангагдсан гэж өнөөдөр шүүхийн практикт тайлбарлан хэрэглэж байгаа юм. 22.1 дүгээр зүйлийн тусгай зохицуулалтууд бий. Энэ нь бол түрүүн Баярсайхан гишүүний асуудаг төрийн өмчийг эсвэл төсвийн хөрөнгийг албан тушаалын байдлаа ашиглаж, хохирол учруулсан хэрэг байгаа юм. Энэ бол албан тушаалын гэмт хэргийн 22.1-д зааснаас ялгагдах ялгаа нь бол нэгдүгээрт халдлагын зүйлээрээ ялгагдаж байна. Энэ бол төрийн өмч эсвэл төсвийн хөрөнгө.

Хоёрдугаарт субъект нь нийтлэг нийтийн албан тушаалтан боловч энэ тохиолдолд төсвийн захирагч нар орж ирж байна. Дээр нь сэдэлт дээр ялгагдана. Мөн үйлдлийн аргаараа ялгагдаж байгаа. Тэгэхлээр 22.8, 88.9 төрийн байгууллагын төсвийн бус хөрөнгө эдгээрт албан тушаалын.../минут дуусав/

Г.Занданшатар: Тодруулъя. Дашдондогийн Ганбат гишүүн. 1 минут.

Д.Ганбат: Баярлалаа би асуугаад байгаа юм л даа. Одоо энэ гадаа байгаа нөхцөл байдал, ард түмний ядуу байгаа, хэдэн хүний төрийн өмчийг завшаад баяжчихсан энэ нөхцөл байдал чинь тэгээд хуульдаа байна уу, хууль хэрэгжүүлээд байгаадаа байна уу. Яг

юундаа байна вэ л гэж асуугаад байгаа шүү дээ. Та нарт тийм шинжилгээ, судалгаа байна уу. Тэрнээс биш би тэр улс төрийн талаар маргалдах хүсэл алга. Цаг хугацаа олоно. Маргалдаж болно. Тэгээд тэрийгээ амьдрал дээр харуул даа. Үгүй ээ, ард түмэн чинь тэрийг л хүсээд байна шүү дээ. Энэ хууль бодлого, шийдвэр чинь амьдрал дээрээ буугаад энэ ард түмэн чинь өнөөдөр сайн, сайхан байгаа бол гадаа ингээд жагсахгүй биз дээ.

Нэг хэсэг нь баяжчихсан, орон шоронд ч орсон юм байхгүй. Ингээд л ард түмнийг доромжлоод л яваад байгаа гэж харж байна шүү дээ. Энийг чинь зохицуулах ёстой л гэдгийг хүсээд байна шүү дээ. Бид хоёрын тэр улстөржих яах вэ. Би өөр янз бүрийн юм яривал.../минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Энэ жагсаал, цуглааны асуудал дээр би жагсагчидтай, төлөөллүүдтэй байнга уулзаж байгаа. Ер нь би сүүлийн 3 жилийн хугацаанд болж байгаа бүхий л жагсаал, цуглаан зохион байгуулсан хүмүүстэй уулзаж, тавьсан шаардлагуудыг нь шийдэхийн төлөө ажиллаж байгаа юм. Тэгэхээр зөвхөн өнөөдөр үүсчхэж байгаа зүйл биш ээ Ганбат гишүүн ээ. Та энэ дээр бас туршилагатай улс төрч хүний хувьд. Энэ өнгөрсөн 30 жилийн бид нарын алдаатай явсан бодлогыг л дүгнэж байгаа юм. Өөрөөр хэлбэл анхнаасаа өмч хувьчлал алдаатай явагджээ. Нийгмийн баялаг тэгш бусаар хуваарилагджээ. Газрын баялаг лиценз нэрийн дор цөөхөн хэдэн гэр бүлд очжээ. Өмч хувьчлал хийгдэхдээ тухайн үед мэдээлэлд ойр байсан хүмүүс нь авчээ гэдэг ийм л зүйл байгаа юм. Тухайлахад хүн болгон Тань ишг Материал импекс гэдэг компанийг хувьчилж авч чадаагүй байна шүү дээ. Тэгэхээр энэ бол өөрөө асуудал нь ерөөсөө өнгөрсөн 30 жилийн тэгш бус байгаад л бухимдаж байгаа ийм

хүмүүсийн бухимдал дээд цэгтээ хүрсэн. Дээр нь сүүлийн жилүүдэд Төрийн өмчит компаниудыг улс төрд нөлөө бүхий этгээдүүд томилдог, тэр нь эргээд өөрөө засаглалын хувьд ил тод биш, тэгш шударга биш байгаад л уурсан олон түмний бухимдал. Тийм учраас энэ олон түмний бухимдлын энэ шаардлагыг бид нар хүлээж авч маш богино хугацаанд төрийн болон орон нутгийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулж, зарим зүйлүүдээ зоригтой төр өөрөө хувьчлах хэрэгтэй. Төр хувийн секторуудтай байнга өрсөлдөж, тэмцэлдэж өөрсөд дээрээ ашигтай, ашиггүй байсан ч гэсэн хувийн секторуудаа татаж унагаадаг энэ явдлыг таслан зогсоох ёстой гэдэг бас нэг шаардлага явж байгаа юм. Дээр нь бид нар томоохон орд газруудаа эзэмшиж байгаа уул уурхайн компаниудаа гадаадын хөрөнгийн биржүүдээр гаргаж нээлттэй хувьцаат компани.../минут дуусав/

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээрт энд горимын санал байна Их Хурлын дарга аа. Аливаа хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй холбоотой олон нийтийн санал хүсэлт ирэх юм бол энийг нээлттэй оролцуулж болно гэсэн ийм 37 дугаар зүйлд нэг агуулга байгаа юм. Энийг Байнгын хорооны хурал дээр гудамжинд жагсааж байгаа хүмүүсээ оруул. Шаардлага тавьж байгаа хүмүүсийг. Ерөнхий прокурорын газар Чинбат прокуророос нэг юм асууя. Ингээд 20, 30 хүний нэр зарлалаа. Танайх цагдаагаас хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаанд явагдаж байгаа хэрэгтэй холбоотой аливаа нэг юмыг танайхаас зөвшөөрөл авдаг. Зарладаг. Мөрдөх байгууллагууд та нар энэ хүмүүсийн нэрийг зарлахдаа ер нь бол цагдаагаас явж байгаа мэдээллүүд Авлигатай тэмцэх газраас явж байгаа мэдээллүүд чинь

тогтоогдсон нотлох баримтаар, шүүхэд шилжих үед нь нэрс байтугай эхнийх нь үсгийг нь л зарладаг юм шүү дээ. Одоо энэ дотор өнөөдөр 7, 8 хүн байх шиг байна. Энэ хүмүүс жишээлбэл би ямар хэрэг хийсэн бэ. Та энийг ярьж өг. Танайхаас зөвшөөрөл авсан юм уу, аваагүй юм уу. Танай хулс төрийн захиалга гүйцэтгэдэг байгууллага болчихсон юм уу эсхүл энийгээ хэлж өг гэж асуумаар байна.

Хоёрдугаарт боловсруулсан хуулийн төслөөс асуух асуулт байна. Энэ дотор хээл хахууль авах гэж гэмт хэрэг дээр 22.4.5 дээр улс төрд нөлөө бүхий этгээд хээл хахууль авсан бол 2-8 жилийн ял авахаар байсан. Улс төрд нөлөө бүхий этгээд эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэглэл гэж. Энэ Таван толгой дээр орсон энэ явж байгаа мөнгөн дүнтэй холбоотой юмнууд бол олон сая тонн нүүрс хулгай хийсэн бол энэ зохион байгуулалттай бүлэг, гэмт хэрэг. Энийг яриад байгаа. Тэр хил дээр ажиллаж байгаа бүх байгууллагууд зохион байгуулалтад орсон байна гэсэн үг. Тагнуул, Хил, Гааль, Иргэний харьяат, Мэргэжлийн хяналт. Тэгээд яагаад энэ дээр хээл хахууль авах гэсэн тэр 22.4.5-ыг хасчхав. Улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг үгийг яагаад хасчхав. Энэ хуулийг хүнд зориулж хийж байна. Та нар хэнд зориулж хийгээд байна. Энийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт 22.1. Би “Эрдэнэс таван толгой”-н удирдлагуудтай холбоотой юм асууна. Ганхуяг гэдэг хүнд өнөөдрийн байдлаар 22 дугаар зүйлээр ял өглөө гэхэд 22.1 гээд явахад 1-5 жилийн ял авна. Энэ хүн та нарын өргөн барьсан төслийн гэм буруугаа өөрөө сайн дураараа хүлээн зөвшөөрөх юм бол гээд 6.7 дугаар зүйл дээр 5 жил хүртэлх ялтай бол өөрөө сайн дураараа гэм буруугаа хүлээн зөвшөөрөх юм бол энэ хүнийг ялаас чөлөөлөөд, дээрээс нь өөрөөр нь сонгуулаад ийм хариуцлага хүлээлгэнэ гэж байгаа юм.

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол эсхүл өөрөө гэмт хэргээ хүлээн зөвшөөрсөн бол хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулна. Эсхүл хорих ял оногдуулахгүй, 3 жил хүртэл хугацаагаар тэнсэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэнэ гэж байгаа юм. Энэ яагаад ингэжхэв. Энэ хүн өнөөдөр яг ийм байдалд л хоригдож байгаа, яллагдагчаар татсан 20, 30 хүн ингээд л явна. Одоо нөгөө удирдагч нар нь алсын удирдлагатай машинаа хамгаалж эхэлж байна шүү дээ. Алсын удирдлага ордон дотор байгаа. Энэ ордон дотор байгаа хулгайч нараа та нар өнөөдөр энэ хуулиараа хамгаалж үлдэж байна. Яагаад тэр гэм буруугаа хүлээгээд хэргээ илчилсэн хүмүүс дээр байсан хуучин зүйлийг та нар хасаад хаячхаж байгаа юм бэ. Нийт ялынхаа 2/3-ыг эдлүүлэх, эсхүл нийт ялын 1/2-ыг нь эдлүүлнэ гээд эдлэх ялынх нь хэмжээнээс хамаараад байсан тэр хязгаарыг та нар байхгүй болгоод, 5 жил хүртэл ялтай бол энэ хооронд ерөөсөө хорих ял өгөхгүйгээр та нар ингээд чөлөөлөөд хаячихлаа шүү дээ. Юун торгуулийн 40 сая вэ. Тэр 40 саяар чинь далимдуулаад бүр бүгдийг нь чөлөөлөөд явуулж байна шүү дээ. Гэртээ 5 жил очиж амьдар, амар.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг. 81.

П.Сайнзориг. Зарим асуултад нь хариулъя. Заримыг нь прокурорын байгууллагаас хариулах юм байна. Ерөнхийдөө энэ хахууль авах гэмт хэрэг дээр ял чангарчхаад байгаа гэдгийг Раднаасэд гишүүнд хэлмээр байгаа юм. 2-8 жил байсныг та нар байхгүй болгоод хаячихлаа, хааччихав гээд байдаг. Харин хахууль авах гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий зохион байгуулалттай этгээдүүд үйлдэх юм бол 12-20 жилийн ялтайг болохоор оруулж ирж байгаа юм. Энэ нөгөө 22.4 гээд орж ирж байгаа гишүүн ээ. Тэгэхээр ийм зүйл байгаа гэдэг зүйлийг танд хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт. 6.7-г яг тайлбарлахад бол энэ нь өөрөө эргээд нэгдүгээрт яг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхнээс нь авхуулаад түргэн шуурхай явуулах болон хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэх гэдэг нөхцөлийг тавьж байгаа юм. Түүнээс биш хэрэг боогдсоны дараа би ингэмээр байна гэдэг зүйлийг ерөөсөө тооцохгүй шүү гэдэг энгийн үгээр хэлэхэд тэгэхээр энийг ийм нөхцөлд тавьж байгаа нь өөрөө эргээд харин хатууруулж байгаа юм. Анхнаасаа тэр хүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцохгүй бол хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй гэсэн үг.

Хоёрдугаарт яг 6.7ийн 1.1, 1.2 бол үндсэндээ тодорхой хөнгөн гэмт хэргүүд дээр л байгаа. Зарим 22 дугаар бүлгийн гэмт хэргүүдийн энэ нь өөрөө эргээд үндсэн бүрэлдэхүүн дээр орно. Өнөөдрийн тодорхой бас хэвлэлээс л харж байгаа нөхцөл байдлаас харахад бол зарим Төрийн өмчит компаниудын асуудалтай холбоотой юмнууд бол үндсэн бүрэлдэхүүнээр зүйлчлэгдэх бололцоогүй л юмнууд харагдаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол шууд чөлөөлөөд явуулах гэж байгаа, 5 жилээс доош хорих ял оногдуулах гэмт хэрэг дээр л тэр тэнсэх асуудал байна уу гэхээс биш, түүнээс дээш хорих ял буюу оногдуулах гэмт хэрэг дээр тэнсэх, чөлөөлөх асуудал байхгүй гишүүн ээ. Тэгэхээр энэ дээр таны ярьж байгаа чөлөөлөөд явуулах гэж байгаа юм байна, суллаад явуулах гэж байгаа юм байна гэдэг зүйлээ байхгүй гэдэг зүйлийг бас хэлье ээ.

Г.Занданшатар: Өөр нэмж хариулах хүн байна уу. Прокурор хариул гэсэн байна. 84. Максимын Чинбат. Ерөнхий прокурорын орлогч бөгөөд Төрийн хууль цаазын шадар зөвлөх.

М.Чинбат: Раднаасэд гишүүний асуултад Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат Хариулъя. Тэгэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуулийн 29.3 дугаар зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалын асуудлыг зохицуулсан байдаг. Нүүрсний гэх тодотголтой нүүрс олборлолт, тээвэрлэлт, экспортлох мөн зөвшөөрөлтэй холбоотой хэргүүдийг Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тус тусдаа өөр өөрсдийнхөө хэргийн харьяаллынхаа хувьд тус тусдаа шалгаж байсан. Энийг нь Улсын ерөнхий прокурорын газраас хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажлын хэсэгт эдгээр 3 байгууллагын төлөөллүүд ороод ажиллаж байгаа. Өчигдрийн Авлигатай тэмцэх газар дээр хийгдсэн хэргийн мэдээллийн хувьд тухайн хэрэгт хяналт тавьж байгаа Нийслэлийн прокурорын газарт Эрүүгийн цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газрын мөрдөх байгууллагынхан хэргийнхээ талаар танилцуулга хүргүүлж, бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нь прокурор хүсэлтийг нь хүлээж авч зөвшөөрлийг олгосон. Энэ хүрээнд тухайн байгууллагууд мэдээлэл хийсэн байна.

Г.Занданишатар: Раднаасэд гишүүн тодруулъя. 1 минут.

Ш.Раднаасэд: Мөрдөн шалгах чиг үүргээ Чинбат прокурор өөрөө хариуцаж байгаа. Жишээлбэл би ямар хэрэгт холбогдсон юм бэ. Би тэрийгээ сонсъя. Энэ 5, 6 хүн ямар хэрэгт холбогдсон юм бэ. Би энийгээ л сонсмоор байна. Энийгээ л сонсмоор байна. Түүнээс тэнд ингээд шалгаад ингэсэн гээд ийм утгагүй юм явж болохгүй байна шүү дээ. Одоо энэ жинхэнэ хулгайчид нь яагаад тэгвэл зарлагдахгүй байгаа юм. Ард түмэн гудамжинд гаргаад тавьчихсан самбар дээр байгаа мэдээлэлтэй, бодитой л юм яваад байна лээ шүү дээ. Энэ хулгайчдыг тэгвэл яагаад зарлахгүй байгаа юм та нар. Энийгээ л та нар хэлж өг.

Хоёрдугаарт энэ Ардчилсан намын бүлэг энэ дээрээ завсарлага аваад энэ хуулиа өөдтэй болгооч ээ. Энэ дотор чинь их асуудал байна. Их асуудал байна.

Өнөөдөр тодорхой хэрэгт зориулж хууль бичнэ гэдэг бол яагаад ч сайн биш шүү. Энэ ерөөсөө л үндсэн зорилго нь тэр хүмүүсийг аврах зорилттой л хуулиуд юм.../минут дуусав/

Г.Занданишатар: Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна. Эрүүгийн хууль ярьж байгаа юм шиг хэрэг ярих юм уу. Прокуророор хэлэх гэсэн юм уу. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Ер нь бол хариулах нь зөв шүү. Би бас нэг хулгайд хардагдсан, зарлагдсан хүний нэг байна. Би бас ямар хэрэг хийснээ мэдэхгүй байгаа юм. Эрүүгийн хэрэг нээсэн юм уу. Надтай уулзаагүй, мэдүүлэг аваагүй тэгээд олон нийтэд зарлачихсан. Энэ чинь хүний нэр хүндийн асуудал гээд зөндөө юм байна шүү дээ. Тэгээд энэ дээр Раднаасэд гишүүнтэй адилхан хариултыг нь Раднаасэд гишүүний хариултаар нь минийхийг нэмээд хариулаач гэж. Дараа нь би асуултаа асууна.

Г.Занданишатар: 82.

М.Чинбат: Энэ нүүрсний гэх тодотголтой ажлын хэсгийг шалгаж байгаа эрүүгийн хэргүүд дээр Нийслэлийн Прокурорын газраас хяналт тавьж ажиллаж байгаа. Тийм учраас тухайн хяналт тавьж байгаа прокурорынх нь бололцоотой гэсэн мэдээллийн дагуу мөрдөх байгууллагын хүсэлт гаргасан тохиолдолд нийтэд мэдээлэх үүрэг нь мөрдөх байгууллагад байгаа. Миний хувьд бол яг өнөөдөр Ерөнхий прокурорын орлогч гэдэг албан тушаал байгаа хэдий чиг энэ бол шууд та бүхний асуултад хариулах боломжгүй байна. Хэрвээ хариулбал би хууль зөрчих асуудал гарна. Тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорын эрх хэмжээний асуудал. Тэндхийн мөрдөх байгууллагын эрх хэмжээний асуудал. Дарга гэдэг утгаар нь, дээд шатны прокурор гэдэг утгаар нь энд асуудлыг бүгдийг мэддэг шийддэг гэсэн асуудал байхгүй. Энэ дээр хууль нь

засагладаг тэр тухайн хууль тогтоомжийнхоо хүрээнд хариуцсан мөрдөгч, прокурорын эрх хэмжээний асуудал. Тийм учраас хариулах боломжгүй байна.

Г.Занданишатар: Асуулт хариултын цаг дуусаж байна. Баттөмөр гишүүний дараа асуулт хариултын цаг дуусна. Санал хураалт явуулах учраас гишүүд чуулганы танхимд цугларна уу. Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Сая тэр Раднаасэд гишүүний асууж байгаа асуулт бол зүй ёсны асуулт шүү. Өнөөдөр ингээд нэг ч дуудаж байцаадаггүй, ярьдаггүй гэв гэнэтхэн нийгэмд очоод зарлачихдаг. Сонин л юм байгаа юм даа. Хууль дүрэмтэйгээ яаж нийцэж байгаа юм болдоо. Энийгээ хариулт өгнө биз дээ. Энэ хуулийг бол бодлогын хувьд яг хулгай хийсэн хүмүүсийн ялыг чангатгана гэдэг утгаар энийг дэмжиж байгаа. Гэтэл манай гишүүдийн яриад байгаа сая Раднаасэд гишүүний яриад байгаа, гишүүдийн ярьж байгаа алдаа оноо бас байж магадгүй. Энэ бол урьд нь байсан хуульд өөрчлөлт оруулж байгаа юм. Ямар ч байсан мэдэж байгаа өнөөдөр миний хэлэх гэж байгаа зүйл бол энэ ардчилсан нийгэмд хууль засагладаг. Ийм учраас бол энэ хууль их сайн гарах ёстой. Манайд бол Авлигатай тэмцэх газрын мэдээлж байгаа мэдээлэл, бусад мэдээллээс харахад энэ авлигаас орж ирж байгаа орлого, тэр нөхөн төлүүлж байгаа хэмжээ энэ тэр бол нэмэгдэж байна л даа. Энэ бол сайн. Нөгөө талдаа тэр олон улсын үзүүлэлтүүд нь их доошоо орохгүй байгаа шүү дээ. 110 гээд л өнгөрсөн жилийн тоо байж байгаа. Тэр тоо хэр зэрэг буурсан бэ гэдэг ийм асуулт байна.

Тэр гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхээс үл хамаарч, хурааж улсын орлого болгоно гэдэгтэй санал нэг байгаа. Бид хэлмэгдлийг асар их түүхтэй улсууд шүү дээ. Мааш их түүхтэй. Аливаа

юм сайн, муу 2 тал байж байгаа. Хууль оруулж ирж байгаа улсууд бол сайжруулж оруулж ирж байгаа гэж байгаа юм. Гэтэл аливаа зүйлд эрсдэлүүд байдаг. Та нар энэ хуулийг яг ингээж баталснаар эрсдэлүүдийг тооцсон уу. Ямар судалгаа хийсэн бэ. Ийм асуултад хариулт авъя гэж бодож байгаа юм.

Дараагийн асуудал юу вэ гэхээр энэ хуулийн 22.10-д бол үндэслэлгүй хөрөнгөжих гээд нэг заалт байдаг юм. Энэ заалт дээр Монголд юу вэ гэхээр зэрэг олсон орлогоосоо илүү их хэмжээний зардалтай ийм хүмүүс маш их олон болсон. Энэ орлого, зарлагыг тооцдог энэ юуг нэгэнт та нар хуульдаа өөрчлөлт оруулж байгаа энийг хэр зэрэг тооцож оруулж ирж байгаа вэ. Зарж байгаа зарлага нь олж байгаа орлоготойгоо нийцэж байх ёстой. Ийм асуулт байна. Ийм 2 асуултад хариулт авъя.

Г.Занданишатар: Эхлээд Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Энэ үндэслэлгүйгээр хөрөнгөжих гээд гэмт хэргийн субъект нь зөвхөн нийтийн албан тушаалтан гэдэг энэ томьёоллоороо хэвээрээ хадгалагдаж байгаа юм. Бид нар хэлэлцүүлгийн шатанд ерөөсөө бүх хүмүүсийг л хөрөнгө, орлогоо нотолдог, татвараа төлдөг л ийм зарчим руу шилжүүлбэл яасан юм бэ гээд өнгөрсөн хаваржин бид нар ажлын хэсэг дээр ярьж, сүүлдээ жирийн иргэдийн бизнес эрхэлж байгаа иргэдэд илүү дарамт шахалттай, хувийн сектор хөгжих боломж нөхцөлийг хаах ийм үндэслэл болно. Хууль сахиулагчид, бизнес эрхлэгчдийг дарамталдаг нэг ийм төрөл, хэлбэр болно гэдэг нэг ийм байдлаар явсан.

Дараагийн дугаарт нь бид нар ер нь нийтийн албан тушаалтны энэ үйл ажиллагаанаас нөгөө ашиг хүртэгч гэдэг томьёоллыг бас Эрүүгийн хуульд оруулж ирье гэдэг байдлаар одоо нөгөө төсөл

дээр яригдаад явж байгаа. Саяын таны хэлж байгаа нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болох нь тогтоогдоогүй бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө орлогыг хурааж, нийтийн албан тушаалд ажиллах эрхийг 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хасаад, 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж байгаа юм. Улс төрд нөлөө бүхий этгээдийн хөрөнгө үндэслэлгүйгээр нэмэгдсэн бол 2-8 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн ийм томъёоллоор оруулж ирж байгаа юм. Тэгэхээр би Баттөмөр гишүүний асууж байгаа асуултын агуулга нь бол та нар орлого нь хэрхэн нэмэгдсэнийг ямар тооцооллоор орж ирж байгаа вэ гэдэг агуулгаар яаж байгаа юм. Тэгэхээр Хөрөнгө, орлогын мэдүүлэгт бөглөгдсөн тэр хөрөнгө нэмэгдэхдээ хууль ёсны татвар төлсөн, хууль ёсны бизнесийн болон ар гэрийнхний үйл ажиллагаанаас орсон орлого нь тогтоогдох ёстой. Энэ байдлаар тогтоогдоогүй хөрөнгө орлого нь нэмэгдсэн тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзнэ.

Хоёрдугаарт Хөрөнгө орлогын мэдүүлэгт хөрөнгөө мэдүүлээгүй байгаа нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэмт хэргийн нэг үйлдэл хэлбэр болно гэж ингэж томъёолж байгаа гэдгийг хэлье. Нэмээд ажлын хэсгээс хариулъя.

Г.Занданишатар: Пүрэвжавын Сайнзориг. 81.

П.Сайнзориг: Бараг сайд бүгдийг нь хариулчихлаа. Нэмээд тодотгоход бас үндэслэлгүй хөрөнгөжих энэ асуудал дээр бас Эрүүгийн хуулийн суурь зарчим буюу өөрөөр нь нотлуулах гээд байдаг зүйл байсан. Одоо яг тэр зүйлд гэмт хэрэгт хардагдаж, сэрдэгдэж байгаа хүнээр. Нотолж чадаагүй бол гээд. Тэгэхээр бид хэд энэ дээр томъёоллыг өөрчлөөд хууль ёсны болох нь тогтоогдоогүй бол гээд үндсэндээ тогтоох буюу шалган

шийдвэрлэх ажлыг бас эрх бүхий этгээд талаасаа хийх ёстой гэдэг томъёоллын өөрчлөлт байгаа. Ял хариуцлагын бодлого дээр бага зэрэг чангаруулсан. Хүндрүүлэх бүрэлдэхүүн 1-5 жил байсныг хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр хүртэл 2-8 жил гэх мэтээр чангаруулж орж ирж байгаа юм.

Хоёрдугаарт ер нь зүгээр Засгийн газраас цаашидаа Төрийн албан хаагчдын бас орлого, хэрэглээтэй нь уялдуулж хянах энэ чиглэлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах үүрэг даалгаврыг Хууль зүйн яаманд өгсөн. Энийг бид нар бас татварын хууль тогтоомжтой уялдуулах чиглэлээр нь бас цаашидаа судалж анхаарах асуудал байгаа.

Г.Занданишатар: Баттөмөр гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Баттөмөр: Эрүүгийн хуулийн 22.10-ийн хэрэгжилт ямар байдаг юм бэ. Энийг нэгдүгээрт хариулаач.

Хоёрдугаарт юу вэ гэхээр энэ хуулийн цоорхойг ашиглаад өс хонзон авах, өөрсдөө хөрөнгөжих, өөртөө ашигтай байдал бий болгох, хүнийг хэлмэгдүүлэх гээд асар их зүйлүүд дагалддаг л даа. Манайд ийм туршлага бол байгаа. Тэрийг Мишинский гээд хүний хэлсэн үг байдаг шүү дээ. Хүн нь байвал зүйл анги нь олдоно гэж. Асар их сенсцтай хэрэг гаргаж ирж тавьчхаад тэр нь нотлогдохгүй болохоор татвар нуусан ч юм уу эсвэл юу ч гэдэг юм нэг юмаар хаасан болоод тэр хүнийг заавал буруутгаж гаргадаг ийм эрсдэл бий болох вий дээ гэсэн ийм болгоомжлолоос асуугаад байгаа юм. Тэгээд эрсдэлийг та нар хариулж өгөөч.

Г.Занданишатар: Сайнзориг дарга хариулъя. 81.

П.Сайнзориг: Ерөнхийдөө бас Авлигатай тэмцэх газар дээрээс тодорхой олон улсын донор байгууллагуудтай хамтраад тал талын судлаачид, тал талын төлөөлөл ороод

бас иц авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэж байгаа дүн шинжилгээ хийсэн байдаг. Энэ судалгаа нь манай яаманд ирсэн. Бид хэд тодорхой хуулийн боловсруулалтыг хийх дээр анхаарч байгаа юм. Энэ дээр бол зарим тодорхой асуудлууд буюу жишээ нь таны яг хөндөж асууж байгаа үндэслэлгүйгээр хөрөнгөжих асуудлын нөхцөл байдлыг дүгнэсэн байгаа. Энэ хууль гэмт хэрэг бол тодорхой хэмжээнд бол бас иргэдийн дунд их гараад байна гэж байгаа боловч бас гэмт хэргийн шинж буюу томъёоллоосоо шалтгаалаад шийдэгдэхэд их хэцүү байгаа. Өөрөөр хэлэх юм бол тайлбарлаж чадаагүй гэдэг энэ агуулгаар одоогийн хүчин төгөлдөр хууль дээр байгаа. Тэгэхээр энэ өөрөөр нь хэргийг нь хүлээлгэх гээд байгаа буюу Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимтай нийцэхгүй байна гэдэг зүйлийг хэрэглэний явцад гаргадаг. Тэгэхээр энийг бид хэд алдааг засаж, тогтоогдоогүй бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулна. Хэлэлцэх эсэх асуудлыг дэмжих, дэмжихгүй томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтын өмнө дэмжиж, дэмжихгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлнэ. Үг хэлэхдээ дэмжсэн, дэмжээгүйгээ хэлээд яваарай. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Яах вэ энэ нөхцөл байдалтай уялдаад Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл оруулж ирж байгаа юм байна. Авлига, албан тушаалын хэрэг дээр хариуцлагыг нэлээн чангатгая гэж орж ирж байгаа зарчмыг нь дэмжээд байгаа юм. Гэхдээ яах вэ хэлэлцэх асуудлыг шийдсэний дараагаар анхаарах юмнууд байгаа юм болов уу гэж л бодоод байгаа юм.

Нэг дэх асуудал нь бид нар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дээр чинь л энэ хулгай

луйвар асар их гараад байна гэж яриад байна шүү дээ. Өнөөгийн нөхцөл байдал, гадаа жагсаал, цуглаан болоод байгаа чинь энэтэй л холбоотой л юм яваад байгаа юм л даа. Тэгэхээр энэ хуульд чинь Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн бол торгох, эсхүл зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хорих ял гээд сонголтууд их ороод иржээ. Би бол нэгэнт хуулийн хариуцлагыг чангатгая гэж байгаа бол авлига, албан тушаалын хэрэг дээр энэ торгох, зорчих эрхийг хязгаарлах ял байх нь зүйтэй юм уу, үгүй юу гэдгийг нэлээн сайн яримаар байна. Би бол ялангуяа тэр торгох ял байх боломжгүй л гэж бодож байгаа юм.

2 дахь асуудал нь бид нар улс төрд нөлөө бүхий этгээдүүдэд хариуцлага тооцох гээд л ингээд л яриад л, масс ч гэсэн яриад л байх юм. Тэгээд энэ хүрээндээ бид нар хувийн хэвшил рүүгээ нэлээн чангалсан юм орчих вий дээ. 13 дугаар зүйлийг чинь яриад байгаа юм шүү дээ. Тэр нийтийн албан тушаалтнаас бусад этгээд гэдэг чинь бас нэлээн орж ирээд хариуцлага нь нэлээн чангарахаар явчихлаа л даа. Тэгэхээр энийгээ дагаад бид нар энэ уур амьсгалыг дагаад, тэгээд хувийн хэвшилдээ бас хариуцлагыг өндөржүүлэх ийм юм хэт бас чангарчихвал зөв үү, буруу юу гэдгийг бас бодох ёстой болов уу гэж бодож байгаа юм.

3 дахь асуудал нь ер нь хялбаршуулах журамтай холбоотой асуудлыг тэр улс төрийн албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээдэд хялбаршуулсан журам байж болохгүй гэж би бодоод байгаа юм. Тэгээд энэ хуулийг чинь харахлаар ерөөсөө хялбаршуулах журам байхгүй болчихож байгаа юм шиг л харагдаад байна л даа. Тэгэхээр төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр байж болох юм. Хялбаршуулсан журам үйлчилж, хялбаршуулахгүй гэж болно. Төсвийн захирагч нар дээр сургуулийн захирал,

цэцэрлэгийн эрхлэгч, эмнэлгийн дарга эд нар гээд төсвийн захирагч нар дээр бас хялбаршуулах журам тэр нийгэмд учруулж байгаа хор хөнөөл эд нар нь бага юм чинь төсөв хөрөнгөд учруулж байгаа хохирол нь бага юм чинь бас хялбаршуулах журам энэ тэр байвал яасан юм бэ? Тэгэхгүй бол бид нэг бол ингээд хэт чангална гээд бүгдийг нь чангална гээд л, нэг бол бүгдийг нь хэт суллана гээд. Тэгээд тэр төсвийн ерөнхийлөн захирагч нар хялбаршуулах журмаар хэрэг шийдүүлж болохгүй. Тэр сайд нар. Улс төрд нөлөө бүхий этгээд бол хялбаршуулах журмаар явж болохгүй. Харин тэр төсвийн захирагч нартай холбоотой юмыг жоохон ялгаж, салгаж авч үзвэл яадаг юм бэ гэдэг ийм 3 санал байна.

Тэгээд хэлэлцэх эсэх дээрээ Байнгын хороо дээрээ ярина биз. Би сая чуулганы үг хэлж байх завсарлагаагаар зарим нэг хуульч гишүүдтэй уулзаж ярилцаж л байлаа. Одоо ингээд Эрүүгийн хуульд өөрчлөлт ороод, авлига, албан тушаалын хэрэгт хариуцлага чангарах юм байна гэж бодоод байгаа юм. Гэсэн ч энэ чинь бол цаашидаа хууль батлагдсанаас хойших гарч байгаа эрүүгийн хэрэг дээр л үйлчлэхээс биш одоогийн бидний яриад байгаа тухайлбал “Эрдэнэс таван толгой” дээр гарсан, төрийн өмчит компани дээр гарсан хулгай луйвартай холбоотой хэрэг дээр энэ чинь үйлчлэхгүй юм байна шүү дээ.

Эрүүгийн хэрэг үйлчилдэггүй л гээд байх юм манай хуульчид. Тэр битгий хэл манай Энхбаяр гишүүний ярьж байгаа 1960 оны Үндсэн хууль ч гэсэн хүчин төгөлдөр байгаа шүү Чинзориг ах л гээд байна. Эрүүгийн хууль. Тэгэхээр энэ чинь тэгээд ямар үр дүн бид нар хүсэн хүлээж байгаа юм. Хууль батлагдсанаас хойш л хэрэг гарвал энэ чангарсан хууль үйлчлэх юм байна. Одоогийн гол асуудал болоод байгаа энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар чинь энэ Эрүүгийн хууль үйлчлэхгүй л юм байна л даа. Тэгээд нэг их тийм сайхан үр дүн гарах юм уу,

үгүй юу. Би бол жоохон эргэлзчихээд сууж байна.

Прокурорын орлогч сууж байна. Прокурорын орлогч ер нь бол бид Ардчилсан Үндсэн хуультай, эрх зүйт төртэй орон. Хүний эрхийг дээдэлдэг орон. Аливаа гэмт хэрэгтэнд, гэмт хэрэг үйлдсэн хүнд хэрэг нээж байж, гэрчээр дуудаж байж, яллагдагчаар татаж байж ядаж олон түмэнд зарладаг байхгүй бол сүүлдээ энэ чинь Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг ноцтой зөрчдөг, урьдчилаад зарладаг, хэрэг ч нээгээгүй зарладаг, тэгээд нийгмээрээ урьдчилаад ялладаг ийм маш том гажуудал руу явах нь байна шүү Прокурорын орлогч оо. Та энийг бас нэлээн цаашид анхаарна биз дээ.

Г.Занданишатар: Дэмжсэн үг хэлсэн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, түүнийг дагасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг дэмжиж байна. Ер нь тэгээд бид нар хуулийнхаа юмыг нөхцөл байдалтайгаа тохируулаад л засаад л яваад байгаа. Би орж ирж байгаа Эрүүгийн хууль дээр цаашид ер нь ажлын хэсэг гарч ажиллах ёстой, тэгээд 3 зүйл дээр анхаарах хэрэгтэй байна гэсэн санал хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт нь хялбаршуулах асуудал байгаа юм. Би ойлгохдоо хялбаршуулахыг ер нь авлигын гэмт хэрэг, албан тушаалын гэмт хэрэг бол дандаа зохион байгуулалттай. Тийм учраас зохион байгуулалттай гэмт хэрэг илрүүлэх зорилгоор л хялбаршуулах асуудлыг оруулж явж байгаа гэж бодож байна. Түрүүний прокурорын байгууллагын танилцуулгаас харахад сүүлийн жилүүдэд нэлээд хэмжээгээр нэмэгдэж байна. Хялбаршуулахын үр дүнд хэрэг илрэх, хохирол барагдах нь нэмэгдэж байна. Энэ бол сайн зүйл байхгүй юу. Тэгэхээр цаашидаа ажлын

хэсэг ажиллаад, хялбаршуулахыг нь ялгавартай болгочихмоор байгаа юм. Хохирлын хэмжээнээс хамаарч болно. Хохирлын хэмжээнээс хамаарч болно. Бүр зарим нь улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг заавал хялбаршдаггүй болго гээд байгаа юм. Бүр болохгүй бол тэр хэдийг нь гаргаж болно. Уг нь тэгж ялгаварлаж болмооргүй л байгаа юм л даа. Хэргийнхээ хүнд, хөнгөн хохирлынхоо хэмжээнээс хамаарч л ялын бодлого явах ёстой. Түүнээс хүнд зориулж явах ёсгүй. Одоо сүүлийн үед манайх чинь хүнд зориулах л юм яриад байгаа юм. Тэр хэдийг бол цаазалчих хэрэгтэй. Энэ хэдийг бол зүгээр байх хэрэгтэй гэсэн юм ярьчих гээд байгаа байхгүй юу. Тийм учраас нэгдүгээрт хялбаршуулах асуудлыг би Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль дээр нь байлгах ёстой. Гэхдээ энийг хохирлын хэмжээ хэргийг хүнд хөнгөнөөс хамааруулж шийддэг болгочихвол яасан юм бэ гэж ингэж бодож байгаа юм.

2 дахь асуудал бол 22.13 дугаар зүйл дээр байгаа юм байгаа юм. Бусад этгээд гэдэг үг байгаа юм. Нийтийн албан тушаалтан ойлгомжтой. Энэ бол авлигын гэмт хэрэгт холбогдвол хариуцлага үүрэх ёстой. Бусад этгээд гэдэг дотор чинь яваандаа бизнесийн байгууллагынхан, хувийн хэвшлийнхэн, иргэн хүнийг оруулж шалгадаг юм руу явчих гээд байгаа юм. Тэгээд энийг нэлээн тийм бусад гэдэг этгээд гэдэг хүрээгээ эсвэл хуульдаа тайлбар хийж энэ энэ гэж. Хуучин бол нөгөө хамтран оролцогч, хамжигч гээд яг нөгөө хэрэгт нь оролцож байгаа хүн л явдаг байсан байхгүй юу. Бусад этгээд гэдэг юмаар явчих гээд байгаа юм. Энийг би бол энэ хүрээнд нь нэлээн тийм тодорхой болгож, тодорхой хүрээнд оруулж өгөх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа юм.

3 дахь асуудал халдашгүй байдал хуулиар баталгаажсан албан тушаалтнуудтай холбоотой асуудал байгаа юм. Энийг сүүлийн үед нэг ийм юм

байгаа юм. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал 2-ыг холиод халдашгүй бүрэн эрхтэй гээд нэг ийм сонин нэр томъёог бий болгочоод байгаа юм. Халдашгүй бүрэн эрхтэй. Хаана ч байдаггүй, дийлддэггүй юм шиг нэг ийм юм бий болчхоод байгаа юм. Бүрэн эрх гэж байна. Халдашгүй байдал гэж байна. Халдашгүй байдал ерөөсөө гуравхан юм л байгаа шүү дээ. Гэмт хэрэг үйлдэж байгаагаас бусад тохиолдолд нь үйлдэл дээрээ баригдаагүйгээс бусад тохиолдолд баривчлахгүй, саатуулахгүй, нэгжихгүй гэсэн ийм л асуудал байгаа. Өөр юу ч байхгүй байхгүй юу. Гэтэл халдашгүй бүрэн эрхтэй гээд юуг ч хийж болдог юм шиг нэг ийм ойлголт нь нийгэмд түгжчихээд байгаа юм. Тэгээд би бол энэтэй холбогдуулаад ямар санал хэлэх гэж байгаа юм гэхээр ерөөсөө Их Хурлын гишүүнийг түдгэлзүүлэхээ больчихмоор байгаа юм. Их Хурлын гишүүн янз бүрийн хэрэгт холбогдлоо. Хөөн хэлэлцэх хугацаа шууд зогсчихдог л болгочихмоор байгаа юм. Тэгвэл энд янз бүр улс төрийн оролцоо орохгүй. Тийм учраас би тийм хэлбэрээр нь явах ёстой болов уу гэж ингэж бодож байгаа юм. Шууд хөөн хэлэлцэх хугацаа нь зогсоод л бүрэн эрх нь дууслаа, хөөн хугацаа нь сэргээд л явдаг ийм л хэлбэр лүүгээ л явах хэрэгтэй гэж бодож байгаа юм. Яах вэ энд нөгөө нэгдүгээр шат нь болохоороо үгүй гэсэн тохиолдолд ингэнэ гээд биччихсэн байна лээ. Тэгэхэд тэгж болохгүй, тэгж нэр хүндэд нь алдаж болохгүй. Ер нь тэгээд сүүлийн үед бүх юмны буруу л энэ Улсын Их Хурал болчихсон юм шиг л юм. Улсын Их Хурал бүх юмны буруу юм шиг.

Харин бид нар чинь авлигатай тэмцэх, хуулиа чангатгах ингэж бүх бодлого чиглэлийг нь гаргаж өгье гэж шаардаж байгаа шүү дээ. Тэгээд хэрэгжүүлдэг байгууллага чинь Засгийн газар, шат шатны байгууллага. Өглөө олон гишүүн үг хэлж байна лээ. Би анхнаас нь хэлж байсан нүүрсний хэрэг гээд гарахад нь Улсын Их Хурлын гишүүдийг хардаж нэр зарлах гэж

байгаагийнхаа оронд та нар тэр ажил хариуцсан хүн дээрээ эхэлж хариуцлага яриач. Тэр Гаалийнхан, тэр хилийнхэн, тэр мэргэжлийн хяналтынхан өөр хэн байна вэ, тэр тээврийнхэн. Энэ чинь ажил хариуцаад Монгол Улсын нэрийн өмнөөс сууж байгаа хүмүүс байж байгаа шүү дээ. Тэрэнтэйгээ хариуцлага ярьж явах байхгүй юу. Түүнээс Улсын Их Хурлын гишүүн гэдэг хүн чинь шийдвэр гаргадаггүй, гэрээ байгуулдаггүй, сонгон шалгаруулалт хийдэггүй хүмүүс байхгүй юу. Гэтэл сүүлийн үед энэ бүгдийг хийдэг юм шиг нэг ийм ойлголт бий болчихсон. Зүгээр Их Хурлын гишүүдийн хувьд ганцхан л асуудал байгаа. Тэр шийдвэр гаргадаг хүнд нөлөөлж үү, үгүй юу л гэдэг асуудал байгаа шүү дээ. Өөр ямар ч юм байхгүй шүү дээ.

Г.Занданишатар: Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Авлигатай тэмцэх ажил бол амаргүй ажил. Авлигатай тэмцэхэд хамгийн чухал хүчин зүйл бол улс төрийн хүсэл зориг байдаг гэж үздэг. Энэ агуулгаараа Монгол Улсын Засгийн газар авлигатай тэмцэх, авлигад холбогдсон хүмүүст оногдуулах ял шийтгэлийг чангатгах чиглэлээр хуулийн төслийг оруулж ирж байна. Монгол Улсын Ерөнхий сайд өөрөө хуулийн танилцуулгыг хийж, ач холбогдол өгч асуудалд анхаарал хандуулж, оруулж ирж байна гэж харж байна. Авлигатай тэмцэх ажилд мэдээж олон хүчин зүйлээс хамаарна. Тэр дотроо ялын бодлогоос их хамаардаг зүйл байгаа юм. Ялын бодлогоос. Ер нь аливаа тодорхой төрлийн хэрэг нэмэгдээд ихсээд эхлэх юм бол энэний гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж үзэх ёстой. Ингээд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлаад, юунаас болж хэрэг ихсэж байна вэ гэхээр мэдээж олон хүчин зүйлүүд байдаг, нөлөөлдөг. Энэ дотроо ялын бодлого их чухал нөлөөтэй. Оногдуулж байгаа ял шийтгэл тухайн этгээдийн учруулсан хор уршигт тохирсон тэр хариуцлагад тохирсон ийм ял шийтгэл

оногдуулж чадаж байна уу, үгүй юу гэдгээс их хамаардаг. Хэрвээ ийм биш байх юм бол энэ төрлийн хэргүүд нь нэмэгдээд байдаг талтай.

Ял шийтгэлийн бодлогоор дамжуулж тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явагдаж байдаг. Яагаад гэвэл тодорхой этгээд бага ял аваад, их завшаад байгаа бол энэ төрлийн гэмт хэргийг хийж болох юм байна. Нэг этгээд тэрбум төгрөгийн хахууль авчхаад 40 сая төгрөгөөр торгуулаад гарч болж байгаа бол би бас нэг иймэрхүү хэмжээний юм хийгээд гарахад тодорхой ял шийтгэл гээд байх юм байхгүй юм байна шүү дээ гэж үзээд хулгай гардаг. Авлига гардаг. Хахууль авагчид өөгшдөг. Ийм учраас л энийг таслан зогсоож ял шийтгэлийг нь чангатгах шаардлагатай. Ял шийтгэлийн бодлогоор дамжуулж төрлийн хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цохилт өгөх ийм ажлууд хийгдэх ёстой. Ийм учраас ял шийтгэлийн бодлогыг чангатгаж байгаа нь зөв. Тодорхой төрлийн торгох ялыг байхгүй болгож байна. Түүний дотроос уг хэрэгт өршөөл, уучлалт үзүүлэхгүй гэдэг асуудлыг ярьж байгаа. Ер нь улс төрд нөлөө бүхий этгээд хахууль авсан бол түүнд оногдуулах ял шийтгэлийг бол хамгийн өндөр буюу Эрүүгийн хуульд заагдсан хамгийн өндөр ял шийтгэлийг оногдуулахаар болж байна шүү дээ. 12-20 жил. Энэ бол хамгийн дээд ял. Хорих ялын дээд хэмжээ. Энэ бол хүн амины хэрэгтэй дүйцэх хэмжээний ял өгч байна гэж ойлгож болно. Ийм хэмжээнд хүртэл чангаруулж байна. Ингэж байж бас энэ хууль батлагдсанаар авлигатай тэмцэх, хахууль авч байгаа этгээдүүдэд дохио болсон, таслан зогсоосон ийм арга хэмжээ болж, хуулийн үр дүн гарах болов уу гэж би харж байгаа юм.

Энэ дотор гэхдээ нэг зүйлийг бид давхар харгалзан үзэх хэрэгтэй. Эрүүгийн хууль, Иргэний хуульд 2 том шинэчлэл орж ирсэн. Нэг нь бол Иргэний хуульд эвлэрүүлэн зуучлах гэж ард иргэдийн иргэний хэрэг дээр маш олон

маргаанууд шүүх дээр гацдаг, явдаггүй энэ асуудлуудыг цэгцлээд, эвлэрүүлэн зуучлаад олон асуудлууд шийдэгдээд, энэ асуудал нэлээн үр дүнгээ өгч байгаа юм. Нөгөөдөх нь бас энэ эрүүгийн хэргийг хялбаршуулан шийдэх журам байгаа юм. Энэ хуулийн гол ач холбогдол нь бол олон сар жилээр мөрдөгддөг, мөрддөг, мөрдөх ажлын зардал нэмэгддэг, хугацаа шаарддаг, нөгөөтээгүүр энэ бас тодорхой төрлийн этгээдүүдийн бид яриад байна шүү дээ энэ танхимд. Жинхэнэ хулгайч, жинхэнэ бус хулгайч гэсэн бараг 2 статустай байдал гарч ирээд байна. Тэгэхээр жинхэнэ этгээдийг нь олж илрүүлэхэд их чухал заалт байгаа шүү дээ. Тодорхой этгээд хэрэг үйлдсэн байна. Тэр этгээд тодорхой төрлийн хэрэг ял оногдуулах нь тодорхой. Гэхдээ өөрийнхөө толгойлогч гэдэг юм уу, тухайн үед гол этгээдээ зааж өгсөн тохиолдолд тухайн хэргийг нь хялбаршуулж, бага ял оногдуулаад гол этгээдийг нь барихад зориулагдсан ийм хууль юм байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн үйлчлэл энэ хугацаанд бас тодорхой хэмжээнд үр дүнгээ өгөөд, тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, хор хохирлыг нөхөн төлүүлэх, нуугдсан эд хөрөнгүүдийг нь гаргаж ирэхэд тодорхой нөлөөгөө үзүүлсэн гэдгийг өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа шүүх, прокурор бусад байгууллагынхан хэлж байна. Ийм учраас энэ зүйл маань бол энэ хэрэгт үйлчлэхгүйгээр болж байна. Тэгээд энэ бол уг нь ялгамжтай хандаад, тодорхой улс төрийн нөлөө бүхий этгээдүүдэд нь үйлчилдэггүй, бас тодорхой төрлийн хэрэг үйлдсэн этгээдүүд нь энд нь үйлдэгдээд явдаг ялгамжтай ийм байдлаар зохицуулаад явсан бол бас зүгээр байсан. Гэхдээ өргөн барьсан хуулийн төслөөр бол 22 дугаар зүйл бүхэлдээ зүйлд хамрагдахгүй болж байгаа юм. Ер нь бол хэрэг хялбаршуулахад чинь ийм шүү дээ. 8 жилээс дээш хэрэгт нь хэрэг хялбаршидаггүй. Одоогийн хуулиараа. 8 жилээс доош бол хэргийг хялбаршуулах асуудал яригдаж байгаа. Тийм ээ. 5-аас

дээш ингээд явж байгаа. Ийм зүйлүүд байгаа юм аа.

Г.Занданшатар: 3 гишүүн дэмжиж үг хэллээ. Дэмжихгүй үг хэлэх 3 гишүүн үг хэлж олно. Сайнхүүгийн Ганбаатар, Шатарбалын Раднаасэд, Баттөмөрийн Энхбаяр 3-аар тасаллаа. Сайнхүүгийн Ганбаатар дэмжихгүй үг хэлнэ.

С.Ганбаатар: Энэ хуулийг нягталж сайн бодох ёстой. Ардчилсан намынхан завсарлага авах байлгүй дээ. Ярьж байгаа олон зүйлүүдийг нягтлах хэрэгтэй. Өнөөдөр хууль шүүх, прокурор, цагдаа та нар бол хам хэрэгтнүүд болчихсон. Та нар улс төрийн захиалгат хэрэгсэл болчихсон. Гэхдээ ганцхан та нар битгий өөр дээрээ хүндээр тусгаж ав. 30 жил ингээд дагнаад явчихсан. 2012-2016 онд бүр гаарсан. Битгий өөр дээрээ хүлээж ав. Зүгээр тогтолцоо ийм арчаагүй болчихсон. Энийг нь яаж нэг эвлэрүүлэх вэ гэж л аргаа барж байгаа хэлбэр. Та нар хамгийн гэмгүйнүүдийг нь шүүгээд, захиалгаар нэрлэчихсэн байна л гэж цаагуур чинь шуугьж байна. Яг тэр талбай дээр нэрдээд байгаа, тэр зурагтай байгаа улсууд дээр гэм зэмгүй гээд хэлчих тэнхэл та нарт байхгүй л дээ. Та нар захиалгатай. Та нар тэр дээр хэн хэнийг сугалсан бэ гээд цаагуур чинь ярьж байна. Ийм байдалд татаа тунгаадуулна гэдэг та нарын ажил. Тэгэхлээр хуулийг эргэж нягталж харах хэрэгтэй байна. Хуулийн судлаач, эрдэмтдийн дүгнэлтийг сонсох хэрэгтэй байна. Өнөөдөр жишээ нь прокурор яг нийтийн өмчийг хулгайлчихаад байхад ард иргэд нийтийн өмнөөс прокурор нэхэмжлэл, гомдол гаргах ёстой. Таг. Хам хэрэгтэн болчихсон юм байлгүй. Таг. Энэ хууль дээр энийг яаж оруулах юм бэ гэдэг асуудлуудыг ярих хэрэгтэй.

Хоёрдугаарт сүүлийн 6 жил Монгол Ардын нам хэнтэй ч ялангуяа удирдлагууд нь хэнтэй ч хуваалцахгүйгээр та нар энэ нүүрсний том хулгайн гэмт хэрэгтнүүд. Тэгээд

жижигхэн жапакуудаа шийдэж өгчөөд амь гарна гэвэл Монголын ард түмэн бүгдийг нь үнэрлэдэг болсон. Гэмгүй хүмүүсийг золиослох эрхгүй. Өнөөдөр Ерөнхийлөгчийг яагаад ард түмнээс сонгодог юм бэ, яагаад нам бус байгаарай гэдэг юм бэ, Яагаад төсөвт оролцуулдаггүй юм бэ. Засгийн газар, Улсын Их Хурал 2 хардагдаж болно. Төсөв баталдаг, төсөв хэрэгжүүлдэг, төрийн өмчийн асуудлаар шийдвэр гаргадаг, төрийн өмчийг хэрэгжүүлдэг. Таван толгойг хэрэгжүүлдэг. Өнөөдөр энэ дээр Ерөнхийлөгч Монгол Улсыг татаад тунгаадуулахгүйгээр шийдвэр гаргаж, шүүх засаглалын тэргүүний хувьд энэ дээр шийдвэр гаргана гэдэгт би итгэлтэй байгаа. Тэр нүүрсчдээс мөнгө аваагүй л бол. Тэгэхлээр энэ хуульд ийм олон санал санаачилгуудыг оруулах хэрэгтэй байгаа. Хэд хэдэн хуульч гишүүд ярьсан. Би ер нь хуулийн асуудал дээр болж өгвөл дуугарахгүй байхыг хичээдэг. Оюутолгой. 20 жил мөн дархалсан хулгайч нарын тухай шүүх, прокурор, цагдаа, тагнуул бүгд хам хэрэгтнүүд. Таг. Олон улсын шүүх дээр л яригдаж байгаа шүү дээ. Швейцарын шүүх дээр л яригдаж байгаа. Та нар тэр дээр таг, ичээд л яваад байдаг. Тэгэхээр ийм арчаагүй байдлыг засаж, залруулах санаачилга гарч байгаа нь зөв. Энэ дээр миний санал бол эрх зүйн улсууд ийм амиа бодогч биш л юм бол эрх зүйн эрдэмтэд дуу хоолойгоо оролцуулмаар байна. Яаралтай гадаа жагсааж байгаа хүмүүс бас энэ хууль дээр санал бодлоо оролцуулах ёстой. Тэдний саналыг авч хэлэлцэх ёстой. Юун интернэтээр, цахимаар ярих биш. Өөрсдөө хүрч очоод 10 гаруй хоног ингээд өлсөөд, цангаад, ядраад явж байгаа улсууд яг хулгайг байхгүй болгоё гэж байгаа дээр саналыг нь оруулах ёстой. Тэдний саналыг авна гэсэн ийм 2 дугаар санаа.

3 дугаар санаа бол өнөөдөр Ерөнхийлөгч шүүх засаглал дээр дорвитой байр суурь гаргахгүй бол татаа тунгаадаад л байна. Энэ хууль дээр миний оруулах санал ийм байгаа.

Саналаа гүйцэд оруулахын тулд эргэж харах нягтлах шаардлага байна гэдэг ийм байр суурьтай байна.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Түрүүн Чинбатаас сонин юм сонсох юм. Нийт өнгөрсөн хугацаанд 226 мянган машин нүүрсгүй гээд хилээр давсан. 2 сая 600 мянган тонн нүүрс гараад явчихсан байна шүү. Энэ дээрээ шалгаж чадаагүй байж тагнуулаа та нар оруулж шалгадаг. Тэгээд АТГ, цагдаатайгаа нийлээд бид нар шалгаж байгаа юм. Тэгээд энэ дотроос харж байгаад бид нар та нарыг оруулсан юм. Ийм утгагүй юм ярихаа боль за юу Чинбат аа. Босоо удирдлагатай байгууллага та нар. Та нар мэдээлэл авч байж явах ёстой. Тэр Голомтын Баясгалан, оффтейкийнхаа юмыг хийсэн хүмүүсийг яагаад оруулж ирэхгүй байгаа юм. Тэрэнд чинь оролцсон энэ Сумъяабазараас эхлээд хүмүүс байна шүү дээ. Яагаад оруулж ирэхгүй байгаа юм. Би энэ улс төрд ойрхон 500 орчим л хүн байгаа. Монголчууд жоохон шүү дээ. Хэн нь хаана юугаа нуугаад иддэг, хаана байна хэнтэйгээ нийлж яаж хуйвалдсаныг. Энэ Эрдэнэс таван толгой дээр онц байдал тогтооё гэхэд манай 5-6 Засгийн газрын гишүүн тогтоохгүй гээд л хамгаалсан юм гэсэн шүү дээ. Хулгайгаа л нуух гэж байгаа биз дээ. Одоо энийг нь бид 5 маргааш гаргаж зарлана, шалгуулна. Яг үнэн мөнийг нь үзье гэж байгаа бол. Зүгээр ингээд гэмгүй нөхдүүдийг аваачиж ингээд олны дунд нийгэмд аваачиж яллаад ингээд гарна гэж байгаа бол эндүүрэл шүү. Харин прокурорын байгууллага, Авлигатай тэмцэх газар шударга ажиллаарай, шударга ажиллаарай. Үнэхээр хийчихсэн хэрэг байгаад, авчихсан юм байгаа бол яллаад яв. Тэгэхгүй зүгээр ингээд өөрчилж байгаа ийм хэлбэрээр та нар тал зассан ийм байдлаар явах юм бол ямар ч хэрэг байхгүй. Байгууллагуудыг бүгдийг нь татан буулга. Хүмүүсийг нь бүгдийг нь

соль. Энэ авлигатай тэмцэх хүсэл зориг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад байгаа байх гэж би харж байгаа юм. Миний нөхөд уучлаарай. Энэ Их Хурал дотор байгаа болон гадуур байгаа 500 гаруй хүн байгаа. Хүний өөрийн намгүй. Эд нарын идсэн, уусан ингэдэг тэгдэг юмнууд, бүх мэдээллүүд нь бид нарт хүмүүс өгч байна. Энийг нь хэлнэ. Энийг нь зарлаад өгнө. Гүтгэж байгаа юм биш. Шалгаад өг, тогтоогоод өг гэж Авлигатай тэмцэх газар басамжилж байгаа юм шиг та нарыг хэн гэм буруутай гэж бид нар зарласан юм, зарлаагүй шүү дээ. Шалгаж үзэх гэж байгаа шүү дээ гэж ийм юм. Ингэж тоглоом хийхгүй Чинбат аа. Ажил хийвэл зөв хий та нар хуулийн дагуу.

Хоёрдугаарт энэ хуультай холбоотой юман дээр нэлээн сайн ажиллах хэрэгтэй. Гадна талд жагсаад байгаа 22.1 гээд яриад байгаа хүмүүсийг нь оруулж ирээд Байнгын хорооны хурал дээрээ суулгаж байгаад яривал юу нь болохгүй байгаа юм. Энэ дотор чинь хуульч хүмүүс байна. Өмгөөлөгч хүмүүс байна. Яг хуулийг хэрэглэдэг хүмүүс өнөөдөр өөрсдөдөө тааруулаад л, дарга нартаа тааруулаад л хуулиа бичиж байгаа шүү дээ. Энэ хүмүүсээ оруулж ирээд энэ дээрээ бич л дээ. Тэгээд албан тушаалтны хэргийг бүрэн эрхийг түдгэлзүүлээгүй бол бүрэн эрх нь дууссаны дараа хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлнэ гээд. Дахин дахин Их Хурлын гишүүн болохын төлөө энэ хүмүүс чинь үхэн үхтлээ явна биз дээ. Ял шийтгэл авахгүйн төлөө, гэмт хэрэг хийсэн, хэдэн тэрбумаар нь мөнгөө хийчихсэн хүмүүс чинь. Бэлэн мөнгө нь гэрт нь багтахаа больчихоод алтаар авч хурааж байна гэж байгаа шүү дээ. Худлаа биш шүү энэ. Бэлэн мөнгө нь гэрт нь багтахаа больчихоод угааж дийлэхгүй болчихоод, гулдмай болгож, алт болгож хадгалж байна гэж байгаа шүү дээ. Энэ хуулийнхны дунд явагдаж байгаа л ярина шүү дээ. Чинбат чи энийг мэдэхгүй байна гэж байхгүй. Та нар ийм хүмүүсээ гаргаж ир л дээ. Ийм хүмүүсээ гаргаж

ирж чадахгүй байж хуулиар ингэж чангалж байна, тэгж байна, гэр доторх хулганын нүхээ бүгдийг нь бөглөж байна гэж ийм утгагүй юм битгий ярь. Хадгаламж, зээлийн банк бус санхүүгийн байгууллагууд дээр явж байгаа, мөнгө угааж байгаа хэргүүдээ та нар үз л дээ. Хэний хэдэн төгрөг хаана нь угаагдаад явж байгааг нь бүгд мэдэж байгаа шүү дээ. Нэртэй устай нь. Яагаад цөөхөн юмыг чинь олоод учрыг олж дийлэхгүй байна гэж байхгүй байгаа шүү дээ. Энэ шиг амархан юм хаа байна. Гудамд зогсож байгаа залуучуудаас 20 хүн оруулаад гаргахад л юм нь явна даа. Аргыг нь зааж өгөөд учрыг нь ухааруулаад явахад. Чин хүү сэтгэл байхгүй учраас та нар ийм байдалтай явагдаж байгаа байх. Одоо боль оо. Одоо ингэж авлигатай тэмцэхгүй. Яг тэмцье гэж байгаа бол бүх юмаа тайлж байгаад гудамжинд нүцгэлээд байгаа ард иргэд шиг тайлж байгаад бүгд шалдан үз. Нэг хэсэг нь хуулиар өөрсдийгөө хамгаалуулсан, албан тушаалаар өөрсдийгөө хамгаалуулчихсан нэг хэсэг нь гудамжинд авлигатай тэмцэнэ гээд ингээд явна гэж байхгүй. Энэ төр оршье гэж байгаа бол өнөөдөр. Өнөөдөр бид нар энийг цэгцэлж авахгүй бол дахиад 20 жилийн дараа цусаар уйлаад ч энэ авлигачидтайгаа тэмцэж чадахгүй шүү. Цусаар уйлаад ч баян хоосны ялгаа чинь туйлдаа хүрнэ. Тэр цаг үед Энэтхэг шиг, кастелын систем рүү энэ улс чинь өөрөө орно. Энийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангалж байгаа Засгийн газрын санаачилгыг дэмжиж байгаа юм. Өөрчлөлт дотор байгаа 2 асуудал дээр бол нухацтай ярих ёстой гэсэн хангалттай ийм үндэслэл сонсоогүй учраас тодруулах шаардлага байгаа.

Нэгдүгээрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заасан

уучлал үзүүлэх бүрэн эрхэд хязгаарлалт тавьж байгаа асуудал дээр төрийн тэргүүний байр суурь саналыг авсан уу. Бусад улс оронд миний ойлгож байгаагаар энэ бол нэлээн геополитик харилцааны асуудал байдаг. Аль ч улсын дайн хийж байгаа төрүүд ч харилцан гэмт хэрэгтнээ солилцдог юм. Өнөөдөр одоо дайтаж байгаа Украин Орос 2 дайн хийж байгаа мөртөө харилцан хоригдлуудаа солилцож байгаа шүү дээ. Энхийн хэлэлцээрээр тусдаа шугам гаргаад. Өнгөрсөн 7 хоногт жишээлбэл АНУ-ын сагсчин Брити Гринерс Оросын нөгөө нэг зэвсгийн наймаачин Виктор Бот 2-ыг солилцлоо шүү дээ. Энэ 2 улс. Хүйтэн дайны үеүдэд ЗХУ болон АНУ-ууд харилцан баригдсан тагнуулуудаа байнга солилцож байсан. Тэгэхээр энэ асуудал ямар шугамаар хийгддэг вэ гэхээр улс орны төрийн тэргүүнүүдийн шийдвэрээр хэдий муудаж байгаа ч үргэлж эвлэрэх орон зайг аль ч улсууд хадгалж байдаг. Ялангуяа цөмийн зэвсэгтэй улс орнууд. Тийм учраас энэ харилцан ялтнаа солилцох боломжийг бид үргэлж хадгалж байх ёстой байдаг. Гадаад улсын жишээлбэл иргэн Монгол Улсад ял эдэлж байж болно. Манай улсын магадгүй тагнуул гадаад улсад баригдаж болно. Тэгэхээр ийм асуудлууд дээр гадаад харилцааны ийм дипломатын асуудлыг үүсэхийн тулд төрийн тэргүүний уучлал үзүүлэх бүрэн эрхийг бүрэн хаасан ийм зохицуулалтыг оруулах дээр би жоохон эргэлзээд байгаа юм. Тийм учраас асуудлыг нэгдүгээрт авч үзээч гэсэн бодол байгаа юм.

2 дахь асуудал нь дагуулаад манай парламент Монгол Улсын ардчилал бас тусгаар тогтнолын баталгаа. Энэ баталгаа юугаар илэрдэг вэ гэхээр парламент өөрөө хууль тогтоох парламентын шийдвэр бол хүн бүхэнд таалагдах алба байдаггүй. Ямагт ямар нэгэн хүний эрх ашгийг хөндсөн ийм шийдвэрүүд гаргадаг. Энэ дархлааг нь хангахын тулд парламентын гишүүдэд зоригтой үгээ хэлэх, хэнтэй ч атугай тэмцэх, ямар ч хулгайчийг илрүүлэх, шалгах, энэ мандатыг нь олгохын тулд

халдашгүй бүрэн эрх олгодог юм. Тэрнээс биш гэмт хэрэг хийвэл халдашгүй байна гэсэн үг биш. Энэ бүрэн эрх байгаа учраас өнөөдөр жишээлбэл миний хувьд Хөгжлийн банкны түүр хороог ахлаад хүний өөрийнгүй шалгах ажил дээр зоригтой явж байгаа. Тэгтэл бүрэн эрх буюу парламентынх нь дархлааг нь устгах гэсэн хуулийн байгууллагуудад барьцаанд өгөх гэсэн ийм санаархлыг зөвшөөрч болохгүй. Тухайлбал тэр сонирхлын зөрчлийн хуулиар Авлигатай тэмцэх газарт ийм бүрэн эрхийг парламентыг барьцаанд өгч болохгүй. Тэнд Хурц гэж нөхөр байхдаа парламентыг барьцаалж байсан. Дорлигжсав гэж прокурор байхдаа энэ гишүүн нь өөрөө хэлж байсан юм. Дэмбэрэл гэж гишүүнийг Норовын Алтанхуяг гэдэг Ерөнхий сайдыг огцруулахын тулд дүүг нь барьж шоронд хийж байгаад чи огцруулах кноп дарвал дүүг чинь суллана гэдэг ийм юм явж байсан гэж өөрсдөө хэлдэг шүү дээ. Монгол Улсын парламентыг хуулийн байгууллагын барьцаанд өгч болохгүй. Энэ хуулийн байгууллагынхныг ард түмний нэрийн өмнөөс бид шахааж шаардах ёстой. Хулгайчдыг эцсийн дүндээ Их Хурал ял оноодог газар биш. Хуулийн байгууллага заримыг нь хаацайлж байгаа. Энийг чинь парламентын хяналт байх ёстой. Тэгэхэд хуулийн байгууллагын барьцаанд өгвөл энэ парламент чинь яах юм. Энэ ард түмний ингээж эрхийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй 3, 3 гишүүн үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье.

Өнөөдрийн анхны санал хураалт учраас бүртгэл, туршилтын санал хураалтыг зэрэг явууллаа. 12 гишүүнд анхааруулаарай. Сүүлд нь эсрэг гарсан асуудал үүснэ шүү. Бүртгэлийн санал хураалт. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Эрүүгийн хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг түрүүн би уншиж танилцуулсан хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 32 гишүүн дэмжиж 74.4 хувийн саналаар санал дэмжигдэж, төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлнэ. Нямбаатар сайд өнөөдөртөө хэлэлцүүлгээ эхэлчихье гэсэн. Байнгын хороо өнөөдрийн чуулганы, өнөөдөр Байнгын хороогоо хуралдаад ажлын хэсгээ байгуулчих. Ямар ч байсан Байнгын хороо хуралдъя. Хууль зүйн байнгын хороо. Дараагийн асуудалд орно.

15.48 цагт.

Хоёр. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 11 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Булгантуяа, Т.Доржханд, Г.Тэмүүлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгийн төслийн зарим нэр, томъёог жигдлэн, тодорхой болгох зорилгоор форвард гэрээ гэж уул уурхайн бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд тохиролцсон нөхцөлөөр биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээ гэж нэмж тусгасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн арилжааны гэрээг бүртгэх, хэрэгжилтийг хангах, биржээр бүрэлдэхүүнийг арилжаалахад 4 төрлийн гэрээ байгуулж, арилжааны гэрээний үүрэг хариуцлагыг тухайн арилжаанд зуучилсан брокер хариуцах, хуулийн дагуу бүртгэх, хадгалах. Спот гэрээгээр арилжаалах бүрэлдэхүүн нь биржийн

итгэмжлэгдсэн терминалд байришиж бүртгэгдсэн байх, Биржийн арилжааны төлбөр тооцооны хувьд фьючерс болон опцион гэрээний арилжааны төлбөр тооцоог үнэт цаасны төлбөрийн болон тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйцэтгэх, спорт болон форвард гэрээний арилжааны төлбөрийн үйл ажиллагааг дотоодын арилжааны банк эсхүл үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйцэтгэх, Санхүүгийн зохицуулах хорооноос биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг батлах, бирж, брокер нь биржийн хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, биржийн дүрмийн сангийн доод хэмжээ түүнд тавих шаардлагыг тогтоох, биржийн үйлчилгээний төлбөр хураамжийн тухай оролцогчдын саналыг харгалзан тогтоохоор тус тус өөрчлөн найруулах санал бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Ажлын хэсгийн зүгээс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар шинэ заалт нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт биржийн төрийн өмчийн оролцоо 66 хувиас доошгүй байх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Отгоншарын Батнайрамдал, Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Батсүхийн Элбэгзаяа, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, Монголын Хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Хангайн Алтай, Монголын Хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн Бизнес хөгжлийн газрын захирал Тамирын Хаш-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөх Пүрэвсүрэнгийн Эрдэнэсүвд, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх Алтанбулагийн Нинжсин, Санхүүгийн зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн ахлах референт Жаргалсайханы Мөнх-Оргил, Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч Дамбын Галсандорж.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Төмөртогоогийн Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Ням-Осорын Учрал гишүүн асуулт асууна.

Н.Учрал: Уул уурхайн яам Ганбаатар сайд олон жил яригдсан хуулийг зориг гаргаад оруулаад ирж байгаад их талархалтай байгаа. Жишээ нь уул уурхайн яамнаас орж ирж байгаа уул уурхайн биржийн хууль бол өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдлыг арилгахад үнэхээр том хувь нэмрээ оруулна гэж үзэж байгаа юм. Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газар сая энэ хөрөнгийн бирж дээр нүүрсийг арилжаалах түр журмаа гаргаад, 01 дүгээр сарын 01-ээс хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаа явагдах ийм нөхцөл бололцоо бүрдсэн гэж ойлгож байна. Тэгэхээр хулгай хийх боломж бол хулгайчийг төрүүлж байна. Тийм учраас уг үндсээр нь устгахын тулд хүнээс хамааралтай бус технологид суурьтай ийм биржүүдийг байгуулах, цаашиаад боомтын үйл ажиллагаа борлуулахаас нь авхуулаад худалдан авагчид хүртэлх нийт процессыг автоматжуулах ёстой. Тийм ч учраас энэ Сангийн яамны зүгээс яг автоматжуулах ажлыг нэлээд үр дүнд хүргээд 01 сарын 01-ээс бас боомтын үйл ажиллагаа цахимжаад, автоматжаад явахаар гааль, татварын системтэйгээ нэгдээд гаалийн бүрдүүлбэрээ цахимаар хийгээд татвар нь ноогдоод, тэгээд борлуулалтын гэрээ, тэр тээвэрлэлтийнх нь гэрээ, худалдах, худалдан авах гэрээнүүд нь цахим бирж дээр арилжаалагдаад, нөгөө ханцуйдаа нуугаад яваад байдаг байсан мөнгө төгрөг, нөгөө цүнхэндээ мөнгө барьчхаад улс төрд нөлөө бүхий хүмүүст өгөөд байна гээд энэ нөхцөл байдал яг нүүрснийхээ бодит үнэ дээр нөлөө үзүүлнэ гэж ойлгож байгаа шүү дээ.

Тийм учраас уул уурхайн биржийн хууль батлагдсанаараа энэ Засгийн газрын түр журам хэрэгжээд эхлэхээр

бол авлигагүй, ил тод, ард түмний нүдэн дээр нүүрсний зах зээл, зах чинь өөрөө 24 цаг асаалттай байна гэж ойлгож байна. Иргэд өөрөө хянаана. Иргэдийн хяналтад энийг өгөх гэж байна гэж бодож байна шүү дээ. Тэгээд нууцаар хаалттай харанхуйд нуугаад байдаг байсан гэрээнүүд нь цахим дээр бүртгэгдээд эхлэхээр энэ байдал эрс багасна. Цаашидаа хулгай нүүрлэхгүй байх асуудлыг шийдэхгүй бол хүн солигдсоноор дахиад дараагийн хулгайч төрөх магадлалтай байхгүй юу. Тэр чинь цаад талын нөлөөлөл орно. Тэгэхээр дэлхий дахин бол авлигагүй, ил тод, нийгмийг бүтээхэд бүх салбарыгаа цахимжуулаад, технологиор шийддэг бол л гэж байгаа юм. Тэгэхээр цаашидаа бид нар боомтын үйл ажиллагаанд ч гэсэн хиймэл оюун ухаан ашиглах ёстой. 21 дүгээр зуунд өнөөдөр машин тэргээ хүн тоолдог биш хиймэл оюун ухаанаар тоолоод бүх зүйл нь бүртгэгдээд, автоматжуулаад ингээд явах ёстой шүү дээ. Тэгэхээр иргэд тийм бүрэн дүүрэн ойлголттой биш байна. Одоо бол бүгдээрээ шийдлээ ярих цаг болчихсон. Тэгэхээр Их Хурал ч бай, Засгийн газар ч бай энэ ажлуудыг хурдан шуурхай шийдээд ингээд ажлууд урагшилж байгаа юм гэдгийг иргэддээ зөв мэдээлэл өгөх ёстой.

Тэгэхээр би ажлын хэсгээс ялангуяа хөрөнгийн биржээс асуулт асуумаар байгаа юм. Алтай захирал та иргэдэд маш энгийн үгээр Засгийн газраас түр журам гарчихлаа. Ингээд нүүрсний хулгай худалдан авагчдаа олон улсын үнээр зарагдах ёстой бараа. Тэгэхэд тээвэр жингийн асуудал дээрээ л энэ хулгай нүүрлээд байна шүү дээ. Тэгэхээр энийг ингээд цахим арилжаа дээр тавихаар яг ямар нөхцөл байдал үүсэх юм бэ? Яг хэзээ энэ түр журмын хүрээнд Хөрөнгийн бирж нүүрсээ арилжаалж эхлэх вэ гэдгийг та яг нэг энгийн, маш энгийн үгээр тайлбарламаар байна. Гадаад үг хэллэг оруулахгүйгээр бүгдээрээ энийг тэгэхгүй бол commodity exchange гэхээр чинь иргэд ойлгохгүй

байна шүү дээ. Яг энгийн үгээр нэг тайлбарлаадахмаар байна.

Г.Занданишатар: 86. Хангай Алтай. Хөрөнгийн биржийн захирал.

Х.Алтай: Учрал гишүүний асуултад хариулъя. Өчигдөр Засгийн газрын холбогдох шийдвэр гараад түр журам батлагдсан. Энэхүү түр журам бол 01 сарын 01-ээс хэрэгжээд эхэлнэ. Энэ бол маш энгийн. Зарчим нь Эрдэнэс таван толгой юм уу эсвэл аль нэгэн хүссэн байгууллага, уурхай Монголын Хөрөнгийн биржид би энэ сард энэ хэмжээний ийм чанартай, ийм хэмжээний нүүрсийг борлуулах боломжтой гээд бид нарт мэдээлэл өгнө. Бид нар тэрийг ил тодоор өөрийн цахим хуудсаараа дамжуулаад мэдээлнэ. Нөгөө талаас тэр бүтээгдэхүүнийг худалдаж авах хүсэлтэй байгаа, авъя гэсэн худалдан авагчид нь өөрийнхөө 10 хувийн дэнчинг тавиад шууд тухайн нүүрсийг худалдаж авах боломжтой. Ийм энгийн зохицуулалт хөрөнгийн бирж гэдэг өөрөө бол нээлттэй commodity exchange үнэт цаасны. Уучлаарай. Хөрөнгийн бирж таваарын бирж бүгдээрээ нээлттэй ил тод байдаг. Ингэснээрээ нүүрсний борлуулалт өөрөө ил болох юм аа. Баярлалаа.

Г.Занданишатар: Болсон уу. Учрал гишүүн тодруулж асууя.

Н.Учрал: Сангийн яамнаас автоматжуулах системийг хийгээд үр дүнд хүргэж байгаа юм байна лээ. Одоо энэ боомтын чинь үйл ажиллагаа борлуулалтаас авхуулаад худалдан авагчид хүрэх хүртэлх бүх процесс автоматжана. Тэгээд тэр тээвэрлэлтийн гэрээний дагуу тээвэрлэгдээд ирсэн чинь нүүрс чинь гаалийн шинжилгээний лабораторитойгоо нийцэж байгаа хэсэг нь хянагдаад ингээд явах систем л дээ. Тэгээд үүний дараа яг нөгөө борлуулалт хийх гэж байгаа тэр цахим бирж дээр ингээд л арилжаалагдаад эхлэхээр

нүүрсний үнийн өсөлтөд ч гэсэн энгийнээр би нөлөөлнө гэж бодоод байгаа юм.

Тэгээд энэ ажлын хэсэг дээр яригдсан. Цаашидаа энэ түр журам хэрэгжээд явах юм байна. Цаашидаа уул уурхайн биржийн хууль гарсны дараа төрийн өмчийн оролцоотой тусдаа тэр хувийн хэвшлийн тодорхой төлөөллийг нь оруулсан, иргэд нь хяналттай төр нь ч оролцоотой. Тэгээд ард түмний нүдэн дээр ийм хяналттай бирж байгуулагдах нөхцөл бололцоо бүрдэнэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр Уул уурхайн яамнаас бол ер нь цаашидаа иргэдийн хяналтыг яаж энэ бирж дээр оруулах вэ. Хууль гарснаар.

Г.Занданишатар: Жамбалын Ганбаатар сайд хариулна.

Ж.Ганбаатар: Засгийн газрын шийдвэрээр биржийн ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11-д зааснаар эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж болно гэсэн ийм заалт хуульд нэмж орж байгаа. Энэ үүднээсээ бол иргэдийн хяналт гэдэг юм уу, хувийн хэвшлийн хамтарч ажиллах боломж нээгдэж байгаа. Гэхдээ зүгээр бид юу гэж үзэж байгаа вэ гэхлээр Энхбаяр гишүүн өчигдөр Байнгын хороо дээр санал гаргуулсан юм. Ер нь бол бб хувиас доошгүй байя гэж. Төрийн хяналт төрийн оролцоо. Зүгээр яах вэ яамны хувьд бид тийм байх нь эхний ээлжид зөв гэсэн ийм байр суурьтай байгааг хэлье. Зүгээр яах вэ бирж байгуулагдсанаараа энэ амны үнэ гэдэг юм уу Цагаан хад, жишиг үнэ гэрээний үнэ гээд яриад байгаа олон зүйлүүдийг нэг мөр болгоод биржийн үнэ гэдгийгээ.../минут дуусав/

С.Одонтуяа: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ их чухал ач холбогдолтой хууль байгаа юм. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн тухай хууль гарснаараа уул уурхайд ил

тод байдал бий болно, хариуцлагатай байдал бий болно, өрсөлдөөн бий болно, үнийн хувьд бид нар дэлхийн зах зээлийн үнээр борлуулах боломж нөхцөл бүрдэнэ гэж ингэж харж байгаа юм. Тийм учраас энэ хуулийг баталж гаргах ийм саналтай байгаа. Б и 2 зүйлийг тодруулж асууя гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт нүүрсний асуудал бол бид нар үндсэндээ дэлхийн зах зээл дээр гаргах гэж байна л гэсэн үг. Бүтээгдэхүүнээ, нүүрсээ, зэсээ, алтаа, төмрийн хүдрээ гэсэн үг. Тэгэхлээр нэгдүгээрт нь миний асуух гээд байгаа юм дэлхийн олон улсын биржид гарах боломж энэ хуулиар нээгдэх үү. Энэ хууль гарснаараа бид нар хамгийн наад талын захын жишээ БНХАУ-ын томоохон биржүүдэд Монгол Улсын аж ахуйн нэгж орох боломж бүрдэх үү. Монгол Улсад бий болсон бирж, манайд бий болсон бирж, манайд бий болсон биржээр хэрэв арилжаалагдах юм орж ирэхгүй орж ирсэн ч нөгөө зах зээлийн өрсөлдөөн нь бага байвал бид нар гадагшаа гарах боломж байна уу энэ хуулиар. Энэ чинь хамгийн гол нь бид нар чинь нөгөө бүтээгдэхүүнээ үнэтэй зарахад л чиглэгдэж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар олон улсад тэр дотроо нүүрс дээр БНХАУ-д гарах боломж энэ хуулиар гарах уу. Манай аж ахуйн нэгж. Энэ бол би чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарт гаднын аж ахуйн нэгжүүд манай бирж рүү орж ирэх нөхцөл бүрдэх үү гэдэг ийм асуулт байгаа юм. Нэг дэх нь. Хоёрдугаарт нь би ганцхан нүүрс дээр асууя. Бусад нь бол стандарттай. Алт, зэс, төмрийн хүдэр өөрийн гэсэн стандартаар явчихна. Нүүрсний стандарт дэлхийн зах зээлийн шаардлагыг хангах уу гэдэг асуудал байгаа юм. Эрчим хүчний, коксожсон, олон угаасан гээд олон зэрэглэл байна. Энэ зэрэглэл гараад ирэхээр бидэнд тавигдах шаардлага аягүй өндөрсөнө. Энэ хууль гарснаар. Бид нар нүүрсээ үнэд оруулъя гэвэл бидний зүгээс хийх ажил их

гарч ирнэ. Ялгах, угаах гээд олон юмнууд гарч ирнэ. Тэгэхлээр энэ нөхцөл манайд бүрдэж байгаа юу. Зүгээр манайх гаргаж байгаа шиг хольсон нүүрсийг хэн ч авахгүй байх гэж бодож байгаа байхгүй юу. Холиод ингээд хар наймаа хийж байгаа юм шиг юмыг хэн ч авахгүй байх ийм нөхцөл манайд бүрдсэн үү гэдэг ийм 2 зүйлийг асууя. Баярлалаа.

С.Одонтуяа: Хэн хариулах уу. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ганбаатар хариулъя.

Ж.Ганбаатар: Эхлээд хууль бол өнөөдрийн хэлэлцэгдэж байгаа хууль маань 7 сарын 01-ээс хэрэгжихээр байгаа. Тэгэхээр бид эхний ээлжид 7 сарын 1-ээс өмнө өчигдөр Засгийн газрын хуралдаанаар журам батлагдаад нүүрсийг 7 сарын 1 хүртэл, 2 сарын 1-ээс Эрдэнэс таван толгой болоод Энержи Ресурс, нэмэгдээд хувийн компаниуд нэмэгдэх боломжтой. Тэгээд 1 сардаа багтаад дунджаар 1 сая тонн нүүрсийг биржээрээ зарна гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна. 7 сарын 1-ээс хууль хэрэгжээд явахад нэлээн түлхэц болох юм. Энэ журмаар зөвхөн нүүрсээ зарах гэж байгаа юм. Ер нь зүгээр Уул уурхайн яамнаас ойлголт ямар байна гэхээр бид өөрийнхөө ашигт малтмалыг биржээрээ зарах гэж байгаа юм. Хятад руу гаргах уу гэдэг дээр бол хөрөнгийн бирж хариулах ёстой байх гэж бодож байна. Гэхдээ худалдан авагч одоогоор байгаа. Манайхыг ингээд хольчихсон нүүрсийг авах уу, энэ нүүрсийг чинь авах хүн олдох юм уу гэдэг дээр уучлаарай манай нүүрсийг нэг их айхтар голоод байдаг зүйл бол бага байна. Зэс дээр ч гэсэн, төмрийн хүдэр дээр ч гэсэн. Алт бол энэ чинь Монгол банканд тушаагдаад явна. Тэгэхлээр яах вэ нөгөө нефтийн бүтээгдэхүүн өөр хуулиар зохицуулагддаг учраас энэ дээр одоохондоо бид бол тэрийг энэ биржээр зарна гэж тооцохгүй байгаа. Манай итгэмжлэгдсэн лаборатори нүүрснийхээ чанарыг тодорхойлдог. Энэ чанарын тодорхойлолтоор бол Хятад улсын

худалдан авч байгаа компаниудаас гомдлууд нэг их айхтар гараад байдаггүй юм. Яах вэ зарим тохиолдолд бол тэр нь энэ чанарынх биш, энэ чинь 24 чанар байгаа. Энэ нь тэр чанар байна тэр нь энэ чанар биш байна гэсэн иймэрхүү гомдлууд анзаарагддаг гэдгийг хэлье. Тэгээд яах вэ? Би түрүүн нөгөө энэ бол бирж байгуулагдсанаараа ер нь олон янзын үнүүдийг цэгцэлнэ, татвараа зөв авна, АМНАТ-аа зөв авна. Тэрнээс гадна аж ахуйн нэгжүүдэд өсгөх бололцоог гаргаж өгнө. Худалдан авагч нарт маш зөв таатай боломж олдоно. Худалдан авагч нар та бүгд мэдэж байгаа шүү дээ. Тийм гэрээ хийгээд өгөөч, энийг гэрээ хиймээр байна. Тэр хүнээр дамжуулмаар байна, тэр хүнтэй ингэж яривал гэрээ хийчихдэг бололцоотой юм шиг байна. Тэгье, ингэе гээд энэ баахан ярианууд явдаг. Тэгэхлээр худалдан авагч нар биржээс нүүрсээ, зэсээ зэсийг яах вэ бид нар нэлээн урт хугацаанд гэж төлөвлөж байгаа. Бэлтгэл ажил маш их байгаа. Тогтохсүрэн гишүүний хэлж байгаа зөв 11 журам батлах ёстой энэ хооронд. Яах вэ бид яг биржийн өнөөдрийн төлөвлөж байгаагаар бол Хөрөнгийн биржийн доор охин компани маягаар ажиллуулах ийм л төлөвлөгөөтэй байгаа. Шинээр томоохон бирж байгуулаад л, хөрөнгө зарцуулаад л том том платформ бий болгоод л, тэрийг худалдан авах ийм зүйлүүдийг бол бирж маань өөрөө нэлээн томроод ирчихсэн үед энэ бол тийм боломжтой байгаа. Хуульд бол 2 гарцтай байгаа. Эсхүл тусад нь бирж байгуулж болно. Эсхүл Хөрөнгийн биржтэйгээ ингээд хамтраад явчхаж болно гэсэн ийм хариултыг хэлье. Баярлалаа.

С.Одонтуяа: Нэмээд Батнайрамдал дэд сайд нэмж хариулъя. 85 дугаар микрофон.

О.Батнайрамдал: Тогтохсүрэн гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Таны 3 дахь асуулт стандарттай холбоотой. Монгол Улсын нүүрсний стандарт яг энэ жилийг хүртэл 2014

оны ангиллаар нийтдээ бол түүхий, баяжуулсан бүгд нийлээд 11 төрлийн л ангилалтай байсан. Нэг ёсондоо бол жишигээр коксжих нүүрс ганцхан ангилагддаг гэсэн үг. Тэгэхээр энийг энэ жил Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нүүрс экспортлогчид бүх талын оролцоог хангасан ажлын хэсэг гараад, нүүрсний стандартаа бид нар олон улсын жишигтэй ойртуулж шинэчилсэн байгаа. Одоо шинэчилсэн Монгол Улсын нүүрсний стандартаар бол нүүрс баяжуулсан, баяжуулаагүй бүх нүүрс ороод 30 ангилал руу энэ нь өөрөө яг БНХАУ-ын нүүрсний ангилалтай маш ойрхон болсон. Тэгэхээр ер нь бол бид нар яг нүүрсээ сүүлийн 10 жил бол Монголын нүүрсний зах зээл нэлээн хөгжсөн, олон төрлийн нүүрс гардаг болсон. Тэгэхээр үүнтэйгээ уялдуулаад бид нар нүүрсний стандартын ангиллаа шинэчилж гаргасан. Тэгэхээр яг энэ стандартынхаа дагуу бүтээгдэхүүнээ бид нар яг уул уурхайн бирж дээрээ цаашаагаа зараад авна гэсэн хүлээлттэй байгаа юм. Баярлалаа.

С.Одонтуяа: Хангайн Алтай Монголын Хөрөнгийн бирж. 86 дугаар микрофон.

Х.Алтай: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Бид бүхэн Засгийн газрын холбогдох журам гаргах гээд ажиллаж байхад бол хувийн хэвшилээс бидэнд хандсан. Танай биржээр дамжуулаад бид нар өөрийнхөө нүүрсний арилжааг хийе. Энэ нь тод тунгалаг ийм болох юм гээд. Тэгээд бид бүхэн танай худалдан авагч тал чинь энэ биржээр ингээд хийвэл авах уу гэсэн ер нь мэдээж манай нүүрс өөрөө урд хөрш рүү экспортлогддог. Тэгэхлээр Хятадын болон ямар ч гаднын худалдан авагч Монголын бирж дээр Монголын уул уурхайн бирж дээрээс Монголын уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг авах боломжтой. Тухайлж хэлэх юм нүүрс дээр сая Батнайрамдал сайд хэллээ. 30 орчим нүүрсний төрлийн Монголын стандарт гарчихсан. Энэ нь өөрөө олон

улсын стандарттай мөрдүүлээд гарчихсан. Энэ дагуу ийм стандартын ийм хэмжээтэй ийм бүтээгдэхүүнүүд манайх энэ сард зарна гээд. Тэрийг нь би ирж өөрөө олон нийтэд ил тавиад энд ямар ч гаднын болон дотнын дотоодын аж ахуйн нэгж, иргэд худалдаанд оролцоод худалдан авах боломжтой.

С.Одонтуяа: Галсандорж гуай нэмж хариулъя. Монголын Экспортлогчдын Холбооны ерөнхийлөгч. 87.

Д.Галсандорж: Тогтохсүрэн гишүүний түрүүний асуулт. Монголд уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулагдсанаар Монголын экспортын бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд гарах уу, бусад ижил төрлийн биржүүдтэй бүс нутгийн бөгөөд олон улсын биржүүд дээр гарах уу гэж асуулаа л даа. Тэгэхээр энэ уул уурхайн бүтээгдэхүүнээр эхний ээлжид биржийн бус бараа гэж нэрлэдэг. Олон улсад бирж байдаггүй нүүрс, жоншны баяжмал, төмрийн баяжмал одоогийн тулд борлогдоно. Түрүүн сайдын хэлснээр бол өнгөт металл, зэсийн баяжмал юм уу, цайрын баяжмал бол дараа шатандаа явна гэж бодож байгаа. Тэгэхээр хамгийн гол нь бирж байгуулагдсанаар өнөөдөр нүүрс дээр ч ялгаагүй зэс, төмрийн баяжмал дээр үйлдвэрлэгч гэхээсээ дундын зуучлагч, трейдерүүд их орж ирж авч байгаа. Энэ бирж байгуулагдсанаар манай нүүрсийг Хятадын гангын үйлдвэрүүд тухайлбал Бугат ч байдаг юм уу, Бээжингийн ойролцоо байж байгаа томоохон гангын үйлдвэрүүд шууд авах, Хятадын үйлдвэрлэгч эцсийн хэрэглэгч нар манай уул уурхайн бүтээгдэхүүний бирж дээр брокероор дамжуулж захиалгаа өгөөд худалдан авах нээлттэй олон худалдан авагч нар орж ирснээр үнэ бол зах зээлийн ч зарчмаар өндөр тогтоно гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт бид нар бас уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулахтай холбогдуулаад олон

биржүүдийг судалсан. Биржийн бус бараа нүүрс, төмөр, жоншны баяжмалыг борлуулж байгаа Хятадын Тянь Жинийн бирж байгаа эрх чөлөөтэй. Тийм учраас Тянь Жинийн бирж байгуулагдаад 10 гаруй жил болж байгаа ч гэсэн нэг триллион долларын арилжаа хийж байна шүү дээ. Тянь Жинийн бирж дээр арилжаа хийж байгаа нүүрс худалдаж авч байгаа төмөр, жоншны баяжмалыг худалдаж авч байгаа хэрэглэгч нар манай уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авахаар энэ уул уурхайн бүтээгдэхүүний бирж дээр өргөнөөр орж ирнэ гэж ойлгож байгаа.

С.Одонтуяа: Тилеуханы Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Уул уурхайн яамнаас оруулж ирж байгаа асуудлыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ нь улс, эх оронд үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой төрийн өмчит компаниудыг тонон дээрэмддэг, ард түмний авах ёстой байсан боломжийг өөртөө давуу тал бий болгож харанхуйгаар нүүрсний үнийг наймаацдаг ухаандаа Бээжинд очоод л Хятадын бизнесменүүдтэй Хятад хоол идэж сууж байгаад л үнээ тохирдог байсан явдалд цэг тавих ийм нэг ажлын эхлэл гэж би харж байгаа юм. Шилэнгээр, нээлттэйгээр хөрөнгийн бирж дээр арилжаад сая хэллээ шүү дээ. Эцсийн хэрэглэгчдэдээ хүрэх бүрэн бололцоо үүсэж байна гэж. Үнэн шүү дээ. Дунд нь байсан трейдерүүд, нөгөө нууц гэрээ хийдэг, нүүрсний гэрээ зарагдаж байсан нь үнэн. Сая Тогтохсүрэн гишүүн хэлсэн үү. Нүүрсний гэрээ алив нэг тэдэн тонны гэрээ хийгээд өгчхөөч, тонныг нь тэд дээр гэж байсан бүх асуудалд цэг тавих асуудал гэж би харж байгаа юм. Тийм учраас энэхүү асуудлыг дэмжиж байна. Тэгээд уул уурхайн бирж, хөдөө аж ахуйн бирж гээд явж байсан. Уул уурхайн бирж бол Ганбаатар сайд маш түргэн шуурхай энэ асуудлыг оруулж ирж байгаад талархаж байна. Хөдөө аж ахуйн биржээ бид нар яаж явуулах учраа

олохгүй л мунгинаад байж байгаа. Энийгээ ч гэсэн бид нар энэ асуудалтайгаа зэрэгцүүлээд Монголын Хөрөнгийн бирж рүүгээ төвлөрүүлээд 30 гаруй жил ажиллачихсан туршилагатай Хөрөнгийн бирж. Өчигдөрхөн өөрийнх нь Монголын Хөрөнгийн биржийг олон нийтийн болгох асуудал нь шийдэгдээд Санхүүгийн зохицуулах хороо дээр бүх асуудлууд яваад эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор өчигдөр шийдэгдсэн асуудал маань бас экспортод гарч байгаа нүүрсний нээлттэй цахим арилжааны журмыг маш шуурхай батлаад гаргалаа. Ингэснээрээ төрийн өмчит компаниуд тоногдоод байгаа, ард түмэнд хардалт, сэрдэлт бий болж байгаа асуудалд цэг тавих ажлын эхлэл гэж харж байгаа юм. Засгийн газар гарч ирээд л анхнаасаа хэлж байсан. Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулъя. Олон нийт ийм болгоё, энэ олон ашиггүй ажиллаад байгаа компаниудыг олон нийтийн болгоод, тодорхой хувийг нь олон нийтийн болгох юм бол олон нийтийн оролцоо, хяналт бий болно. Ингээд нөгөө компани маань ашигтай ажиллах бололцоо бий болгох юм гэсэн Засгийн газрын тавьсан зорилтуудын эхний ажлууд явж байгаа гэж харж байгаа юм. Тийм учраас асуудлыг би дэмжиж байна. Тэгээд энэ дээр Хөрөнгийн бирж жишээлбэл түрүүн Тогтохсүрэн гишүүн асуулаа. Дэлхийн жишигт үнийг нийцүүлэх, стандартыг нийцүүлэх, Танай хөрөнгийн бирж маань борлуулалт арилжаагаа хийх хурдыг дэлхийн жишигт хүргэх бололцоо бий юу. Одоо биржээр арилжъя гээд л жишээлбэл нөгөө компани маань нүүрснийхээ борлуулах захиалгаа өгдөг. Гэтэл борлуулалт янз бүрийн сервер янз бүрийн юман дээр чинь гацаа гараад байдаг ч юм уу, үгүй бол боловсон хүчний дутагдлаас болоод нөгөө нэг ажил маань доголдоод эхлэх вий дээ.

Танайхыг 30 жилийн туршилагатай, дэд бүтэц бүх юм нь бэлэн байгууллага гэж ойлгож байгаа. Энэ дээр танайх дэлхийн жишигт хурдыг нь гүйцээж

ажиллах бололцоо бий юу. Дээрээс нь Ганбаатар сайдаас энэ уул уурхайн биржийн асуудал яригдаж байхад бол уул уурхайн бирж гээд тусдаа байгуулагдах юм. 10 гаруй сая доллароор шинэ платформ бий болгоод, дахиад дэд бүтэц, хүн хүч, ажиллах хүчнээ гаргаад дахиад нэг байгууллага гарч ирэх юм гэж би сонсож байсан. Би Байнгын хороо дээр бас байр сууриа илэрхийлж байсан. Тэртээ тэргүй 30 жил ажиллаад явж байгаа, бэлэн байгаа байгууллагаа өнгө оруулж зүлгээж, өнгө оруулж дэмжээд явах байтал дахиад хажуугаар нь нэг юм гараад ирэх юм биш биз дээ. Хуулийн хүрээнд. Ийм байж болохгүй. Бид нар 30 жилд сайн, муу он, цаг, жилийг туулаад олон улсын түвшинд коннекшинтой дотооддоо хүртэл коннекшинтой хэд хэдэн банкны IPO гаргалаа. Ийм байгууллага байтал дахиад хажууд нь явахгүй бас нөгөө олон нийтийн хэлдгээр цүнх баригчдыг томилдог ийм дахиад нэг төрийн өмчит бирж гараад ирэх вий дээ. Энийгээ хуулиараа зохицуулалт хийж өгсөн үү гэдэг ийм 2 асуулт байна. Эхнийх нь бирж. Дараа нь Ганбаатар сайдаас.

С.Одонтуяа: Ганбаатар сайд эхэлж хариулъя.

Ж.Ганбаатар: Яг Аубакир гишүүний гаргасан саналын дагуу Байнгын хорооны даргаас бас ажлын хэсэгт чиглэл өгөөд 5.9 гээд одоо санал хураалт хураагдана. Аубакир гишүүн ээ, энэ ямар санал вэ гэхээр Засгийн газрын шийдвэрээр биржийн арилжааг үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж болно гэдэг нь Хөрөнгийн биржийг хэлж байгаа юм. Анх хууль өргөн баригдахдаа яг хатуу, зөвхөн уул уурхайн бирж гэж байсан бол одоо хөрөнгийн биржээр явуулж болно гэдэг заалтыг оруулж өгсөн. Тэгэхээр таны хэлж байгаа зардлууд бол яг уул уурхайн биржийг хэрвээ дангаар нь байгуулна гэвэл бас тодорхой зардлууд бол гарна. Мэдээж яг

эцсийн зардлыг бол хэлж мэдэхгүй байна. Гэхдээ маш нэлээн томоохон зардлууд гарахыг бол үгүйсгэхгүй.

Тийм учраас бид нарын зүгээр эхний ээлжид төлөвлөж байгаагаар бол эхний металлуудаа болоод нүүрсээ хөрөнгийн бирж дээрээ түшиглээд явуулах нь зөв байна гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Одонтуяа: Хэн хариулах уу. Ажлын хэсгээс. Хангайн Алтай Монголын Хөрөнгийн бирж. Хэддүгээр микрофон байна. 86.

Х.Алтай: Аубакир гишүүний асуултад хариулъя. Боломжтой. Манай хөрөнгийн бирж олон улсын практик байдаг. Жишээлбэл Франкфуртын бирж, Хонг Конгын бирж адилхан түүхий эд арилжаалж байдаг. Тэгэхлээр Монголын Хөрөнгийн бирж бол энэ зарчмаар явах боломжтой. Дэд бүтцийн хувьд бид нар олон улсын дэлхийн томоохон хөрөнгийн биржүүд ашигладаг цөөхөн хэдэн платформ программ хангамж байдаг. Тэрний нэг болох millennium it гэдэг бид нар программ хангамжийг бол ашигладаг. Хууль батлахтай зэрэгцээд энэ дээр мэдээжийн хэрэг санхүүгийн шинэ, шинэ бүтээгдэхүүнүүд үүсмэл үнэт цаас гэх мэт шинэ бүтээгдэхүүнүүд гарна. Үүнтэй холбоотой бид нар системдээ тодорхой хэмжээний өөрчлөлтүүд бол хийнэ. Millennium it гэдэг системийг Лондоны металлын бирж ашигладаг. Тэр утгаараа бас commodity exchange буюу таваарын биржийн чиглэлээр гишиглах боломжтой. Мэдээжийн хэрэг шинэ бүтээгдэхүүн учраас бид бүхэн боловсон хүчний хувьд мэдээж шинэ нэгж байгуулах магадгүй групп компаниар үйл ажиллагаа явуулна. Ер нь товчхондоо хэлэхэд хийх боломжтой.

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжих нэг том шалтгаан байгаа. Монголоор дүүрэн уул уурхайн том хулгай нүүрлэчихсэн. Тэгээд энэ дээр бас салбарын итгэдэг, салбартаа олон жил ажилласан эрдэмтэн хүн энийг эх барьж орж ирж байгаа гэж би итгэж байгаа. Тэр нь бол үнэхээр сайн тал. Харин айж байгаа нэг зүйл байна. Монголчууд бид чинь ер нь Засгийн газраасаа, сайд нараасаа, улс төрчдөөсөө л ухаан алдталаа айдаг ард түмэн шүү дээ. Тэд нарын микроп шунал бол зүгээр ковидын вирусээс илүү нарийн давхиж орж ирнэ шүү дээ. Аймшигтай шүү дээ. Тэгэхлээр асуулт. Засгийн газрын, төрийн өмчит байна л гээд байгаа. Яг тэр олон судалгаа хийсэн, тэр олон металлын янз бүрийн биржүүд дээр чинь яг төрийн өмчит нь их байна уу. Яг энэ практик нь хаана байгаа юм. Манайд Төрийн өмчит компанийн хэлбэртэй гэж байгаа шүү. Энэ чинь бас яг төрийн өмчит гэж хэлэхгүй байгаа юм. Хэлбэртэй гээд заачихсан байгаа юм. Хуулийн төсөл бирж нь төрийн өмчит компанийн хэлбэртэй байна гээд 5.1.3-д, хуудас 3-д заасан Энэ зохимжтой юу. Та нар хөдөө аж ахуйн биржийг бол зүгээр супер дамнууруулсан шүү дээ. Тэгээд энэ дээр нөгөөдүүлийг чинь шунал орж ирэхгүй гэсэн баталгаанууд нь хэр байгаа вэ. Яагаад асууж байна гэвэл Төлөөлөн удирдах зөвлөлийг нь дандаа улс төрчид тавьж байгаа л даа. Таван толгой Төлөөлөн удирдах зөвлөлтэй шүү дээ. Тавантолгойн том хулгай ярьж байна. Төлөөлөн удирдах зөвлөлд нь дандаа улс төрчдийн микроп үнэртсэн хүмүүс орсон шүү дээ. Оюутолгой ингээд л улс төрийн амралтад очсон юм шиг нэг хүн байдаг. Зүгээр улс төрч. Очоод л нэг амралтад байдаг. Тэгээд Монголчуудыг төлөөлж байгаа юм юу ч байхгүй. Эрдэнэт адил тэр, Таван толгой, Оюу толгойг л лав би мэдэх юм байна. Тэгэхлээр Төлөөлөн удирдах зөвлөл. Нэгдүгээр асуулт тодорхой байгаа байх. Бирж төрийн өмчит байх нь зөв үү.

Хоёрдугаарт олон нийтийн хэлэлцүүлэг хийх юм байгаа юу. Төлөөлөн удирдах зөвлөлд орох хүмүүс чинь. Энэ хэдэн их наядын мөнгийг цааш нь нааш нь болгох эрх мэдлийг өгч байгаа шүү дээ. Нөгөө улс төрч чинь зүгээр баярлаад л гүйгээд ороод ирнэ шүү дээ. Бөөн баяр. Эд нарын шийдэх юмнууд нь их байгаа шүү дээ. 5.6-д бирж нь янз бүрийн тэр арилжааг зохион байгуулах болон тээвэр логистикийн төв, шинжилгээний лаборатори гээд эд нарын авлига авах олон юмнууд байна л даа. Энэнээс сэргийлсэн механизмыг та нар судалсан уу. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуултаа биржийн арилжааны үнийг хил залгаа улсын хилийн боомтын үнээр зарлана гэж байгаа юм. Хятадын, Оросын Холбооны Улсын. Лондоны металлын биржээр яваад байдаг байсан. Тэр бүр хамаагүй болох уу. Энийг яаж судалсан бэ. Энэ бодитой судалгаан дээр гарч ирсэн дүгнэлт үү. Үнийг бол 2 хөршөөсөө асууна л гэсэн юм ярьчихсан байна.

Гуравдугаарт мөнгө орно. Энэ чинь мөнгөтэй юм байна лээ шүү дээ. Миний тооцоогоор программ хангамж гээд 24, 25 тэрбум байсан. Тэгээд нийтдээ 35 тэрбум төгрөгөөр анхны гарааны зардал гарах юм байна лээ. Хаанаас олох вэ, энэ хаанаас гарах вэ. Тэгээд цаашаа бие даагаад явах дээр ТЭЗҮ гэдэг нь алга байна. Энэ хэзээ эхлэх юм. Тэр 6 сар гээд түрүүн ярьж байсан. Би ТЭЗҮ-г нь хараагүй учраас энийг асууж байна. Тэр 35 тэрбум төгрөг хаанаас гарах вэ.

Дараагийн миний асуулт төслийн хэрэгцээ шаардлагаас эхлээд бол зүгээр төмөр, нүүрс, жонш явах юм байна. Хоёрдугаар үе шатандаа алт, зэс орж ирнэ гэж байна. Алт, зэс хэзээ орох вэ. Алт, зэсийн биржээр хэлэлцдэг наймаа дараагийн шат гээд биччихсэн байгаа юм. Хугацаа алга. Хэзээ вэ гэсэн ийм 4 асуултад би хариултаа авмаар байна. Тэгээд биржийн ажиллах тэр яг бизнес төлөвлөгөө, ТЭЗҮ-г бол би лав

танилцуулга дээрээс олж харсангүй. Тэр талаар бас надад хариулна гэж би бодож байна.

С.Одонтуяа: *Байнгын хорооны дарга Цэрэнпунцаг хариулаад, дараа нь сайд Ганбаатар.*

Ц.Цэрэнпунцаг: *Манай Ганбаатар гишүүн санаа зовдог гол юмнуудаа ярьж л байх шиг байна. Тэгэхдээ танд нөгөө наад уншиж байгаа хуулийн төсөл чинь эхнийх нь байх шиг байна. Төрийн өмчит биш, төрийн өмчийн оролцоотой л гэж байгаа. Хамгийн сүүлийн хувилбараар. Танд аягүй бол эхнийх нь байгаа байх шүү. Тэгэхээр яг таны тэр эхний яриад байгаа гол асуудал тэр компанийн засаглалын асуудал, тэр Төлөөлөн удирдах зөвлөл нь дандаа улс төрчид тавигддаг гээд байдаг асуудлуудыг шийдэхийн тулд Хөрөнгийн бирж маань 2023 ондоо 34 хүртэлх хувиа хувийн хэвшлийнхэнд, хувийн хөрөнгө оруулагчид нээлттэй болгоё гэж байгаа. Тэгээд нар маань орж ирээд засаглалыг сайжруулах чиглэлд ажиллах учраас хөрөнгийн бирж дээр угаасаа хийх нь зүйтэй юм байна гээд ингээд явж байгаа шүү.*

Таны эхний асуудал бол бүхэлдээ сүүлийн тэр төсөл дээр байж байгаа юм. Ганбаатар сайд дараагийн асуултуудад нь хариулах байх.

С.Одонтуяа: *Ганбаатар сайд хариулъя.*

Ж.Ганбаатар: *Байнгын хорооны даргад баярлалаа. Гүйцээж хариулъя. Байнгын хорооны даргынхаа юуг. 5.1-д бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байна гэж заасан. 6.2-т биржийн хувьцаа эзэмшигч нь Засгийн газар, бирж хувь нийлүүлсэн бусад этгээд байна гэж заасан. Биржийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчийн хурал байна. Энэ бол ингэхээс өөр арга байхгүй. Бид нарын олж тавьж байгаа хамгийн зөв зарчим л гэж ойлгож байгаа. Тэгэхлээр 7.2-т*

Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд 4 гишүүн нь хараат бус байна гэж байгаа юм. Тэгэхээр энийг бас та харсан байх гэж бодож байна.

Үнийн хувьд бол эхлээд нүүрс дээр бол өчигдөр бид нар журмаараа батлахдаа бол үүнийг бол Эрдэнэ таван толгой юм уу, тэр арилжаанд оролцож байгаа компаниуд доод үнээ өөрсдөө зарлана гэж байгаа юм. Цаашидаа бол бирж зарлана. Яг хуулиараа бол бирж доод үнээ зарлана гэж. Тэгэхлээр одоо худалдан авагч нарын хувьд бол юу гэдэг юм. Яг нэг тийм ч худалдан авагчгүй улс бол бид биш шүү дээ. Манай яг уул уурхайн энэ металлуудын хувьд баяжмалуудын хувьд ер нь худалдан авагч харьцангуй бас сонирхол ихтэй. Тийм учраас бид нар нэг их айхтар тийм юу гэдэг юм манай бирж рүү ирж оролцох сонирхолгүй гэж үзэхгүй байна. Зүгээр айж байгаа энэ тэр гэдэг дээр тэр намайг хэлсэн юм болов уу, яасан юм бол. Би нэг их айлгаад байгаа зүйл нь гайгүй болов уу гэж бодож байна шүү дээ. Тэгээд уул уурхай энэ тэр рүү өөрөө нэг хуруу дүрээд байх тийм зүйл гаргахгүй л гэж үзэж байна шүү дээ. Тийм юм байхгүй. Тэгэхлээр 6 сарын 30-аас эхэлнэ гэдэг нь таны хэлж байгаа бэлтгэл ажлууд их явна. Та зөв харсан. Их бэлтгэл ажлууд байгаа. Зэс, алтны хувьд бид биржээрээ учиргүй алтаа зараад байна гэж бодохгүй байгаа. Зэс бол цаашидаа тодорхой хугацаа шаардлагатай. Энийг бид Засгийн газартайгаа ярьж байгаад энийг шийднэ. Шууд өнөөдөр тэдэн сарын тэдэнд зарна гэдэг зүйл юу байна. Ямар ч байсан эхний ээлжид төмрийн хүдэр, нүүрс, жонши, цайр, хар тугалга гээд энэ металлуудаа зарна гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тэр бусад яг Хөрөнгийн биржтэй холбоотой асуудлууд дээр нь манай дэд ажлын хэсгийнхэн хариулъя дарга аа. Баярлалаа.

С.Одонтуяа: Хэн хариулах уу. 85. Батнайрамдал дэд сайд.

О.Батнайрамдал: Ганбаатар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Бид нар энэ хуулийг бичиж байхдаа олон улсын жишигийг судалсан. Ер нь дэлхий даяар 200-аад гаруй таваарын биржүүд олон байдаг. Ер нь 2000 оноос хойш ялангуяа хөгжиж буй орнууд экспортынхоо бүтээгдэхүүнийг цаашаа идэвхтэй, зах зээлийн зарчмаар чөлөөт өрсөлдөөнөөр гаргахын тулд маш олон таваарын биржүүдийг байгуулсан байдаг. Ялангуяа хөгжиж байгаа орнуудад бирж эхэлж байгуулагдахдаа төрийн өмчийн оролцоо зайлиггүй шаардлагатай байдаг. Яагаад гэхээр бирж гэдэг маань өөрөө итгэлцүүр дээр явдаг олон талын оролцоог хангадаг учраас. Тэгэхээр ер нь тэгээд яваандаа эд нар их дийлэнх нь хувьцаат компанийн хэлбэр рүү ордог байгаа юм. Тэгэхээр төрийн өмчийн оролцоотойгоор эхлээд ер нь хөгжчихсөн орнуудад бол дийлэнх нь хувьцаат компанийн олон нийтэд нээлттэй компанийн хэлбэртэй байдаг. Жишээлбэл яг хөгжиж байгаа орнууд жишээлбэл Польшийн, Туркийн жишээнүүд байгаа. Жишээлбэл Туркт алтны салбараа либералчилж илүү чөлөөтэй болгохын тулд яг таваарын биржийг 1993 онд байгуулж, энэ нь цаашаа томорсоор таваарын бирж болж хөгжсөн байдаг. Энэхүү биржийг бол яг төрийн өмчийн оролцоотойгоор яваад, одоо яг эзэмшигч нь өөрөө Туркийн баялгийн сан байх жишээтэй. Польш ч гэсэн тухайн үедээ бол илүү эрчим хүчний салбараа либералчлахын тулд таваарын биржийг гаргаж ирж, бүр цаашидаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хүртэл тэлсэн ийм жишигүүд олон байдаг. Баярлалаа.

С.Одонтуяа: С.Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Би нэг их хувь хүнтэй холбоотой юм ярих дургүй. Сайд гээд эмзэглүүлчих шиг боллоо. Зайлуул. Үхсэнийх нь тийм хардах уу. Хамгийн гол нь улс төрчид, сайд, Засгийн газрын институцийнхээ хувьд хулгайч болчихоод

байгаа гэдэг санааг хэлээд, би сонсохыг хүссэн хариулт бол тэр хараат бус Оюутолгой, Таван толгой удирдах зөвлөл дээр дандаа л улс төрчид очиж байгаа. Энэ дээр стейк холдерууд гэж яриад байгаа шүү дээ. Салбарын оролцогч тэр ухдаг, экспортолдог, боловсруулдаг янз бүрийн тэр салбарын оролцогч, бүлэглэл, сонирхлын бүлгүүдийн төлөөллүүдийг энэ дээр яг институцийнх нь хувьд хүчтэй оруулж ирэх механизм байгаа эсвэл байхгүй, оруулах гэсэн чинь улс төрчид зовоогоод байна гэдэг. Ийм хариулт хэлбэл наадах чинь их сонсголонтой мэргэжлийн болж хувирна.

С.Одонтуяа: Эдийн засгийн байнгын хорооны дарга нэмж хариулъя. Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар гишүүн ээ, энэ чинь бирж нь бол нөгөө бүтээгдэхүүн уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжааг нь хийнэ шүү дээ. Тэгэхдээ бирж дээр тэр бирж нь тусдаа арилжаагаа хийх одоо Хөрөнгийн бирж ажиллаж байгаа. Хөрөнгийн бирж цаашдаа 34 хувь нь ингээд хувийн хөрөнгө оруулагчид ороод ирэх юм бол бирж дээр байгаа хөрөнгө оруулагчид хувьцаа эзэмшигчид нь тэр бирж дээрээ энэ биржийнхээ үйл ажиллагаа нь энэнтэй холбоотой шийдвэрүүд дээр нь гаргаад явна гэсэн үг шүү дээ. Борлуулагдах бүтээгдэхүүн нь уул уурхайн бүтээгдэхүүнүүд нэмж орж ирж байгаа. Энэ бол үнэт цаасны арилжаа явагдаж байгаа ийм л бирж шүү дээ Хөрөнгийн бирж. Тэгэхээр ийм юу байгаа шүү. Жишээлбэл энэ бид нарын яриад байгаа энэ хуулиар чинь тэр уул уурхайн олборлолт, тэр тэсэл дэлбэлдэг юм.../минут дуусав/

С.Одонтуяа: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Ганбаатар гишүүний яриад байгаа тэр хяналтыг маш зөв зохион байгуулалттай, дахиад хулгайн замаар орохгүй байх дээр нь

одоогоос хуулиараа сайн чагталж өгье гээд байгаатай санал нэг. Энэ үнэхээр чухал байхгүй юу. Үеийн үед л яг л яригддаг. Одоо жишээлбэл сая Эрдэнэс таван толгой руу экспортын 50 гаруй хувь нь нүүрсний шүү дээ эзэлж байгаа. Гэтэл иргэд маань 1072 хувьцаагаа ч цаг хугацаандаа авч чадахгүй байхад нэг хэсэг хүмүүс тэрбум тэрбумаар нь зүгээр л сууж байгаад л хулгайгаар аваад л хагартлаа байж байна шүү дээ. Тэгээд л хуулийн хамгаалалтад хүртэл орчхоод, энэ нь өөрөө иргэдийн бухимдлыг төрүүлж, өнөөдөр хуульдаа хүртэл чангатгах хууль оруулах зайлиггүй шаардлагатай гээд бид ингээд хэлэлцээд сууж байна л даа. Би бол уул уурхайн биржийн хуулийг үнэхээр дэмжиж байгаа. Гэхдээ саяын яг Ганбаатар гишүүний хэлдэг шиг одоогоосоо тэр Төлөөлөн удирдах зөвлөл үү эсвэл тэр хяналтын механизмыг бүрдүүлэх дахиад энэ нь өөр бүлэглэл ингээд л хулгайн зам руу оруулчихгүй байх юман дээр бид онцгой анхаарч, хуульд оруулах ёстой шүү дээ. Бид нар төмөр замыг нүүрсээр санхүүжүүлсэн гэрээг нууцалсны нэг гол шалтгааныг л хараад үзэхэд нэг километр зам л гэхэд 4.6 сая доллар. Энэ нь өөрөө дэлхийн зах зээлийн үнээс 2 дахин. Манай бүтээгдэхүүнийг авч байгаа БНХАУ-ын зах зээлээс л 3 дахин илүү үнээр гэрээлээд л нууц гэрээ гээд л өөрсөд дөө ашиг унагаагаад сууж байгааг өнөөдөр гадна, дотнын эдийн засагчид бүгд л ингээд л яриад л, олон улсын телевизүүдээр гайхшираад л ингээд л гарчихна шүү дээ.

Тийм учраас л бид нар энэ дээр үнэхээр анхааралтай хандах ёстой гэж бодож байгаа. Засгийн газрын хуралдаанаас экспортод гарах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам баталчихсан юм байна лээ. Тэгэхээр нөгөө нэг хууль гартал 7 сарын 1 хүртэл 2 сарын 1-ээс 7 сарын 1 хүртэл нүүрсийг 30 хувьд нь л гаргах тухай асуудал яригдаж байгаа юм байна шүү дээ. Тийм ээ. Хяналтыг нь Санхүүгийн зохицуулах хороо тавина гээд тэгж байна. Тэгэхээр

энэ дээр би Алтай даргаас л асууя гэж бодож байна. Манай Хөрөнгийн бирж маань яг түрүүн хэлээд байгаа Франкфуртын түүхий эдийн бирж байна. Лондоны металлын бирж гээд л бид бас үүний дэд бүтэц, тэр хүний нөөц, зохион байгуулалтын үнэ ханишийг нь судлаад л олон удаа явж байсан. Бид нар одоо яг 2 сарын 1-ээс 30 хувьдаа нүүрсээ дэлхийн зах зээл дээр гарах 2 дахь зах зээл рүү гаргая гээд л үзье. Гэрээгээ ингээд хийчихнэ сонирхож байгаа хүмүүс их байгаа гэж байна. Гэрээлчихсэн байлаа. Гэтэл нүүрсний үнэ ханишийн хэлбэлзэл эсвэл огцом өсдөг ч юм уу эсвэл бүр буурах юм уу, энэ хэлбэлзлийг гэрээлж байхдаа яаж, ямар, аль биржийн үнээр гэдэг юм уу, яаж тогтоох энэ тэр дээр одоогоос яг судалгаа тооцоо хийж байгаа, энэ дээр төлөвлөж байгаа зүйл байгаа юу. Энэ өөрөө их чухал шүү дээ. Бид нар нөгөө гадаад улс оронтой Чалкотой ийм гэрээ хийчихсэн байсан. Гэтэл зэсийн үнэ ингээд унаснаас болоод бид алдагдал орчихсон тухайн үеийнхээ ханшаар хийнэ гээд хатуу тогтчихсон учраас яах аргагүй энүүгээрээ хийж байна гээд бид нар өмнө нь ийм асуудлууд жишээлбэл зэс дээр гарч байсан шүү дээ. Тэгэхээр одоо бид нүүрс дээр ийм үнийн ханишийн зөрүүний алдагдлаас манай улс юм уу эсвэл тухайн хөрөнгө оруулагч их хэмжээний алдагдал хүлээхгүй байх энэ аргачлалыг жишээ нь яаж бодож тооцоолж байгаа бол. Энэ дээр хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Хэн хариулах уу. 86. Хангайн Алтай Монголын Хөрөнгийн бирж.

Х.Алтай: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Бирж дээрх үнэ яаж тогтох вэ гэхээр дэлхийн зах зээлийн үнэтэй уялдсан, манай аж ахуйн нэгж байгууллагуудын зардал нь нэмэгдсэн, тээврийн ч гэдэг юм уу, тээвэр, хүргэлтийн зардал нэмэгдсэн энэ үнээ ил тод хөрөнгийн бирж дээр тавиад эндээс худалдан авагчид нь өөрсдөө хэн нь

хамгийн өндөр үнэ өгсөн тэр нь худалдаж авах тийм механизмаар л явах юм.

Г.Занданшатар: 83.

Б.Дөлгөөн: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хороо. Ажлын хэсгийн гишүүн Дөлгөөн байна. Тус хуулийн төсөлд биржийн арилжааны үнийг хил залгаа улсын хилийн боомтын үнээр буюу тухайн яг хил дээрх хүн дээр аваачсан нөхцөлд хэрхэн худалдах вэ гэдэг үнийг тогтоох ёстой. Ингэхдээ биржийн арилжааны үнийг олон улсын зах зээлийн үнэд нийцсэн тэгш шударга зах зээлийн эрэлт, нийлүүлэлт зарчимд үндэслэнэ гэсэн ийм зарчмыг баримталж тавьж байгаа. Энэ дотор мэдээж тухайн уурхайн амнаас аваад тээвэрлэлт болон агуулах бусад шаардлагатай зардлуудыг шингээж тухайн яг хил дээр хүрэх бодит зардлыг тооцсон үнээр тухайн үнэ бол мэдээж түүнээс цаашаагаас бас бусад улсын яг биржүүд дээр очих үнийг харьцуулсан байдлаар яг олон улсын жишигт нийцүүлж үнийг тогтооно гэсэн ийм зарчмыг баримтална. Тухайн үнийг бол ялангуяа фьючерс, опцион гэх зэрэг энэ ирээдүйд гарах хэлцэлтэй холбогдсон үнэ, тэр нь хоёрдогч зах зээл дээр бусад одоо худалдан авагч нарт эргэлдэж болох энэ гэрээний үнийг яг тухайн өдөр болгон яг зах зээлийн ханиид суурилж тогтооно Энэ үнийг бирж өөрөө зарлахаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Энэ нь яг олон улсын бирж дээр одоо яг ашиглагддаг арга байгаа. Түрүүн бас Оюунчимэг гишүүн асуусан. Хяналтын хувьд асууж байсан. Тус хуулийн төслөөр бол Төлөөлөн удирдах зөвлөлийг нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх гэж заасан бөгөөд үүний 4-өөс доошгүй нь хараат бус гишүүн байгаа юм. Мөн хуулийн төсөлд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагууд байгаа. Үүнд мэдээж түрүүн Ганбаатар гишүүний асуулт асуултад дурдсан. Уул уурхайн мэргэжилтэй хүн тус Төлөөлөн удирдах

зөвлөлийн төлөөлөлд орох боломжийг хуулийн төслөөр нээж өгсөн байгаа. Түүнээс гадна мэдээж Монголын Хөрөнгийн биржээр хэрвээ энэхүү арилжаа маань явагдахаар бол хөрөнгийн бирж маань нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох ийм компани байгаа. Ингэснээр компанийн засаглал, шийдвэр гаргалт нь яг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан яг энэ дэлхийн яг сонгодог хувьцаат компанийн засаглалаар бол цаашид үйл ажиллагаа явуулна.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүний 1 минут тодруулъя.

М.Оюунчимэг: Ганбаатар сайдыг ингэж шуурхай оруулж ирж байгаад талархаж байгаа. Өмнөх 4 жилд ялангуяа Сумъяабазар сайд байхдаа бас IPO гаргах гээд л нэлээд л ингээд л явж байсан. Гэхдээ Засгийн газрынхаа босгыг давж чадаагүй л дээ. Одоо Их Хурал өөрөө энийг илүү их анхаарч дэмжээд, шуурхай хэлэлцээж байна. Хамгийн гол нь бид нар сая хэлж байна. Хараат, хараат бус Төлөөлөн удирдах зөвлөл гээд л яриад байгаа. Тэр бүтцэдээ биш ээ, TVЗ нь хараат, хараат бус биш байг энэ нь хамаагүй. Хамгийн гол нь тэнд томилж очиж байгаа хүмүүс нь л улс төрийн зорилготой юм уу, яг тухайн шийдвэр гаргаж байгаа хүний нөгөө нэг цүнх барьдаг хүмүүс нь очоод завхрал үүсгээд байгааг бид нар Эрдэнэс таван толгойн бүх юман дээр л харж байна шүү дээ. Тийм учраас энэ дээр л бид нар тэр гишүүний сонгох шалгуур нь өөрөө аягүй чухал байх нь их чухал байгаа шүү гэдгийг нэгд хэлчихье.

Өчигдөр Эдийн засгийн байнгын хороо дээр төрийн өмчийн оролцоо 66 хувьтай байна гэдэг нь арай дэндүү төрийн оролцоо байна. Энд хувийн хэвшил юм уу бусад оролцоог нь хангах ёстой гэдэг байдлаар зарим гишүүд хандаад 66 хувь гэдэг бол Эдийн засгийн байнгын хороо дээр дэмжигдээгүй. Тэгэхээр энэ .../минут дуусав/

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн. Саналаа Баттөмөрийн Энхбаяр гишүүн татсан ишг санах юм. Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Ер нь бол төрийн өмчийн оролцоотой байна гэдэг нь Энхбаяр гишүүн нөгөө төрийн өмчийн оролцооны доод хэмжээ нь 66 хувь байна гэдэг санал хураалгаад дэмжигдээгүй л дээ. Тэгэхдээ бол чуулган дээр хураагдах болов уу гэж ойлгож байгаа шүү дээ. Ер нь уул уурхайн яам бас эхний ээлжид эхний 2, 3 жилдээ төрийн өмч давамгайлсан байх нь зүйтэй гэдэг ийм байр суурьтай байгаа гэдгийг Оюунчимэг гишүүнд хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Нөгөө 66 хувийг асуугаад байна. Тэрийг ч өөрчилнө шүү дээ. Татаад өөрчлөх юм. Энхбаярын Батиугар гишүүн.

Э.Батиугар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Түрүүн сайд хэлж байна. Дэлхийд бол өнөөдрийн байдлаар 204 таваарын бирж байдаг. Үүнээс хамгийн том нь Chicago Mercantile exchange. 2 дахь нь Токио Commodity exchange. Токиод болоод сонирхуулж хэлэхэд 17 дугаар зууны хамгийн анхны цагаан будааны фьючерс гэрээ хийх хэлцэл хийгдсэн. 3 дахь нь бид нарын сайн мэддэг london metal exchange байгаа. Хэд хэдэн асуулт асууя. Эхнийх нь хуулийн 12.3 дээр ямар ямар бүтээгдэхүүнүүд арилжих вэ гэдэг дээр бас спот гэрээ, фьючерсийн гэрээ, опцион гэрээ гэж байна. Энэ дээр derivatives гэрээ орох уу. Derivatives бол хамгийн түгээмэл хэрэглэгддэг ийм таваарын бирж дээр. Тэгэхээр энэ орох уу гэж асуумаар байна.

2-т нь опцион гэрээ нь ямар байдлаар үнийг нь тогтоох юм бэ? Яагаад гэвэл опцион үнийг тогтоох арга нь black scholes арга гэж аргачлал байдаг. Энэ бол нэлээн нарийн мэргэжлийн хүмүүс санхүүжилт

гаргадаг арга л даа. Тэгэхээр та бүхэнд яг хүний нөөц байгаа юу. Энэ гэх мэтчилэн *derivatives, option, futures*-ийн үнийг тогтоох *clearing* хийх байгууллага нь ямар байгууллага юм бэ гэж асуумаар байна. Жишээлбэл *london metal exchange* дээр бол *clearing* нь *London clearing house* хийдэг. Өмнө нь *international commodities clearing house* 1992 он хүртэл хийж байгаад тэгээд *London clearing house* худалдаж аваад хийж эхэлсэн. Дараачийн асуудал бол зах зээлийн *manipulation* хийхийг урьдчилан сэргийлэх ямар механизм байгаа вэ. Хэрвээ та бүхэн санаж байгаа болгоны 3 сард никелийн үнэ чинь бүр замбараагаа алдаад, тэгээд *london metal exchange* арилжаагаа хааж байсан Никель дээр. Тэгэхээр яг иймэрхүү нөхцөл байдал үүсэхийг ямар механизмаар урьдчилан сэргийлэх вэ гэж асууя. Мэдээж энд орж байгаа юм чинь маш олон гадаадын худалдан авагч болон оролцогч байна. Тэгэхээр эд нартаа зориулсан *central depository* дээр яаж холбогдох юм бэ? Нэг ёсны үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь яаж гадаадын худалдан авагчтай холбогдох вэ гэж асууя. Бас бид нар *option, futures* ярьж байгаа юм чинь *short selling* заавал үүнтэй холбогдоно. Тэгэхээр *short selling* хийх тийм бололцоо байгаа юу. Нээгдсэн байгаа юу гэж асууя.

Сүүлчийн асуудалд бол Монгол Улсын бүх төлбөр тооцоо төгрөгөөр явна гэсэн тийм хууль байдаг. Тэгэхээр энэ хуульд нэмэлт өөрчлөлт орж байгаа юу үүн дээр. Яагаад гэвэл хэлэлцээр нь хэрвээ гаднын биржүүдийг дагах юм бол дандаа доллароор байдаг. Гэхдээ Монголд төлбөр тооцоо бүгд Монгол Улс үндэсний валют болох төгрөгөөр хийгдэнэ гэсэн дүгнэлт байдаг. Баярлалаа.

Г.Занданиатар: Хэн хариулах уу.
83.

Б.Дөлгөөн: Батшугар гишүүний асуултад хариулъя. Энэхүү хуулийн

төслөөр бол яг олон улсад нийтлэг ашиглагддаг яг санхүүгийн үүсмэл хэрэгсэл буюу *Derivatives* гэрээнүүдийг бүгдийг нь оруулсан байгаа. Үүнд *option, futures, forward* гэрээнүүд мөн *spot* гэрээгээр бас тодорхой бүтээгдэхүүнүүд арилжаалахаар тусгагдсан. *Clearing house* буюу яг үнэт цаасны *clearing* үйл ажиллагааг Монгол улсад Монголын үнэт цаасны клирингийн төв гэж байгууллага байгаа. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нь бол үнэт цаас болон энэ хуулиар мөн адил хүчин төгөлдөр явагдаж байгаа *фьюечерс, опцион* нь бол үнэт цаасныхаа төрөлд хамаарна. Ингэснээр *фьюечерс, опцион* арилжаасан тохиолдолд Монголын үнэт цаасны клирингийн төвөөр дамжиж явагдахаар байгаа. Хадгаламж буюу төвлөрсөн хадгаламжийн тухайд мөн адил төвлөрсөн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв төрийн өмчит компани байгаа юм. Энэхүү компани маань бол Монгол Улсад байгаа үнэт цаасны бүх бүртгэл хадгалалтын үйлчилгээг үзүүлж байгаа. Тэгэхээр энэ байгууллага бас яг энэ *фьюечерс, опцион* гэрээ буюу яг үнэт цаасных нь яг хадгалалтыг хийгээд явна. Ингэснээрээ гаднын худалдан авагчдын яг өмчлөх эрхийг баталгаажуулалт нь чухал нөлөөтэй байгаа. Бусад *spot* гэрээний тухайд бол шууд худалдах, худалдан авах гэрээний төрөлд хамаарагдаж явах учраас үнэт цаасыг хадгалагдах буюу энэ *централ секьюрити депозиторын* үйлчилгээ явагдахгүй байгаад байгаа юм. *Short selling* хийх бололцоо мэдээж тодорхой түвшинд хийгдэх боломжтой байгаа. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүлээгдэж байгаа үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тодорхой зохицуулалтууд орж байгаа. Энэ зохицуулалтыг орж батлагдсанаар *Short selling* зохицуулалт бас бүрэн нээгдэх ийм боломжтой болж байгаа юм. Мөн адил түрүүн хэлсэн нөгөө валютаар илэрхийлэгдэх үнийг илэрхийлэхэд буюу Монгол Улсад

илэрхийлж байгаа хуулийн нэр нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль байгаа. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар бол Монгол банкны зөвшөөрлөөр Монгол Улсад бараа, ажил, үйлчилгээг төгрөгөөр илэрхийлж болохоор байгаа юм. Гадаад валютаар илэрхийлж болохоор байгаа. Тэгэхээр энэ тохиолдол мөн адил Монгол банкнаасаа уул уурхайн биржийн бүтээгдэхүүнүүдийг гадаад валютаар илэрхийлэх зөвшөөрөл олгосон тохиолдолд бол энэхүү арилжаа маань гадаад валютаар илэрхийлэгдээд валютын гүйлгээ хийх бүрэн боломжтой гэсэн байгаа юм.

Г.Занданишатар: Батиугар гишүүн тодруулъя.

Э.Батиугар: Нөгөө option pricing гээд option-ийнхаа үнийг яаж тодорхойлох гэж байна. 2-т нь нөгөө market manipulation гэж яриад байгаа зах зээлийн manipulation хийх нь урьдчилан сэргийлэх механизмын талаар товчхон тайлбарлаж өгнө үү.

Г.Занданишатар: 83.

Б.Дөлгөөн: Батиугар гишүүний асуултад тодруулъя. Manipulation буюу зах зээлийг урвуулан ашиглахтай холбогдсон харилцааг мөн адилаа журмын төсөлд зааж өгсөн байгаа. Тодорхой хэлцлүүдийг бол шинж чанарыг нь заагаад үүнийг хэрэглэхийг хориглох заалтууд орчихсон байгаа. Мөн адил энэхүү бас зах зээлийг урвуулан ашиглах буюу Монголын Хөрөнгийн бирж болон бусад яг уул уурхайн бүтээгдэхүүний бирж тусдаа бий болсон бол аль ч тохиолдолд системээр дамжиж явагдана. Тэгэхээр тухайн систем нь өөрөө surveillance буюу яг дотоод мэдээлэл эзэмшиж арилжаанд оролцохоос гадна зах зээлийг урвуулан ашиглаж байгаа тохиолдолд бол автоматаар тэр surveillance систем нь ажиллаж дохио өгдөг. Тэгэхээр яг энэ чиглэлээр нь оруулахаар байгаа. Мөн адил

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль дээр зах зээлийг урвуулан ашиглахтай холбогдсон харилцааг мөн адил энэ хуулийн зохицуулалтын орчинд бол нээгдэж болж байгаа юм. Option pricing хувьд мэдээж тухайн зах зээл дээр тогтох ёстой байгаа. Нэн тэргүүнд эхний.../минут дуусах/

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчих. 83.

Б.Дөлгөөн: Опцион үнэ тогтолтын хувьд мэдээж зах зээлийн тухайн үеийнхаа нөхцөл байдлаас хамгийн түрүүнд шалтгаална. Түүнээс гадна энэхүү хуулийн төслийг бичиж боловсруулж байх үед бол Монгол Улсад нэн тэргүүнд болон спот, форвард буюу худалдах, худалдан авах гэрээ, богино хугацааны ирээдүйд нийлүүлэх гэрээнүүдээ түлхүү арилжаалагдана гэсэн яг хуулийн төслийн концепт явагдсан байгаа. Энэ тохиолдолд мэдээж үнэ тогтолтыг яг түрүүн дурдсан яг биржийн үнэ тогтолтын арга. Олон улсын жишигт нийцүүлж нээлттэй шударга энэ үнийн арга хэрэгслээр тогтооно. Option pricing дээр хэсэг хугацаа өнгөрсний дараа бол энэхүү арилжаа маань гарна. Option pricing-ийн өөрийнх нь үнэ тогтох арга бол мэдээж үнэ ханшийн тогтолтын холбогдсон шаардлагатай журмуудыг яг уул уурхайн бирж нь өөрөө бас баталж явж байгаа. Тэгэхээр зах зээлийнхээ зарчимд нийцэж байгаа. Мөн үнийн яг бодит үнэ нь мэдээж зах зээлийн хани тогтолт дээр өөрөө бий болоод явах юм.

Г.Занданишатар: Батиугар гишүүн та 2 тэр яг санхүүгийн мэргэжлүүдийн талаар нь сайн дараа нь тодруулаарай. Одоо Төмөртгоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа хөрөнгийн биржээр дамжуулаад Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний үнийг тогтоож худалдаалахыг дэмжиж байгаа. Гэхдээ та хэд нэг юман дээр их

сайн ойлгоорой. Хилийн үнэ гэдэг бол бодит үнэ биш шүү. Тийм учраас биржийн анхны үнийг төмөр ч гэдэг юм уу, нүүрс ч гэдэг юм уу анхны үнийг аль биржийн үнээр тогтоож явах юм бэ гэдэг чинь хамгийн чухал шүү. Тэгээд энэ дээр нэг хариулт авъя.

2 дахь асуудал. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах болон баяжуулах үйлдвэрүүд баригдсангүй, хийгдсэнгүй. Энэ бол АМНАТ-аас болсон асуудал. Тэгэхээр би энэ биржээр бол жоншны баяжмал, төмрийн хүдрийн баяжмал, төмрийн хорголжин төмөр ч гэдэг юм уу энэ биржээр зарагдах юм байна гэж ойлгож байгаа. Энэ биржээр зарагдсан хагас боловсруулах бүтээгдэхүүнүүд, энэ биржийн үнэ дээр нь дагалдуулаад АМНАТ-ыг тооцох юм байна гэж би бодож байгаа. Ингэвэл бодит болно. Ингэвэл Монгол цаашидаа олон тийм эцсийн шатны боловсруулах үйлдвэрүүд баригдах юм байна гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ дээр нэг хариулт хэлээдхээч гэдгийг хэлмээр байна.

3 дахь асуудал. Хөрөнгийн биржийн хэдэн хувийг олон нийтийн болгох юм бэ. Сая тэр 34 хувь гээд яриад байх шиг байна лээ. Хэрвээ олон нийтийн болгож байгаа бол 66 хувийг нь олон нийтийн болгох хэрэгтэй. Дараа нь танай Хөрөнгийн бирж дээр бас л юу гэдэг юм маргаан гарлаа гэх юм бол БЭГ тавих ийм асуудал гарна шүү. Тийм учраас аль болохоор хувьцаат болгох, олон нийтийн болгох асуудлыг нь Хөрөнгийн бирж дээр тавьж өгөх хэрэгтэй. Төр олон юу гэдэг юм хувийг нь эзэмшихээрээ л хулгай явдаг шүү дээ. Тийм учраас энэ дээр нэг хариулт хэлэх хэрэгтэй байна.

4 дэх асуудал бол яах аргагүй биржээр явж байгаа бүтээгдэхүүнээс хөрөнгийн бирж хэдэн төгрөгийн 1 тонн тутамд ч гэдэг юм уу 100 тонн тутамд ч гэдэг юм уу хэдэн төгрөгийн хураамж авах юм. Энийг нэг хэлж өгөө. Энэ 4

асуудал дээр. Тэгээд цаашаа үргэлжлүүлээд асууя.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Би сүүлийн 2-т нь хариулъя. Эхний 2-ыг нь манай дэд ажлын хэсгийнхэн бэлдэж байгаарай. Тэр хураамжийн хувьд бол хуульд тодорхой заалт байхгүй байгаа. Тэгээд яах вэ бид журам дээрээ би бүр ер нь олон улсын тэр биржүүдийн шимтгэлийг харж байгаад хамгийн багаар нь буюу 0.1 гэдэг энэ хэмжээг тавьж өгсөн. Ер нь бүр 0.01 гэдэг байдлаар явуулъя гэсэн ийм саналуудыг гаргаад явсан. Гэхдээ бас энэ чинь хөрөнгийн бирж чинь программ хангамж платформоо update хийж шинэчилж байх шаардлагатай. Зүгээр 1 сая тонн гээд бодоход бол энэ чинь 1000 доллар болж байна уу даа. Биш ээ, 100 мянган доллар болж байна уу? Нэг ийм л юм байгаа юм. Тэгэхлээр ер нь миний бодол Засгийн газарт энэ Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороотойгоо яриад ер нь 0.1-ээс хэтрүүлэхгүй гэдэг ийм чигтэй байна гэдгийг танд хариулъя.

Хөрөнгийн биржийн дээр хэдэн хувийг төр эзэмших вэ гэдэг дээр бол Засгийн газар шийднэ. Засгийн газар хэдэн хувиа хувийн хэвшилээр хийлгүүлэх боломжтой юм гэдгийг Засгийн газар шийднэ. Зүгээр яах вэ. Би зүгээр түрүүн хариулахдаа юу гэж хариулсан бэ гэхлээр Энхбаяр гишүүн өчигдөр санал гаргаад Энхтүвшин гишүүн ээ, Энхбаяр гишүүн санал гаргаад 66 хувиас доошгүй нь төрдөө байя гэсэн ийм санал гаргасан юм. Би бол тэр саналыг дэмжсэн юм. Ийм л хариулт байна. Уул уурхайн яам яг юу гэж бодож байна гэвэл эхний 1, 2 жилийн дотор бол төр давамгайлсан байдалтай явах нь зөв гэсэн ийм бодолтой байна. Зүгээр яах вэ танд хэлэхэд бол хэрвээ хувийн хэвшлийн оролцоонууд их яваад ирэх юм бол тэр 0.1 гэдэг юм уу тэр 0.01 гэдэг хувиуд

дээшээ, доошоо хөдлөөд бас энэ тал руугаа хэт дэвийлгээд хоорондоо маргалдаад тэгээд ингээд байх тийм өнцгүүд харагдаж байгаа юм. Тийм учраас бас нэг юу гэдэг юм бэ дээ бас төрийн оролцоотой байгаад, зөв тал руу нь зүгшрүүлээд тэгээд бас тодорхой хувиудаа хувийн хэвшилд шилжүүлээд ийм алхам алхмаар явах нь зөв байна гэсэн Уул уурхайн яам ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: 85.
Батнайрамдал дэд сайд хариулъя.

О.Батнайрамдал: Энхтүвшин гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр хуулийн 10.1.5-д олон улсын зах зээлийн үнэд нийцсэн нээлттэй, ил тод, арилжааны зарчимд тулгуурлан тогтсон бүтээгдэхүүний үнэ зарлаад явна гэж байгаа юм. Тэгэхээр энэ хууль маань 6 сарын 30-аас хэрэгжинэ гэж тооцоолж байгаа. Тэгэхээр тэр хүртэл Засгийн газраас сая баталсан түр журмаараа бид нар нүүрсээ Гашуун сухайт боомтоор жишигээр арилжаалаад эхлэхэд тэндээс хил нөхцөлөөр зах зээлийн үнэ нь бид бүхэнтэй тогтоож байна гэж ойлгож байгаа. 6 сарын худалдаанаас ер нь Монгол Улсын нүүрсний ялангуяа Гашуун сухайт боомтоор гарах үнэ нь яг тогтоно гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт баяжуулах үйлдвэр мөн АМНАТ-тай холбоотой. Тэгэхээр ер нь Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний хил үнэ нь өнөөдөр тогтоогүй учраас гадаадын Австралийн ч юм уу заримдаа Мексикийн ч юм уу үнэ ингэж зайлшгүй авч эндээс бодогдохоос өөр гарцгүй болдог. Тэгэхээр энэ бирж байгуулагдсаны нэг маш том давуу тал бол манай Монгол Улсаас гарч байгаа уул уурхайн бүтээгдэхүүнүүд Монгол Улсын хил нөхцөлөөр олон улсын яг зарчимтай ялгаагүй. Тэгээд хил нөхцөлөөр зарагддаг болсноороо тэрнээс татвар хураамж тооцох ч юм уу тэр үнийн өөрөө жишиг нь тогтоно. Тэгэхээр энэ нь ингээд энэ

асуудлыг бас цогцоор нь шийдэх шийдэл нь өөрөө уул уурхайн бүтээгдэхүүн бирж гэж тооцож байгаа. Тэгэхээр АМНАТ цаашидаа тэгэхээр одоо яг хил үнэ байхгүй учраас жонши дээр, төмөр дээр жишигээр Австралийн, Хятадын жишиг үнүүдийг бид нар аваад байгаа юм. Тэгэхээр энэ Монгол Улсын хил нөхцөлөөр тухайн бүтээгдэхүүнүүд зарагдаад эхлэхээр яг хил нөхцөлөөр зарагдах үнэ, жишиг үнэ өөрөө тогтоно гэсэн үг. Тэгэхээр яг энэ үнэ өнөөдөр байхгүй болохоор яг гадаадын зах зээл дээр Австралидаа ч юм уу, Хятад дээр зарагдаж байгаа, Мексик дээр зарагдаж байгаа үнийг бид нар тухайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигийн төлбөр, хураамж тооцоход бол хэрэглээд байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ асуудлыг уул уурхайн бүтээгдэхүүний бирж маань өөрөө цогцоор нь шийдэх боломжтой.

Г.Занданшатар: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Т.Энхтүвшин: Би нэг ийм юм асуугаад байгаа юм л даа. Энэ хорголжин төмөр хийж байгаа жоншины баяжмал хийж байгаа, төмрийн баяжмал хийж байгаа хүмүүс наад биржээр чинь бүтээгдэхүүнээ зарна. Наад биржийн үнээр чинь АМНАТ төлөх юм уу, төлөхгүй юм уу гэдгийг л нэг хэлээд өгөөч. Одоо наад хүмүүс чинь дандаа гадаадын юу гэдэг юм зах зээлийн үнээр АМНАТ төлөөд маш хохиролтой. Үүнээс болоод Монголд баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүд хөгжихгүй байна. Тийм учраас АМНАТ-ыг энэ биржийн үнээр төлнө гэдгийг л хэлээд өгөөч. Олон хүн үзэж байгаа байх. Энэ биржийн тухай хуулийн ганц ач холбогдол татвараа үнэн зөв тооцох, АМНАТ-аа үнэн зөв төлөх л асуудал байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр л нэг хариулт хэлээдэх л дээ.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Ер нь Ашигт малтмалын тухай хуульд АМНАТ-ын асуудал тийм орон зай ихтэй Сангийн яам тайлбарлаад явчих бололцоонуудыг их үг, өгүүлбэрийн тийм орон зай гарсан юм байна лээ. Хуулийн хийдэл ч гэдэг юм уу. Тэгэхдээ бид бол Ашигт малтмалын хуулийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаагаад өргөн барина. Маш нарийн яг АМНАТ-ын асуудлыг маш нарийн өргөн барина гэж бодож байгаа юм. Ер нь бол зүгээр танд хэлэхэд бирж гаргаад биржээр зарсан үнээрээ л АМНАТ авах ёстой. Уул уурхайн яам ийм байр суурьтай байна. Гэхдээ энэ АМНАТ-ын асуудал яг яаж авдаг аргачлалыг Сангийн яам Засгийн газраар батлуулдаг. Энийг та өөрөө ойлгож байгаа байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Үг дараа нь санал дээрээ л хэлнэ. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Бирж байгуулах гэж байгаа нь зөв. Бирж байгуулах гэж оролдож байгаа нь зөв гэж бодож байна. Тэгээд хэд хэдэн юм тодруулмаар байх юм. Өмнө нь Хөрөнгийн бирж дээр л түшиглэж байгуулж байгаа юм байна л даа. Байгаа материаллаг бааз дээрээ тэгж ойлголоо. Өмнө нь Хөдөө аж ахуйн бирж гээд байгуулах гэж оролдож байсан уу. Ямар байсан билээ. Тэрийг та нар судалсан уу. Тэр хөдөө аж ахуйн бирж нь одоо ажилладаг юм уу. Ажилладаггүй бол яагаад ажилладаггүй юм бол. Энэ биржийн хуулийг оруулж ирж байгаа болохоор та нар мэдэж байгаа байх.

2-т нь худалдан авагч тодорхой шүү дээ. Манай урд хөрш л байгаа шүү дээ. Урд хөршийн хэдий хэмжээний, хэдэн компани оролцоно гэж бодож байгаа юм. Бараг л ганц хоёрхон л компани оролцох байх даа. Одоо авч байгаа хүмүүс нь ингээд эргэж аваад л тэр Бугатын төмрийн үйлдвэр дээр л коксжих нүүрс чинь очно. Тэгээд нүүрс энэ тэр гээд л үзэхэд хэдэн төрлийн

нүүрс байна. Хамгийн гол нь эхлээд нүүрс дээрээ төвлөрч байгаа байх гэж бодож байна. Тэгээд жишээлбэл “Эрдэнэс таван толгой”-н нүүрснийхээ 100 хувийг зарах юм уу, хэдэн хувийг зарах юм. Биржээрээ дамжуулаад яг тийм тоо байна уу. Тэгнэ ингэнэ гэсэн. Нөгөө хувийн компаниуд байгаа бас энэ уул уурхай, ашигт малтмалыг олборлодог бас л урд хөрш рүүгээ л зарна. Тэр худалдан авагч нар нь байдаг ингээд тодорчихсон ийм л зүйл байна. Тэгээд тэрнийхээ хувийн компаниуд заавал зар гэх үү. Заавал тэр /ДАФ/ Гашуун сухайт ч гэдэг юм уу тэр нөхцөл байдлаа шаардах уу. Амнаасаа зарахгүй гээд л ингэх үү. Яах вэ өнөөдөр нүүрсний хэрэгцээ өндөр байгаа ийм л үе л дээ. Ингээд ахиад унаж болно. Зах зээл юм чинь бүр 20, 28 доллар ч хүрч болно. Тэгээд мөнгө төгрөгөө байршуулна энэ тэр гээд л зөндөө асуудал байгаа байх. Бас л одоо шинэ луйврууд гарч эхэлнэ. Яг энэ бирж байгуулснаар бүх юм шийдэгдэнэ гэж байхгүй л дээ. Тэгээд энийгээ дагаад үнэт цаас, Эрүү, Зөрчлийн хуульд өөрчлөлт орох уу. Оруулахгүй ингээд явчхаж болох юм уу. Оруулж байгаа бол ямар ямар заалтуудыг оруулж байгаа юм. Тэгээд цаашидаа ямар ямар луйврууд гарч болохоор байна. Хэрвээ биржээр зарах гэж байгаад наад биржээр зарна гэдэг чинь наад гарч байгаа бараа таваарынхаа баталгааг бүрэн хангана л гэсэн үг шүү дээ. Хариуцна л гэсэн үг. Тэрийгээ батлан даах уу. Хүний мөнгийг оруулж ирээд өгнө, авна гээд гэрээ хэлцэл хийчхээд, дараа нь баахан луйвар болоод төр бб хувийг нь эзэмшинэ барина гээд л яах юм. Үгүй тэгээд төр чинь тэрийгээ яг хариуцах юм уу. Тэр биржээр арилжаа хийсэн бүх гэрээ хэлцэл, бараа таваараа нөгөө мөнгөө төлсөн хүн чинь шаардана шүү дээ. Мөнгөө урьдчилж төлөх юм уу, дараа нь төлөх юм уу эсвэл мөнгөө яаж байршуулах юм гэх мэтчилэн ийм зүйлүүд байна л даа. Түрүүн тэр юань, доллар гээд л асуучих шиг болно лээ. Тэгээд энэтэйгээ уялдуулаад бас ярина байх гэсэн ийм бодол байна. Бас ахиад

нөгөө хөдөө аж ахуйн биржийг би дампуурчихсан гэж ойлгосон. Энэ уул уурхайн би чинь бас л дампуурчих юм биш биз. Яг хэдэн брокерын төв байна манайд. Тэр брокерын төвөөрөө дамжиж оролцох уу, яаж оролцох юм гэсэн ийм зүйлүүд байх юм.

Г.Занданшатар: Ганбаатар сайд хариулъя. Жамбалын Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ганбат гишүүн их чухал зүйл асууж байна л даа. Ер нь яг таны санаа зовж байгаа өнөөдөр 5, 6 худалдан авагч яаж гэрээ хийдэг нь мэдэгдэхгүй, хаанаас эх үүсвэрээ авдаг юм ямар яаж гэрээгээ хийдэг энэ зүйлийг засах гэж бирж байгаа юм. Та энийг сайн ойлгож байгаа. Тийм учраас Хятадад нүүрсийг худалдаж авъя гэсэн ийм хэрэгцээ ийм хүсэлтэй компаниуд маш их байгаа. Тийм учраас түр журмаар хууль байгуулагдахаас өмнө гарч байгаа түр журмаар бол хамгийн дээд тал нь 180000 тонн нүүрс л зарна гэж байгаа юм. Нэг багц нь нэг худалдан авагчид тэр 2, 3 саяар нь юм уу 500 мянга мянгаар нь зардаг байсныг журмаар зохицуулж байгаа. Тэгэхээр олон хүмүүс ирнэ гэсэн үг. Эхний ээлжид бол түр журмаар “Эрдэнэс таван толгой” компанийн нүүрсний 30 хувийг зарна гэж байгаа юм. Тоо байна уу гэж асуусан. Танд 30 хувийг нь зарна. Тэгээд аажим аажмаар ахиад хууль хэрэгжих үеэс эхлээд ер нь “Эрдэнэс таван толгой” компанийн төрийн гэсэн үг шүү дээ төрийн өмчит нүүрсний 100 хувь нь биржээр зарагдах байх ёстой гэсэн ийм зорилттой байна. Хувийн хэвшил сайн дураараа оролцоод явах бүрэн боломжтой. Түр журмаараа бол Энержи Ресурс компани оролцоод явж байгаа юм. Сар бүр 200000 тонн нүүрс биржээр зарна гэсэн хүсэлтээ бид нарт өгчихсөн байгаа. Тэгэхээр хувийн хэвшил эхний ээлжид сайн дураараа явж байгаа гэдгийг танд хэлье.

Ер нь тэгээд бирж байгуулагдсанаараа бид бүх зүйлийг бас бүр мундаг болчихно гэж хэлэхгүй байна. Гэхдээ бид ахиц гарна гэдэгт 100 хувийн итгэлтэй байна. 100 хувийн итгэлтэй байна. Ямар ч байсан ахиц гаргана. Ямар ч байсан энэ 2, 3, 4, 5-хан хүн гэрээ хийдэг, компани өөрчлөөд цаад эздүүт нь хэвээрээ байгаад л байдаг энэ зүйлүүдийг засна. Мэдээж гол худалдан авагч нар мэдээж цаана очоод тэр гангийн үйлдвэрүүдэд л очно л доо. Тэр бол манай экспортын гол юу бол коксожсон нүүрс байгаа. Тийм учраас цаана очоод тэнд очих нь ойлгомжтой гэдэг. Бусад асуултаудад манайд дэд ажлын хэсгийнхэн хариулаад явах байх. Баярлалаа.

Г.Занданшатар: 83 Дөлгөөн.

Б.Дөлгөөн: Ганбат гишүүний асуултад ажлын хэсгийн гишүүн Дөлгөөн тодруулъя. Хөдөө аж ахуйн бирж бол одоо үйл ажиллагаа явуулж байгаа. 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Нийт хийгдсэн арилжааны мэдээллийг хэлэх юм бол сүүлийн 3 жилийн тухайд 2019 онд 706 тэрбум, 2020 онд 488, 2021 онд 794.5 тэрбум, энэ онд 1 их наядын арилжаа хийгдсэн байгаа. Энэ зах зээл дээр яг одоогийн байдлаар нийтдээ 8 хөдөө аж ахуйн бирж, брокерын тусгай зөвшөөрөлтэй этгээд үйл ажиллагаа явуулж байгаа. Компанийн хувьд төрийн өмчтэй компани. Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг одоогийн байдлаар Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тогтсон байдаг. Хууль батлагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдсанаар бол энд байгаа 1 онцлог зохицуулалт нь бол төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд яг уул уурхайн бүтээгдэхүүний бүтээгдэхүүний биржээр өөрийн бүтээгдэхүүнээ заавал арилжаалахаар

тусгагдсан. Тэр төлбөр тооцооны тухайд мэдээж спот арилжааны хувьд дэнчин тавьж арилжаанд оролцоно. Тэгээд тухайн арилжааны хэлцэл биелсэн тохиолдолд тухайн бирж маань ялангуяа дуудлага худалдааны аргаар явж байгаа тохиолдолд шалгарсан тохиолдолд үлдэгдэл төлбөрийг худалдагч талд шилжүүлснээр энэхүү арилжаа маань хувьд амжилттай биелэхээр байгаа.../минут дуусав/

Г.Занданишатар: 83. Гүйцээгээд хариулчих.

Б.Дөлгөөн: Тус хуулийг дагасан Зөрчлийн тухай хуулиуд бол энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн зохицуулалт орж байгаа. Яг үнэт цаасны зах зээлийн тухай хуульд холбогдох өөрчлөлт нэмэлт орохгүй. Тусдаа юугаар зохицуулалтын этгээдээр явж байгаа юм. Тэгээд эрүүгийн хуульд мөн адил өөрчлөлт ороогүй.

Г.Занданишатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Яах вэ хөдөө аж ахуйн бирж чинь ажиллаж байгаа юм у. Ажиллаж байгаа бол тэгээд тэр хөдөө аж ахуйн түүхий эд ч уг нь талын нэг гуу жалгаар л дүүрэн хэвтэж байна л даа. Тэр арьс ширээ юу энэ тэр гээд. Хэдэн нүүрс маань тийм битгий болчхоосой л гэж бодож байна. Тэгээд судалгаа шинжилгээ сайн хийсэн юм байгаа биз дээ. Тэгээд ямар ч байсан ажиллуулаад л үз. Тэгээд үүнээс гадна дээрээ нөгөө ашигт малтмалынхаа лицензүүдийг зарж барьдаг болдог тийм юм руу явах уу яах вэ. Биржээр үнэ тогтоогоод. Энэ чинь уг нь нөгөө худалдан авагч, худалдагч 2-ыг л уулзуулдаг л газар шүү дээ. Энгийнээр ойлговол. Тэрийг л аль болохоор л ил тод л хийх ийм байна. Тэгээд мэдээллүүдээ яаж өгч байх юм. Энэ дээр зарагдаж байгаа тэр гэрээ хэлцэл, нүүрс, АМНАТ тэрээ.../минут дуусав/

Г.Занданишатар: Ганбаатар сайд хариулна.

Ж.Ганбаатар: Бирж бол үнийг зарлана. Бирж ямар үнээр явах вэ гэдгийг зарлана гэсэн. Хил үнийг бирж зарлана гэсэн. 15.1, 15.2 дээр биржийн арилжааны үнийг хил залгаа улсын боомтын үнээр бирж зарлана гэсэн ийм юутай байна. Хөдөө аж ахуйн биржийн хувьд амжилттай биш байгаа. Та хэлж байгаа. Ер нь бол оролцогч талуудын сонирхол их, бага байгаа. Тэрнээс гол нь шалтгаалж байгаа. Тэгэхлээр Хөдөө аж ахуйн бирж шиг болгохгүйн төлөө бид яах вэ, уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн худалдан авах сонирхол мэдээж экспортод гаргана, урд хөрш худалдаж авна. Тийм учраас уул уурхай бирж шиг болохгүй байхын төлөө бид ажиллана. Гэхдээ Уул уурхайн яам зөвхөн бодлого гаргадаг, хяналт тавьдаг байгууллага бол Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавиад явна.

Г.Занданишатар: Нэг гишүүний асуултын дараа зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж асуулт хариултын цаг дуусах тул гишүүд чуулганы танхимд цуглая. 40 санал хураалт байгаа. 40 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгээд би уул уурхайн биржийн тухай хуулийн ажлын хэсэгт байгаа. Тэгээд ажлын хэсэг Лондонд ажилласан. Лондонд ажиллахдаа Лондоны металлын бирж мөн түүнчлэн Английн компаниуд, Европын компаниудтай уулзалт хийсэн. Тэгээд уулзалтаар тодорхой дэмжиж байгаагаа илэрхийлж уулзалтын хүрээнд Борис Жонсон Ерөнхий сайдын Монголыг хариуцсан төлөөлөгч гэдэг юм уу даа. Тэр хүн биднийг хүлээж аваад ер нь Монголын ардчиллыг дэмжихэд зориулж ажил хийх боломжтой гэсэн. Үүний дагуу 5 тэрбум долларыг Монголд зориулж зээл өгөөч гэдэг хүсэлтийг

тавихад манай тэр хамт явсан хүмүүс гайхаж байсан л даа. Үгүй ямар том тоо вэ гээд. Тэгээд тун удалгүй 1 сарын дараа Кавческий ирээд Монголд 3 тэрбум долларын зээлийн шугам нээхэд бэлэн байна гэж. Тийм учраас ер нь гадаад явж байгаа хүмүүс Занданишатар дарга үр дүн юу юм бэ гэдгийг хэлж бай гэж хэлж байсан. Тэгэхээр би бас энэ ажлын хүрээнд ийм үр дүн гаргаж ирсэн шүү гэдгийг хэлье. Яг хамт явж байсан хүмүүс байж байна. Тэгэхээр ер нь Монгол бол Пандемикийн дараа дээрээс нь Украин Оросын дайны дараа бол ер нь Монгол нэлээн үнэд орсон ийм стратегийн байришилд тоглогч болох ийм боломжтой. Ер нь дэлхийн худалдаа бүх зүйл ерөөсөө энэ 2 геополитикийн том асуудлын дараа шал ондоо болно. Тэр үед манай уул уурхайн бирж бол үнэд орох цаг ирнэ гэдэгт би огт эргэлзэхгүй байгаа. Тийм учраас уул уурхайн биржийн хуулийг бас Засгийн газар одоогийн нөхцөл байдалтай холбогдуулан маш хурдтай оруулж ирж байгааг их баяртай байна. 2 санал байна.

Ер нь 66 хувийг нь төрд аваад, 34 хувийг нь олон нийтэд борлуулна гэсэн, нээлттэй хувьцаагаар борлуулна гэсэн энэ биржийн ийм бодлоготой явж байгаа юм байна. Тэгэхээр ер нь төр 51 хувийг л ав. Тэгээд 34 хувиа олон нийтэд нээлттэй зар, дахиад үлдсэн 15-ыг стратегийн түншүүдэд борлуул, тэр дээр Засгийн газар ажилла. Тэр 15 хувь дээр Лондоны биржийг заавал оруул энэ бол ардчиллын баталгаа болгож оруулж байгаа юм. Дээрээс нь туршилагыг нь бодож оруулах хэрэгтэй.

Хоёрдугаарт нь Далианы Хөрөнгийн биржийг оруулах хэрэгтэй. Энэ бол худалдан авагч талыгаа ширээний ард урьж байгаа хэрэг. Ингэж байж энэ уул уурхайн бирж чинь урагшаа явна. Бусдаар Монголын Таван толгойн нүүрс зардаг ийм бирж байх юм бол сайн явахгүй. Өнөөдрийн энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар энийг урагшлуулна гэвэл энэ бирж чинь нөгөө

хөрөнгийн бирж шиг хэдэн 10 жил хий эргэнэ. Тийм учраас энэ саналыг оруулах хэрэгтэй байна.

Хоёрдугаар асуудал бол биржийн худалдаагаа монгол төгрөгөөр явуул. Монгол төгрөгөөр явуулахаар яах вэ гэхээр гадаадын худалдан авагч тал чинь Монгол банканд валютаа зараад металлын бирж дээрээ төгрөгөө байршуулах байхгүй юу даа. Ингэхээр нэгдүгээрт хамгийн гол нь бид нар нөгөө барааныхаа урьдчилгааг авчхаж байна гэсэн үг байхгүй юу. Түрүүлж төлбөр төлдөг ийм систем бүрдэнэ гэсэн үг. Монгол төгрөгөөр худалдаа хийхийн ач холбогдол нь. Ийм 2 зүйлийг маш сайн хийх хэрэгтэй. Тэгэх юм бол.../минут дуусав/

Г.Занданишатар: Ж.Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Сүүлээс нь эхлээд хариулъя. Ер нь бол Монгол банкны хуулиар аль нь ч болно гэсэн. Эсвэл валютаар, эсвэл төгрөгөөр. Тэгээд Пүрэвдорж гишүүн бол төгрөгөөр хийх нь зөв гэсэн санал гаргаж байна. Ер нь бол яах вэ бид валютынхаа нөөцийг нэмэгдүүлэх, нөгөө талаас нь Пүрэвдорж гишүүний хэлж байгаа санал зөв гэдгийг хэлье. Тэр оролцооны хувьд Засгийн газар тогтооно гээд нээлттэй үлдээчихсэн байгаа. Энэ хуулиар шүү дээ. Оролцоог Засгийн газар хэд байхыг нь тогтоох вэ гэдэг. Санал гараад санал дээр тайлбарлахдаа бол Уул уурхайн яам нэгэнт л хууль өргөн барьсан учраас бид эхний энэ бирж ер нь бол үйл ажиллагааг тогтворжих, гадаад улсад нэр хүнд олох, ер нь бол энэ соёл тогтох энэ хүрээнд төр давамгайл байх нь зөв гэсэн ийм байр суурьтай байсан гэдгийг хэлье. Бусад зүйлийн хувьд та санал хэллээ гэж ойлголоо. Баярлалаа.

Г.Занданишатар: 85. Батнайрамдал сайд.

О.Батнайрамдал: Пүрэвдорж гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тантай бол санал нэг байна. Таны дурдсан Лондоны металлын бирж, Далианы таваарын бирж энэ 2 дэлхийн топ 5 биржийн яг 2 сонгодог жишээнүүд байна. Тэгэхээр ер нь энэ эрхийг яг Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд бид нар хуульдаа оруулж өгсөн байгаа. Тэгэхээр Монголын Хөрөнгийн бирж маань үйл ажиллагаагаа явуулаад, олон нийтийн компани болоод 34 хувиа гаргаад цаашидаа 66 хувиа стратегийн түншилэл, томоохон биржүүдийг оруулж ирээд тэрнээс нь нау хау суралцах ийм гадаадын жишгүүд маш олон байдаг. Хамтын ажиллагааны хүрээнд. Тэгэхээр энэ бол хуулиараа нээлттэй байгаа. Тэгэхээр энэ бол цаг хугацааны хувьд үе шаттайгаар хэрэгжих ёстой зүйлгээж бодож байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулна. Хууль зүйн байнгын хороо хуралдаад байх шиг байна. Энэ хооронд Алтай даргаас 2, 3 асуулт байна. Алтай, Дөлгөөн 2-оос нэг асуугаадахъя.

Нүүрсний хулгай ер нь нүүрсний борлуулалтыг ил тод болгох, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор 2.5 сая иргэнийхээ хувьцааг хөрөнгийн бирж дээр бүртгэж аваад, тэгээд энийгээ баталгаажуулахын тулд Хөгжлийн банк, Монгол банк, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорац зэрэг маркет мэйкинг хийж болох уу. Эрдэнэс тавантолгой share buyback plan зарлаад, дээр нь 2012 оноос хойш төрсөн хүүхдүүд ороогүй байгаа энэ Таван толгойн хувьцаа эзэмшилд. Энийг Батнайрамдал сайд энийг ингээд бүртгэж аваад, 2012 оноос хойш төрсөн хүүхдүүдээ Эрдэнэс таван толгойнхоо хувьцаа эзэмшигч болгомоор байгаа юм. Нэмж 10 хувийг нь хуваарилах өөрөөр хэлбэл. Өмнө нь хувьцаагаа аваагүй бүх иргэдийг л үүнд хамруулаад, нийтийн эзэмшлийн болгох. Тэгээд энэ компанийн

засаглал, удирдлагын нээлттэй байдлыг баталгаажуулж, олон улсын стандартад хүргэх, тэгээд тохиромжтой цаг нь ирэхээр олон улсын зах зээл дээр давхар листинг хийх замаар SPO хийх ийм бололцоонуудыг ер нь Хөрөнгийн бирж судалж, дээр үед бид нарыг ажиллаж байхад л энүүгээр аягүй их бараг IPO гаргая гээд л бид нар чинь баахан юм болоод явж байсан. Энэ тэгээд яачихсан юм бэ. Энийг гишүүд цуглалал Хангайн Алтай. Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал хариулъя. 86.

Х.Алтай: Занданишатар даргын асуултад хариулъя. “Эрдэнэс таван толгой”-г 1072 хувьцааг эзэмшүүлэх шийдвэрийг 2012 онд гарсан. 2012 оны 3 сарын 1-ээс өмнө төрсөн Монгол Улсын бүх иргэнд нийтдээ “Эрдэнэс таван толгой”-н 20 хувь хувьтай тэнцүү хувьцааг бол өгсөн байдаг. Харамсалтай нь энэхүү хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж ерөөсөө гараагүй. Энэ шийдвэр нь гараагүй байсаар өнөөдөр 10 жил боллоо. Мөн 2010-2012 онуудад бол олон улсын томоохон хөрөнгө оруулагчид олон улсын хөрөнгийн бирж дээр “Эрдэнэс таван толгой”-г гаргах сонирхлыг илэрхийлж байсан. Гэхдээ сүүлийн 10 жилийн хугацаанд бол нөхцөл байдал нь нэлээд өөрчлөгдсөн. Тухайлбал ESG гээд нүүрсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд байдаг. Дэлхийн томоохон биржүүд листинг хийхгүй байх гэдэг юм уу тиймэрхүү бодлогууд гараад ирсэн учраас өнөөдөр ахиад энэхүү “Эрдэнэс таван толгой” компанийг дахин өөр хаана гаргаж болох вэ, ямар бүтээгдэхүүн гаргаж болох вэ гэдгийг бид бүхэн бас судлаад явах нь зүйтэй гэж бодож байна. “Эрдэнэс таван толгой”-н иргэдэд тараасан хувьцааны ийм share buyback-ийн хувьд зөв зүйтэй зүйл гэж бодож байна. Учир нь юу вэ гэхээр нийтдээ анх 20 хувийг Монголын ард түмэнд, иргэдэд тараасан байдаг бол өнөөдөр 14.75 хувь нь Монголын иргэдийн гар дээр байж байгаа. Мэдээжийн хэрэг тэр 1072 хувьцааг

эдийн засгийн эргэлтэд буюу Хөрөнгийн биржээр дамжуулан борлуулж, худалдан авах тэр боломжоор нь нээх юм бол мэдээжийн хэрэг тодорхой хэмжээнд үнэ тогтворжуулах зорилгоор “Эрдэнэс таван толгой” компани өөрөө share buyback программ хөтөлбөр хэрэгжүүлж болно гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Бирж дээр бүртгэж байгаа share buyback энэ тэрийг хийхийг байна шүү дээ. Эдийн засгийн байнгын хороо дагаж гарах тогтоол дээрээ тусгаад тэгээд компанийн засаглалыг сайжруулах, төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах, уул уурхайн компанийн олборлох байдлын ил тод байдлын санаачилгын хуулиа батлах эд нар чинь бүгд хоорондоо холбогдоно. Паблик компани болохыг Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Дөлгөөн, Алтай дарга та нар түүх яриад байх шүү. Би та нараас шийдэл асуугаад байна шүү дээ. Энийг ингээд тогтоолд тусгана шүү. Энийг ингээд энэ юман дээр чинь олон нийтийн хяналтад оруулж паблик компани болгож, хараат бус гишүүнээс авхуулаад л олон нийтийн хяналт байх ёстой байна шүү дээ. Хөрөнгийн бирж дээр Алтай чи тэр Монгол шууданг хувьчилсан шиг ганц ч юм хийж чадсангүй шүү яг үнэн дээ. Монгол шуудангийн 34 хувь ямар их өгөөжтэй болсон. Олон нийтийн хяналтад ороод. Өдий хүртэл уул уурхайн том компаниудыг, Эрдэнэтийг хүртэл 10 хувийг нь гарга гээд Засгийн газрын тогтоол 2018 онд бид нарыг ажиллаж байхад гаргасан шүү дээ. Ядаж 10 хувийг нь гаргаж, олон нийтийн хяналтад оруулах ёстой байхгүй юу. Тэгвэл энэ хулгай, энийг чинь хэвтээ хариуцлагатай хяналтын тогтолцоо гэж байгаа юм. Босоо төрийн хяналтын тогтолцооноос ард түмний нүд, ард түмэн нүдтэй, ард түмний хяналтад оруулах чинь үр ашгийг сайжруулах хамгийн үр дүнтэй арга гэж дэлхий даяараа нотолчхоод байхад энийг тэгээд бид нар ярьсаар суугаа чинь бол бас

ичгэвтэр хэрэг шүү. Хийх ёстой байхгүй юу. Зүгээр л хий л дээ. Юу дутаад байгаа юм.

Санал хураалт. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “биржийг үүсгэн байгуулах,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Баагаагийн Баттөмөр, Хүрэлбаатарын Булгантуяа, Тогмидын Доржханд, Ганзоригийн Тэмүүлэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ гэнэ.

Ер нь бол Улсын Их Хурлаас энэ төрийн өмчийн компаниудыг паблик олон нийтийн болго гэдэг ийм шийдвэр гаргаад, хэрэгжүүл гээд жагсаалт батлаад яваад байгаа шүү дээ. Монгол шуудангийн сайн кейсийг яриад л байдаг мөртөө одоо бол ганц ч гарахгүй байна гэдэг бол ийм байдалд хүргэж байгаа шүү. Гэхдээ тэр олон нийтийн хяналт болохоор Монгол шуудангийн үр ашиг маш сайжирсан байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль,” гэсний дараа “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “Санхүүгийн зохицуулах хорооноос” гэсний дараа “тусгай” гэж нэмж, “суудлын” гэснийг, мөн зүйлийн 4.1.5 дахь заалтын “брокерын санал болгосон” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын “спот гэрээ,” гэсний дараа “форвард гэрээ,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын “арилжих” гэснийг “худалдах, худалдан авах” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.11 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын “уул уурхайн бүтээгдэхүүний” гэсний өмнө “Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.16 дахь заалт нэмэх:

“4.1.16.“форвард гэрээ” гэж уул уурхайн бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн ХОЁРДУГААР БҮЛЭГ-ийн гарчгийн “, ЗОРИЛГО” гэснийг хасаж, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байна.”

“5.2.Биржийн бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлийг дүрэмд тусгана:” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтын “төлбөр тооцоо, хийх” гэснийг “арилжаа болон клирингийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.3.2 дахь

заалтыг, мөн зүйлийн 5.3.3 дахь заалтын “даатгалын тогтолцоо,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.4 дэх шинэ заалт нэмж, мөн зүйлийн 5.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.4.эрсдэлийн удирдлагын бодлоготой байх бөгөөд учирч болзошгүй эрсдэлээ даатгалд даатгуулсан байх.”

“5.4.Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Дөлгөөн энэ commodity exchange чинь публик компаниуд байгаа биз дээ. Тэгээд төрийн өмчийн оролцоотой олон нийтийн компани байна гэж бичиж болоогүй юм уу.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.6.Бирж нь хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэхгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.9 дэх хэсэг нэмэх:

“5.9.Биржийн арилжааг үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд Засгийн газар шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 7 дугаар зүйлийн 7.5.2 дахь заалтын “худалдаа,” гэсний дараа

“санхүү,” гэж нэмж, мөн заалтын “үнэт цаас,” гэснийг хасаж, мөн зүйлийн 7.5.6 дахь заалтын “үнэт цаасны” гэснийг “санхүүгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтын “үнэт цаасны арилжаа,” гэснийг, мөн зүйлийн 8.4.2 дахь заалтыг, мөн зүйлийн 8.7 дахь хэсгийн “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага нар нь биржийн эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 9 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтын “шаардсан” гэснийг, 10.1.9 дэх заалтын “гишүүнд суудлын эрх, гишүүн бус оролцогчид” гэснийг, 10.1.13 дахь заалтын “асуудлыг төрийн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 10.2.1 дэх заалтын “коджуулах,” гэснийг, 10.2.6 дахь заалтын “, нөхөн бүрдүүлэх” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 10.1.13, 10.2.9 дэх заалтын “терминал,” гэсний дараа “тээвэр логистик,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ангилал код, чанар стандарт, сорьцын жагсаалтыг” гэснийг “ангиллыг геологи,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энхбаяр гишүүн ээ, албан тушаалд тавьж байгаа шаардлагаасаа гадна нөгөө нээлттэй сонгон шалгаруулалтын зарчим, шүүхийн хуульд хийж байсан

шүү дээ. Тийм ээ. Тийм юм хийхгүй бол бас нэг л юу болох вий дээ. Тэрийг анхаараарай. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.3, 12.4 дэх хэсгийг тус тус хасах.

“12.1.Биржийн арилжааг энэ хуулийн 10.2.4-т заасан журмын дагуу зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Арилжааны гэрээг бүртгэх, хэрэгжилтийг хангах

13.1.Биржээр бүтээгдэхүүнийг арилжаалахад дараах төрлийн арилжааны гэрээг байгуулна:

- 13.1.1.спот гэрээ;
- 13.1.2.форвард гэрээ;
- 13.1.3.фьючерсийн гэрээ;
- 13.1.4.опцион гэрээ.

13.2.Биржийн арилжаа хийгдэж, хэлцэл биелснээр арилжааны гэрээг байгуулсанд тооцно.

13.3.Бирж арилжааны явцад хийгдсэн гэрээг энэ хуулийн 10.2.11-т заасан журмын дагуу бүртгэнэ.

13.4.Арилжааны гэрээний үүрэг, хариуцлагыг тухайн арилжаанд зуучилсан брокер хариуцна.

13.5.Бирж, биржийн брокер нь холбогдох баримт бичгийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу бүртгэж, хадгална.

13.6.Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүн нь биржийн итгэмжлэгдсэн терминалд байршиж,

бүртгэгдсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “биржид арилжаалахаар бүртгүүлсэн,” гэснийг “биржээр” гэж, мөн хэсгийн “байгуулна” гэснийг “байгуулж болно” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “биржийн бус зах зээлд” гэснийг “биржээс гадуур” гэж, 15.5.4 дэх заалтын “Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчаас” гэснийг “Хорооны улсын байцаагчаас” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Биржийн арилжаанд оролцогч дараах нөхцөл, журмыг зөрчиж арилжаанд оролцсон бол арилжааг зогсооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Биржийн арилжааны төлбөр, тооцоо

16.1.Фьючерс болон опцион гэрээний арилжааны төлбөр, тооцоог үнэт цаасны төлбөрийн болон тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйцэтгэнэ.

16.2.Спот болон форвард гэрээний арилжааны төлбөрийн үйл ажиллагааг дотоодын арилжааны банк, эсхүл үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дамжуулан гүйцэтгэнэ.

16.3.Төлбөр, тооцоог хийхэд баримтлах журмыг Санхүүгийн

зохицуулах хорооны зөвшөөрлөөр биржийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

16.4.Бирж нь тооцооны үйл ажиллагааг өөрөө, эсхүл үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр тооцооны үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Нэг өгүүлбэрт тооцооны үйл ажиллагаа гэдэг үг 3 удаа орсон байна шүү. Найруулах хэрэгтэй юм байна. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Галсандорж гуай та хуучны хүн байж ийм үг, үсгийн юмыг анзаарах хэрэгтэй. Нэг өгүүлбэрт, 10 хэдэн үгтэй өгүүлбэрт тооцооны үйл ажиллагаа гэдэг үг 3 давтагдаж байна шүү дээ.

20.Төслийн 17 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 18, 19 дүгээр зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17 дугаар зүйл болгох:

“17 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

17.1.Биржийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.биржийн үйл ажиллагааг зохицуулах асуудлаар Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

17.1.2.биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг холбогдох этгээдээс авах.

17.2.Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох

журмыг батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Үг Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр таслалаа. Баттөмөр Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Та бүхэн анзаарч байгаа байх. Уул уурхайн биржийн хууль бол ялангуяа дээр дооргүй хулгай ярьж байгаа үед бол маш чухал ийм хуулийг бид хэлэлцэж байгаа. Бид нар бол нүүрсний хулгайтай зүгээр нэр ус зарлах, тэгээд болчихлоо гэдэг түр зуурын асуудал биш. Энэ ер нь хулгай гарах болсон үндсэн шалтгаан юу байв. Энхийг нүх сүвийг хаах, бөглөх цаашид байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд жинхэнэ утгаар нь хүртээх чиглэлд Эрдэнэс баялгийн биржийн асуудал бол маш том ийм асуудал болж байгаа. Энэ асуудлыг яг цаг агиинд шуурхай хэлэлцэж, баталж байгаа Засгийн газар, сайд Ганбаатар, Улсын Их Хурлын дарга, Ажлын хэсэгт талархсанаа илэрхийлье. Энэ бол бодит үйлдэл. Энэ дээр гэхдээ цаашид энэ зүйлийг бид дөнгөж анхны алхмаа хийж байгаа юм. Анх удаа байгуулах гэж байгаа учраас бид нэг амьсгаагаар бүгдийг ишийдэх боломж, бүгдийг харж үзэх боломж байхгүй. Ганбаатар сайд, Засгийн газар бол ерөөсөө энийг өчигдөр журмыг нь гаргаад эхлүүлж байгаа гэдэг ийм мэдэгдлийг хийсэн. Засгийн газар эхлүүлчихсэн. Эхлүүлж байгаа юм байна он гаргаад, хуулиа хүлээлгүйгээр. Энэ бол туйлын зөв. Энэтэй хамт би юу хэлэх гэж байна вэ гэхээр та бүхэн саяын уншсан томьёолол биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох журмыг Засгийн газар батлах гэж байгаа юм. Энэтэй хамт саяын бид нар 20 томьёолол дотор энэний дараа унших 3 томьёолол бүгд дандаа журам батлах гэж явж байгаа юм. Энэ юу хэлж байна вэ гэхээр шинэ тутам байгаа учраас бүх асуудлыг урьдчилж хараад, хуульдаа шигтгэ ийм боломж байхгүй. Одоо Засгийн газар сая баталсан энэ журам бид нарт маш их туршлага болно. Нөгөө тест болно. Бид нар чинь ямарваа нэгэн хуулийг тестлэх ёстой. Энэ бол их зөв

болж байгаа юм. Тестлээд юу болж байна, юу болохгүй байна гэдэг юмнуудыг. Тэгээд магадгүй тестийн 6 сарын дараа бас сайдад нэг баримжаа харагдах байх. Дахиад хууль дээрээ арай нэг хараагүй юм юу байж болох уу, энэ чинь ингээд боловсронгуй болгочих юмнууд юу байна гэдэг юм харагдах байх.

Ер нь цаашидаа ялангуяа энэ байгалийн баялаг ихтэй холбоотой асуудлууд дээр ийм журмаар зохицуулах харилцааг Улсын Их Хурал буюу хууль тогтоох байгууллага, бүх түвшинд багасгах ёстой. Журам батлах, эрх шилжүүлэх гэдэг бол хэрэг дээрээ хууль тогтоох эрх мэдлээ шилжүүлээд байгаа юм. Засгийн газар руу шилжүүлээд л, сайд нар руу шилжүүлээд л байгаа. Тэгээд журмууд аягүй том том журмууд байгаа. Жишээлбэл Санхүүгийн зохицуулах хороо байгалийн баялгийн нөгөө шимтгэлийн хувь хэмжээг тогтоох, шимтгэлийн хувь хэмжээ гэдэг бол ерөнхий журам гэж байгаа боловч үүний цаана хэдэн их наядын борлуулалт яригдаж байгаа учраас үүний хувь гэдэг бол 0.01 хувь дээр л хэдэн тэрбум төгрөг яригдаж байх магадлалтай. Тийм учраас ийм том том эрхүүдийг олгож байгаа гэдгийг тэмдэглээд, цаашидаа энэ асуудлуудыг аль болох хуульчлах ёстой. Жишээлбэл энэ экспортлох журмыг боломжтой юмнуудыг бүгдийг нь хуульчлах ёстой цаашидаа. Яг нүүрсийг яаж экспортлох юм, алтыг яаж экспортлох юм. Үүний дараагийн журмууд гэхээр тэр биржид тавигдах шаардлага, брокерт тавигдах шаардлага, эд нарт тавих хяналтын журмууд гээд явж байгаа. Ер нь цаашидаа эд нарыг ер нь хуульчлах ёстой шүү гэдэг зүйлийг протоколд тэмдэглүүлье.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Санал хураалт. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ. Журмууд тэгээд эрх зүйн актаар хууль зүй, дотоод хэргийн яамд бүртгэгдэх ёстой.

22.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 20.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

20.2.4.биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоосон журам батлах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.5.бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг батлах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтын “хийгдэж төлбөр, тооцоо хийх” гэснийг “төлбөр, тооцоо хийх ерөнхий” гэж, 20.4 дэх хэсгийн “хянан шалгагчийн” гэснийг “Хорооны улсын байцаагчаас өгсөн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 20.2.7 дахь заалт нэмэх:

“20.2.7.биржийн зах зээлд оролцогчдын үйлчилгээний төлбөр, хураамжийг тухайн оролцогчдын саналыг харгалзан тогтоох.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Хороо нь” гэсний дараа “геологи,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3, 21.4 дэх хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн “биржийн гишүүнээр элсэж суудлын эрх авсан” гэснийг “биржид гишүүнчлэлтэй” гэж, мөн зүйлийн 21.6.1, 21.6.2 дахь заалтын “харилцагчийн” гэснийг “биржийн арилжаанд оролцогчийн” гэж, 21.6.3 дахь заалтын “харилцагчаа төлөөлөн биржийн” гэснийг “биржийн арилжаанд оролцогчийг төлөөлөн” гэж, 21.6.4 дэх заалтын “биржийн бараа” гэснийг “биржээр арилжаалах” гэж, “харилцагчид” гэснийг “биржийн арилжаанд оролцогчид” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 21.6.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.10 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтын “байгуулах” гэсний дараа “, түүнд хувьцаа эзэмших” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 24.2.7 дахь заалт нэмэх.

“24.2.7.биржийн арилжааны оролцогчийг арилжаанд оролцуулахгүй байх, үнэ ханшид нөлөөлөх зорилгоор бодит бус, төөрөгдүүлсэн, эсхүл хуурамч мэдэгдэл, амлалт, таамаг гаргах, нийтлэх, чухал үйл баримтыг нуун дарагдуулсан, бодит үйл баримтын талаар худал мэдэгдэл хийх замаар хэлцлийн нөгөө талыг төөрөгдүүлсэн, эсхүл тодорхой арга, хэрэгсэл тоног төхөөрөмж ашиглан хэлцлийн нөгөө тал болох этгээдийг төөрөгдүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй гаргах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “зохицуулах байгууллагын” гэснийг “Хорооны” гэж өөрчилж, 25.2, 25.4 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.2.Биржийн гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон дотоод аудитын алба нь биржийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.”

“25.4.Бирж, биржийн арилжаанд оролцогч брокер нь биржийн хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхэд Хорооноос хяналт тавина.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “хуанлийн” гэснийг хасаж, 26.3 дахь хэсгийн “маргааныг хүлээн авч хуанлийн” гэснийг “энэ зүйлийн 2-т заасан гомдлыг хүлээн авснаас хойш” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн” гэснийг “биржийн арилжаанд оролцогчийн” гэж, мөн зүйлийн 27.2 дахь хэсгийн “26.2” гэснийг “26 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх. 57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны

тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Шилжилтийн хууль хийхгүйгээр хойш нь шидэж болох уу. Дагаж мөрдөх журмын тухай хууль хийгээд, зарим заалтыг шилжүүлээд явахгүй бол бүхэлдээ 6 сарын 30-аас болчихоор чинь энэ чинь хуулиа 1 сарын 1-ээс хэрэгжүүлээд явах нөхцөлөө яаж хангах юм бол. Энийг хууль зүйн техникийн хувьд Тамгын газар Агар-Эрдэнэ дарга үзээрэй. Тэгэхгүй бол энэ хууль чинь яаралтай шаардагдаад байгаа шүү дээ.

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “Бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байна” гэсний дараа “Биржийн төрийн өмчийн оролцоо бб хувиас доошгүй байна.” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Цөөнх болсон. Цөөнх болсон гишүүн үндэслэлээ тайлбарлаж саналаа хэлж болно. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр бидний байгуулах гэж байгаа уул уурхайн

бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байхаар бид шийдвэрлэж байгаа. Төсөл бол ер нь 100 хувь төрийн өмчийн компанийн хэлбэрээр орж ирсэн. Энэ бол ажлын хэсэг дээр төр ер нь та бүхэн харж байгаа. Одоо энэ нүүрсний хулгай чинь ерөөсөө л дандаа л төр 100 хувь мэддэг, эзэн сууж байгаа юм чинь хэрэг дээрээ эзэнгүй хулгай нүүрлэж байна. Аль болох л нэмэхгүй байх ёстой гэдэг ийм санал явж байгаа. Үүний дараа Цогтбаатар гишүүн манлайлаад, бидний санаачилж байгаа төрийн өмчийн компанийг цаашид нэмэхгүй байх ийм тогтоолын төслийг хэлэлцэнэ. Тэгээд миний хувьд Байнгын хороо дээр ямар асуултыг асуугаад байсан бэ гэхээр төрийн өмчийн оролцоотой болж байгаа бол төрийн өмчийн оролцооных нь хамгийн доод хэмжээ нь хэд байх вэ гэдэг асуулт асуугаад хариулт авч чадаагүй юм. Тэгээд яг хэд байх юм бэ. Энэ чинь төрийн өмчийн оролцоо 1 хувь байх юм бол тэр 1 хувийн хэрэг байхгүй шүү дээ. Энэ чинь зүгээр цэвэр хувийн компани болчхож байгаа юм. 10 байх юм уу, 20 байх юм уу, 30 байх юм уу, 50 байх юм уу, 60 байх юм уу, ингээд хувь асуугаад би хариулт авч чадаагүй юм. Тэгсэн Ганбаатар сайд Засгийн газар бол төрийн өмчийн оролцоотой энэ журмаараа бол төрийн өмчийнхөө оролцоог 66 хувиар доошгүй гэж зааж журмаа гаргаж байгаа гэхээр нь би санаа аваад тэгвэл Засгийн газрын энэ шийдэж байгаагаар нь санал гаргачихъя гээд ингээд 66 хувиас доошгүй байна гэдэг санал гаргачихсан юм. Ингээд цөөнх болчихсон. Энэ хугацаанд бас энэ бодлоосоо би ухарч, миний бодол санаа өөрчлөгдсөн. Энд х нөлөөлсөн хүн бол Учрал сайд байгаа. Би энэ хууль гарсны дараа Учрал сайдын нэлээн олон танилцуулга юмнуудыг ярьж эхэлснийг анзаарч би чинь өөрөө нөгөө Хөгжлийн банкны түр хороо гэсээр байгаад хорвоо ертөнцөд юу болж байгааг ерөөсөө танилцахгүй яваад. Тэгээд Учрал сайдын танилцуулга юмнуудыг сонирхоод үзсэн чинь маш их зөв юмнууд ярьж байна. Ялангуяа энэ цахим биржийг байгуулах,

тэгээд энэ нь өөрөө бирж нь өөрөө олон нийтийн нийт ард түмний хувь хувьцаа оролцоо шингэсэн байх. Өөрөөр хэлбэл нийт ард түмнээрээ энэ байгалийн баялгийнхаа бас үр өгөөжийг хүртээх, энэ менежментэд ард түмнийг улам ихээр оролцуулах, тэгэхдээ энийгээ бас цахим платформоор дамжуулж олон нийтэд нээлттэй, хяналттайгаар хэрэгжүүлэх ийм сайн санаачилгуудыг ярьж байгааг сонсоод нэг хоногийн өмнө ухар мөчид ийм санал гаргасныгаа ухаарч тэгээд энэ саналаа татаж авч байгаа юмаа. Гэхдээ Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэг дээр төрийн өмчийн оролцооны доод хэмжээг заавал заах ёстой. Тэгэхгүй бол энэ 1 хувь юм уу, 2 хувь нэмчхээд ингээд төр оролцсон уу, оролцсон гээд ингээд байж байж болохгүй. Тийм учраас эцсийн хэлэлцүүлэг дээр бол нөгөө бид нар стратегийн орд газрууд дээр хэрэглэдэг томъёолол байгаа шүү дээ. 34 хүртэл төрийн өмчийн оролцоотой байна гэдэг томъёоллоор бид бүгд явж байгаа. Тэгэхээр яг энэ томъёоллоор нь уул уурхайн биржийн хувьд бол 34 хүртэл байна гэдэг ийм томъёоллоор бол эцсийн хэлэлцүүлэг дээр нь оруулах дээр Улсын Их Хурлын дарга ийм чиглэл өгөх бололцоо байх болов уу. Ийм нөхцөлтэйгөөр би саналаа татаж авч байгаа юм дарга аа.

Г.Занданшатар: Учрал гишүүн бид нар ч гэсэн ярьсан. Энэ төрийн оролцоо хяналт хувийн эзэмшлийг хангасан, одоо байгаа Хөрөнгийн биржийн доор эрдэнэс түүхий эдийн цахим бирж байгуулах. Ард иргэд нээлттэй шударга, ард иргэдийн хяналт, тэгш оролцоо, баялгийн тэгш хуваарилалт, төрийн зохистой оролцоог хангасан түүхий эдийн бирж байгуулах ийм программ хангамжийн холбооны Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооны санал ирээд энийг би бас Энхбаяр гишүүн Эдийн засгийн байнгын хороонд цохсон. Учрал гишүүн ч гэсэн энэ талаар уулзаж ярилцаад, энэ бол ард иргэд блокчэйн технологи дээр суурилсан тийм

технологийн шийдлээр бурууг нурааж, зөвийг бүтээе гэсэн ийм уриатай ийм санаачилгыг Учрал гишүүн дэмжээд орчин үеийн технологийн шийдлийг олсон, хамгийн хурдан хэрэгжиж болох энэ цахим биржтэй чинь энийг уялдуулаад тогтоолын төсөлдөө тусгаад, энэ дээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол дуусаж байгаа учраас эцсийн хэлэлцүүлэг дээр дагаж мөрдөх журмын тухай хууль юм уу аль эсвэл тогтоол санаачлаад тогтоолдоо энэ асуудлуудыг тусгах чиглэл өгч байна.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн саналаа татаж аваад, тэгээд ийм чиглэлийг, олон саналуудыг энэ бас залуучуудын санаачилга бас олон нийтийн юутай ч их холбоотой юм байна лээ. Энэ бол шийдэл болж чадах юм байна билээ. Ард түмнийг хяналтад оруулах.

Одоо найруулгын саналаар санал хураалт явуулна.

Гурав. Найруулгын санал

1.Төслийн нэрийн “ХУУЛЬ” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтын “бүхий” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.2.8, 10.2.9, 10.2.10, 10.2.11 дэх заалтын “журам” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтын “үүрэг” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтын “үйл ажиллагаа” гэснийг, долдугаар бүлгийн гарчгийн “ЗҮЙЛ” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ бол найруулгын санал байна. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ. Уул уурхайн биржийн тухай хуулиар санал хурааж дууслаа. Одоо дагалдах хуулиудын талаар санал хураалт явуулна.

Уул уурхайн биржийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “11.33 дугаар” гэснийг “11.34 дүгээр” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “өөрийн харилцагчийн” гэснийг “Биржийн арилжаанд оролцогчийн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 11.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “суудлын эрх бүхий” гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн ““6.18 дахь заалтын “11.30” гэсний дараа,” гэснийг “6.18 дахь заалтын “11.33,” гэсний дараа “11.34,” гэж,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн үг хэлнэ. Дэмжигдсэний дараа чиглэл. Та үгээ хэлчих. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Их Хурлын даргаас чиглэл авъя. Саяын 2 дээр уншсан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай. Энэ дээр бол дугаарлалт өөрчлөгдсөн байгаа учраас энийг дахиж боловсруулах чиглэл өгөөч гэж.

Г.Занданшатар: Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

3.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох.

“1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалт:

“3.1.12.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

2/6 дугаар зүйлийн 6.1.13, 6.1.14 дэх заалт:

“6.1.13.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;”

6.1.14.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, түүнд тавих шаардлагыг тогтоох.”

3/6 дугаар зүйлийн 6.2.9 дэх заалт:

“6.2.9.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааны чиглэлээр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтын дугаарыг “3.1.13” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Агар-Эрдэнэ дарга аа, Эдийн засгийн байнгын хорооны ажилд тусалж бай. Үг үсгийн найруулгууд маш их, Мягмарцэрэн даргад тусалж бай. Дандаа үг давхардуулж хэрэглэнэ, давтаж хэрэглэнэ. Эшлэл гээд хууль зүйн техникийг сайн хянах хэрэгтэй.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс

дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Түрүүний заалтуудад чинь энэ заалтаар засагдчихна шүү дээ Мягмарцэрэн референтээ. Дугаарлалт, эшлэл өөрчлөлт орсон юмнуудаа дахиад энүүгээрээ засчихдаг байхгүй юу. 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

6 сарын 30-аас хэрвээ хэрэгжихээр бол наана нь түр журмаар нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, цахимаар зохион байгуулах, тэгээд саяын хэлсэн юмнуудыг бүгдийг нь тусгасан тийм тогтоолын төсөл, дагаж мөрдөх журмын тухай хууль санаачилж оруулж ир. Дараагийн асуудалд оръё.

18.09 цагт.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд Жамъянхорлоогийн Сүхбаатар сайд танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 3 дахь удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд

ноогдож байх, иргэдэд тэгш шударга хүртээх эрх зүйн үндэс орон нутгийн өмчийн биеэ даасан байдлыг тодруулан хуульчилсан.

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим өмчийн эрх зүйд нийцүүлж боловсронгуй болгох зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Иймд. Үндсэн хуулийн болон эрх зүйн шинэчлэл хөгжлийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хангах, төрийн бүтээмж, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, өмчийн харилцааны эрх зүйн зохицуулалтын хийдэл зөрчлийг арилгах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь 1996 онд батлагдсан бөгөөд хэрэгжиж эхэлснээс хойш 26 жилийн хугацаанд нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсан болно. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд тус хуульд нийт 33 удаа буюу өөр өөр зорилго цаг хугацаанд удаа дараа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хуулийн зохицуулалтын нэгдмэл цогц байдлыг алдагдуулахад хүргэсэн байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын шинжтэй шинэлэг зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн зорилтыг өргөжүүлэн томъёолж тус хуулиар зохицуулах харилцааны хүрээг тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг нэгтгэн тогтоосон. Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж, төрийн нийтийн болон тусгайлан өмч мөн орон нутгийн өмч гэсэн ангиллаар ялган тодорхойлсон. Өмчийн удирдлагын хэрэгжүүлэгч болох Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал Засаг даргын эрх хэмжээг шинэчлэн тодорхойлж, өнөөгийн хууль, хэрэглээний практикт үүсээд байгаа чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, харилцан уялдааг хангахад анхаарсан. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг шинэчилж хөрөнгийн эрхийн нийтлэг болон онцлог байдлыг тодорхойлсон, төрийн байгууллага албан газраас гадна Улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар зэрэг Иргэний хуулиар зохицуулаагүй хуулийн этгээдийн хэлбэрийг хуульд тусгасныг өөрчилж, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг компани, улсын төсөвт үйлдвэрийн газрыг албан газрын ангилалд хамруулан зохицуулсан.

Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодруулж өмчийг удирдах ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, өмчийн бүртгэл тооллогыг зохион байгуулах, төрийн хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан. Түүнчлэн орон нутгийн өмчийг удирдах үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг нэгдсэн журмаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн өмчийн газрын чиг үүргийг тодорхойлсон. Төрийн болон орон

нутгийн өмчит хөрөнгө олж авах, үнэлж бүртгэх, тоолох болон эзэмшиж ашиглах, бусдын өмчлөлд шилжүүлэх, данснаас хасах зэрэг хөрөнгийн харилцааны журмыг шинэчилсэн. Мөн өмч шилжүүлсний дараах хяналтыг хэрэгжүүлэх үндэслэл журмыг тогтоов. Өмчийн хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хяналтын журмыг нарийвчилж Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь өмчлөгчийн хяналтыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн өмчийн газар нь төрийн хяналтыг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Төрийн болон орон нутгийн өмч, түүний хөдөлгөөн, тооллого, тайлан болон хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн. Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, цаг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт хамгаалалтыг хангах үүргийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцахаар зохицуулсан. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь олон нийтэд ил тод нээлттэй байхаар тусгалаа.

Хуулийн шинэчлэлд нийцүүлэх нэр томъёог жигдлэх зорилгоор Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Соёлын өвийг хамгаалах тухай Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай зэрэг 30 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг дагалдуулан боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах нөхцөл, журам, компанийн ангилал, зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчийн эрх болон хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай бие даасан хуулиар зохицуулах болно. Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, Хянан шалгах түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрх хэмжээг тогтоох, төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгө авах, бүртгэх, үнэлэх ажиллагаа, өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах асуудлыг тус хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 1 жилийн хугацаанд багтаан зохион байгуулах, хууль хоорондын хийдэл, зөрчил арилж төрийн нийтийн өмчид хамаарах газар байгалийн баялаг болон бусад хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих хууль зүйн нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг *D-Parliament.mn* цахим сайтад

байриуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр энэ хуулийг шинэчлэхээр оруулж ирж байгааг дэмжиж, төслийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлтэй нэгтгэн, нэг ажлын хэсэг байгуулж ажиллуулах талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гео зураг зүйн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Болдын Цэнгэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын ахлах референт Доржсүрэнхорлоогийн Саруул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын шинжээч Бат-Эрдэнийн Төрбат, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн

удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн хууль, эрх зүйн хэлтсийн дарга Даваасамбын Дэлгэрмаа, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга Даваахүүгийн Нарангэрэл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн дарга Цэрэнбалын Түвшинзаяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Нармандахын Жамъянхүү.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Дамбын Батлут гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэлэлцэхийг нь дэмжиж байгаа юм. Сүүлийн үед чинь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд дээр чинь л хулгай, луйвар их гардаг, дээр нь төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүдийн үр өгөөж муутай гэсэн ийм л зүйл маш их яригдаж байна л даа Цэнгэл дарга аа. Тэгээд энэ хууль батлагдсанаар одоогийн байгаа энэ байдлыг засаж сайжруулна гэж өөрчлөх, сайжруулах, боловсронгуй болгох талаар ямар арга хэмжээ авахаар хуульд оруулж ирж байгаа юм. Ялангуяа энэ төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдийг менежментийг сайжруулах талаар ямар арга хэмжээ авах юм. Үр өгөөжийг нь нэмэгдүүлэх талаар ямар өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Цаашидаа төрийн өмчийн болоод төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хулгай луйвар гарахгүй байх тийм нөхцөл боломжийг нь хааж байгаа ямар зохицуулалтууд орж байгаа юм бэ гэдэг нэг асуулт.

2 дахиаас нь бидэнд нэг дутагдал байгаа юм. Томоохон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлуудыг шууд Засгийн газраас томилоод явчихдаг. Үүнээс чинь болоод л бид нар горьг нь амсаж байна шүү дээ. Ганхуяг гэж залууг бид нар “Эрдэнэс таван толгой”-н захирлаар тавьсан, Засгийн газар томилсон.

Ерөөсөө төрийн ажлын дадлага туршилага багатай, аж ахуйн ажлын дадлага туршилага багатай ийм залуу хүнийг ийм том төрийн өмчийн компанийн захирлаар тавиад, тэгээд сүүлдээ ажлаа унагачихдаг. Залуу хүнийг өөрийг нь ч гэсэн баллаж байгаа шүү дээ. Тэгэхээр цаашидаа энэ төрийн өмчийн оролцоотой, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудад гүйцэтгэх удирдлагыг нь яаж шийдэж байх юм. Засгийн газар ингээд томилоод л яваад байх юм уу. Нээлттэй сонгон шалгаруулалтаар ил тод зарлаж сонгож байх юм уу. Энэ дээр бид нар нэг томоохон зарчмын ахиц өөрчлөлт гарахгүй бол болохгүй нь ээ. Цэнгэл дарга минь.

2 дахь асуудал нь энэ Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд чинь бүгд ТУЗ-тай өөрийн удирдлагатай Төлөөлөн удирдах зөвлөл нь ч гэсэн дандаа л үндсэндээ танай төрийн өмчит хувьцаат л шийдвэрээр томилж байгаа шүү дээ. Энэ томилгоонуудыг цаашидаа ил тод болгох юм, нээлттэй болгох юм. Олон нийтийн оролцоо, хяналтыг яаж бий болгох юм. Энэ Төлөөлөн удирдах зөвлөлүүд чинь ерөөсөө ард түмний өмчид, ард түмнээ төлөөлж хяналт тавьж байгаа улсууд. Тэгээд ерөөсөө ард түмэндээ тайлан тавьдаггүй, мэдээлэл өгдөггүй ийм л байдалтай байх юм. Хаагдмал байх юм байна шүү дээ. Энийг яаж сайжруулах юм бэ гэж.

3 дахь асуудал нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудад энэ газартай холбоотой маш их зөрчил маргаан гардаг. Ер нь танай дээр ийм судалгаа байна уу, үгүй юу. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудаас газраас хууль бусаар бусдад шилжүүлсэн, худалдсан хэчнээн хэмжээний га газар байна. Судалгаа байна уу, үгүй юу. Энийг бид нар буцааж төрд нь төрийн мэдэлд нь авах ийм боломж нөхцөл байна уу, үгүй юу. Ер нь цаашидаа бид нар төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудыг ил тод болгох, нээлттэй болгох, олон түмний хяналтад оруулах талаар хуульд ямар ахиц өөрчлөлтүүд та бүхэн оруулж байгаа юм бэ гэсэн ийм 4 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Болдын Цэнгэл.
83.

Б.Цэнгэл: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Бид Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам мөн бас олон улсын байгууллагуудтай хамтраад ер нь энэ төрийн болон төрийн өмчит компаниудыг өнөөгийн нөхцөл байдлын талаар нэлээн гайгүй судалгаанууд хийсэн. Тэгээд энэ дээр үндсэндээ яг таны яриад байгаа төрийн өмчит компаниудыг засаглал нь болохгүй байна. Төрийн өмчийн компаниудын үр өгөөж ерөөсөө хангалтгүй байна. Улсад үзүүлж, нийгэмд үзүүлж байгаа дорвитой хувь нэмэр оруулахгүй байна гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар ерөөсөө төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудад бүтцийн өөрчлөлт хийх цаг нь болсон юм байна. 30 орчим жил явж ирсэн энэ тогтолцоог өөрчлөхгүй бол болохгүй гэдэг агуулгаар асуудал хандаж байгаа. Энэ агуулгаараа бид бол 2011 онд батлагдсан Компанийн тухай хууль, 1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас болон төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн холбогдох

заалтуудыг аваад тэрийг нь олон улсын болон өнөөгийн компаниудад хэрэгжиж байгаа зүйлүүдийг тусгаад анхдагч хууль болгоод төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийг өнгөрсөн 10 дугаар сард Их Хуралд өргөн бариад хэлэлцэх эсэх нь дэмжигдчихсэн явж байгаа.

Энэ дээр таны асуугаад байгаа асуудлын гол нь бол яг төрийн болон төрийн өмчит компанийн тухай анхдагч хуулиуд бол бүх зарчмууд нь тусгагдсан байж байгаа. Тэгээд энэ хуулийг өнөөдрийн өмчийн хуультай бараг зэрэгцээд шахуу хамт хэлэлцэх нь их оновчтой зүйл гэж бид үзэж байгаа. Яг энэ хуультай холбогдуулаад асуусан учраас ер нь бол компанийг гүйцэтгэх удирдлага засаглал нь ямар байх юм бэ гэж та асууж байна. Яг үнэхээр манайд компанийн засаглалын зарчим алдагдчихсан байгаа нь үнэн. Өнөөдөр төрийн болон төрийн бус компаниудын ерөнхийдөө улс төрийн бараг шахуу томилгоогоор томилж байгаа нь бол нууц биш. Бид энэ өргөн мэдүүлчихсэн байж байгаа компанийн тухай хууль дээр ерөөсөө хэд хэдэн зарчмыг баримталж байгаа юм. Нэгдүгээрт нь ерөөсөө компани цаашидаа улс төрөөс хамааралгүй байх нь зүйтэй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт компанийн гүйцэтгэх удирдлага бол мэргэшсэн буюу мэргэжлийн хүн удирдах нь зүйтэй.

3 дахь асуудал нь компанийн удирдлагыг сонгохдоо. Сонгон шалгаруулалтын зарчмаар ерөөсөө хийх ёстой. Компанийнх нь зэрэглэл буюу нийгэмд гүйцэтгэж байгаа үүргээс нь хамаараад шаардлагатай гэж үзэх юм бол олон улсын хэмжээний менежерийг сонгон шалгаруулах хэлбэрээр ажиллуулах. Тэгээд ийм байж байгаа. Нөгөөтээгүүр үйл ажиллагаа нь ил тод байх ёстой гэдэг үндсэн ийм зарчмуудыг бол компанийн анхдагч хууль дээр хийж өгсөн. Өнөөдөр хэлэлцэж байгаа өмчийн хууль дээр нь бол ерөнхий зарчим бол

туссан. Юу гэж тусгасан бэ гэхээр ер нь.../минут дуусав/

Г.Занданшатар: 83. Гүйцээж хариулъя. Товч тодорхой хариулъя.

Б.Цэнгэл: Манай өмчийн хууль дээр таны хэлээд байгаа зарчим бол үр өгөөжтэй, ашиг бий болгох ийм зарчимтай байх ёстой гэж үзэж байгаа. Яг газартай холбоотой асуудал дээр манай Нарангэрэл дарга нэмэлт хариулт өгөх байх. 84 дүгээр микрофон.

Г.Занданшатар: 84.

Д.Нарангэрэл: Газар эзэмших, ашиглах эрхийн сая Чинзориг гишүүний асуусан асуултад хариулахад урьд нь энэ бол эзэмших, ашиглах гэрчилгээг тухайн шатны Засаг дарга нар олгоод явж байсан. Бид нар 2018 онд Засгийн газрын шийдвэрээр эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэснээр энд байгууллагын үндсэн үйл ажиллагаа эрхлэхэд шаардаж байгаа газрыг үнэлж, бүртгэж хяналтдаа авсан байдаг. 2018 онд үнэлж, бүртгэж авч байсан газраас бид нар энэ жил улсын нэгдсэн тооллого явуулахад бас нэлээд ахиц гарсан. 128000 га газар төрийн болон орон нутгийн өмчтэй 6600 нэгж байгууллагад эзэмшиж, ашиглаж байна. Энэ байгууллагуудын бүртгэлийг бусдад шилжүүлсэн, бусдад шилжүүлснийг нь цуцлуулах шийдвэрийг 2020 оны Засгийн газрын 10 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Энэ дагуу бид нар алдсан газруудыг буцааж авах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа. Саяын тооллогын үр дүнгээс харахад бас төрийн болон албаны нууцад хамаардаг байгууллагын ч гэсэн газрууд, тусгай хэрэгцээний газрууд, эмнэлэг, сургууль, цэцэрлэг бүхий л төрийн өмчтэй байгууллагуудад газрын маргаанууд нэлээд хэмжээтэй байгаа учраас бид энийг бас буцааж авах, буцааж байгууллагад нь эзэмшүүлэх шийдвэр гаргуулах талаар Засгийн газарт танилцуулахаар бэлтгэсэн байгаа.

Шинэ хуулийн төслөөр хязгаарлагдмал эрхээр ашиглуулах асуудал Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтад олгосон газрыг эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр бусдад хязгаарлагдмал эрхээр ашиглуулах зориулалтын бус барилга байгууламж барихыг хориглох тухай заалтыг өнөөдөр танилцуулж байгаа төслийн 42.5-д тусгасан байгаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя. 1 минут.

С.Чинзориг: Төлөөлөн удирдах зөвлөл гээд дандаа Төрийн өмчийн хороо л голцуу томилдог шүү дээ. Тэгээд тэр Төлөөлөн удирдах зөвлөл чинь ерөөсөө ажиллахгүй байна Цэнгэл дарга аа. Хариуцлага хүлээхгүй байна. Та бүхэн тэд нартай төрийг төлөөл гэж ямар чиглэл, үүрэг өгч ажиллаж байдаг юм бэ. Тэндээ хариуцлага тооцдог юм уу. Тэд чинь тэгээд энэ төрийн өмчийг төлөөлөөд, иргэдийн төлөөлөл болоод хяналт тавьж байгаа, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж байгаа энэ хүмүүс чинь тайлангаа тавьдаг юм уу. Оюутолгой гээд байна. Ерөөсөө л энэ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь ганц ч үг ган хийхгүй юм байна шүү дээ. Ийм байдлыг яаж засах юм бэ. Ер нь цаашидаа танай Төрийн өмчийн хороо энэ төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын менежментийг нь сайжруулах, хариуцлагыг нь сайжруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх талаар ер нь ямар арга хэмжээ авах юм бэ. Танай дуу хоолой ч гэсэн энэ дээр ерөөсөө л гарахгүй юм байна шүү дээ Цэнгэл дарга аа. Энийг бид цаашидаа жаахан сайжруулмаар байна шүү дээ.

Г.Занданшатар: Болдын Цэнгэл. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга. 83.

Б.Цэнгэл: Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон орон

нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль дээр ер нь Төлөөлөн удирдах зөвлөлд хэрэв төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани бол төрийн төлөөлөл буюу дандаа яам, Тамгын газраас Төлөөлөн удирдах зөвлөлд байхаар тусгачихсан байдаг. Одоогийн мөрдөж байгаа хуулиар. Нэг Төрийн өмчит компаниар жишээ татаад ярихад ТУЗ-ийн гишүүнтэй байлаа гэхэд түүний 6 нь төрийн төлөөлөл. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь манай дээр бол яамд батлан хамгаалахын салбарынхан нь өөрсдөө аваад явчихдаг. Тэгээд төрийн өмчийн бодлого дотоодын газар гээд ер нь одоо бол 7 субъект хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч болчихсон яваад байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар оруулж ирж байгаа Компанийн тухай хууль дээр, Өмчийн тухай хууль дээр ч гэсэн ер нь тогтолцоог өөрчлөхгүй бол болохгүй. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь ингэж олон хуваагдал байдалтай байж болохгүй. Аль нэг нь дангаараа энийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг байдлаар томъёолол оруулж байгаа юм. Ер нь төлөөлөн ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүний нэг бол ер нь аль болохоор хараат бус гишүүдийг ач холбогдол өгдөг ийм байдаг л даа. Ер нь ТУЗ-ийн даргыг хүртэл хараат бус гишүүнээр томилох нь зүйтэй гэдэг ийм чиглэлийг олон улсын энэ яг компанийн засаглалыг судалдаг байгууллага ийм зөвлөмж чиглэл өгч байгаа. Манай хэлэлцүүлэхээр өргөн барьчихсан байгаа Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль дээр бид бол энэ асуудлыг засаж, залруулах чиглэлээр оруулж ирсэн байж байгаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. МАН-ын бүлгийн дарга.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бол яах аргагүй их том хууль. Бид 2019 онд үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгдсэн. Энэ Үндсэн хуулийн нэмэлт,

өөрчлөлтийн дараа Улсын Их Хурлын 02 дугаар тогтоол гэж гарсан. Энэ тогтоолоор Засгийн газарт нийт 40 хуулийг бид эрх зүйн шинэчлэл хийнэ гэсэн. Энэ эрх зүйн шинэчлэлийн нэг том реформын нэг том юм нь бол өмчийн харилцааг зохицуулахтай холбоотой маш том харилцаа байгаа юм. Энэ нэлээн удаж орж ирж байгаа юм. Би хууль санаачлагчаас 2 асуулт асууя гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт бид нар энэ хуулиар төрийн нийтийн өмчийн асуудлыг зохицуулах ёстой. Үндсэн хуулийн 6.2-ыг амилуулах хэрэгтэй. Бид 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ 6.2 гэж заалтыг өөрчилсөн. Энэ бол төрийн нийтийн өмчтэй байна. Нийтийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна. Нийтийн өмчийг ард түмэнд хүртээлтэй болгоно. Баялгийн сан байгуулна гээд нэг баахан зүйлийг 6.2 дээр зааж өгсөн. Одоо энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль орж ирэхээр энүүгээр бид нар энэ харилцааг зохицуулах ёстой. Энэ харилцаа орж ирэв үү. Зүгээр унхсан энэ харилцаа огт алга. Ерөнхий нэг нийтийн өмч ийм юм байна гээд 6 юм биччихсэн өөр юу ч байхгүй. Энэ харилцаа маш муугаас болоод бид нар өнөөдөр яг энэ түвшинд хүрч байгаа байхгүй юу. Тэгэхээр нийтийн өмч, байгалийн баялаг, түүний үр ашигтай холбоотой асуудлыг суурь харилцааг энэ хуулиар зохицуулна. Тусгайлсан харилцааг Ашигт малтмалын хуулиар нь зохицуулна. Өөрийнх нь салбар хуулиар нь зохицуулна. Байгаль орчны бол байгаль орчны хуулиар. Гэтэл суурь харилцааг зохицуулах нөгөө хууль нь энд огт тусгагдаагүй байдаг. Тийм учраас 6.2-ыг амилуулах хууль орж ирээгүй байна гэж би үзэх гээд байгаа юм. Тэгээд би энэ дээр хууль санаачлагчийн саналыг сонсьё гэж бодож байна. Нэг дэх асуудал.

Хоёрдугаарт нь төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулах, үр ашгийг нь дээшлүүлэх, үр ашиг муутай компаниудыг хувьчлах, олон

нийтийн хяналтыг бий болгох, төрийн оролцоо, хяналтыг бий болгохтой холбоотой асуудлыг бид нар ярихаас өөр аргагүй байгаа юм. Өнөөдөр бид нар байгалийн баялгийн тухай яриад л байж байна. Алдагдсан тухай яриад л байж байна. Гэтэл Монгол Улс чинь эзэнтэй шүү дээ. Яг энэ төрийн өмчит компаниудын менежментийн асуудал, төрийн өмчит компаниудын үр ашгийн асуудлыг хариуцдаг байгууллагыг би танай байгууллага гэж ойлгож байгаа. Төрийн өмчийн хороо. Бид чинь шат шатандаа ерөөсөө хариуцлага тооцож юмаа ярихгүй. Нүүрс хулгай болчихлоо. Үгүй тэрийг чинь хараад байж байгаа газар тэр Гааль, Хил тэр төрийн өмчийн хороо, төрийн өмчийн компани бүгд байж байгаа юм шүү дээ. Гэтэл хэдэн Их Хурлын гишүүн хулгай хийчихсэн юм шиг л юм яриад байх юм. Монголын төрийн нэрийн өмнөөс төрийн байгууллага байж байгаа шүү дээ. Гэтэл тэр ажиллаж байгаа байгууллага нь ажлаа хийдэггүй. Тэгээд энд орж ирчхээд Цэнгэл дарга юу гэж байна вэ гэхээр менежмент нь бүгд байхгүй болчихсон юм даа эд нар гээд. Энийг цэгцлэх гэж төрийн өмчийн хороо байж байгаа юм байгаа биз дээ. Энийг цэгцлэх гээд Засгийн газар байж байгаа юм байгаа биз дээ. Тэгээд энэ байгууллагууд нь ажлаа хийдэггүй. Сүүлд нь юун дээр буудаг вэ гэхээр Их Хурал дээр л буудаг. Бүх буруу юм нь. Одоо бараг нүүрсний хулгай энэ юм чинь очиж очиж бараг л бүгдээрээ Их Хурал дээр ирж байна шүү дээ. Гэтэл энийг чинь байлгах гэж бид нар Хилийн цэрэг байж байна харах гэж, Энийг чинь хянах гэж Гааль байж байна. Энийг хянах гэж мэргэжлийн хяналт байж байна. Энийг зохицуулах гэж Авто тээврийн төв байж байна. Энийг зохицуулах гэж энэ төрийн.../минут дуусав/

Г.Занданшатар: 85.

Д.Саруул: Гишүүний асуултад хариулъя. Төрийн нийтийн өмчийн асуудлаар Үндсэн хуульд заасан төрийн байгалийн баялаг нийт ард түмний эрх

ашиг нийтлэг хэрэгцээнд зориулж ашиглах зориулалттай хөрөнгүүдийг төрийн нийтийн өмч гэдэг нэрээр нь бол төрийн тусгайлсан өмч буюу төрийн байгууллагуудын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зориулалтаар ашиглах, өмчөөс нь ялгаад нэрлэн зааж өгсөн. Энэ хуулийн төсөл дээр. Энэ нь одоогийн явж байгаа өмчийн тухай хууль дээр заагдсанчлан Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг ой, ус гээд Үндсэн хуульд заасан өмчөөс гадна Эрдэнэсийн сан, Үндэсний баялгийн сангийн хөрөнгө мөн Төрийн архивын сан, Палеонтологи, археологийн олдвор зэрэг энэ нийтийн сайн сайхан, нийтийн эрх ашгийн чиглэлээр ашиглах өмчүүдийг нэрлээд заасан. Гэхдээ өмчүүдийн маань хувьд нөгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах ч гэдэг юм уу тооллого, бүртгэл явуулах харилцаа маань өөрөө тусгайлсан нарийвчилсан хуулиар зохицуулагдаж байдаг учраас хуулийн төслийн 3.2.5 дээр энэ харилцааг тусгайлсан бие даасан хуулиар нь зохицуулна. Гэхдээ зохицуулж байгаа харилцаа маань өөрөө энэ нийтлэг харилцааг зохицуулж байгаа өмчийн хуулийн өмчийг удирдах зарчим, зориулалт, ангилал болон нөгөө өмчийг удирдах эрх бүхий субъект буюу Улсын Их Хурал, Засгийн газарт хуулиар олгочихсон эрх хэмжээний хүрээнээс халихгүй. Энд нийцсэн байх зарчмыг тусгаж өгсөн юм.

Дараагийн нэг юу болохоор ялангуяа төрийн нийтийн өмч зориулсан өмчийг хуульд тусгайлан заагаагүй л бол бусдын өмчлөлд шилжүүлэхийг бас хуулиар хориглосон. Мөн ашиглалт бүртгэлтэй холбоотой тэр баримтлах нийтлэг зарчмуудыг өөрийнх нь хууль дээр тусгаж өгсөн ийм онцлогоор орж ирж байгаа. Мөн юу гэдэг юм төрийн болон орон нутгийн өмчийн нийтийн зориулалттай байна уу эсвэл тусгайлсан байна уу ялгаагүй бүртгэлийг нэгдсэн журмаар хийхээр энэ хууль дээр тусгаж өгч байгаа. Тэгэхээр энэ бүртгэл нь

хийгдээд тайлан мэдээ нь нэгдсэн журмаар гараад, ил тод байхаар зохицуулсан. Баярлалаа.

Г.Занданишатар: 83. 2 дахь асуултад Болдын Цэнгэл.

Б.Цэнгэл: Тогтохсүрэн гишүүний асуулт хариулъя. Бид бол 20 гаруй жилээ ингээд яваад ирчихсэн ийм тогтолцоог л өөрчилж байгаа шүү дээ Тогтохсүрэн гишүүн ээ. Тэгэхээр энэ бол тийм амар ажил биш юм шиг байгаа юм. Гэхдээ Засгийн газар энд ханиуу шамлаж орж байгаа. Бид олон компанийг нэгтгэж, нийлүүлж байгаа, татан буулгаж байгаа. Хамгийн сүүлийн жишээ татахад төмөр замын компаниудыг бид нар цэгцлэх Засгийн газрын 2 тогтоол гаргууллаа. Зүүн баян төмөр замын компанийг татан буулгаж байгаа. Таван толгой компанийн хувьцаа эзэмшигчдийнх нь асуудлыг эргэж харъя гэж байгаа. Монголын Төмөр зам компани дээр нэгтгэх асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ эүх зүйлийг хийхэд бас тийм амаргүй байсан. Гэхдээ энийг хийж байгаа. Одоо бид нар Их Хурал үндсэн чиглэл баталчихсан. 2022-2023 онд 23 компани дээр IPO гаргах ажлыг хийнэ. Энэ ондоо багтаагаад Хөрөнгийн биржийг хийнэ. Тэгээд ингээд засаглалын хэлбэрүүдийг нь сайжруулах асуудлуудыг үе шаттай ярьж байгаа. Сая Засгийн газрын хурлаар өнгөрөгч Засгийн газрын хурлаар ороод Эрдэнэт үйлдвэр болон Таван толгой хувьцаат компанийг олон нийтийн компани болгох асуудлыг яаралтай судалж оруулж ир гэдэг ийм үүрэг, чиглэл аваад ажиллаж байгаа. Тэгэхээр ер нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг олон нийтийн хяналттай болгох, нээлттэй хувьцаат компани болгох чиглэлээр бол Энэ зорилгыг бид ухрахгүй энийг хийнэ. Магадгүй Их Хурлын үндсэн чиглэлд. Компанийн хууль дээр ирчихсэн тийм.

Г.Занданишатар: Тогтохсүрэн гишүүн. МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн.

Д.Тогтохсүрэн: Манай Их хурлын гишүүд ч гэсэн анхаарах хэрэгтэй байгаа юм. Ингээд л орж ирээд худлаа яриад л, тэгээд л бид нарт баахан худлаа тайлбар тавьж байгаад л гардаг. Жишээлбэл Таван толгой ХК-ийн менежмент дээр танай хороо л хариуцаж байгаа юм шүү дээ. Төлөөлөн удирдах зөвлөлийг хэн томилж байгаа вэ? Танайх л томилж оролцож байгаа шүү дээ. Хяналтыг хэн хэрэгжүүлж байна. Танайх л оролцоно шүү дээ. Тэгээд нүүрсний хулгай тийм юм гарлаа гэж байна. Сүүлд нь Их хурал буруудчихсан юм шиг, Засгийн газар буруудчихсан юм шиг л байгаа шүү дээ. Та нар энэ төрийн өмнө ажил хариуцаж байгаа юм байгаа биз дээ энэ талаар. Тэгээд юм асуухтай зэрэг энэ хуульд хэрвээ засаглалаа сайжруулах юмаа энэ хуульдаа хийж өгөхгүй, өөр юм яриад л ингээд суугаад байх юм. Их Хурлын өмнө та нар Засгийн газрын өмнө ажил хариуцаж байгаа юм байгаа биз дээ.

Г.Занданишатар: 82. Баяр-Эрдэнэ.

Ц.Баяр-Эрдэнэ: Тогтохсүрэн гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Ер нь бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх гэдэг ойлголт өөрөө компани болгон тус тусдаа хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлбэл 14, 15 ийм, орон нутгийн нэг нутгуудыг нэмбэл 20 гараад явчихсан байгаа. Тэгээд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь өөрөө ГУЗ-аа томилдог. Тусдаа хяналт тавьдаг ийм тогтолцоо байгаа. Энэ нь бол өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчийн хуульд 2014 онд орсон өөрчлөлтөөр бий болоод ирсэн ийм л тогтолцоо. Энэ байдлыг өөрчлөхийн тулд төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн анхдагч хуульд тодорхой зохицуулалтууд орсон байгаа. Энэ хууль дээр бол хувьцаа эзэмшигчийн эрхийг төвлөрүүлсэн байдлаар зохион байгуулъя гэдэг ийм заалт орсон байгаа гэдгийг. Яг өнөөдөр төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бол

Эрдэнэс таван толгой ХК-ийн ТУЗ-ийг сонгодоггүй, томилдоггүй, энд оролцдоггүй ийм байдалтай байгаа. Яагаад гэхээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч биш учраас. Тэгэхээр ер нь цаашидаа ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг дагнасан мэргэжлийн нэгдмэл ийм байдлаар удирдах энэ зохицуулалт бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд орж ирж байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулга дотор бол 6.2-т буюу Үндсэн хуулийн стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үр өгөөж ард түмэнд нийтлэг байх тэр үндсэн зохицуулалтын хүрээнд Улсын Их Хурал, одоо стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын батлах тэр эрх мэдлийг нь Их Хуралд, ер нь бол мэргэжлийн байгууллага удирдаад явах олон нийтийн нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгэх удирдлагыг нь томилдог. Олон нийтэд бүх мэдээлэл нь ил тод нээлттэй байдаг энэ тогтолцоог энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиар, энэ 2 хуулийн нэг нь нөгөөг.../минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль их чухал хууль. Энэ ер нь өмчийн харилцааны өөрийнх нь суурь хууль байхгүй юу. Энэ хуулийн үзэл санаа дээр тулгуурлагдаж цаад тэр компанийн хууль бүх юм чинь гарах ёстой. Тийм учраас энэ хуулийг бид нэлээн өөр өнцгөөс хармаар байгаа юм. Сая Тогтохсүрэн дарга асуулаа. Төрийн нийтийн өмчит бид тэр газар, баялгийг бүгдийг оруулсан. Үгүй ээ, энэ төрийн нийтийн өмч дээр тэгвэл бид ямар удирдлага хэрэгжүүлэх юм. Энэ хуульд чинь суурь заалт байх ёстой шүү дээ. Юу хэрэгжүүлэх юм. Тийм учраас үүн дээрээ юмнуудаа тодруулах ёстой. Цаашид тэр

хувийн хэвилийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын үр дүн дээр бий болчихсон ордуудыг төр үнэхээрийн баялаг нь л нийтийн өмч мөн юм бол ямар байдлаар хяналт тавьж, зохистой ашиглалтыг нь явуулах ёстой юм. Төрийн хөрөнгөөр хайгуулын ажил нь хийгдээд, нөөц нь тогтоогдчихсон үйл явцыг яаж хэдүүлээ үнэлж зохицуулалтыг нь хийх ёстой юм. Энэ юмнууд чинь энэ хууль дотор л яг шигтгээж орох ёстой шүү дээ. Үндсэндээ зүгээр нэг тийм хуулийн заалт болгож оруулчихаад, эзэнгүй орхихоод л байгаа байхгүй юу. Өнөөдөр бид нар. Тэгэхээр үүнийг яаж зохицуулах юм бэ гэдэг асуудал нэг.

2 дахь асуудал. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар энэ өмчийн хуулиар ямар эрх хэрэгжүүлнэ гэж тодотгож орчхоод байгаа юм. Одоо бид нар өөрсдийгөө хамгаалаад том том үнэ цэнтэй аж ахуйн нэгжүүд дээр бид Төлөөлөн удирдах зөвлөл ч тавьдаггүй, гүйцэтгэх захирал ч тавьдаггүй, бид үүнийг хэрэгжүүлдэггүй гээд ярьцаагаад байна шүү дээ. Яг нарийндаа энэ төрийн өмчийн бүхий л бодлого зохицуулалтыг хариуцах ёстой үндсэн байгууллага нь танайх. Танайх үүнд чиг үүрэг хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр энэ хуулиар ямар нэмэлт юм юу тусаж орсон юм бэ. Нэг зүйл үүнийг асуумаар байгаа юм.

3 дахь зүйл. Төрийн өмчтэй болон орон нутгийн өмчтэй компаниудын хууль гэж нэг хууль орж ирсэн. Тэр дээр тэр сонгон шалгаруулдаг, барьдаг тэр юмнууд орж ирсэн. Би мэдэж байна. Гэхдээ Эрдэнэс Монгол билүү, тэр чинь ер нь ямар статустай байгууллага юм бэ. Тэрийг ер нь ямар эрх зүйгээр зохицуулаад байгаа юм бэ. Корпорацын хэлбэр юм уу гэж харагдаад байгаа юм. Одоо сая буцаагаад л Эрдэнэт, Монголросцветмет тэд нарыг бүгдийг нь дотор нь нийлүүлсэн. Тэгвэл тэр Эрдэнэт дээр Монголросцветмет дээр ТУЗ байх юм уу, байхгүй юм уу гээд наадах чинь шаталсан бүтэц юм бол яаж харилцааг нь зохицуулах юм. Тэр

компанийн хуулиар зохицуулна гэхээсээ илүүтэйгээр энэ өмчийн хууль дотор үндсэн суурь үзэл санаа нь суух ёстой. Төрийн өмчтэй компани байж болно. Тэр компани ийм байна гэдэг юмыг энэ дотор оруулж өгөх ёстой.

Хоёрдугаарт. Одоо бид нар энэ хулгай зэлгий, дээрэм тонуул яриад төрийн 100 хувийн өмчтэй аж ахуйнууд бол гэмтэй юм байна даа. Олон нийтийн засаглалтай болгоё доо гэдэг эрэл хайгуулд оров уу. Орж байгаа биз. Тэгвэл одоо энэ энэ өмчийн хууль дотор чинь төрийн өмчтэй компанийн чинь суурь зарчим дотор ер нь ямар оролцоотой, юу байх юм гэдэг юм чинь заагдахгүй юм уу. Би бол тэгж л хараад байгаа юм. Төрийн өмч нь хэдэн хувьтай байж болох юм. Энэ асуудал чинь энэ л юмандаа орж өгөхгүй бол цаашаагаа явахгүй ээ. Тийм учраас энэ харилцааг яаж зохицуулах юм гэдэг асуудал байгаад байгаа юм. Би ийм хэдэн зүйл дээр бусад төрийн байгууллагуудын зардал нэмэгдүүлээд байгаа юм, Байр ашиглалт хийгээд тогтмол зардлаа.../минут дуусав/

Г.Занданишатар: 83. Болдын Цэнгэл.

Б.Цэнгэл: Бид ерөнхийдөө өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байгаа. Энд асуугдаад байгаа олон асуултууд өргөн барьчихсан байгаа Төрийн өмчит компанийн тухай хуулийн л юм асуугаад байна л даа. Тэгээд нэгэнт асууж байгаа учраас хариулъя. Ер нь энэ 2 хуулийг бараг хамтад нь л бараг хэлэлцвэл үр дүнтэй гэж бид үзээд байгаа юм. Тэгэхээр яах вэ ерөнхийдөө өргөн баригдаад байгаа өмчийн хуулиар шинэчилсэн найруулгаар манай байгууллага бол тохируулагч агентлаг болж байгаа юм. Тохируулагч агентлаг ажилладаг арга хэлбэр нь хэвээрээ хорооны зохион байгуулалтаар байна. 9 гишүүнтэй байна. Шийдвэр нь яах вэ нөгөө тогтоол тэмдэглэл хэлбэрээр гардаг. Тэгээд нэг шинэлэг зүйл нь бид яг

өмчийн байцаагчтай болж байгаа. Өөрөөр хэлбэл яг өмчийн асуудлаа хянан шалгах ийм чиглэлийн улсын байцаагчийн эрхтэй ийм болж байгаа. Өмнө нь бол асуудал байхгүй байсан. Орон нутагт бас өмчийн асуудлаар бас нэлээн эрх мэдэл олгож байгаа. Өөрөөр хэлбэл орон нутагт бол энэ хуулиар орон нутаг өмчийн газартай байна. Өмчийн газар нь тухайн орон нутгийн өмчит компанийнхаа бас үйл ажиллагааг бас хянаж шалгаж байхаар зохицуулалт хийгдсэн. Энэ хуульд орсон нэг том зүйл гэх юм бол мэдээллийн нэгдсэн сантай байх тухай асуудал байж байгаа. Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан. Бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бас нэлээн ач холбогдол өгч байгаа. Хяналт шалгалтын асуудал бас нэлээн өргөн хүрээгээр хийгдэхээр ингэж орж ирж байгаа. Тийм учраас ер нь манай ТӨХ гэдгээрээ нэршлийг гэж явж байгаа. Хороо бол өөрөө тохируулагч агентлаг тодорхой энэ хуулийг дагасан журам манайх гаргах ийм эрх хэмжээтэй болж байгаа. Ерөнхийдөө хянан шалгах, бүртгэл хийх, тооллого хийх ийм статусаар явна. Ер нь өмчийн тухайлбал төрийн болон ТӨК-уудад өмчөө нааш нь цааш нь шилжүүлэх асуудал өөрсөд дээр нь очиж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол шинэлэг зүйл гэж бид үзэж байгаа. Тийм хариуцлагын механизмыг энд оруулж өгсөн. Ерөнхийдөө өмчийн хууль дээр бас нэлээн шинэлэг зүйлүүдийг тусгаж өгсөн гэж бид үзэж байгаа.

Ер нь сая Эрдэнэс Монголын талаар та асуулаа. Эрдэнэс Монголын Хувьцаа эзэмшлийн эрхийг хэрэгжүүлэгч нь Монгол Улсын Засгийн газар байж байгаа. Түрүүн сая Тогтохсүрэн гишүүн асууж байна лээ. Эрдэнэс таван толгой танай мэдэлд байдаг шүү дээ гээд. Эрдэнэс таван толгой манай мэдэлд байхгүй шүү дээ. Эрдэнэс таван толгойн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч нь хамгийн сүүлд Эрдэнэс Монгол болсон. Бүх шийдвэр нь тэр дээр гардаг. Тийм учраас тэр дээр.../минут дуусав/

Г.Занданишатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм шинэлэг юм орсон л гэх юм. Шинэлэг юм нь юу ч орсон юм би мэдэхгүй байна. Үнэхээрийн л төрийн нийтийн өмчөө л гэж бид Үндсэн хуульд заагаад, энэ хуульд хэдүүлээ 6 зүйл дурдчихаад байгаа. Тэр дээр тавьдаг хяналт юмнууд өмч л юм бол яаж явах юм бэ. Энэ харилцаа чинь хаа байна. Нэг.

Хоёрдугаарт тэр Эрдэнэс Монгол гэдэг чинь ер нь корпораци юм уу, эсвэл бодлого зохицуулалтын газар юм уу. Ямар статусаар яваад байгаа юм. Энэ шинэ хуулиар яаж суурь харилцааг нь ойлгож зохицуулах гээд байгаа юм. Би бол гайхаад байгаа юм. Үндсэндээ баахан том компаниудыг авч ирээд өөрийнхөө охин компани болгоод шахуу авчхаж байгаа юм билээ. Дор нь авчраад. Тэгээд тэр охин компаниуд дээр чинь Төлөөлөн удирдах зөвлөл байх юм уу, байхгүй юм уу. Ингээд их сонин сонин юм гараад байгаа байхгүй юу наадах чинь. Төрийн .../минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах уу.
83. Болдын Цэнгэл.

Б.Цэнгэл: Баялгийн сангийн хууль бас Улсын Их Хурлаар хэлэлцэгдэнэ. Баялгийн сангийн хуультай бас урьтал болгож бид нар компаниудыг корпорацийн хэлбэр рүү оруулж байгаа. Эрдэнэс Монгол бол корпорацийн зохион байгуулалтад орж байгаа компани гэж ойлгож болно. 100 хувь төрийн өмч дээр суурилсан ХХК гэж явж байгаа. Корпорац нь өөрөө ажиллахдаа бол группийн зарчмаар ажиллана. Корпорацийн доор 3-4 группүүд үүснэ. Зэс металлын групп, нүүрсний групп, дэд бүтцийн групп гэх зэрэг. Өнөөдрийн байдлаар бол 2 групп нь үндсэндээ үйл ажиллагаагаа явуулж байгаа. Зэс металлын групп дээр ерөнхийдөө Эрдэнэт үйлдвэр, Монрос, Оюутолгой зэрэг компаниуд багтсан байж байгаа.

Нүүрсний групп бол Эрдэнэс таван толгой багтчихсан явж байгаа. Монголросцветметийг тийш нь оруулсан. Сүүлд Төмөрлөгийн үйлдвэрийг оруулсан. Ингээд үйл ажиллагаа нь ингээд жигдрээд явж байгаа. Энэ бол нөгөө Үндсэн хуулийн 6.2 буюу баялгийн үр өгөөжийн дийлэнх хэсэг нь ард түмэнд хүртэх ёстой гэдэг зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор хийж байгаа Засгийн газрын компаниудаа энэ чиглэл рүү зохион байгуулалтад оруулж байгаа хэлбэр гэж ойлгож болно. Баярлалаа.

Г.Занданишатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асууна.

Т.Энхтүвшин: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль орж ирж байна. Төрийн өмчит байгууллага ч гэдэг юм уу орон нутгийн өмчтэй байгууллагын өмч хөрөнгийн асуудал ойлгомжтой. Хамгийн гол ярьж байгаа асуудал бол төрийн болон орон нутгийн өмчтэй компаниудын засаглалыг яаж сайжрах вэ гэдэг асуудлыг л олон нийт ярьж байна шүү дээ. Тэгээд би энэ дээр юу хэлэх гээд байна вэ гэхээр ТӨХ маань жоохон зоригтой ажилламаар байна. Энэ засгаа мэдээ мэдээллээр сайн хангаж өгмөөр байна. Ер нь бид төрийн болон орон нутгийн өмчтэй компаниудаас салах цаг нь болчихсон байна. Зоригтой шийдэл гаргамаар байна. Засгийн газрын тогтоол гарсан. Төрийн өмчтэй компаниудыг хувьчлах жагсаалт гарсан байж байгаа юм. Дандаа алдагдалтай ажилладаг компаниудыг олон нийтийн болгохоор л ийм Засгийн газрын тогтоол гарсан шүү дээ. Энэ бол амьдрал дээр хэрэгжихгүй шүү. Харин эсрэгээрээ энэ ашигтай ажиллаад байгаа олон нийтийн сонирхлыг татаад бусад юу гэдэг юм төрийн өндөр албан тушаалтнууд оролцоод байгаа ийм компаниудаа олон нийтийн болгох ийм Засгийн газрын тогтоолыг яаралтай оруулж ирээч Та хэд маань. Тэр зам арчлалтын компаниудыг чинь хэн ч авахгүй. Харин ч алдагдалтай ажилладаг компани улсын төсвийн хөрөнгөөр болон орон нутгийн

хөрөнгөөр тавигдсан замуудаа арчлаад явах нь зөв. Тийм учраас олон нийтийн болгох энэ тал дээр бол томоохон энэ юу гэдэг юм тэр Хөтөлийн цемент ч гэдэг юм уу, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ч байдаг юм уу, Таван толгой ч байдаг юм уу. Бүр цаашаа та хэд бол Жижиг Таван толгойн 51 хувийг ч гэсэн юу гэдэг юм чиглэл өгөөд, Аймгийнх нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар нь олон нийтийн болгох 51-ээс 10 хувийг нь ч юм уу, 30 хувь нь ч гэдэг юм уу олон нийтийн болох энэ асуудал дээр ч гэсэн чиглэл өгч ажиллаж болно шүү дээ. Энэ тал дээр нэг анхаарч ажиллаач гэдэг асуудал байна.

2 дахь асуудал байж байна. Төлөөлөн удирдах зөвлөл гээд нэг байж байна. Энийг ер нь ямар сонгон шалгаруулалтаар, ямар шалгуураар сонгодог юм.

2 дахь асуудал. Танайх ингээд тохируулагч агентлаг болох юм байна. Энэ юу гэдэг юм Сангийн яаманд байж байгаа санхүүгийн хяналт ч байдаг юм уу ийм хяналтын тогтолцоо танай дээр ирэх үү. Би бол энэ мэргэжлийн хяналтыг татан буулгасан янз янзын мэргэжлийн байцаагч нарыг Сангийн яам болон Нийслэл дээр байж байгаа санхүүгийн хяналтуудыг танай дээр төвлөрүүлээд тохируулагч агентлагаар нь төрийн өмчтэй болон орон нутгийн өмчтэй компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийдэг ийм тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Ийм зүйл явж байна уу гэдэг дээр хэлж өгөөч. 2 дахь асуудал бол орон нутгийн эрх мэдлийг, өмчийн эрх мэдлийг нэмэгдүүлж байгаа гэж яриад байна. Яг ямар нэмэгдлүүд орсон юм. Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага өмчийн эзэн гэж явдаг. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд ямар давуу эрхтэй орон нутгийнхаа хөрөнгийг захиран зарцуулдаг ийм заалтууд орсон юм. Дараагийн асуудал ерөөсөө энэ Төр ер нь бизнес хиймээргүй байна. Энэ хууль дээрээ та хэд орон нутагт байж байгаа,

төрд байж байгаа бизнесийн байгууллагуудыг хувийн хэвшилээр гүйцэтгүүлдэг нийтлэг үйлчилгээ гээд л бүх газрууд л байж байна шүү дээ. Бүх аймгуудыг дагасан нийтлэг үйлчилгээнүүд байж байна. Тэрийг бусад хувийн хэвшилээр гүйцэтгүүлдэг ийм тогтолцоог энэ хууль дээр хийж өгсөн үү. Бүгд л ингээд нэг төрийн өмчтэй компани байгуулах гээд, орон нутгийн өмчтэй компани байгуулах гээд ерөөсөө төр засаг маань бүгд л бизнесийн байгууллага болоод байна шүү дээ. Цогтбаатар гишүүн ч гэсэн бүр арга ядаад төрийн өмчтэй төрийн өмчийн оролцоотой компанийг дахиж байгуулахгүйгээр ийм хуулийн төсөл хүртэл санаачилж оруулж ирж байгаа шүү дээ. Яг ийм тогтолцоо ийм хуулийн заалт энэ дотор байна уу? Энийг хэлж өгөөч.

Г.Занданшатар: 83. Болдын Цэнгэл.

Б.Цэнгэл: 2022-203 онд төрийн болон төрийн өмчийн оролцоотой 26 аж ахуйн нэгжсийг олон нийтийн болгох ийм асуудлыг бид эхлүүлээд явж байгаа. Төрийн банк сая олон нийтийн болох үйл ажиллагаа амжилттай явагдсан. Одоо бид нар энэ ондоо багтаагаад Монголын Хөрөнгийн биржийг бас биржээр гаргах асуудлыг хийх гэж байна. Ер нь авто зам арчлалтын талаар ярьсан таны саналтай төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бол ер нь санал нэг байгаа. Манайх засаг дээр яригдаад ер нь Их Хурлаас баталсан үндсэн чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, нэн ялангуяа Эрдэнэс таван толгой зэрэг компаниудыг олон нийтэд нээлттэй болгох асуудлуудыг яаралтай судалж оруулж ир гэсэн байж байгаа. Энэ чиглэлээр бас ажиллаж байгаа. Тэгэхлээр бас нэлээн бодитой олон нийтийн хүлээлт үүсгэсэн ийм төрийн өмчит компаниудын асуудлыг бас цаг алдалгүй оруулъя гэдэг чиглэлээр ажиллаж байгааг хэлье ээ. Орон нутгийн өмчийн тухай асуудал хяналт шалгалтын чиглэлээр манай 80,

81 дүгээр микрофоноос хариулна. Мөн 82 бас.

Г.Занданшатар: 82.

Ц.Баяр-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн асуултад нэмэлт хариулт өгье. Ер нь ТУЗ-ийн гишүүдийг сонгох, томилох тогтолцоо бол өнөөдөр нөгөө хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дээрээ төвлөрөөд, тэгээд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа хүмүүс нь төрийн захиргааны албан хаагч байх ийм хатуу зохицуулалттай яваад байгаа юм. Улс төрийн албан тушаалтан бол төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх бололцоогүй. Хараат бус гишүүдийг бол компанийнхаа хуулийн зохицуулалтаар олон нийтэд нээлттэй зарладаг ийм зохицуулалт яваа. Энэ асуудлыг төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулга дээр авч үзэхдээ бол төрийн өмчит энэ төр дээр суурилж бизнес хийж байгаа байгууллагуудын ангиллыг нэлээн тодорхой болгоод, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэдэг ангиллыг байхгүй болгоод албан газар, компани гэдэг 2 чиглэл рүү оруулж байгаа. Компаниуд бол үндсэндээ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг их өндөрсгөж өгсөн. Тухайлбал төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийн 27 дугаар зүйл дээр маш нарийн зохицуулалтууд орсон байгаа.

Сүүлийн 8 жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй, Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн авлигын өмчийн эсрэг гэмт хэрэг шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа хамаарах салбарын болон санхүүгийн мэдлэг туршилагатай тухайн салбарт 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан холбогдох яг тэр тухайн чиглэлийн компанийн салбарын чиг хүрээнд нийцсэн ийм

мэргэжилтэй байх гээд босго шалгуурыг нэлээн өндөрсгөж өгч байгаа юм. Тэгэхээр зохицуулалтууд маань өөрөө ТУЗ-ийн чадамжийг сайжруулах ийм нөхцөл болно гэж үзэж байгаа.

Дараагийн нэг тодотгож хэлэх зүйл ер нь стратегийн орд ер нь ТӨК-ийн хувь хувьцааны асуудлыг Улсын Их Хурал мэддэг, тэр чиглэлээр нь тодорхой үүрэг чиглэл Засгийн газарт өгдөг байхаар энэ хуулийн агуулга орж ирж байгаа. Энэ төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулга дотор. Тэгэхээр энэ хүрээндээ Их Хурал стратегийн асуудлуудыг, орон нутгийн түвшинд орон нутаг зөвхөн иргэдийнхээ нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагаатай хамааралтай тэр чиглэлд компани байгуулах асуудлыг нь зохицуулахаар оруулж ирж байгаа. Тэгэхээр хийдэг хийдэг хүрээндээ тэр хүрээ хязгаарыг нь тодорхой болгож өгч байгаа. Тэгээд тухайн салбарт компани байгуулах асуудлуудыг жишээ нь төрийн өмчит компани байгуулах асуудал дээр төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар буюу одоо энэ хуулийн төсөл дээр байгаа ТӨХ санал, дүгнэлт гаргадаг. Орон нутагт компани байгуулах асуудал дээр орон нутгийн өмчийн газар мэргэжлийн байгууллага санал, дүгнэлт гаргадаг. Тэгээд компани байгуулах асуудлыг нэлээн шалгуур шаардлагыг нь өндөр болгож нэлээн олон дүгнэлт гаргадаг байдлаар зохицуулсан байгаад байгаа юм. Чиглэлүүдийг нь нэлээн тодорхой зохицуулж өгсөн байгаа юм.

Г.Занданшатар: 80.

Ц.Түвшинзаяа: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар маань өнөөдөр ТХШТХ-ийн 7.4-д заасны дагуу мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. 2016 оноос өнөөдрийг хүртэл агентлаг байгуулагдсанаас хойш гэсэн үг. Нийтдээ 223 төрийн өмчит хуулийн этгээдэд хяналт шалгалт

хэрэгжүүлээд байна. Шинэ хуулиараа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр орон нутгийн өмч дээр орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрууд дээр төрийн хяналтыг хэрэгжүүлэхээр шинэчилж заасан зохицуулалт маань орж байгаа нь энэ хуулийн онцлог заалт болж байгаа. Өнөөдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын улсын байцаагч нар Сангийн сайдын тушаалаар санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхээр хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. Энэ маань санхүүгийн хяналт шалгалтын стандартаар төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, захиран зарцуулалт дээр хяналт шалгалт хийнэ гэсэн чиг үүргийнхээ дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг гэсэн үг ээ. Өнөөдөр танилцуулагдаж байгаа шинэчлэгдсэн хуулийн төсөл дээр 62.5 дээр ТӨХ болон орон нутгийн өмчийн газрын хяналтын байцаагчийн чиг үүргийг тодорхой зааж өгсөн байгаа.

Г.Занданишатар: Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Т.Энхтүвшин: Яамдууд сүүлийн жилүүдэд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай ингээж зөвшөөрөл авахгүйгээр төрийн өмчтэй компаниуд байгуулаад байгаа ийм асуудлууд байгаа шүү. Энэ дээр та хэд маань нэлээн сайн анхаараарай.

2 дахь асуудал. Би тэр тохируулагч агентлаг болно гэдэг маш сайн дэмжиж байгаа. Ер нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудаа 2 жилд 1 удаа санхүүгийн хяналт хийдэг ийм тогтолцоо руу л бид нар яаралтай орох хэрэгтэй. Үнэхээр манай ТӨХ хүчгүй явж ирсэн нь энэ зарцуулалтыг, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийдэггүй олсон орлогыг нь ингээж тооцдоггүй, ийм хяналтын механизм байхгүйгээс болоод их олон өмч

хөрөнгүүд бас алдагдаж байсан шүү. Төрийн өмчтэй компаниуд дээр.

Тийм учраас цаашидаа бол хяналтын тогтолцоог хэрэгжүүлээд 2 жил тутамд.../минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэлчихлээ. Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Хуулийн төсөл дээрээс хэд хэдэн асуулт байна. Төрд өөрт нь тусгайлсан өмчлүүлсэн ард иргэдэд огт хамааралгүй эд хөрөнгө гэж байхгүй. Төрийн өмч бол ард иргэдийн эрх ашгийн төлөө байх, ашиглагдах учиртай. Харамсалтай нь манай улсад эсрэгээрээ мөрдөгдөж байгаа. Тийм учраас нүүрсний хулгай, Хөгжлийн банкны луйвар, жижиг дунд үйлдвэрийн асуудлууд гарч ирж ард иргэд үүнд бухимдаж байна. Энэ хуулийн төслийн 18.13-т төрийн өмчийн компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигч нь Засгийн газар, орон нутгийн компанид бол аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байна гээд нэг хамтын удирдлагын загвар хариуцах эзэн тодорхойгүй, эзэнгүйдсэн ийм заалт байгаа юм. Тэгэхээр бид энэ харилцааг зохицуулахдаа зөв, оносон ямар шийдлүүдийг гаргаж ирээд байгаа юм бэ. Та бүхэн өнөөдөр хуулийн цоорхой түүнийг ашиглаж гарч байгаа луйвруудтай холбоотой асуудлыг мэдэж байгаа. Энэ ямар зүйл заалтаас болоод гараад байгаа юм бэ гэдгийг ч ойлгож байгаа. Үүнийг хаасан ямар зохицуулалтуудыг хууль дээр оруулж ирээд байгаа юм бэ. Энэ дээр хариулт авъя.

Хоёрдугаарт нь төрийн өмчийн компаниуд дээр л хууль зөрчсөн хулгай луйврууд явагдаж байна. Энэ компаниудаа бид хэрхэх ёстой юм бэ цаашидаа. Олон нийтийн оролцоотой компани байгуулъя гэдэг асуудал ярьж байгаа. Түрүүн Энхтүвшин гишүүн ярилаа. Олон нийтийн оролцоотой компани байгуулъя гэхээр нөгөө л нэг ашиггүй шахуу зам арчлалтын

компаниудаа оруулаад ирчихдэг. Нөгөө уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Таван толгойн нүүрс гээд өгөөжөө өгч болохуйц, цаашилаад олон жил ашигтай ажиллах боломжтой ийм компаниуд дээр олон нийтийн оролцоо оруулж ирэх тал дээр ямар ч санаачилгагүй ажиллаж байгаа юм. Хэрвээ бид нар энэ компаниудаа олон нийтийн оролцоотой болгож чадах юм бол нөгөө далд эдийн засаг, энэ хулгай луйврууд чинь алга болно шүү дээ. Ард иргэдэд өгөөж өгнө. Тэгэхээр энэ асуудлыг хэзээ эхлэх юм бэ. Та бүхэн энэ дээр ямар төлөвлөлтүүд хийж байгаа юм бэ гэдэг дээр хариулт өгөөч ээ.

Гуравдугаарт нь Эрдэнэс Монгол гэж компани групп байна. Уг нь хэмнэлтийн тухай хуулиараа төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулахгүй л гээд байсан. Байгуулж байгаа юм байна л даа. Тэгээд өөрөө нэг хууль гаргачхаад Засгийн газар, буцаагаад түүнийгээ зөрчөөд байж болдог л юм байх даа. Би ойлгохгүй байна. Тэгээд энэ группийг байгуулангуутаа уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн жилийн борлуулалтын орлогын 2 хувь буюу 60 гаруй тэрбум төгрөгийг менежментийн зардалд авна гээд явж байгаа юм. Энэ чинь юу гэсэн үг юм бэ. Тийм мөнгөтэй байгаа юм уу манай Монгол Улс. Гайгүй ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдээ янз бүрийн байдлаар ингэж цөлмөж менежментийн зардал гэж аваад татаад унагачихвал бид яах юм бэ. Улсын орлогоо яаж бүрдүүлэх болох юм сүүлдээ. Ер нь Эрдэнэс Монгол гэж групп чинь ер нь хэнд зориулагдсан групп юм бэ. Яг ямар үйл ажиллагаа явуулах юм. Ингээд л энд тэндхийн татаасаар ажиллаж, амьдраад байх ёстой юм уу. Энэ 60 гаруй тэрбум төгрөг чинь мөнгө шүү дээ. Тэр Эрдэнэт үйлдвэрт хэрэгтэй. Эрдэнэтийн ард иргэдэд хэрэгтэй шүү дээ. Монголчуудад хэрэгтэй мөнгө шүү дээ. Зүгээр нэг компанийн менежментийн зардалд ингээд оруулаад явах ёстой юм уу. Энхийг

хэрхэх тухайгаа та бүхэн тайлбарлаж хэлээч гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 83. Болдын Цэнгэл асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга

Б.Цэнгэл: Өмчийн хуулийн шинэчилсэн найруулгын 18.13 дээр ТӨК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчид нь Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн хувьцаа эзэмшигч нь тухайн иргэдийн төлөөлөгчдийн хурал байна гэж заасан. Энэ бол яах вэ яг зарчмын заалт. Хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч гэдэг ойлголт байгаа. Хувьцаа эзэмшигч чинь өөрөө хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчээ бас шийддэг ийм зарчимтай. Өнөөдрийн мөрдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 2014 оны өөрчлөлтөөр бол тухай бүр нь Монгол Улсын Засгийн газар шийдээд явдаг ийм зохицуулалт өнөөдөр хэрэгжиж байгаа юм. Бид өнөөдрийн хуваарьт хэлэлцэж байгаа хууль биш, нөгөө төрийн өмчит компаниудын хуулийн төсөл дээр бол Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч нь нэг субъект байхаар ингээд төсөлд явж байгаа. Эсвэл юу гэдэг юм яам эсвэл төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байх юм гэдэг ийм зохицуулалтаар явж байгаа. Бид энэ дээр нөгөө олон хувьцаа эзэмшигчтэй байх асуудлыг цэгцэлье гэдэг ийм агуулгаар асуудал орж байгаа гэдгийг хэлье.

Эрдэнэс Монгол компани бол төрийн өмчит ХХК байж байгаа. Зүгээр компанийн үйл ажиллагааных нь хэлбэр нь бол нэгдэл маягтай корпорац маягаар явж байгаа. Гол нь нөгөө Баялгийн сангийн тухай хууль буюу Үндсэн хуулийн 6.2-т заасан уул уурхайн бүтээгдэхүүнээс гарч байгаа баялгийг үндэсний баялгийн санд хуримтлуулах гэсэн энэ том агуулгаар нь бид нар группийн зохион байгуулалтад оруулаад, ингээд явж байгаа юм. Тэгэхээр одоогийн

байдлаар 2 групп компани үйл ажиллагаагаа бүр эхлээд ингээд зохион байгуулалтынхаа ажлыг эхлээд явж байна. Тэр менежментийн зардал гээд юм явж байгаа асуудал бий. Энэ дээр эцэслэсэн байдлаар шийдэгдээгүй. Ерөнхийдөө тийм санал тавигдчихсан явж байгаа. Бид энэ дээр бас эргэж харж, ярих ийм асуудлууд байж байгаа юм.

Г.Занданишатар: Батлут гишүүн 1 минут тодруулж асууя.

Д.Батлут: ТӨК-удынхаа асуудлуудыг бид нар яаралтай шийдэж, олон нийтийн оролцоотой болгохгүй бол энэ мэтчилэн мөлжөөд дуусах нь ээ. Эрдэнэт үйлдвэрийг, Эрдэнэс таван толгойг. Бид нар төрийн өмчтэй ингээд л байгаад байх юм бол засаглалын хямрал явагдана. Нөгөө хулгай нь арилахгүй. Засаглалд нь улс төрийн нөлөөлөл нь арилахгүй. Тийм учраас олон нийтийн оролцоотой болох асуудлыг яаравчилъя. Энэ Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс таван толгой гэх мэтчилэн олон аж ахуйн нэгж дээр шүү. Одоо ингээд нэг групп байгуулж байгаа нэртэй. Тэр нь яах вэ нэг Эрдэнэсийн санд хуримтлал бий болгох асуудлыг л хариуцах юм байна л даа. Тэр байгууллагыг байгуулснаараа ийм асуудлыг шийдэх гэж байгаа, түүнд нь менежментийн зардал болгож 60 тэрбум төгрөг буюу жилийнх нь орлогын 2 хувийг зарцуулна гэж байгаа бол болио, боль л доо. Түүнгүйгээр шууд шийдчих боломж байгаа.

Г.Занданишатар: Тэгээд энэ хуулийн гол эх зохиогч нь хэн юм бэ. Гол ажлын хэсэг бичсэн хүн нь хэн юм. Тогтохсүрэн гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн тэгээд Энхтүвшин гишүүдийн яриад байгаа яг өмчийн эрх зүйн суурь ойлголт, орон нутгийн эрх мэдэл тэр бүх юмыг ер нь маш түүхий болчихсон байна гэж яриад байгаа үндэстэй байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ Чимэд гуайн өмчийн эрх зүйн тухай ойлголт хийсэн хуучин хуулийг өөрчлөөд, тусгайлсан өмч гэж дэлхийд байхгүй

өмчийн нэр томъёо гаргаж ирээд, Улсын Их Хурал бүх өмчийн өмчлөгч болоод төрийн нийтийн өмчийг л Улсын Их Хурал өмчлөгч нь байж шийдвэр гаргадаг. Тэгэх юм бол бүх асуудал Улсын Их Хурлаар шийдвэрлэгддэг болох юм байна шүү дээ. Орон нутгийн өмчийн эрхзүйн асуудал. Тэгээд орон нутгийн өмчийн эрх зүйн асуудлууд энэ тэр маш сайн ажиллахгүй бол энэ дээр яг нөгөө нэг өмчийн хөрөнгийн шилжүүлэг, тооллого нөгөө деталь руугаа ороод яг үндсэн философи нь гишүүдийн яриад байгаа дээр орон нутгийн өмчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх энэ тэр гэж бид нарын ярьж байсан юмыг чинь бүр өөрчлөөд, судалгаа их л сайн хийгдсэн гэсэн. Тэгээд та хэд бас гишүүдийн хэлж байгаа юмнуудыг их анхааралтай сайн хариулсангүй. Төрийн нийтийн өмч, төрийн өөрийн өмч хоёрынхоо ялгааг, төрийн нийтийн өмчийн компаниудынхаа ялгааг ч гэсэн тодорхой хэлэхгүй ингэж явсаар байгаад маш сонин байдалд орж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ хууль бол. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх үү. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо дэмжсэн дэмжээгүй 3 хүртэл гишүүд үг хэлж болно. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу. Батжаргал гишүүнээр тасаллаа. Санал хураахгүй. Санал хураавал ил тодоор маргааш хэлэлцсэн нь дээр байх. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж, чуулганы хуралдааны цаг дууссан учраас хойшууллаа. Маргааш өглөө Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуулийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

ДУУНЫ	БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ	
ДЭЛГЭРЭНГҮЙ	ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ,	
ХЯНАСАН:	ШИНЖЭЭЧ
	Э.СУВД-ЭРДЭНЭ

